

Монгол Улсын Хивэгч малын хамгаалалттай аж ахуй

Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар

Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам
(ХХААХҮЯ)-тай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд

Төслийг санхүүжүүлэгч:

Дэлхийн Банк Группын Олон Улсын Санхүүгийн Корпораци

Хамтрагч байгууллага:

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Мал эмнэлгийн ерөнхий газар

болон

Монгол Улсын Мал аж ахуйн салбарын төрийн бус байгууллага,
хувийн хэвшлийн төлөөлөл

Гарчиг

Хэсэг А. Ерөнхий мэдээлэл	4
А.1. Стратегийн зорилго.....	4
А.2. Олон улсын нөхцөл байдал	5
А.3. Үндэсний нөхцөл байдал	7
А.4. Аж ахуйн нэгж, байгууллагын нөхцөл байдал	11
А.5. Хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах ажлын хүрээ	14
А.6. Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага	21
А.7. Оролцогч компанийн үүрэг хариуцлага	25
А.8. Хамгаалалттай аж ахуйд ханган нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага	28
Хэсэг В. Биохамгааллын нийтлэг заавар: Хамгаалалттай аж ахуйн өмчлөгчид зориулсан стандарт ажиллагааны заавар (САЗ)	33
В.01. Газар зүйн нөхцөл байдал, байгууламжийн зохион байгуулалт, бүтэц	33
В.02. Орцын хяналт: Мэдрэмтгий зүйлийн амьд мал	35
В.03. Орцын хяналт: Генетикийн материал (Үр, хөврөл үр).....	40
В.04. Орцын хяналт: Тэжээл, ус.....	43
В.05. Орцын хяналт: Эмийн бүтээгдэхүүн (Вакцин, бичил биетний эсрэг эм).....	45
В.06. Орцын хяналт: Тоног төхөөрөмж	47
В.07. Орцын хяналт: Хэвтрийн материал	48
В.08. Биоаюулын эрсдэлийн удирдлага: Тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл	49
В.09. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Хүний нөөцийн удирдлага, сургалт.....	52
В.10. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Зочид	55
В.11. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар	57
В.12. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн ээлж хоорондын биохамгааллын заавар	60
В.13. Биоаюулын эрсдэлийн удирдлага: Ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт	62
В.14. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Зэрлэг амьтан, шувуу, хортон шавж, мэрэгчтэй тэмцэх	64
В.15. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Биохамгааллын зөрчлийн үед хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө	66
В.16. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн гүйцэтгэлд хийх хяналт-шинжилгээ	68
В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр	70
В.18. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Вакцинжуулах хөтөлбөр.....	73
В.19. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Эмчилгээний хөтөлбөр	77
В.20. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх, удирдах.....	79

V.21. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Бичил биетний эсрэг эмийн болгоомжтой хэрэглээ	81
V.22. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Малын тавлаг байдал	83
V.23. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Өвчин үйл явдал тохиолдох үеийн бэлэн байдлын төлөвлөгөө	85
V.24. Гарцын хяналт: Мал	89
V.25. Гарцын хяналт: Генетикийн материал (Үр, хөврөл үр)	92
V.26. Гарцын хяналт: Мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн	95
V.27. Гарцын хяналт: Үхсэн мал, хог хаягдал, бохирын ус.....	98
V.28. Гарцын хяналт: Тоног төхөөрөмж	100
V.29. Дотоод хяналт: Баримт бичиг, бүртгэл хөтлөлт.....	101
V.30. Дотоод хяналт: Тогтмол тайлагналт	103
V.31. Дотоод хяналт: Хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх, тайлагнах	105
V.32. Хөндлөнгийн хяналт: Төрийн баталгаажуулагч этгээдийн хийх хөндлөнгийн хяналт шалгалт	107
Хэсэг С. Компанийн хамгаалалттай аж ахуйд зориулсан зөвлөмж, загвар, маягт	111
C.01. Хамгаалалттай аж ахуй бүртгүүлэх өргөдлийн маягт.....	111
C.06. Хамгаалалттай аж ахуйд байгууламж бүртгүүлэх өргөдлийн маягт	113
C.03. Тогтмол илгээх тайлангийн загвар	115
C.04. Үл тохирлын мөрөөр авах арга хэмжээний тайлангийн загвар	118
C.05. Компанийн хамгаалалттай аж ахуй гэрчилгээний загвар.....	119
C.06. Оролцогч компани болон лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэх эрх бүхий бүхий этгээд хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар.....	120
C.07. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн чадамж, зардал.....	131
C.08. Лабораторийн оношлох үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг барагцаалан тооцоолох үйл явц	133
C.09. Өвчнөөр тайван болохыг нотлох судалгааны хувилбар боловсруулахад өгөх зөвлөмж	137
C.10. Оролцогч компани болон зөвшөөрөл бүхий хөндлөнгийн	142
баталгаажуулагчийн хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар	142
C.11. Онцгойлсон өвчний эпидемиологийн үндсэн үзүүлэлт	151
C.13 Нэр томъёоны тодорхойлолт	154

Хэсэг А. Ерөнхий мэдээлэл

А.1. Стратегийн зорилго

Хамгаалалттай аж ахуй, түүний байгууламж дахь мал, амьтны дэд-популяци онцгойлсон өвчингүй, тайван, ~~тэрхүү дэд-популяци~~ бэлтгэсэн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн ариун цэврийн шаардлага хангасан болохын баталгааг хэрэглэгч болон тухайн улсын Ариун цэвэр, ургамлын ариун цэвэр (АЦУАЦ)¹-ийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагад өгч байдаг.

Хамгаалалттай аж ахуйг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-аас төр, хувийн хэвшлийн түншлэл гэж үзэж байна.

Монгол улсад мал, амьтны эрүүл мэндэд холбогдох ариун цэврийн асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) төрийг төлөөлж хариуцдаг. МЭЕГ нь дүрэм журмыг тодорхойлж, тэдгээрийн биелэлт, хэрэгжилтийг удирдан чиглүүлж хяналт тавих, зөвшөөрөл олгох, худалдааны түншийн АЦУАЦ-ийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагатай ариун цэврийн арга хэмжээний эн тэнцүү байдлын талаар хэлэлцэн тохиролцох, экспортын албан ёсны баталгаа гаргаж гэрчилгээ олгох чиг үүрэгтэй.

Компаниуд өөрсдийн хамгаалалттай аж ахуйг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд, тэр дундаа МЭЕГ-аас тавьсан шаардлагын дагуу боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын зааврыг баримтлан байгуулж, шаардлага хангаснаа баталгаажуулах хүсэлтээ МЭЕГ-т гаргах замаар энэ үйл хэрэгт оролцох сонголтоо сайн дурын үндсэн дээр хийнэ.

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар нь зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хэлэлцээрийг амжилттай хийж, түүнийгээ худалдааны түншийнхээ АЦУАЦ-ийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх хамгийн таатай боломж олгодог бөгөөд ДМАЭМБ-ын стандарт, удирдамжийн дагуу хивэгч малын хамгаалалттай аж ахуйг байгуулах, зөвшөөрөхөд нь төрийн болон хувийн хэвшлийн салбарын аль аль нь ашиглах боломжтой эх сурвалж болгон боловсруулав.

МЭЕГ-т салбарынхаа хамгаалалттай аж ахуйн тогтолцоог удирдан зохицуулах чиг үүргээ биелүүлэхэд нь нэмэлт эх сурвалж болгон хамгаалалттай аж ахуйн захиргаа, удирдлагын гарын авлагыг мөн боловсруулав.

¹ АЦУАЦ гэж Дэлхийн Худалдааны Байгууллагын “Ариун цэвэр, ургамлын ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” хэлэлцээрт тодорхойлсончлон мал, амьтны эрүүл мэнд, ургамлын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог ойлгоно.

А.2. Олон улсын нөхцөл байдал

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Ариун цэвэр, ургамлын ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрээр ДМАЭМБ-ыг мал, амьтны эрүүл мэнд, зооноз өвчний талаар олон улсын стандарт тогтоох чиг үүрэг бүхий байгууллага болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

Монгол улс Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) болон Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) -ын гишүүн юм. ДХБ-ын Ариун цэвэр, ургамлын ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх хэлэлцээр (ДХБ-ын АЦУАЦ-ийн хэлэлцээр), ДМАЭМБ-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодекс (ДМАЭМБ-ын Кодекс), ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлага (ДМАЭМБ-ын Гарын авлага)-д тодорхойлсон бүрэн эрх, хүлээх үүрэг нь хамгаалалттай аж ахуйг худалдааны түнш зөвшөөрч, тийнхүү хүлээн зөвшөөрснийг зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хоёр талт протоколд тусгахад нь дэмжлэг болдог.

Хамгаалалттай аж ахуйг ДМАЭМБ-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодекс (ДМАЭМБ-ын Кодекс)-т дараах байдлаар тодорхойлжээ:

ХАМГААЛАЛТТАЙ АЖ АХУЙ

гэж мэдрэмтгий бусад популяциас биохамгааллын нийтлэг арга хэмжээгээр зааглан нэг, эсхүл хэд хэдэн аж ахуйд маллаж байгаа, олон улсын худалдааг дэмжих болон улс, бүсэд өвчин тархахаас хамгаалах, тэмцэх зорилгоор шаардлагатай тандалт, биохамгаалал, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлдэг, нэг буюу хэд хэдэн халдвар, үе хөлтний шимэгчлэлд хамаарах эрүүл мэндийн тусгай статустай мал, амьтны дэд-популяцийг хэлнэ.

Хамгаалалттай аж ахуйд тавих шаардлагыг ДМАЭМБ-ын Кодексын олон улсын дараах стандартад тодорхойлсон байна:

- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 4.4. Бүсчлэл ба хэсэгчлэл
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 4.5. Хэсэгчлэлийг хэрэглэх нь
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 5.3, ялангуяа Зүйл 5.3.7. Бүс эсхүл хамгаалалттай аж ахуй байгуулах, түүнийг олон улсын худалдааны зорилгоор хүлээн зөвшөөрөх арга хэмжээний дараалал

Өвчинтэй тэмцэх албан ёсны хөтөлбөр, эрх бүхий чадварлаг мал эмнэлгийн алба, экспортын гэрчилгээний найдвартай байдлыг хангаж өгдөг эрүүл малыг зах зээлд гаргах хөтөлбөр, мал, амьтны ялган тэмдэглэгээ, мөшгөн тогтоох хөтөлбөр, оношилгооны өндөр чадвартай лабораторийн үйл ажиллагааны үр дүнд хэрэгждэг биохамгааллын үр дүнтэй стандартууд нь хамгаалалттай аж ахуйг худалдааны түншүүдээр хүлээн зөвшөөрүүлэхэд дэмжлэг болох төдийгүй тийм боломжийг бүрдүүлнэ.

Иймд Монгол улсад хамгаалалттай аж ахуй байгуулахдаа дараах нэмэлт стандарт, удирдамжийг ашиглах нь зүйтэй:

- ДМАЭМБ-ын кодекс Хэсэг III. Мал эмнэлгийн албаны чанар
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 4.2, 4.3. Мал, амьтныг ялган тэмдэглэх, мөшгөн тогтоох
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 4.19. Тусгай ангиллын эсхүл шинэ ба сэргэж байгаа өвчинтэй тэмцэх албан ёсны хөтөлбөр
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 5.1, 5.2 Худалдаанд зориулсан гэрчилгээ олголт

- ДАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлага (ДМАЭМБ-ын гарын авлага)

Хивэгч мал, тэдгээрийн малын гаралтай бүтээгдэхүүн нь олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг онцгойлсон өвчингүй, тайван гэсэн баталгааг монгол улсын хамгаалалттай аж ахуй хангах ёстой. Тиймээс тэдгээр онцгойлсон өвчний талаарх ДМАЭМБ-ын олон улсын стандартыг дагаж мөрдөх явдал ч бас үүнд хамаарна. Эдийн засаг, практикийн болон зах зээлд нэвтрэх шалтгаанаар гаргасан шийдвэр нь олон улсын тэдгээр стандартад заасан техникийн шаардлагатай үл нийцэж болох ч гаргасан шийдвэр нь үндэслэлтэй, ил тод байх байх ёстой.

- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 8.8 Шүлхий өвчний вирусийн халдвар
- ДМАЭМБ-ын кодекс Бүлэг 14.7 Бог малын мялзан өвчин (БММӨ)-ий вирусийн халдвар

Хил даван тархдаг мал, амьтны өвчинтэй шат ахиулан тэмцэх даян дэлхийн зохицуулалт (GF-TADs) нь ДМАЭМБ болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (НҮБ-ын ХХААБ)-ын хамтын хөтөлбөр юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд шүлхий болон бог малын мялзан өвчин (БММӨ)-тэй тэмцэх дэлхийн хэмжээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Монгол улс шүлхий өвчинтэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага болох Зүүн-Өмнөд Ази, БНХАУ-ын шүлхий өвчинтэй тэмцэх комиссын гишүүн юм. Зүүн-Өмнөд Ази, БНХАУ-ын шүлхий өвчинтэй тэмцэх комисс бүс нутгийн хэмжээнд дүн шинжилгээ хийж зөвлөмж гарган ажилладаг бөгөөд тус комиссын жил бүрийн ээлжит хурлын үеэр Монгол улс шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийнхөө хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, гарч буй ахиц дэвшлийг танилцуулдаг. Тус комисс мал эмнэлгийн албаны чадамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, тодорхой асуудлын талаар техникийн удирдамж, зааварчилгаагаар хангадаг.

Монгол улс дэлхийн олон улс оронтой худалдааны хэлэлцээр байгуулаад байна. Тэдгээр хэлэлцээр нь МЭЕГ болон худалдааны түншийн АЦУАЦ-ийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага хооронд хийх зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хэлэлцээрийн суурь нөхцөл болж өгнө.

Хамгаалалттай аж ахуй нь түүний баталгаат байдлыг хангах тогтолцоонд тавьсан шаардлагын дагуу зөвшөөрөл авч, өөрийн боловсруулж албажуулсан техникийн нөхцөлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байвал МЭЕГ нь:

- Баталгаажуулсан хамгаалалттай аж ахуйг өөрөө зарлан тунхагласнаа ДМАЭМБ-д мэдэгдэнэ;
- Зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколын хүрээнд хамгаалалттай аж ахуйн баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрүүлэх талаар хэлэлцээр хийнэ.

А.3. Үндэсний нөхцөл байдал

Оршил

Монгол улс мал аж ахуй эрхлэх олон мянган жилийн туршлагатай. 2023 оны жилийн эцсийн байдлаар 189,300 малчин өрх (нийт өрхийн 20%) улсынхаа нутаг дэвсгэрийн 70%-ийг эзлэх бэлчээрт 64.7 сая толгой мал маллаж байна. Тус улсын үйлдвэрлэлийн салбарт хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуй шийдвэрлэх үүрэгтэй байдаг учраас Монгол улсын Засгийн газраас мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Тухайлбал “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын эхний үе шатад (2021-2030) Монгол улс мал аж ахуйгаас үйлдвэрлэх бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлэх замаар экспортын зах зээлийг хөгжүүлэх, дараагийн 2 дугаар үе шатад (2031-2040) мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд суурилсан хөнгөн үйлдвэрийг улам хөгжүүлэхээр төлөвлөөд байна.

Монгол улсад мал, амьтны эрүүл мэндэд холбогдох ариун цэврийн асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллага нь Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) юм. МЭЕГ нэн тэргүүнд анхаарах эндемик тархалттай өвчин, тэр дундаа махны салбарын хамгаалалттай аж ахуйд онцгойлсон өвчин, тухайлбал шүлхий, бог малын мялзан өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үндэсний эдгээр стратегийг хэрэгжүүлэх нь мал, амьтны эрүүл мэндэд гаднаас учирч болох эрсдэлийн дунд оршиж түүнийг бууруулахаар ажиллаж байдаг хамгаалалттай аж ахуйн баталгаат байдлыг хангахад дэмжлэг болно.

Дэлхийн Банкны Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) болон МЭЕГ нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хууль эрх зүйн орчин, институцийн чадавхыг сайжруулах, ялангуяа дор дурдсан чиглэлээр хамгаалалттай аж ахуй байгуулах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт гарган хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан юм. Үүний дагуу:

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд хамгаалалттай аж ахуйг байгуулах нөхцөлийг бүрдүүлэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Хамгаалалттай аж ахуйн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, техникийн нөхцөлийг тогтоосон журам боловсруулах;
- Зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэхийн тулд хүнсний аюулгүй байдлын дүрэм журмыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
- Зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх үүднээс хамгаалалттай аж ахуйд төрийн зүгээс хяналт тавих, зааварчлан удирдах, нөхцөлийг бүрдүүлэх баталгаажуулалт, хяналт шалгалт хэрэгжүүлэх чадавхыг бий болгох зэрэг болно.

Хамгаалалттай аж ахуйд хамаарах онцгойлсон өвчний үндэсний статусыг харуулах, түүнчлэн олон улсын стандартыг хэрэгжүүлэх Монгол улсын үүрэг амлалтын биелэлтийг ил тод харуулахад Монгол улсаас ДМАЭМБ-ын Мал, амьтны эрүүл мэндийн мэдээллийн системд илгээсэн өвчний мэдэгдэл, зургаан сар тутмын болон жил бүрийн тайлан чухал ач холбогдолтой юм.

Үүрэг, хариуцлага

Хамгаалалттай аж ахуйд төр болон хувийн хэвшил аль аль нь эрсдэлийг удирдах үүрэг хүлээж, хамгаалалттай аж ахуйн албан ёсны баталгааг хангах нийтлэг зорилтод хүрэхээр харилцан тохиролцсон төр, хувийн хэвшлийн түншлэл юм.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах журамд малын эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын үндэсний тогтолцоон дахь засгийн газрын агентлаг, хувийн хэвшлийн байгууллагын чиг үүрэгтэй уялдуулан тэдгээрийн үүргийг тодорхой заасан байдаг.

1. Мал, амьтны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг зохицуулагч

МЭЕГ нь:

- а) Шүлхий, бог малын мялзан өвчинтэй тэмцэх үндэсний албан ёсны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- б) Мал, амьтны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг удирдах, экспортын гэрчилгээ олгох хамгаалалттай аж ахуйн үндэсний бодлого, техникийн нөхцөлийг боловсруулна.
- в) Оролцогч компани тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, биоамгааллын зааврыг хянан үзэж, баталгаажуулагч этгээд хяналт шалгалт хийсний дараа тэдгээрт зөвшөөрөл олгоно.
- г) Оролцогч компани, хамгаалалттай аж ахуй, байгууламжийн албан ёсны бүртгэл хөтлөнө.
- д) Хамгаалалттай аж ахуй, оролцогч компани тус бүрээс ирүүлсэн жилийн эцсийн тайланг хүлээн авч баталгаажуулна.
- е) Мал эмнэлгийн мэдээллийн нэгдсэн систем (МЭНС)-ийг мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрүүдийг дэмжих мэдээлэл технологийн платформ болгон удирдана.

2. Олон улсын гэрчилгээ олголтыг зохицуулагч

МЭЕГ нь:

- а) Зүүн-Өмнөд Ази, БНХАУ-ын шүлхий өвчинтэй тэмцэх комисс (SEACFMD)-ын хурал гэх мэт олон улсын хурал, чуулган, уулзалтад оролцох, хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван байдлыг өөрөө баталгаажуулсан тухайгаа ДМАЭМБ-аар зарлуулах хүсэлтээ гаргах замаар Монгол улсын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах бодлогыг сурталчлан таниулах;
- б) Хамгаалалттай аж ахуйн баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрсөн худалдааны түнштэй зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколыг хэлэлцэн тохиролцох;
- в) Зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн хэлэлцэн тохиролцсон протоколын дагуу хамгаалалттай аж ахуйн гаралтай мал, малын гаралтай бүтээгдэхүүн нь экспортын шаардлага хангасан болохыг гэрчлэх;
- г) Шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний албан ёсны хөтөлбөрийг ДМАЭМБ-аар албан ёсоор баталгаажуулж, түүнийгээ хэрэгжүүлэх.

3. Баталгаажуулагч этгээд

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биоамгааллын нийтлэг заавар

Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

8

МЭЭГ нь:

- а) Журам болон холбогдох техникийн нөхцөлд заасан давтамжаар оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж нэг бүрд тавигдах шаардлагын дагуу боловсруулсан хяналтын хуудсыг ашиглан хяналт шалгалт хийх;
- б) Журам болон холбогдох техникийн нөхцөлд заасанчлан хяналт шалгалтын үеэр илэрсэн аливаа үл тохирлыг өндөр эрсдэлтэй, дунд эрсдэлтэй, бага эрсдэлтэй (ISO 9001 стандартад заасны дагуу үл тохирлыг ноцтой, томоохон, жижиг гэж ангилсантай уялдуулан) гэж ангилах;
- в) Үл тохирлыг хангалттай хэмжээнд шийдвэрлэх хүртэл түүний мөрөөр компанийн зүгээс хэрэгжүүлж буй залруулах арга хэмжээнд хяналт тавих.

4. Оношлох үйлчилгээ

Монгол Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ) нь мал, амьтны эрүүл мэнд, өвчний шинжилгээний үндэсний стандартыг онцгойлсон өвчинд зориулсан ДМАЭМБ-ын олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

УМЭАЦТЛ ая эсхүл хамгаалалттай аж ахуйн байгууламж үйл ажиллагаагаа явуулж буй аймагт үйлчилгээ үзүүлдэг эрх бүхий мал эмнэлгийн бүсийн лаборатори дараах чиглэлээр шинжилгээ хийнэ. Үүнд:

- а) Онцгойлсон өвчний шинжилгээ хийх оношилгооны ур чадвартай, ISO 17025 стандартаар магадлан итгэмжлэгдсэн байх;
- б) Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн журамд заасны дагуу онцгойлсон өвчинд зориулан тодорхой тогтоосон шинжилгээний арга хэрэглэн тандалтын сорьцод шинжилгээ хийх;
- в) Малын эрүүл мэндийн үйл явдлын тохиолдлыг судлан шинжлэх явцад оношлох үйлчилгээ үзүүлэх.

5. Оролцогч компаниуд

Оролцогч компани бүр нь:

- а) Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагааг хариуцан ажиллаж, үйлдвэрлэл, боловсруулалтын бүх байгууламжийг бүхэлд нь удирдахад шаардагдах бүрэн эрхийг хэрэгжүүлэх ахлах түвшний хангалттай туршлагатай хүнийг томилон ажиллуулна.
- б) Хамгаалалттай аж ахуйн үндсэн мэдээлэл, нийлүүлэлтийн сүлжээний тодорхойлолтыг боловсруулах, хамгаалалттай аж ахуйд хамаарах үйлдвэрлэл, боловсруулалтын байгууламж тус бүрийн үйл ажиллагааны замын зураглал гаргаж, тэдгээрт дүн шинжилгээ хийнэ.
- в) Хамгаалалттай аж ахуйд хамаарах үйлдвэрлэл, боловсруулалтын бүх байгууламжид хийх хяналт-шинжилгээ, тайлагналтын биелэлтэд дотоод хяналт тавих журам, зааврыг боловсруулж, баримтжуулан хэрэгжүүлнэ.
- г) Биохамгааллын зааварт заасан шаардлагыг үйлдвэрлэл, боловсруулалтын баримт бичигт нэгтгэн оруулж өгнө.
- д) Хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн бүтэц, үйл ажиллагаа нь шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

- е) Ажиллагсад нь хамгаалалттай аж ахуйд хамаарах үйлдвэрлэл, боловсруулалтын бүх байгууламжид тэдний гүйцэтгэх ажил үүрэгт тавигдах бүх шаардлагыг хэрхэн хангах талаар сурч дадлагажсан байна.
- ж) Хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгааг нотлон харуулах бүртгэл тэмдэглэл хөтөлнө.
- з) Хамгаалалттай аж ахуйд хамаарах үйлдвэрлэл, боловсруулалтын бүх байгууламжид баталгаажуулагч этгээдээр бүхэлд нь хяналт шалгалт хийлгэх хуваарь гаргана;
- и) Баталгаажуулагч этгээд хяналт шалгалт хийх зорилгоор хамгаалалттай аж ахуйн байгууламжид тодорхой давтамжтайгаар тогтоосон хугацаанд нэвтрэх эрх олгоно;
- к) Малын эрүүл мэндийн үйл явдал, тандалтын үр дүн, хөтөлбөрийн шаардлагыг зөрчсөн тохиолдол, хяналт шалгалтын үр дүнг МЭЕГ-т тайлагнана.

A.4. Аж ахуйн нэгж, байгууллагын нөхцөл байдал

Оролцогч компани ба харилцагч түншүүд

Оролцогч компани болон харилцагч түншүүдийн товч мэдээлэл, тодорхойлолтыг энэ хэсэгт оруулна.

Нийлүүлэлтийн сүлжээ, бүтээгдэхүүний тойм

Энэ хэсэгт дор дурдсан асуудлыг оруулан баталгаатайд тооцогдсон мал, малын гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь тодорхойлно.

- Хамгаалалттай аж ахуйд өсгөж буй малын төрөл зүйл, үйлдвэрлэж буй малын гаралтай бүтээгдэхүүн
- Зөвшөөрөл авсан хамгаалалттай аж ахуйн онцгойлсон өвчингүй, тайван байдал
- Мал маллагааны арга ажиллагаа болон хорио цээрийн байр ашиглах зэргээр хамгаалалттай аж ахуйд хийгдэх мал нийлүүлэлт, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн
- Малын ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоох тогтолцоо
- Тэжээлийн ханган нийлүүлэлт
- Багаж төхөөрөмж, эмийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, амьтны эрүүл мэндийн үйлчилгээ
- Үйлдвэрлэлийн байгууламж, мал аж ахуй эрхлэх тогтолцооны товч танилцуулга
- Мал төхөөрөх, боловсруулалт хийх тогтолцоо
- Хадгалалт, түгээн борлуулалтын тогтолцоо
- Бүтээгдэхүүний ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоох тогтолцоо
- Байгууламж хоорондын тээвэрлэлтийн зохион байгуулалт

Нийлүүлэлтийн сүлжээний тодорхойлолт нь хамгаалалттай аж ахуйг дараах байдлаар ангилахад тусална:

- Үйлдвэрлэлийн зориулалттай бол **нээлттэй эсхүл хагас-хаалттай**²
- Боловсруулалтын зориулалттай бол **нэгдсэн эсхүл салангид**³
- Үйлдвэрлэл болон боловсруулалтын зориулалттай бол **нэг дор эсхүл тархмал**⁴ байршилтай гэж тус тус ангилна.

² Дотроо үржүүлгийн үйл ажиллагаа явуулах хүчин чадал бага учраас хамгаалалттай аж ахуйн гадна орших өөрийн аж ахуйгаас аль эсхүл гуравдагч этгээдээс мал тасралтгүй оруулах шаардлагатай байдаг нийлүүлэлтийн “нээлттэй” сүлжээ бүхий хамгаалалттай аж ахуй.

Дотроо үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг учраас байнгын үржүүлэг хийх зориулалтаар гаднаас мал тасралтгүй оруулах хэрэгцээ гардаггүй, нийлүүлэлтийн “хагас нээлттэй” сүлжээ бүхий хамгаалалттай аж ахуй. Ийм аж ахуйд үр, хөврөл үр гэсэн генетикийн материал эсхүл үржүүлгийн мал үе үе нийлүүлж байх хэрэгцээ бий.

³ Үйлдвэрлэл, боловсруулалтын байр, тоног төхөөрөмжийг аль алиныг өмчлөгч компани малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулахад зориулсан нийлүүлэлтийн “нэгдсэн” сүлжээ бүхий хамгаалалттай аж ахуй эрхэлнэ.

Боловсруулалтын байр, тоног төхөөрөмж өмчилдөггүй, төхөөрөх, боловсруулах ажлыг гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлдэг компани малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулахад зориулсан нийлүүлэлтийн “салангид” сүлжээ бүхий хамгаалалттай аж ахуй эрхэлнэ.

⁴ Газар зүйн хувьд “нэг дор байршилтай” хамгаалалттай аж ахуй нь үйлдвэрлэл болон/эсхүл боловсруулалтын нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлдэг бүх байгууламжийг нэг ижил эсхүл маш ойр орших зайд (жишээ нь хэдхэн километр ч хүрэхгүй) байршуулсан байна.

Газар зүйн хувьд “тархмал” хамгаалалттай аж ахуйн бүх байгууламж нь хоорондоо газар зүйн хувьд алслагдмал байршилтай байна.

Үйлдвэрлэл, боловсруулалтын болон бусад байгууламж

Энэ хэсэгт хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүнд оруулахаар төлөвлөж буй бүх байгууламжийн нэр, хаяг, газар зүйн байршил, үйл ажиллагааны зохион байгуулалт, хууль ёсны үйл ажиллагаанд хамаарах аливаа онцлогийг (ж. нь. аж ахуйн албан ёсны оноосон нэр эсхүл бүртгэлийн дугаар) тодорхойлж өгнө.

Байгууламж бүрийг дараах төрөлд ангилна:

Монгол улсын махны салбарын хамгаалалттай аж ахуйн тогтолцоон дахь байгууламжийн ангилал

А. Ерөнхий байгууламж: гадны олон эх үүсвэрээс эрүүл мэнд, тавлаг байдлын үзүүлэлтээр тэнцсэн малыг хүлээн авч тэжээлд дасгах, бүлэглэн маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

В. Бордооны байгууламж: өсвөр малыг бүлэглэн байран маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

С. Ерөнхий болон бордооны нэгдсэн байгууламж: ерөнхий болон бордооны үйл ажиллагаа хослон эрхлэх зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

Д. Үржүүлэг, үйлдвэрлэлийг нэгдсэн байгууламж: үржүүлгийн сүрэг, мал, амьтан өсгөн бойжуулах хэсэгтэй байж гаднаас мал авах хэрэгцээг багасгах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

Е. Төхөөрөх, боловсруулах байгууламж: мал, амьтныг төхөөрч, гулуузыг боловсруулах байгууламж

Ү. Үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэгдсэн байгууламж: үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах үйл ажиллагаа явуулах нэг дор байршуулсан байр, байгууламж

Г. Үржүүлэг, үйлдвэрлэл, төхөөрөлт, боловсруулалтын нэгдсэн байгууламж: үржүүлэг, үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэг дор байршуулсан байр, байгууламж

Гол мэргэжилтэн

Хамгаалалттай аж ахуй болон түүний байгууламж бүрд тавигдах шаардлагыг биелүүлэх ажлыг хариуцсан гол мэргэжилтний нэр, албан тушаал, харилцах дэлгэрэнгүй мэдээллийг энэ хэсэгт оруулна.

МЭНС-ийн зохицуулалтын болон тайлагналтын шаардлагыг хангахын тулд хамгаалалттай аж ахуйн байгууламж тус бүрд ажиллах эсхүл гэрээгээр үйлчилгээ үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МҮЭН)-ийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг оруулна.

Оношилгоо, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэгч

Энэ хэсэгт хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд дараах үйлчилгээ үзүүлэх, зохицуулалтын эрх бүхий үйлчилгээ үзүүлэгчийг тодорхойлно:

- Оношлох үйлчилгээ (ө.х. МЭЭГ-аас эрх олгосон лабораторид лабораторийн шинжилгээ хийх)
- Баталгаажуулах үйлчилгээ (ө.х. МЭЭГ-аас эрх олгосон малын эмчийн хяналт шалгалт хийх).

Бусад бараа, ажил үйлчилгээ үзүүлэгч

Энэ хэсэгт хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд шаардлагатай дараах бараа ханган нийлүүлэх, ажил үйлчилгээ үзүүлэгчийг тодорхойлно:

- тэжээл,
- тээвэр,

- төхөөрөмж,
- эмийн бүтээгдэхүүн,
- мал, амьтны эрүүл мэндийн үйлчилгээ (дээр дурдсан МЭҮН гол гүйцэтгэгч байж болно).

Zero Draft

А.5. Хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах ажлын хүрээ

Эрх зүйн зохицуулалтын хүрээ, хууль тогтоомж

Монгол улсын хамгаалалттай аж ахуй дараах хууль тогтоомжид заасан зохицуулалтыг дагаж мөрдөнө:

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам
- Хивэгч малын хамгаалалттай аж ахуйн МЭЕГ-ын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар
- Хамгаалалттай аж ахуйн МЭЕГ баталсан захиргаа, удирдлагын гарын авлага
- МЭЕГ-аас боловсруулсан мал, амьтны холбогдох өвчинтэй тэмцэх заавар, нөхцөл
- Хүнсний аюулгүй байдлын тухай холбогдох хууль, техникийн заавар, нөхцөл

Хяналт шалгалтаар төрийн баталгаажуулалт хийх (Хөндлөнгийн хяналт)

ДМАЭМБ-ын олон улсын стандартад зааснаар хамгаалалттай аж ахуйд экспортлогч улсын төрийн байгууллагаас хяналт шалгалт хийдэг байх шаардлагатай. Хяналт шалгалт хийх удирдамж, хяналтын хуудсыг ДМАЭМБ-ын зөвлөмжид оруулсан байдаг. Төрийн хяналт шалгалтаар дараах асуудлыг баталгаажуулна:

1. хамгаалалттай аж ахуй өөрийн биохамгааллын зааврыг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар өдөр тутмын үйл ажиллагааныхаа бүхий л явцад эпидемиологийн эрсдэлийг удирддаг болохыг;
2. хамгаалалттай аж ахуйн доторх мал, амьтны дэд-популяцид онцгойлсон өвчний/өвчнүүдийн статусыг баталгаажуулахад шаардлагатай тандалтын болон хяналт-шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг болохыг тус тус баталгаажуулна.

Баталгаажуулалтын эдгээр үр дүнд хүрэхийн тулд оролцогч компани өөрийн стандарт ажиллагааны заавар (САЗ) боловсруулж болно. Биохамгааллын зааварт оруулсан оролцогч компанийн САЗ-ыг хяналт шалгалт хийх үед барьж ашиглах үндсэн лавлах материал гэж үзнэ. Оролцогч компанийн боловсруулсан САЗ нь тухайн хүссэн үр дүнд хүргэж чадах эсэхийг хамгаалалттай аж ахуйд зөвшөөрөл олгох, бүртгэх ажлын явцад судалж тогтооно.

Оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн төрийн хяналт шалгалтыг МЭЕГ эсхүл түүний зөвшөөрөл олгосон, тухайн хамгаалалттай аж ахуйн байгууламж оршдог аймгийн мал эмнэлгийн газрын эрх бүхий малын эмч гүйцэтгэнэ.

Хөндлөнгийн хяналт шалгалтыг гүйцэтгэх албан ёсны эрх бүхий малын эмч дараах шаардлагыг хангасан байна:

- Монгол улсын Үндэсний мэргэшлийн хүрээгээр хүлээн зөвшөөрсөн ISO:9001 чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт шалгалт хийх чиглэлээр мэргэшсэн
- Малын эмч мэргэжилтэй
- Мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалтын өөрийн ажилд хамаарах туршлагатай

Ээлжит хяналт шалгалтын хоорондох хугацааг 6 сараас хэтрүүлэхгүй (эсхүл сайн гүйцэтгэлд үндэслэн давтамжийг жилд нэг удаа хийхээр цөөрүүлсэн бол жилээс хэтрүүлэхгүй – доор дурдсаныг үз)-н тулд компани энэ хугацааг урьдчилан тооцоолж хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх хүсэлтээ гаргана. Хяналтын байцаагч нь хяналт шалгалтын удирдамжаа өөрийн туршлага, агентлагийн шаардлагын дагуу боловсруулж, хэрэгжүүлнэ. Хөндлөнгийн хяналт шалгалт хийх САЗ, хөндлөнгийн хяналтын хуудас, үл тохирлын мөрөөр авах арга хэмжээний загварыг энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар болон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглах загварын эмхэтгэлд оруулсан болно.

Компани хөндлөнгийн хяналт шалгалтын үед хяналтын байцаагчийг биохамгааллын шаардлага хангуулан байгууламжид нэвтрүүлэх, гол ажилтнуудыг (ө.х. САЗ-д тухайлсан асуудлыг хариуцахаар заасан ажилтнууд, МЭҮН) бэлэн байлгах, баримт бичиг болон бусад нотлох баримттай (ө.х. САЗ -д заасан нотлох баримт) танилцах боломжоор ханган тусална.

Хөндлөнгийн хяналт шалгалт хийх үеэр оролцогч компани өөрийн биохамгааллын албан ёсоор бүртгүүлсэн зааварт тусгагдсан САЗ-ыг дагаж мөрдөөгүйг илтгэх аливаа тохиолдол илэрсэн бол түүнийг үл тохиролд тооцно. Үл тохирол бүрийг дээрх гол үр дүнд учрах эрсдэлийн зэргээс хамааруулан ангилна (ө.х. 1. Хамгаалалттай аж ахуйн эпидемиологийн эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа; 2. Мал, амьтны эрүүл мэндийн төлөв байдлыг тандалт, хяналт-шинжилгээгээр баталгаажуулдаг эсэх). Доорх хүснэгтэд хамгаалалттай аж ахуйн журамд заасан үл тохирлын ангиллыг ISO9001 стандартад тодорхойлсон ангилалттай уялдуулан үзүүлэв. Компани үл тохирол бүрийг залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Залруулах арга хэмжээг хяналт шалгалт хийх үеэр хяналтын байцаагч болон компани хоорондоо хэлэлцэж эсхүл хяналт шалгалтын дараа компани өөрөө тодорхойлно. Үл тохирлыг залруулах арга хэмжээ нь эрсдэлийн нөлөөллийн зэргээс хамаарна.

Хүснэгт 1. Үл тохирлын ангилал, түүний мөрөөр авах арга хэмжээ

Журамласан ангилал	ISO 9001 ангилал	Эрсдэлийн зэрэгт үзүүлэх нөлөөлөл	Үл тохирлын мөрөөр авах залруулах арга хэмжээ	Хугацаа
Өндөр эрсдэлтэй	Ноцтой	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл алдагдахад хүргэх өндөр эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Өмнө нь гарсан үр дагавар байгаагүй нотолгоо гаргах	7 хоногийн дотор
Дунд эрсдэлтэй	Томоохон	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл алдагдахад хүргэх дунд зэргийн эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Эрсдэлийг цаашид бууруулж байгаанын нотолгоо гаргах	1 сарын дотор
Бага эрсдэлтэй	Жижиг	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл алдагдахад хүргэж болзошгүй бага зэргийн эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Эрсдэлийг цаашид бууруулах чиглэлээр САЗ-д хийсэн өөрчлөлт эсхүл	Дараагийн хяналт шалгалтаас өмнө

			сургалтын талаар тайлбар өгөх	
--	--	--	----------------------------------	--

Хөндлөнгийн хяналт шалгалтыг ихэвчлэн 6 сараас багагүй хугацааны давтамжтайгаар (хэвийн давтамж: 6 сар тутам) хийнэ. Гэхдээ тухайн компани 6 сар тутмын хяналт шалгалтыг дөрвөөс доошгүй удаа хийлгэсэн бөгөөд энэ хугацаанд "ноцтой" эсхүл "томоохон" ангиллын үл тохирол илрээгүй бол хяналт шалгалтын давтамжийг жил тутам нэг удаа хийхээр цөөрүүлж болно (гүйцэтгэлд үндэслэн цөөрүүлсэн давтамж: жил тутамд).

Хөндлөнгийн хяналт шалгалтаар "ноцтой" ангиллын үл тохирол илэрсэн бол хяналтын байцаагч дараагийн хяналт шалгалт хийх хугацааг 3 сарын дотор (ноцтой үеийн давтамж: 3 сар) товлоно. Тус шийдвэрийг хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээний талаарх компаниас ирүүлсэн мэдээллийн үнэлэлт дүгнэлтэд тулгуурлан хөндлөнгийн хяналтын байцаагч өөрөө шийдвэрлэнэ.

МЭЕГ-аас хөтөлдөг албан ёсны бүртгэлд зөвшөөрөл бүхий хамгаалалттай аж ахуй бүрд хийх хяналт шалгалтын давтамжийг оруулна.

Дотоод хяналтын тогтолцоогоор дамжуулан хийх компанийн баталгаажуулалт (Дотоод хяналт)

Компани бүр хамгаалалттай аж ахуйнхаа байгууламж тус бүрд дотоод хяналт хэрэгжүүлдэг байх ёстой. Дотоод хяналтын зорилго нь:

- Биохамгааллын батлагдсан зааврыг мөрдөн үйл ажиллагаагаа явуулдагийг баталгаажуулах;
- Биохамгааллын батлагдсан зааврыг сахин биелүүлдэгийн нотолгоог бүртгэн тэмдэглэж, ээлжит хяналт шалгалтын үеэр хөндлөнгийн хяналтын байцаагч үзэх боломжтой байлгах;
- Хамгаалалтын аж ахуй бүр үнэн зөв бөгөөд хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлагын дагуу МЭЕГ-т тайлагнадаг, мэдэгддэг болгох;
- Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд тулгарч буй биохамгааллын зааврыг хянан үзэж, түүнийг шинэчлэхэд хүргэж болзошгүй асуудлыг тодорхойлох.

Үүнээс гадна дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр компанийн удирдлага хамгаалалттай аж ахуй үйл ажиллагааны уялдаа холбоог бүрэн ойлгож, аливаа асуудал, эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх боломж олгодгоороо ач тустай.

Дотоод хяналтын тогтолцооны зарчмын элементүүд:

1. Биохамгааллын зааварт оруулсан стандарт ажиллагааны заавар

Биохамгааллын нийтлэг зааврыг компаниудад удирдамж болгон боловсруулсан. Оролцогч компаниуд хамгаалалттай аж ахуйн шаардлагыг одоо хэрэглэж байгаа чанарын баримт бичигт нэгтгэн оруулах боломжтой. Биохамгааллын нийтлэг зааварт тусгасан техникийн нөхцөлөөс зөрсөн тохиолдолд адил үр дүнд хэрхэн хүрэхийг харуулсан эрсдэлийн үнэлгээ хийнэ.

Биохамгааллын зааврыг наад зах нь жил бүр хянаж үзнэ. Хяналт шалгалтын үеэр (дотоодын эсхүл хөндлөнгийн) илэрсэн САЗ-т хянах эсхүл өөрчлөн шинэчлэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх хүртэл хянаж байх ёстой.

2. Ажилтанд зориулсан сургалт, мэдлэг, ур чадварын үнэлгээ

Ажилтан нь сургалтад хамрагдаж, өөрийн гүйцэтгэх ажил үүрэгт хамаарах биохамгааллын зааварт орсон САЗ-ыг баримтлан ажиллахад бэлтгэгдсэн байна. Сургалтыг ажилтныг анх ажилд авах болон дадлагажуулах үед явуулах, түүнчлэн байнга мэргэжил дээшлүүлэх байдлаар эсхүл биохамгааллын зааварт орсон САЗ-ыг хянаж, өөрчлөлт хийсний дараа явуулна.

Сургалтын үеэр мэдлэг, ур чадварыг үнэлж, гүйцэтгэх ажил үүрэгт нь хамаарах биохамгааллын зааварт орсон САЗ бүрийг баримтлан ажиллахад тухайн ажилтны мэдлэг, ур чадвар хэр түвшинд байгааг хамт ажиллагч, хянан зааварлагч нь мэддэг байх хэрэгтэйгээс гадна тэдгээрийг баримтжуулсан байна. Жишээ нь:

- Шинэ хүн (зааварчлах шаардлагатай)
- Ур чадвартай
- Мэдлэг туршлагатай (бусдад зааварчлах боломжтой)

3. Хяналт-шинжилгээний тогтолцоо, бүртгэл

Биохамгааллын зааварт орсон САЗ-т холбогдох САЗ тус бүрд бүртгэл хөтлөх хяналт-шинжилгээний тогтолцоотой байж, үйл ажиллагаа үр дүнтэй, баталгаатай хэрэгждэгийг нотлох бүртгэл хөтөлдөг байна.

Биохамгааллын зааварт орсон зарим САЗ-ын үндсэн зорилго нь хяналт-шинжилгээний тусгайлсан тогтолцоо ямар байхыг тодорхойлж өгөхөд орших ба жишээ нь САЗ В.16. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага хэсэгт: Үйлдвэрлэлийн гүйцэтгэлд хийх хяналт-шинжилгээний тогтолцоог тодорхойлж өгсөн болно.

Хяналт-шинжилгээний тогтолцоогоор цаашид нотолгоо болж үлдэх баримт бичгийг бүрдүүлнэ.

Хяналтыг тасралтгүй тавих механизмыг бий болгох, хамгаалалттай аж ахуйн тухайн үеийн баталгаат байдалд нөлөөлж болзошгүй аливаа үйл явдал тохиолдоход шуурхай арга хэмжээ авах зорилгоор компани бүр МЭЕГ-т тайлагнаж, мэдэгдэж байх тусгай шаардлагыг тусгаж өгсөн. Эдгээрийг хоёр тусгай САЗ-д, ө.х. В.30. Дотоод хяналт: Тогтмол тайлагналт, В.31. Дотоод хяналт: Хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх, тайлагнах хэсэгт оруулав.

Монгол Улсын хуульд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн шаардлагыг үл харгалзан биохамгааллын зааварт орсон САЗ-д заасан хяналт-шинжилгээний тогтолцоонд хамаарах баримт бичгийг хамгийн багадаа хуанлийн хоёр (2) жилийг бүрэн дуустал хадгална. Экспортын ачаанд дагалдуулсан баримт бичгийн бүртгэл тэмдэглэлийг хамгийн багадаа хуанлийн таван (5) жилийг бүрэн дуустал хадгална.

4. Дотоод хяналт шалгалт

Дотоод хяналтын тогтолцоотой байхыг чухалчлах хэрэгтэй. Гэхдээ түүний ямар бүтэц, зохион байгуулалттай байх, хэрхэн хэрэгжүүлэхийг компани өөрөө шийднэ.

Дотоод хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэхдээ дараах зөвлөмжийг харгалзана:

- Чанарын менежер, хамгаалалттай аж ахуйн менежер гэх мэт удирдлагын зохих эрх бүхий ажилтанд дотоод хяналтын тогтолцоог бүрэн хариуцуулна.

- Энэ ажил үүрэгт дотоод хяналтын хуваарь гаргах, хяналтыг хэрхэн гүйцэтгэх талаар зааварчилгаа өгөх, хяналт шалгалтын үр дүнгийн мөрөөр авах арга хэмжээг нягтлан хянах зэрэг багтана.
- Ажилтныг сургах, хөгжүүлэх үйл ажиллагааны нэг хэсэг болгон ажилтнуудыг өөрсдийн хариуцаж буй чиглэлээр дотоод хяналтыг төлөвлөх, гүйцэтгэх, хяналтын мөрөөр арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг ажилд оролцуулна.
- Биохамгаалалын зааварт заасан бүх САЗ-ыг хоёр жилийн хугацаанд багтаан дотоод хяналтад бүрэн хамруулах хуваарь гаргана.
- Хяналтын үр дүн, зөвлөмжийг бүртгэх нэгдсэн тогтолцоог бий болгож, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажилтныг сургах эсхүл САЗ хянах (аль хамаарахаар нь) ажлыг гүйцэтгэх зэргээр хяналт шалгалтын үр дүнд илэрсэн аливаа асуудлыг шийдвэрлэж дуустал хэрэгжилтийг хянана.
- Тасралтгүй сайжруулж байх ажлын байрны соёлыг төлөвшүүлэхийн тулд дотоод хяналтын тогтолцооноос гарсан үр дүн, ахиц дэвшлийн жишээг ажилтны сургалт, уулзалтын үеэр танилцуулдаг байх.

5. Гуравдагч этгээдийн баталгаа

Компаниуд бусад хувийн байгууллагаас чанарын болон техникийн баталгаа хангах стандартаар итгэмжлэгдэж болно, жишээлбэл:

- ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо
- ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо
- Хөдөө аж ахуйн зохистой дадал

Экспортын гэрчилгээ олголт

Монголын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны үндсэн зорилтын нэг хэсэг нь экспортыг дэмжих явдал юм. Иймд энэ тогтолцооны тавьдаг шаардлага экспортын гэрчилгээ олголтыг хэрхэн дэмждэг болохыг ойлгох нь бүх компанид ач холбогдолтой.

Монгол улсын хивэгч **малын** хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо нь шаардлагатай гэж үзвэл хамгаалалттай аж ахуйгаас гаргадаг мал, малын гаралтай бүтээгдэхүүнд хамгаалалттай аж ахуйн өмчлөгчийн олгодог гэрчилгээ болон баталгаа хангах шаардлагад нийцсэн аливаа бусад нотолгоо бүхий мэдээллийг МЭНС-ийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олголтод ашиглах үүднээс МЭНС-д оруулна.

Хамгаалалттай аж ахуй нь экспортын хэлэлцээр болон экспортын гэрчилгээнд шууд лавлагаа болгон оруулах (жишээ нь: хамгаалалттай аж ахуйн өмчлөгчөөс гарцын хяналтын явцад олгосон “Энэхүү амьд мал/үржүүлгийн материал/махыг Монгол улсын хамгаалалттай аж ахуйн тухай хууль тогтоомж, журам, техникийн заавар, нөхцөлийг бүрэн хангасан, онцгойлсон өвчин: шүлхий, БММӨ-гүй, тайван гэдэгт итгэлтэй байж болох бүртгэлтэй аж ахуйгаас бэлтгэсэн болно” гэсэн гэрчилгээ нь мал эмнэлгийн гэрчилгээний нэмэлт болж өгнө) боломжтой “тогтолцоонд суурилсан” баталгаа юм.

Зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколын хүрээнд хамгаалалттай аж ахуйг хүлээн зөвшөөрөх үүднээс худалдааны түнш бүр уг тогтолцоо хэрхэн хэрэгждэгийг ойлгож авах, тогтолцоогоор тавьсан шаардлагыг хэр зэрэг үр дүнтэй хэрэгжүүлж байгааг магадлан баталгаажуулах эрхтэй. Тогтолцоонд суурилсан ийм ойлголтыг дараах механизмаар авна:

- Хамгаалалттай аж ахуй өвчингүй, тайван болохыг өөрөө зарлан мэдээлсэн талаар Монгол улсын Засгийн газар/МЭЕГ-аас Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-д илгээсэн мэдэгдэл, өөрийгөө зарлан тунхагласан баримт бичгийг ДМАЭМБ-ын олон улсын стандартын шаардлага ханган боловсруулна. Олон улсын стандартын шаардлагыг ханган боловсруулсан болохын нотолгоог хангалттай гэж ДМАЭМБ үзвэл өөрийн цахим хуудсанд тухайн улс өөрийгөө зарлан тунхагласан тухай нийтэлнэ.
- Үндэсний хууль тогтоомж, стратегийн төлөвлөгөө эсхүл хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагааны заавар, биохамгааллын төлөвлөгөөний загвар гэх мэт захиргааны баримт бичиг зэрэг дэлгэрэнгүй баримт бичиг;
- Компанийн хамгаалалттай аж ахуй болон байгууламжийн бүртгэл, зөвшөөрөл.
- Хөндлөнгийн баталгаажуулалтын хяналт шалгалтын тайлан

Олон улсын гэрээ, стандартад заасны дагуу гадаад худалдааны түнш нь хөтөлбөрийг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааны явцад, жишээлбэл бүс нутгийн үйл ажиллагааны хүрээнд эсхүл худалдааны хоёр талт хэлэлцээр, тодорхой бараанд зориулсан экспортын протокол байгуулах явцад дээрх мэдээллийг хүсэх эрхтэй.

Түүнчлэн зарим улс орон ариун цэврийн арга хэмжээний эн тэнцүү байдлыг тодорхойлох үеийн эрсдэлийн үнэлгээний нэг хэсэг болгон экспортын баталгаажуулалт хийх зайлшгүй шаардлагатай улсын үндэсний тогтолцоог өөрөө бие даан магадлан баталгаажуулах эрх олгохыг шаарддаг. Үүнийг ДМАЭМБ-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодексын 5.3.5 зүйлд дараах байдлаар заасан байна:

13. экспортлогч улс нь импортлогч улсын хүсэлтээр эн тэнцүү байдлыг тодорхойлохтой холбогдуулан аливаа журам, тогтолцоог шалгах, үнэлэх боломжоор хангана;

Тогтолцоонд суурилсан баталгаажуулалтыг олон улсын стандартаар эн тэнцүү гэж тооцдог хэдий ч зарим улс экспортын ачилт бүрд тухайн улсад тавьдаг шаардлагыг хангасныг нотлох (ө.х. “ачилт бүрд суурилсан” баталгаажуулалт) экспортын гэрчилгээ болон бусад дагалдах бичиг баримт шаардсан хэвээр байна. Ийм тохиолдолд компаниуд экспортын барааны ачилт бүрдээ үйлдвэрлэлийн болон боловсруулах байгууламжаа МЭЕГ бүртгүүлж, зөвшөөрөл авсан нотолгоог Засгийн газрын эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан экспортын журамд тавьдаг шаардлагын дагуу биохамгааллын зааварт орсон САЗ-ыг хэрэгжүүлэх замаар хүрсэн үр дүнгийн нотолгоо, ө.х. тодорхой тогтоосон хугацаанд аж ахуй онцгойлсон өвчингүй, тайван байсны нотолгоо, экспорт/үр цуглуулах/ мал төхөөрөхөөс өмнө тогтоосон хугацаанд онцгойлсон өвчнийг шинжилсэн нотолгоо зэрэг нэмэлт нотолгооны хамт дагалдуулан өгөхөд бэлэн байх хэрэгтэй. Ийм шалтгааны улмаас биохамгааллын зааварт орсон САЗ-ыг ДМАЭМБ-ын олон улсын стандарт, үүний дотор өвчин (Шүлхий, БММӨ) бүрд тусгайлан оруулсан бүлэгтэй нягт уялдуулах шаардлагатай байдаг юм. Онцгойлсон өвчинд зориулсан ДМАЭМБ-ын олон улсын стандартаас зөрөх аливаа асуудлыг өвчингүй, тайван болсныг өөрөө зарлан тунхагласан тухай ДМАЭМБ-д илгээсэн мэдэгдэл болон зах зээлд нэвтрэх хэлэлцээрийн явцад ил тод, тодорхой мэдээлэх хэрэгтэй.

Монгол улс худалдааны голлох түншүүдийнхээ дийлэнхтэй нь өргөн хүрээнд чөлөөт худалдааны гэрээ (ЧХГ) эсхүл худалдааны хоёр талт гэрээ, хэлэлцээрүүд байгуулжээ. ДХБ болон түүний хэлэлцээр, түүний дотор ДХБ-ын АЦУАЦ хэлэлцээрт тусгасан эрх, үүргийг ЧХГ-ээр дахин баталгаажуулах нь нийтлэг юм.

МЭЕГ нь АЦУАЦ-ийн эрх бүхий Монгол улсын Засгийн газрын байгууллага юм. Иймд МЭЕГ нь зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ын шаардлагыг тохиролцох хэлэлцээрийг тэргүүлэх, тодорхой улстай мал, тэдгээрийн гаралтай барааг худалдаалах АЦУАЦ-ийн шаардлагыг тусгасан худалдааны хоёр талт протоколд гарын үсэг зурах, экспортын гэрчилгээнд гарын үсэг зурах албан ёсны эрх бүхий малын эмчид зөвшөөрөл олгодог.

Zero Draft

А.6. Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Онцгойлсон өвчин

Хивэгч **малын** хамгаалалттай аж ахуй бүрд заавал сэргийлэн хамгаалах ёстой онцгойлсон өвчнийг тодорхой тогтоон зааж өгсөн байна. Үүнд:

Хамгаалалттай аж ахуй дотроо үхэр маллаж байгаа үед:

- Шүлхий өвчин

Хамгаалалттай аж ахуй дотроо хонь, ямаа маллаж байгаа үед:

- Шүлхий өвчин
- Бог малын мялзан өвчин (БММӨ)

Халдвар дамжих зам, эрсдэлтэй бараа

Хамгаалалттай аж ахуйн хамгийн гол баримтлал нь онцгойлсон өвчний болзошгүй эх үүсвэрээс эпидемиологийн хувьд зааглагдсан байх явдал юм. Онцгойлсон өвчин тус бүрийн халдварлах эх үүсвэр, дамжих замыг ДМАЭМБ-ын стандарт, удирдамж, зөвлөмжөөс сурвалжлан олж, онцгойлсон өвчний эпидемиологийн анхаарах ёстой гол параметрийг хамгаалалттай аж ахуйн журмын хавсралтад дараах байдлаар нэгтгэн оруулсан байна:

Шүлхий өвчин

Халдвар дамжих механизм

- Халдвартай малд тулж ойртох, хүрэх
- Халдвартай амьтны шүүрэл, ялгадсанд шууд бус замаар өртөх
 - Халдвартай амьтан байсан орчин
 - Халдвартай амьтанд хэрэглэж байсан тоног хэрэгсэл
 - Халдвартай амьтанд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай амьтан малласан орчинд байсан тээврийн хэрэгсэл
 - Халдвартай амьтан, тэдгээрийн байсан орчинд хүрэлцсэн хувцас, гутал
 - Халдвартай мал, амьтанд тулж ойртсон, хүрсэн хүн (хамрын хөндийд 48 цаг тээнэ)
- Халдвартай амьтны гаралтай зүйлээр өөр амьтан тэжээх (ө.х. хоолны үлдэгдэл, хаягдлаар тэжээх)
- Агаар дуслаар тархах

Худалдаанд эрсдэл учруулах бараа

- мэдрэмтгий зүйлийн амьтан
- мэдрэмтгий зүйлийн амьтны үр, хөврөл үр
- мэдрэмтгий зүйлийн амьтны мах, махан бүтээгдэхүүн
- мэдрэмтгий зүйлийн амьтны сүү, сүүн бүтээгдэхүүн
- мэдрэмтгий зүйлийн амьтны арьс, шир, ноос, үс
- мэдрэмтгий зүйлийн амьтан хүрсэн мал, амьтны тэжээл

Бог малын мялзан өвчин (БММӨ)

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар
Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

Халдвар дамжих механизм

- Халдвартай амьтанд тулж ойртох, хүрэх
- Халдвартай амьтны шүүрэл, ялгадсанд шууд бус замаар өртөх
 - Халдвартай амьтан байсан орчин
 - Халдвартай амьтанд хэрэглэж байсан тоног хэрэгсэл
 - Халдвартай амьтанд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай амьтан малласан орчинд байсан тээврийн хэрэгсэл

Худалдаанд эрсдэл учруулах бараа

- мэдрэмтгий зүйлийн амьтан
- мэдрэмтгий зүйлийн амьтны үр, хөврөл үр
- мэдрэмтгий зүйлийн амьтны мах, махан бүтээгдэхүүн
- мэдрэмтгий зүйлийн амьтны сүү, сүүн бүтээгдэхүүн
- мэдрэмтгий зүйлийн амьтны арьс, шир, ноос, үс
- мэдрэмтгий зүйлийн амьтан хүрсэн мал, амьтны тэжээл

Биохамгааллын зааврын САЗ-т тодорхойлсон эрсдэлийн удирдлагын хүрээнд авч үзэх гол нэвтрэх замыг хураангуйлбал:

- i. мэдрэмтгий зүйлийн мал, амьтан
- ii. генетикийн материал (үр, хөврөл үр)
- iii. тэжээл, ус
- iv. эмийн бүтээгдэхүүн (ялангуяа вакцин)
- v. мал, амьтанд ашигласан тоног төхөөрөмж
- vi. хэвтрийн материал
- vii. тээврийн хэрэгсэл
- viii. хүн (ажиллагсад, зочид орно)
- ix. Зэрлэг амьтан, хортон шавж, мэрэгч, халдвар дамжуулагчид

Хамгаалалттай аж ахуйд биохамгааллын эрсдэлийг удирдахад чиглэсэн гол үйл ажиллагааг дараах байдлаар нэгтгэн авч үзэж болно:

- i. Орцын хяналт болон/эсхүл гол нэвтрэх замд хэрэгжүүлэх биохамгааллын эрсдэлийн удирдлага
- ii. Малыг ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт
- iii. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг оруулсан эрүүл ахуйн арга дадал
- iv. Тандалт, хяналт-шинжилгээний тогтолцоо
- v. Дархлаажуулалт болон/эсхүл эмчилгээний хөтөлбөр
- vi. Үйл явдлыг судлан шинжлэх, дэгдэлтийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө

Орцын хяналтын болон биохамгааллын эрсдэлийн удирдлагын САЗ нь онцгойлсон өвчин нэвтрэхээс хамгаалахад зориулагдсан. Малыг эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагын САЗ нь хамгаалалттай аж ахуйгаас мал, генетикийн материал, малын гаралтай бүтээгдэхүүн шилжүүлэхэд онцгойлсон өвчингүй, тайван болохыг баталгаажуулах ёстой. Хамгаалалттай аж ахуйгаас эргэн тойрныхоо аж ахуйд учруулж болзошгүй биохамгааллын эрсдэлийг бас авч үзэх хэрэгтэй ба хог хаягдлын гол зайлуулах урсгал дээр гарцын хяналт тавих замаар тэдгээр эрсдэлийг удирдана.

Биохамгааллын зааврыг үр дүнгээ өгдөг байлгахын тулд онцгойлсон өвчний эпидемиологийн үндсэн үзүүлэлтийн дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт С хэсгийг үзнэ үү.

Төхөөрөх, боловсруулах үеийн эсрдэлийн удирдлага

Компаниуд үйлдвэрлэл, төхөөрөлт/боловсруулалтын байгууламжийн хувьд нийлүүлэлтийн нэгдсэн эсхүл салангид, нэг дор эсхүл тархмал байршилтай аль ч хэлбэрийн сүлжээтэй байж болно. Мал төхөөрөх, боловсруулах үеийн малын эрүүл мэндийн эрсдэлийг удирдах арга ажиллагаа нийлүүлэлтийн эдгээр сүлжээнд ялгавартай байж болно. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг удирдах арга ажиллагаа нь мал төхөөрөх, боловсруулах, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн хадгалах үйл ажиллагаа явуулдаг бүх байгууламжид нийтлэг байна.

1. Малын эрүүл мэндийн шаардлага

Аль нэгийг сонгох:

- а) Төхөөрөх болон боловсруулах байгууламжид төхөөрөх мал, малын боловсруулах махыг ЗӨВХӨН компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас БАЙНГА авна (Жич: Энэ нь зөвхөн нэгдсэн үйлдвэрлэлийн байгууламжид төхөөрөлт, боловсруулалт хийдэг нөхцөлд мөрдөх хувилбар юм. Энэ тохиолдолд хамгаалалттай аж ахуйгаас бусад эх үүсвэрээс мал авч болохгүй)

Эсхүл:

- б) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас малыг ЗӨВХӨН бусад мал байхгүй эсхүл мэдрэмтгий бусад мал төхөөрөөгүй, махны боловсруулалт хийгээгүй өдрүүдэд хүлээн авах бөгөөд энэ нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авсан малыг төхөөрч, боловсруулж дуустал (ө.х. төхөөрөх болон боловсруулах эхний өдөр) үргэлжилнэ.
- в) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авч байгаа малыг тээвэрлэлтийн явцад болон төхөөрөх байгууламжид оруулсан байхад нь ч бусад ямар ч аж ахуйн малтай хавьтал үүсгэхээргүй байлгана.
- г) Компанийн хамгаалалттай аж ахуйд мал хүлээн авах, төхөөрөх болон боловсруулалт эхлэхээс өмнө байгууламжийн мал төхөөрөх байр, тэр дундаа мал хүлээн авч байлгах хэсгийг маш сайн цэвэрлэсэн байна.
- д) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авсан малыг төхөөрөх байгууламжид 24 цагийн дотор төхөөрнө.
- е) Компанийн хамгаалалттай аж ахуйн төхөөрөх болон боловсруулах байгууламжаас гарах мах, махан бүтээгдэхүүн нь ялгагдах тэмдэглэгээтэй, мөшгөн олох боломжтой байх ба агуулахад аливаа бусад бүтээгдэхүүнээс тусад нь хадгална.

Эдгээр шаардлагыг САЗ-д оруулсан болно. В02. Орцын хяналт: Мал.

2. Хүнсний аюулгүй байдлын шаардлага

Компанийн хамгаалалттай аж ахуйн мал төхөөрөх, боловсруулах байгууламж нь хүнсний аюулгүй байдлын талаар дээрх байгууллагад тавьдаг Монгол улсын доор дурдсан хууль тогтоомжийн бүх шаардлагыг ханган ажиллах ёстой:

- ~~Монгол улсын~~ Хүнсний тухай
- ~~Монгол улсын~~ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль

- Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- Усны тухай хууль

Үүнээс гадна хүнсний аюулгүй байдлын олон улсын стандарт хангаж байгаагаа хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартын магадлан итгэмжлэлээр нотлон харуулахыг сайшаан дэмжинэ.

Төхөөрөх, боловсруулах байгууламжийн биохамгааллын заавар

Төхөөрөх болон боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа байгууламж бүр хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах бүхий л техникийн шаардлагыг тусгасан биохамгааллын заавартай байх ёстой. Төхөөрөх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууламжид (ө.х. үйлдвэрлэлтэй нэгтгээгүй) дараах САЗ төдийлөн хамаарахгүй:

САЗ В.2. Орцын хяналт: Генетикийн материал

САЗ В.05. Орцын хяналт: Эмийн бүтээгдэхүүн болон вакцин (жич. вакцин болон эмийн бүтээгдэхүүнийг байгууламж дахь агуулахад хадгалдаг бол үүнийг хэрэглэхгүй).

САЗ В.11. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар (ЖИЧ: САЗ В.1 Орцын хяналт: Мал байгаа хэсэгт үндсэн эрүүл ахуй болон малын төрөл бүрийн бүлгийг зааглах талаар оруулна)

САЗ В.12. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар.

САЗ В.16. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, Хяналт-шинжилгээ. (ЖИЧ: САЗ В.1 Орцын хяналт: Амьд мал хэсэгт авчирсан малын бүлэгт болон ачуулахын өмнөх хүлээлгийн үед малын өвчлөл, хорогдлыг судлах асуудлыг оруулна).

САЗ В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр

САЗ В.18. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Дархлаажуулах хөтөлбөр.

САЗ В.19. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Эмчилгээний хөтөлбөр.

САЗ В.21. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Бичил биетний эсрэг бодисын болгоомжтой хэрэглээ (ЖИЧ: Компанийн хамгаалалттай аж ахуй бичил биетний эсрэг эмийн нийцэмжтэй бодлогын дагуу төхөөрөх болон боловсруулах байранд байгаа малд бичил биетний эсрэг эм хэрэглэхийг хориглох, төхөөрөх үед болон өмнөхөн нь бичил биетний эсрэг эмээр эмчлэх шаардлагатай болсон ямар ч малыг хүний хүнсний хэрэгцээнд зориулж төхөөрөхгүй).

В.25. Гарцын хяналт: Генетикийн материал

А.7. Оролцогч компанийн үүрэг хариуцлага

Хамгаалалттай аж ахуйн өмчлөгч

Оролцогч компаниуд нь хамгаалалттай аж ахуйн өмчлөгч бөгөөд компанийн хамгаалалттай аж ахуйнхаа менежер нь юм. Оролцогч компани өөрийн компанийн хамгаалалттай аж ахуйд хамаарах бүх байгууламжид зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, тэдгээрт хэрэгжүүлэх биохамгааллын зааврыг боловсруулах, хэрэгжүүлэх, мэдэгдэх, тайлагнах асуудлыг хариуцна.

Тус тусынхаа компанийн хамгаалалттай аж ахуйг удирдахаар зохицуулан оролцогч олон тооны компанийг хамруулсан хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах үндэсний тогтолцоонд оролцогч компани бүр өөрийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, түүний үр дүнг хариуцан ажиллана.

Ийм учраас компанийн хамгаалалттай нэг аж ахуйд гарсан өвчний дэгдэлт тус хамгаалалттай аж ахуйн бүх байгууламжийн статусын зөвшөөрлийг тэр даруйдаа түдгэлзүүлэхэд хүргэх ба энэ нь оролцогч компани дэгдэлтийн шалтгааныг судлан тогтоож, үүсгэсэн шалтгааныг арилгах, дэгдэлттэй тэмцэхэд эрсдэлийн удирдлагыг хэрхэн өөрчлөхөө харуулах, өмнөх статусаа дахин сэргээх хүртэл үргэлжилнэ.

Компанийн хамгаалалттай аж ахуйд гарсан өвчний дэгдэлт бусад оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөлд нөлөөлөхгүй. Гэвч тэмдэглэхэд, өвчин нэг дэгдлээ гэхэд хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах үндэсний хэмжээний тогтолцоонд зохицуулалт хийж байгаа МЭЕГ-ын баталгаанд найдах гол түншүүдийн итгэл, үнэмшил буурна.

Компанийн хамгаалалттай аж ахуйд байх малын зүйл, онцгойлсон өвчнийг тогтоох

Хамгаалалттай аж ахуйд маллаж байгаа малын зүйлээс хамаарч онцгойлсон өвчнийг (Шүлхий, БММӨ) албан журмаар тодорхой тогтоож өгөх ба үүнийг биохамгааллын зааварт тусгана.

Үйлдвэрлэл, боловсруулалтын байгууламжийг ялган тодорхойлох

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийг үйлдвэрлэлийн төрөл болон байгууламжуудыг хооронд нь холбож байдаг нийлүүлэлтийн сүлжээнийх нь дагуу тодорхойлж, ангилсан байна.

Байгууламжийн газар зүйн байршил, үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн үйл ажиллагааг САЗ В.1 Байгууламжийн газар зүйн байршил, үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц гэсэн хэсэгт заасны дагуу тодорхойлж газрын зураг, гэрэл зургаар баяжуулна.

Хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврыг боловсруулах, хэрэгжүүлэх

Компанийн хамгаалалттай аж ахуйн САЗ-т оруулах шаардлагыг биохамгааллын нийтлэг зааварт тодорхойлно.

Оролцогч компани бүр компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавраа боловсруулах үүрэгтэй ба энэ нь байгууламжид нэвтрэх зам нэг бүрийг авч үзсэн, биохамгааллын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хамарсан байна. Үүнийг биохамгааллын нийтлэг зааварт үзүүлсэн маягтын дагуу эсхүл компанийн одоо байгаа чанарын тогтолцоонд нэгтгээд хийж болно. Биохамгааллын нийтлэг заавраас зөрсөн гэж үзэхээр асуудал байвал оролцогч компанийн биохамгааллын зааврын шаардлагын хаана нь асуудал байгааг зааж өгнө.

Дотоод хяналтын тогтолцоог бий болгох

Оролцогч компани бүр өөрийн дотоод хяналтын тогтолцоог боловсруулж, албажуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Дотоод хяналтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт өгөх зөвлөмжийг дээрх А5 хэсэг болон биохамгааллын нийтлэг зааварт тусгасан дотоод хяналтын талаарх САЗ-д оруулав.

В.29. Дотоод хяналт: Баримт бичиг, бүртгэл хөтлөлт

Компанийн хамгаалалттай аж ахуйг бүртгүүлэх, зөвшөөрөл авах хүсэлтээ МЭЕГ-т гаргах

Оролцогч компани өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын зааврыг хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны хүрээнд тавьдаг шаардлагын дагуу боловсруулсан бол хамгаалалттай аж ахуйн түр зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болно. Оролцогч компани өөрийн хамгаалалттай аж ахуй, түүний бүрэлдэхүүн хэсэг болох байгууламж нэг бүрийг бүртгүүлэхдээ зөвшөөрөл хүсэх өргөдлийн маягт ашиглана. Өргөдлийн маягтыг үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын С хэсэгт оруулсан. Гаргасан өргөдөл шийдвэрлэгдэх хугацаанд компани өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын зааврын хуулбарыг бүртгүүлэх болон батлуулах зорилгоор МЭЕГ-т илгээнэ.

Хэрэв үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын заавар хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны шаардлагыг хангаж байна гэж МЭЕГ үзвэл компанийн хамгаалалттай аж ахуйг “бүртгэсэн” тухай мэдэгдэл МЭЕГ-аас гаргаж, компанийн хамгаалалттай аж ахуй болон бүх байгууламжийг албан ёсны бүртгэлд оруулна.

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд шийдвэрлэгдээгүй аливаа ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ/НОЦТОЙ эсхүл ДУНД ЭРСДЭЛТЭЙ/ТОМООХОН үл тохирол байхгүй, ө.х. хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтын үеэр илэрсэн аливаа ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ/НОЦТОЙ эсхүл ДУНД ЭРСДЭЛТЭЙ/ТОМООХОН үл тохирлыг залруулах арга хэмжээгээр хангалттай шийдвэрлэсэн бөгөөд энэ нь дараагийн хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтаар батлагдсан нь тогтоогдсон болохыг хөндлөнгийн баталгаажуулагч эхний хяналт шалгалтын тайлангаар харуулсан нөхцөлд МЭЕГ компанийн хамгаалалттай аж ахуйг “зөвшөөрсөн” гэж үзнэ. Компанийн

хамгаалалттай аж ахуй болон бүх байгууламжийг албан ёсны бүртгэлд “зөвшөөрсөн” гэж шинэчлэн бүртгэнэ.

Ийнхүү зөвшөөрөл олгох хугацаанд ДМАЭМБ-ын олон улсын стандарт ёсоор хамгаалалттай аж ахуйн байгууламжийн эргэн тойрны 10 км-д онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) тохиолдол гараагүй байх ёстой. Ийм тохиолдол гараагүйг МЭНС-ээс яавлаж баталгаажуулна. Компани болон МЭЕГ малын эрүүл мэндийн статусыг тогтооход чухал идэвхгүй тандалтыг дараах арга замаар хэрэгжүүлэх хамтын үүрэг хүлээнэ:

- байгууламжийн эргэн тойрны 10 км-д оршин суух малчин, мал өмчлөгчийг тогтоох;
- тэдгээрийн малд онцгойлсон өвчний эмнэл зүйн шинж тэмдэг, өвчин гарвал заавал мэдэгдэх үүрэг, мэдэгдэх арга замыг ойлгуулсан байх;
- тэдэнд өвчинтэй тэмцэх үндэсний стратегид тусгагдсан бүхий л шаардлага, тэр дундаа малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналт, дархлаажуулах шаардлагыг ойлгуулсан байх.

Компаниуд тухайн үеийн гадаад эрсдэлт хүчин зүйлийн нөхцөл байдлыг мэдэж байх үүднээс хамгаалалттай аж ахуйн байгууламжийнхаа эргэн тойрны мал өмчлөгчтэй дээрх харилцаатай байхыг чухалчлах хэрэгтэй. Орчин тойронд нь онцгойлсон өвчин дэгдвэл биохамгааллын эрсдэлийн удирдлагыг идэвхжүүлнэ.

Хөндлөнгийн баталгаажуулагч этгээдийн хяналт шалгалт

Оролцогч компани бүр МЭЕГ эсхүл түүний хөндлөнгийн баталгаажуулагч гэж зөвшөөрөл олгосон үйлчилгээ үзүүлэгчтэй харилцаж, хяналт шалгалтын хуваарь гаргах, хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг дээрх А2 дугаар хэсгийн дагуу, биохамгааллын нийтлэг зааварт орсон дараах САЗ-ыг мөрдөн хэрэгжүүлнэ:

В.32. Хөндлөнгийн хяналт: Баталгаажуулагч этгээдийн хяналт шалгалт

Компанийн хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын заавар МЭЕГ-аар батлагдсаны дараа хөндлөнгийн баталгаажуулагч этгээдээр эхний хяналт шалгалтыг хийлгүүлнэ.

Тайлагналт ба мэдэгдэл

Оролцогч компани бүр биохамгааллын нийтлэг зааварт орсон дараах САЗ-ын дагуу МЭЕГ-т тогтмол тайлан хүргүүлэх, хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх үүрэг хүлээнэ.

В.30. Дотоод хяналт: Тогтмол тайлагналт

В.31. Дотоод хяналт: Хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх, тайлагнах

Компанийн хамгаалалттай аж ахуй бүртгэгдсэнээр тайлагнах үүргээ биелүүлж эхэлнэ.

А.8. Хамгаалалттай аж ахуйд ханган нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага

Орцын хяналт болон биохамгааллын эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх үүргийг хамгаалалттай аж ахуйн өмчлөгч болох оролцогч компани хариуцна. Гэсэн хэдий ч хамгаалалттай аж ахуйн өмчлөгч болон хамгаалалттай аж ахуйд бараа нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлэгч аль альд нь биохамгааллын шаардлагыг ойлгоход нь туслах үүднээс хамгаалалттай аж ахуйн гол орцыг ханган нийлүүлэгч этгээдэд холбогдох хатуу шаардлагыг энэ хэсэгт хураангуйлан оруулав.

Амьд мал, генетикийн материал

Компанийн хамгаалалттай аж ахуйд мал, амьтан, үр, хөврөл үр нийлүүлж байгаа аж ахуй нь доор дурдсан өвчнөөр тодорхой тогтоосон хугацаанд (ДМАЭМБ-ын олон улсын стандартаас энэ шаардлагыг лавлана) тайван байх ёстой.

- Шүлхий өвчнөөр над зах нь гурван (3) сар тайван байсан (Зүйл 8.8.12; 8.8.13)
- Бог малын мялзан өвчнөөр наад зах нь хорин нэг (21) хоног тайван байсан (Зүйл 14.7.10; 14.7.12)

Өвчингүй, тайван байсан гэдэг нь:

- Батлагдсан аливаа тохиолдол байхгүй
- Эмнэл зүйн сэжигтэй бүх тохиолдлыг малын эмчийн үзлэг шинжилгээгээр онцгойлсон өвчин биш болохыг тогтоосон

Өвчингүй, тайван болохыг баталгаажуулахын тулд:

- Орон нутгийн мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын төлөөлөгчтэй хамтран ажиллаж заавал мэдэгдэх өвчин байхгүй болохыг баталгаажуулах;
- Аж ахуйд аливаа сэжигтэй өвчлөл, хорогдол гарсан эсэхийг тогтоохын тулд эрүүл мэндийн бүртгэл, тэмдэглэлийг шалгах, судлан шинжлэх ажлын үр дүнтэй танилцах;
- Генетикийн материал авахаас өмнө 48 цагийн дотор аж ахуйн бүх малд мал эмнэлгийн байцаагч үзлэг хийж өвчний сэжигтэй тохиолдол байхгүй болохыг баталгаажуулах;
- Тодорхой хугацаанд онцгойлсон өвчин байхгүй байсан эсэх талаар тухайн аж ахуйн өмчлөгчөөс мэдүүлэг авна.

Мал эсхүл генетикийн материал шилжүүлэхийн өмнө ба шилжүүлэх үед баримтлах биохамгааллын шаардлагад холбогдох өвөрмөц шаардлагыг биохамгааллын нийтлэг зааварт орсон САЗ В.2. Орцын хяналт: Мал, В.3. Орцын хяналт: Генетикийн материал (Үр, хөврөл үр) хэсгээс үзнэ үү.

Тэжээл

Тэжээлийг хамгаалалттай аж ахуй дотроо тариалах, аль эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг, найдвартай нийлүүлэгчээр бэлтгүүлж авна.

Айл өрх, хүнсний зах, ресторан, эмнэлэг, супермаркет болон бусад аливаа эх үүсвэрээс цуглуулсан хоолны үлдэгдэл, хаягдлаар мал тэжээхийг хамгаалалттай аж ахуйн бүх байгууламжид хориглоно.

Тэжээл, тэжээлийн орцыг бөөний эсхүл жижиглэнгийн савлагаатай эсэхээс үл хамааран мал түүнчлэн зэрлэг амьтан, шувуу, мэрэгч зэрэг хортон ямар нэг байдлаар хүрэхээс хамгаалан хадгална.

Мал ачих зориулалттай тээврийн хэрэгслээр тэжээл, түүний орцыг тээвэрлэхгүй.

Тэжээлийг халуун, өндөр даралтаар хорголжлох нь халдварт өвчний эрсдэлийг бууруулахад ач холбогдолтой. Хорголжлох боломжгүй эсхүл тэжээл, тэжээлийн орцод бохирдлын эрсдэлийг удирдах чанарын баталгаажуулалтын тогтолцоо байхгүй нөхцөлд худалдан авсан тэжээлээ 120 хоногийн дараа хэрэглэх нь зүйтэй. (ДМАЭМБ кодексийн 8.8.28 дугаар зүйлээс лавлах).

Тэжээлд тавих дэлгэрэнгүй шаардлагыг САЗ В04: Орцын хяналт: Тэжээл, ус гэсэн хэсгээс үзнэ үү.

Мал эмнэлгийн үйлчилгээ

Оролцогч компани Монгол улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрдөг мал эмнэлгийн боловсролын зэрэгтэй, найдвартай, мэргэшсэн хүнийг үндсэн ажилтнаар эсхүл гэрээт ажилтнаар авч ажиллуулах замаар малын эрүүл мэндийн, мал эмнэлгийн үйлчилгээ авна. Малын эмч нь МЭНС-ээр дамжуулан бүртгэл хөтлөх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МЭҮН) хэлбэрээр МЭЕГ-т бүртгүүлнэ.

Мал эмнэлгийн техникийн үндсэн эсхүл гэрээт ажилтан нь малын эмчийн зааварчилсан удирдлагын дор ажиллана.

Эмийн бүтээгдэхүүн, халдваргүйжүүлэгч

Оролцогч компанийн хэрэглэж байгаа аливаа эмийн бүтээгдэхүүн болон эм нь малд хэрэглэхийг МЭЕГ-аас зөвшөөрсөн, бүртгэгдсэн байна.

Мал эмнэлгийн вакцин нь ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын дагуу үйлдвэрлэгдсэн байна.

Оролцогч компанид нийлүүлэх мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн зохистой дадлыг хангасан, чанарын удирдлагын ISO9001 тогтолцоог хэрэгжүүлдэг байна.

Хүснэгт X. Онцгойлсон өвчинд хэрэглэх вакцин, дархлаажуулалтын зөвлөсөн хуваарь

Өвчин	Эхний олголт	Сэргээх тун	Бие гүйцсэн	Тусгай нөхцөл	Монгол улс бүтээгдэхүүний жишээ	Эсрэгтөрөгчийн төрөл	Хадгалах нөхцөл
Шүлхий	14-өөс дээш хоногийн бойжилттой	4-5 долоо хоногийн дараа	6 сар тутамд /вакцинаас хамаарна/			Идэвхгүйжүүлсэн омог, тухайн бүсэд эргэлдэх вируст тохируулан сонгосон	2-8°C
БММӨ	3 сар орчмын бойжилттой хурга, ишгэнд дан тун	1 жилийн настайд сэргээх тун	Зөвхөн нас гүйсэн малыг өвчний дэгдэлтийн үед эсхүл дархлаажуулсан эсэх нь тодорхойгүй малд			Амьд сулруулсан вируст вакцин.	2-8°C

Зөвшөөрөгдсөн халдваргүйжүүлэгч нь онцгойлсон өвчний (шүлхий, БММӨ) эсрэг үр нөлөөтэй нь батлагдсан байна. Зөвлөсөн халдваргүйжүүлэгчийг агуулсан маш олон бэлэн худалдааны бүтээгдэхүүн бий.

Хүснэгт 2. Онцгойлсон өвчний эсрэг хэрэглэхэд зөвлөмж болгосон халдваргүйжүүлэгч

Өвчин	Идэвхгүйжүүлэх арга	Онцгойлсон бүх өвчний үед хэрэглэж болох халдваргүйжүүлэгч
Шүлхий	Натрийн шүлт (2%), натрийн карбонат (4%), нимбэгийн хүчил (0.2%), цууны хүчил (2%), натрийн гипохлорид (3%), калийн пероксимоносульфат/натрийн хлорид (1%), хлоридийн диоксидод идэвхгүйжинэ. Иодофор, дөрөвдөгч аммонийн нэгдэл, фенолд ялангуяа органик нэгдэлтэй нөхцөлд тэсвэртэй.	Исэлдүүлэгч бодис: Натрийн гипохлорид 3% Вирконы нунтаг 2%
БММӨ	алькогол, эфир, ердийн угаалгын бодис, ихэнх халдваргүйжүүлэгч, үүний дотор фенол, натрийн шүлт (2%),	Шүлт: Натрийн шүлт 1% Хүчил: Нимбэгийн хүчил 0.2% Альдегид: Глутаральдгид 2% Формалин 8%

Лабораторийн оношлох үйлчилгээ

Онцгойлсон өвчний холбогдолтой дээж шинжлэх үүрэгтэй мал эмнэлгийн оношилгооны лаборатори нь ISO 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байх ба итгэмжлэлийн хүрээнд шаардлагатай шинжилгээний арга орсон байна.

Компанийн хамгаалалттай аж ахуйд хийх тандалтын үеэр хэрэглэхийг зөвшөөрсөн оношлох шинжилгээг 3 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хамгаалалттай аж ахуйд хэрэгжүүлэх дархлаажуулалтын бодлогыг (ө.х шүлхий болон БММӨ-ий эсрэг дархлаажуулахыг зөвлөмж болгодог) харгалзан үзэж оношилгооны аргыг халдвар авсан болон дархлаажуулсан малыг ялгаварлах талаас нь авч үзэх хэрэгтэй. Хэрэглэх дээжийг (цус/үр, шүлс, баас) хийх шинжилгээний арга зүйд зааж өгнө. УТ-ПГУ-аар шинжилгээ хийхийн өмнө уг шинжилгээнд хэрэглэх дээжийн төрөл бүрд баталгаажуулсан байна. Тандах судалгааны удирдамж боловсруулах явцад оролцогч компани болон МЭЕГ оношилгоонд хэрэглэх боломжтой арга, тэдгээрийг янз бүрийн дээж шинжлэхэд баталгаажуулсан байдлыг Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн оролцоотойгоор авч хэлэлцэх хэрэгтэй.

Лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахад ашиглах оролцогч компани болон лабораторид зориулсан гэрээний загварыг С хэсэгт оруулав. Түүнчлэн УМЭАЦТЛ-иос ирүүлсэн оношлох шинжилгээний чадавхын жагсаалтыг нэгж шинжилгээний үнийн хамт С хэсэгт оруулав.

Хүснэгт 3. Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд хэрэглэхийг зөвшөөрсөн оношилгооны арга

Өвчин	Ердийн илрүүлэх шинжилгээ *	Илрүүлэх шинжилгээний эерэг дүн эсхүл сэжигтэй тохиолдлыг баталгаажуулахад*	ДМАЭМБ-ын Гарын авлагаас лавлах бүлэг

Шүлхий	АВ-ЕЛИЗА (зөвхөн дархлаажуулаагүй нөхцөлд) ББУ-аас цэвэршүүлсэн вакцин хэрэглэсэн нөхцөлд ББУ-Эб-ЕЛИЗА	УТ-ПГУ ВНК-21 эсэд вирус ялгах	Бүлэг 3.1.8
БММӨ	Дархлааны баригч ЕЛИЗА Хэвтээ нэвчилтийн хурдавчилсан сорил	УТ-ПГУ Вирус ялгах	Бүлэг 3.8.9

Баталгаажуулалт хийхэд тохиромжтой гэж тэмдэглэсэн аргыг илрүүлэх шинжилгээнд ашиглаж болох ба харин илрүүлэх шинжилгээнд тохиромжтой байдаг аргаар эерэг дүн үзүүлсэн бол заавал баталгаажуулна (Жич: өвчингүй, тайван болохыг тогтоох явцад хийсэн илрүүлэх шинжилгээний сөрөг үр дүнд найдаж болно). ДИВА (халдвартай амьтныг дархлаажуулсан амьтнаас ялгаварлах) чадавх бүхий тогтмол хэрэглээний ийлдэс судлалын арга байхгүй байж болзошгүй. Эдгээрийг хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт шаардлагатай дархлаажуулалтын бодлогыг иж бүрнээр хэрэгжүүлэхэд зориулан энд тэмдэглэв.

Баталгаажуулах үйлчилгээ (Хөндлөнгийн хяналт шалгалт)

Оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйд төрийн хяналт шалгалтыг МЭЕГ эсхүл МЭЕГ-аас зөвшөөрөл олгосон, хамгаалалттай аж ахуйн байгууламж оршдог аймгийн хяналт шалгалтын үйлчилгээ үзүүлэх этгээдээр хийлгэнэ.

Хөндлөнгийн хяналт шалгалт хийх ажилтан дараах шаардлагыг хангасан байна:

- Монгол улсын Үндэсний мэргэшлийн хүрээгээр хүлээн зөвшөөрсөн ISO:9001 чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт шалгалт хийх чиглэлээр мэргэшсэн
- Малын эмч мэргэжилтэй
- Мал аж ахуйн үйлдвэрлэл, боловсруулалтын чиглэлээр өөрийн ажилд хамаарах холбогдох туршлагатай

Оролцогч компанид зориулсан хөндлөнгийн баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх гэрээний загварыг С хэсэгт оруулав.

Тээврийн үйлчилгээ

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас мал ачих болон байгууламжид мал авчрах аливаа тээврийн хэрэгсэл нь:

- мал ачихын өмнө гүн цэвэрлэсний (органик зүйлийг бүрэн зайлуулсан байна) дараа халдваргүйжүүлсэн (зөвшөөрөгдсөн халдваргүйжүүлэгч ашиглана. 2 дугаар хүснэгтийг үз) байна.
- мал, амьтан бүхий бусад цэгт олон зогсолгүйгээр мал ачих цэгээс буулгах цэг хүртэл шууд явна.

Малын тэжээл тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг мал тээвэрлэхэд ашиглахгүй.

Боломжтой нөхцөлд байгууламжийн бүтээц нь:

- i. байгууламжид нэвтэрсэн тээврийн хэрэгсэл үлдэж хүлээдэг тусгай хэсэг гаргах замаар байгууламж дахь биохамгаалал илүүтэй шаарддаг, мал малладаг хэсэгт тээврийн хэрэгсэл орох, гарах хэрэгцээг дээд зэргээр багасгах;
- ii. байгууламжид орох, гарах, байгууламж доторх биохамгааллын түвшин өөр хэсгийн хооронд явах тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх нөхцөлийг бүрдүүлэх.

Бусад үйлчилгээ

Компанийн хамгаалалттай аж ахуйд өмнө дурдаагүй аливаа үйлчилгээ үзүүлэгчид (жишээ нь: барилга засварын үйлчилгээ, хашаа барих, тоног төхөөрөмж нийлүүлэх, хоол унд хүргэх гэх мэт) байгууламж болон компанийн хамгаалалттай аж ахуйд биохамгаалал хэрэгжүүлэхийн зорилго, ач холбогдол, орох, гарах болон орж ажиллах хугацаанд дагаж мөрдөх арга хэмжээг танилцуулна. Үйлчилгээний цөөвөр, итгэлтэй байгууллагатай тааламжтай нөхцөлөөр тогтвортой нийлүүлэлт хийлгэхээр тохиролцон ажиллах нь зүйтэй.

Хэсэг В. Биохамгааллын нийтлэг заавар: Хамгаалалттай аж ахуйн өмчлөгчид зориулсан стандарт ажиллагааны заавар (САЗ)

В.01. Газар зүйн нөхцөл байдал, байгууламжийн зохион байгуулалт, бүтэц

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн ерөнхий мэдээлэл, газрын зурагт тавих шаардлага

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөлтийг хангах, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний байгууламж бүрд нэр эсхүл дугаар оноож, ангилсан байх ба түүний хаяг, газар зүйн байршлын солбицлын мэдээлэл, байгууламжийг хариуцах менежерийг бүртгэн тэмдэглэсэн байна. Түүнчлэн байгууламж бүр түүний хамгаалалтын хил зааг, орох, гарах цэг, ажиллагсдын орон сууц, мал бүхий бүх байрны байршлыг харуулсан газрыг зурагтай байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Байгууламжийн нэр, дугаар, ангилал, газрын зураг

- i) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүр өөрийн оноосон ялгах дугаар эсхүл нэртэй, МЭНС-д бүтгэлтэй байна.
- ii) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүр дараах тогтолцооны дагуу ангилагдана:

А. Ерөнхий байгууламж: гадны олон эх үүсвэрээс эрүүл мэнд, тавлаг байдлаар тэнцсэн мал, амьтныг хүлээн авч тэжээлд дасгах, бүлэглэн маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

В. Бордооны байгууламж: өсвөр малыг бүлэглэн байран маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж.

С. Ерөнхий болон бордооны нэгдмэл байгууламж: ерөнхий болон бордооны үйл ажиллагаа хослон эрхлэх үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

Д. Үржүүлэг, үйлдвэрлэлийн нэгдсэн байгууламж: гаднаас мал, амьтан авах хэрэгцээг багасгах зорилгоор үржүүлгийн сүрэг, мал, амьтан өсгөн бойжуулах хэсэг бүхий үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

Е. Төхөөрөх болон боловсруулах байгууламж: мал, амьтныг төхөөрч, гулуузыг нь боловсруулах үйл ажиллагаа явуулах байгууламж

Ф. Үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэгдсэн байгууламж: үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах үйл ажиллагааг явуулах нэг дор байршуулсан байгууламж

Г. Үржүүлэг, үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэгдсэн байгууламж: үржүүлэг, үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах үйл ажиллагааг явуулах нэг дор байршуулсан байгууламж

- iii) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүр бүртгэгдсэн хаяг, Монгол улсын газрын зургаас олох боломжтой газар зүйн байршлын солбицолтой байна.
- iv) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүр эргэн тойрны хамгаалалтын хил зааг, орох, гарах цэг, хорио цээрт мал оруулах хэсэг, захиргааны байр, малын байр, ажиллагсдын орон сууц, тэжээлийн агуулах, химийн бодис, эмийн бүтээгдэхүүний агуулах, төхөөрөх болон боловсруулах байр, малын гаралтай бүтээгдэхүүний агуулахыг ялган тэмдэглэсэн газрын зурагтай (байгууламжийн ангилалд хамаатай байхаар) байна.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Удирдлага нь үнэн зөв мэдээллийг бүрдүүлж хадгалах үүрэгтэй.
- б) Мэдээллийг хөндлөнгийн хяналт шалгалтын явцад баталгаажуулна.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Дээрх шаардлагатай бүх мэдээллийг компанийн хамгаалалттай аж ахуйн удирдлагаар дамжуулан бэлэн байлгах ба МЭЕГ эсхүл хөндлөнгийн хяналтын байцаагч хууль тогтоомж, дүрэм журмын аливаа шаардлагын биелэлтийг шалгах, (ө.х. тандах хяналт шалгалт), хөндлөнгийн баталгаажуулалт/хяналт шалгалт хийх, зах зээлд нэвтрэх хэлэлцээрийн явцад шаардах үед бэлэн байлгана.
- б) Оноосон нэр, дугаар, ангиллыг үндэсний хөтөлбөрийн нэгдсэн бүртгэлд компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэлийн хэсэгт оруулна.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. С01. Хамгаалалттай аж ахуйг бүртгүүлэх өргөдлийн маягт
- ii. С02. Компанийн хамгаалалттай аж ахуйд байгууламж бүртгүүлэх өргөдлийн маягт

Хувилбарыг мөшгөх мэдээлэл:

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Туслах материал хэсэгт өөрчлөлт оруулсан. Байгууламжийг МЭНС-д бүртгүүлсэн байх тухай өөрчлөлт орсон.

В.02. Орцын хяналт: Мэдрэмтгий зүйлийн мал

Тодорхойлолт:

Аль ч хамгаалалттай аж ахуйн байгууламжид онцгойлсон өвчинд мэдрэмтгий мал оруулах үед түүний эх үүсвэр, тээвэрлэлт, ирэх үеийн эрүүл мэндийн үзлэг шалгалт, хорио цээрт холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Бусад эх үүсвэрээс солбицон халдварлах болон солбицон бохирдохоос хамгаалах чиглэлээр компанийн хамгаалалттай аж ахуйн мал төхөөрөх зориулалттай байгууламжид тавих тусгай шаардлагыг тусгасан болно.

Жич: Компанийн хамгаалалттай аж ахуйн ийм төрлийн бүх байгууламж мал эрүүл мэндийн статусаараа адилхан учраас эдгээр байгууламж хоорондын шилжилт хөдөлгөөнд энэ шаардлага хамаарахгүй. Тээвэрлэлтийн явцад биохамгааллын арга хэмжээ авах талаар зохих анхаарал тавьж, тээвэрлэлтийн явцад халдварт өртөх эрсдэлийг компани өөрөө үнэлсний дагуу мал, амьтан ирэх үеийн эрсдэлийг удирдах арга хэмжээ авна.

Байгууламжийн ангилалтай уялдах байдал:

Оролцогч компани энэхүү САЗ-т заасан шаардлагыг холбогдох ангиллын байгууламжийн (байгууламжийн ангиллыг САЗ В.01-ээс үзэх) биохамгааллын зааварт хэрхэн нэгтгэж оруулснаа тодорхойлно.

Гарах үр дүн:

Мал нийлүүлж байгаа аж ахуй онцгойлсон өвчингүй, тайван байх ёстой. Гарал үүслийн аж ахуйгаас компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж хүртэл мал тээвэрлэх хугацаанд тэдгээр өвчний халдварт өртөхөөс хамгаалсан байна. Бүх шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлнэ. Малыг ирэнгүүт үзлэгт оруулах ба компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид оруулахын өмнө өвчний ил харагдах шинж тэмдэггүй байх ёстой. Авчирснаас хойш мал, амьтныг:

АЛЬ НЭГИЙГ СОНГОХ: (үйлдвэрлэлийн байгууламж, түүний дотор дотроо үйлдвэрлэл явуулдаг нэгдсэн байгууламжид оруулах бол) онцгойлсон өвчингүй болохыг баталгаажуулах хүртэл хорио цээрийн байранд байлгах,

ЭСХҮЛ (төхөөрөх байгууламжид оруулах бол) - мал байсан, гулуузыг боловсруулсан бүх хэсэгт **гүн** цэвэрлэгээ хийсний дараа хүлээн авч; авчирсны дараах 24 цагт багтаан төхөөрч; төхөөрөх, боловсруулах, хадгалах бүх шатад компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний бус аж ахуйгаас авчирсан мал, махан бүтээгдэхүүнд **хавьцуулахгүй** байлгана.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага:

- а) Үйлдвэрлэлийн байгууламжид мал нийлүүлж байгаа аж ахуй болон байгууламж

Компанийн хамгаалалттай аж ахуйн А, В, С, D, F, G аль ч ангиллын байгууламжид мал нийлүүлэх аж ахуй болон байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна:

- i) Аж ахуйгаас ямар ч мал авахын өмнө тухайн аж ахуй нь заавал мэдэгдэх өвчний сэжиг бүхий малын эрүүл мэндийн аливаа асуудлыг шинжлэн судлах

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар

35

Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

ажлыг багтаасан биохамгааллын зохих тогтолцоотой эсэхийг тогтоохын тулд оролцогч компанийн зүгээс зохих магадлан шалгах ажлыг гүйцэтгэнэ.

- ii) Ачилт бүрийн өмнө нийлүүлэх мал нь тухайн аж ахуйд 30-аас доошгүй хоног тогтмол малласан байсан байна.
- iii) Ачилт хийх бүрийн өмнөх доор тогтоосон аль ч хугацааны дотор онцгойлсон өвчний батлагдсан тохиолдол гараагүй байна:

Шүлхий өвчин: 3 сар

Бог малын мялзан өвчин (БММӨ): 21 хоног

- б) МЭНС-ийн мөшгөлтийн хэсэгт малын шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлж, зөвшөөрөл авах
 - i) Гарал үүслийн аж ахуйг зохих шаардлага хангасан гэж хамгаалалттай аж ахуйн өмчлөгч үзвэл нийлүүлэхээр төлөвлөж байгаа малын шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт оруулж бүртгүүлнэ.
 - ii) МЭНС-д баталгаажуулахад шаардагдах мэдээллийг байгууламжийн МЭҮН бүрдүүлнэ.
- в) Мал тээвэрлэлт
 - i) Мал тээвэрлэх тээврийн хэрэгслийг мал ачихын өмнө цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
 - ii) А.8. Эмийн бүтээгдэхүүн, халдваргүйжүүлэгч хэсэгт тогтоосон халдваргүйжүүлэгчийг хэрэглэнэ.
 - iii) Тээвэрлэх маршрут нь гарал үүслийн аж ахуйгаас хүргэх газар хүртэл аль болохоор шууд, хамгийн цөөн зогсолттой (жолооч болон/эсхүл малын тавлаг байдлыг хангах) байна.
 - iv) Тээвэрлэх маршрут нь өвчтэй мал, амьтан эсхүл бохирлогдсон материалд хавьтах өндөр эрсдэлтэй газраар, жишээлбэл өвчин дэгдсэн нь тодорхой болсон нутаг болон малын зах гэх мэт мал бөөгнөрсөн газраар дайрахгүй байна.
 - v) Мал ачих тээврийн хэрэгслийг компанийн хамгаалалттай аж ахуйн нутаг дэвсгэр дэх мал буулгахад зориулсан хэсэгт оруулахын өмнө гаднах гадаргууг халдваргүйжүүлнэ.
- г) Хүлээн авах хэсэгт хийх үзлэг шинжилгээ
 - i) Гаднаас ирсэн малд ирэнгүүт нь, гэхдээ буулгахаас өмнө заавал мэдэгдэх өвчний эмнэл зүйн илэрхий аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг ажиглана.
 - ii) Буулгахын өмнө болон буулгах явцад өвчний шинж тэмдэг үзүүлсэн малыг олж тогтоон судлан шинжлэх зорилгоор тусгаарлана.
 - iii) Олон мал өвчний эмнэл зүйн шинж тэмдэг үзүүлбэл тэдгээрийг тусгаарлахын оронд тухайн ачилтыг бүхэлд нь хүлээж авахаас татгалзаж **гологдол болгож** болно.
 - iv) Ингэхдээ гарал үүслийн аж ахуйд буцаах аль эсхүл төхөөрөлтөд оруулахаар өөр тийш шилжүүлэх, эсхүл энэрэнгүй аргаар нядалж хүүрийг нь биоаюулгүй аргаар устгах зэрэг аргыг хэрэглэж болно.
- д) А, В, С, D, F, G ангиллын байгууламжид оруулах үеийн хорио цээрийн хяналт (жич: компанийн хамгаалалттай аж ахуйн нэг хэсэг болох бусад байгууламжаас ирсэн, эрүүл мэндийн адил статустай малаас бусад)
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн А, В, С, D, F, G ангиллын байгууламжид нэвтэрч байгаа бүх малыг хамгийн багадаа 30 хоногийн хорио цээрт оруулна.

- ii) Удирдлага, зохион байгуулалтын шалтгаанаар жижиг бүлэгт хуваасан байсан ч гэсэн аж ахуйд нэвтрүүлэх болзлыг хангасан байх шийдвэрийг биелүүлэх үүднээс нэг дор ачигдсан малыг нэг бүлэг гэж үзнэ.
- iii) Хорио цээрт оруулсан малыг хорионы хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуй доторх малтай шууд болон шууд бус хавьтал үүсгэхээргүй байлгана.
- iv) Хорио цээрт оруулсан малыг малын эмч өдөр бүр ажиглана. Өвчний шинж тэмдэг үзүүлсэн ямар ч малыг ялгаж үзлэг шинжилгээ хийнэ. Малын эмч түүнийг заавал мэдэгдэх өвчин гэж сэжиглэвэл үзлэг хийхээс гадна лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авна.
- v) Хамгийн багадаа 28 хоногийн хорио цээрт оруулсны дараа малаас сорьц авч ачигдаж ирсэн мэдрэмтгий зүйлийн малд онцгойлсон өвчнийг оношлох шинжилгээ хийнэ, ө.х.:

үхэрт:

шүлхий

хонь, ямаанд:

шүлхий өвчин, бог малын мялзан өвчин (БММӨ)

- vi) Оношлох шинжилгээг А.8. Лабораторийн оношлох үйлчилгээ хэсэгт заасан илрүүлэх аль эсхүл баталгаажуулах шинжилгээний аль нэг аргаар хийнэ.
 - vii) Хорио цээрт оруулсан бүлэг тус бүрд түүврийн хэмжээ хамгийн багадаа 30 мал, хэрэв 30 хүрэхгүй бол бүлгийн бүх малаас сорьц авна. Түүврийн хэмжээг өвчингүй, тайван болсныг тогтооход ашигладагтай адилхан параметрт (лавлагаа: САЗ В.17) суурилна.
Илрүүлэх шинжилгээгээр эерэг эсхүл сэжигтэй дүн үзүүлбэл бүх дээжийг баталгаажуулах шинжилгээний аргаар дахин шинжилнэ.
 - viii) Баталгаажуулах шинжилгээгээр эерэг дүн ямар нэг байдлаар илэрвэл тухайн хорио цээрт оруулсан бүлэг малыг бүхэлд нь тэнцэхгүй гэж үзнэ.
Тэрхүү бүлэг малыг тухайн оношлогдсон өвчинд холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн **гологдол** болгоно.
- e) Мал төхөөрөх болон мах боловсруулах

АЛЬ НЭГИЙГ СОНГОХ: (үржүүлгийн болон өсгөн бойжуулах байр бүхий F ба G байгууламжид)

- i) Төхөөрөх болон боловсруулах байгууламжид төхөөрөх мал, малын боловсруулах махыг ЗӨВХӨН компанийн хамгаалалттай аж ахуйн доторх бусад байгууламжаас БАЙНГА авна (Жич: энэ нь F ба G ангиллын зөвхөн төхөөрөх нэгдсэн байгууламжид зориулсан хувилбар юм);

ЭСХҮЛ (дан төхөөрөх болон боловсруулах байр бүхий E ангиллын байгууламж)

- ii) Компанийн хамгаалалттай аж ахуйд мал хүлээн авах, төхөөрөх болон боловсруулалт эхлэхээс өмнө байгууламжийн мал төхөөрөх байр, тэр дундаа мал хүлээн авч байлгах хэсгийг маш сайн цэвэрлэсэн байна.
- iii) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас малыг ЗӨВХӨН бусад мал байхгүй эсхүл бусад мал төхөөрөөгүй, мах боловсруулалт хийгээгүй өдрүүдэд хүлээн авах бөгөөд энэ нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авсан малыг төхөөрч, боловсруулж дуустал (ө.х. төхөөрөх болон боловсруулах эхний өдөр) үргэлжилнэ.

- iv) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авсан малын ачилт бүрд дээр дурдсан в) тээвэрлэх, г) ирэх үеийн үзлэг шинжилгээ гэсэн хэсгийн шаардлага мөн хамаарна.
- v) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авч байгаа малыг тээвэрлэлтийн явцад болон төхөөрөх байгууламжид ирсэн байхад нь ч бусад ямар ч аж ахуйн малтай хавьтал үүсгэхээргүй байлгана.
- vi) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас хүлээн авсан малыг төхөөрөх байгууламжид 24 цагийн дотор төхөөрнө.
- vii) Компанийн хамгаалалттай аж ахуйн төхөөрөх болон боловсруулах байгууламжаас гарах мах, махан бүтээгдэхүүн нь ялгагдах тэмдэглэгээтэй, мөшгөн тогтоох боломжтой байх ба агуулахад аливаа бусад бүтээгдэхүүнээс тусад нь хадгална.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Мал нийлүүлэх аж ахуйг магадлан шалгах ажлын хүрээнд тухайн аж ахуйн САЗ-ууд болон өмнө нь хийгдсэн өвчний судалгаа шинжилгээний бүртгэл, баримт бичгийг үзэж шалгах, малын эрүүл мэндийг хамгаалах хууль, журмын шаардлагыг хэрхэн хангаж ирснийг тухайн аж ахуйн харьяалагдах аймгийн мал эмнэлгийн албатай холбогдон лавлах зэргийг оруулна.
- б) Дээрх шаардлагад хамаарах албан баримтад мал нийлүүлж байгаа аж ахуй бүрийн хариуцсан дарга гарын үсэг зурсан байна.
- в) Мал ачихын өмнө тээврийн хэрэгслийг цэвэрлэж халдваргүйжүүлсэн албан баримтад жолооч болон цэвэрлэгээ, халдваргүйтгэл хариуцсан ажилтан гарын үсгээ хамт зурна.
- г) Хүлээн авах малын ачилт бүрийг тээвэрлэхээс өмнө тээврийн маршрутыг удирдлагаас баталсан маршрутын төлөвлөгөөг баримтлан төлөвлөнө.
- д) Тээврийн маршрутын төлөвлөгөөг дагаж хамгийн бага зогсолт хийсэн гэдгийг баталгаажуулахын тулд байршил тогтоох систем (GPS)-ээр хянах болон/эсхүл жолооч албан баримт үйлдэнэ.
- е) Тээврийн хэрэгслээс буулгахаас өмнө малын эмч ачигдаж ирсэн малд мэдрэхүйн эрхтний үзлэг хийнэ.
- ж) Ачааг буулгахыг хариуцсан этгээд малын эмчийн зөвлөмжийн дагуу буулгана.
- з) Ачааг буулгах явцад малын эмч өвчний шинж тэмдэг үзүүлж байгаа мал байгаа эсэхийг ажиглаж шалгана.
- и) Буулгахын өмнө болон буулгах явцад өвчний шинж тэмдэг үзүүлсэн ямар ч малыг тусгаарлах, өвчний шинж тэмдэг үзүүлсэн ямар ч малд үзлэг хийнэ.
- к) Хорио цээрийн хэсэг болон доторх мал нь мал эмнэлгийн хяналтад байна
- л) Малд үзлэг хийх, заавал мэдэгдэх өвчнийг ялгаварлахад зориулан сорьц авах мал эмнэлгийн шийдвэрийн хэрэгжилтийг удирдлагын шийдвэр болон санхүүгийн шалтгаанаар саатуулж болохгүй.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Оролцогч компанийн мал хүлээж авсан аж ахуй, байгууламжийн бүртгэлийг тэдгээрт хийсэн урьдчилан магадлан шалгах ажлын товч тодорхойлолтын хамт;
- б) Хамгаалалттай аж ахуйд оруулсан малын хөдөлгөөн бүрийн МЭНС-ийн бүртгэл;
- в) Ачилт бүрийг газар дээр нь хариуцан ачуулсан эзэн/менежерийн олгосон ачааны дагалдах баримт бичиг (1 жил);
- г) Ачааны машинд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийсэн албан баримт (1 жил);
- д) Тээврийн маршрутын төлөвлөгөө, түүний баталгаажуулалтын хамт (1 жил);
- е) Мал эмнэлгийн байцаагчийн тэмдэглэл;

- ж) Ачааг буцаах үндэслэл, чиглэл бүхий шийдвэр;
- з) Хорио цээрт оруулахаар хүлээн авсан малд хөтлөх дараах мэдээллийг агуулсан бүртгэл (1 жил):
 - i) Оруулсан огноо
 - ii) Орсон малын тоо
 - iii) Малын гарал үүслийн эх үүсвэр
 - iv) Малын эмчийн өдөр тутмын ажиглалтын бүртгэл
 - v) Ямар нэг өвчтэй малд малын эмч үзлэг хийсэн тэмдэглэл
 - vi) Лабораторийн шинжилгээнд сорьц авсан бүртгэл
 - vii) Хорогдсон малын бүртгэл, мал эмнэлгийн задлан шинжилгээний үр дүн
 - viii) Лабораторийн оношилгооны үр дүн
 - ix) Тэнцэхгүй гэж үзсэн бүлэг малыг **гологдол** болгох шийдвэр
 - x) Компанийн хамгаалалттай аж ахуйд нэвтрэх зөвшөөрөл олгосон шийдвэр
 - xi) Компанийн хамгаалалттай аж ахуйд нэвтрүүлсэн малын тоо
- и) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас зөвхөн төхөөрөх малыг баталгаажуулах аргачлал, төхөөрөх хүртэл хэрэгжүүлсэн биохамгаалалт
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламжаас компанийн хамгаалалттай аж ахуйн төхөөрөх болон боловсруулах байгууламж руу шилжүүлж байгаа бүх малд компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг гарцын хяналт: САЗ В24-д заасны дагуу олгоно. Эдгээр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ экспортын шаардлагын дагуу хийх мөшгөн тогтоолт, баталгаажуулалтад чухал ач холбогдолтой.
 - ii) Мал хүлээн авахын өмнө их цэвэрлэгээ хийсэн болохыг албан ёсны эрх бүхий малын эмч баталгаажуулна.
 - iii) Компанийн хамгаалалттай аж ахуйн малыг төхөөрч, боловсруулж, бүтээгдэхүүнийг хадгалах ажил дууссаныг албан ёсны эрх бүхий малын эмч баталгаажуулсны дараа хамгаалалттай бус аж ахуйгаас мал хүлээн авч болно.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Мал нийлүүлэх аливаа аж ахуй өвчингүй, тайван байх шаардлагыг хангасан болохыг батлах гэрчилгээний загвар
- ii. Мал тээвэрлэх ачааны машины жолоочид өгөх бичмэл зааварчилгаа
- iii. Ачааны машинд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх төхөөрөмж бүхий хэсэг
- iv. Мал тээвэрлэх маршрутыг төлөвлөхөд анхаарах тээврийн маршрутад ойр малын зах эсхүл өндөр-эрсдэлтэй нутаг
- v. Ачааны машин үзлэг шалгалтад орох зогсоол, ачаа ачих, буулгах талбай, хорио цээрийн байгууламжийг тодруулж харуулсан байгууламжийн газрын зураг
- vi. Хорио цээрт оруулсан ачаа бүрийн бүртгэлийн загвар
- vii. Төхөөрсөн малд төхөөрөлтийн өмнө ба дараа хийсэн үзлэгийн тэмдэглэл

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Хянуулах анхны төсөл
25/04/2024	0.2.	Орсон өөрчлөлтүүд: Хорио цээрийн үеийн шинжилгээ хийхэд хэрэглэх сорьц түүвэрлэх арга зүй Хамгаалалттай аж ахуй руу хийгдэх малын бүх шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртгүүлэх

В.03. Орцын хяналт: Генетикийн материал (Үр, хөврөл үр)

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн аль ч байгууламжид гадна эх үүсвэрээс генетикийн материал (үр, хөврөл үр) оруулах үед түүний эх үүсвэр, авчирсан байдал, хадгалалт, ашиглалтад хамаарах шаардлага, түүнийг хангах аргачлал

Байгууламжийн ангилалд хамаарах байдал:

Оролцогч компани энэхүү САЗ-т заасан шаардлагыг дараах ангиллын байгууламжийн биохамгааллын зааварт хэрхэн нэгтгэж оруулснаа тодорхойлно.

D. Үржүүлэг, үйлдвэрлэлийн нэгдсэн байгууламж

Гарах үр дүн:

Генетикийн материал (үр, хөврөл үр)-аар хангаж байгаа аж ахуй нь шүлхий болон БММӨ-гүй, тайван байх ёстой. Генетикийн материал (үр, хөврөл үр)-ыг үндэсний эрх бүхий этгээдээс олон улсын стандарт хангасан гэсэн зөвшөөрөл авсан аж ахуй дээр болон/эсхүл мэргэжилтний баг эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг ханган цуглуулна. Хэрэв Монгол улс дахь эх үүсвэрээс шилжүүлэн авах бол түүний хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгэнэ.

Хэрэв Монгол улсад импортлох бол генетикийн материал (үр, хөврөл үр) нь тус улсын импортын шаардлага хангасан, МЭНС-ийн мал эмнэлгийн олон улсын гэрчилгээний хэсэгт дурдсан хорио цээрийн хязгаарлалтад орохооргүй байх ёстой. Генетикийн материал (үр, хөврөл үр) хийсэн гуурс дээр ялгах тэмдэглэгээг хийж дагалдах мэдээлэлд нийлүүлсэн эх үүсвэрийн мэдээллийг оруулна. Генетикийн материалыг (үр, хөврөл үр) ашиглахынхаа өмнө ариутгаад шинэ хөлдөөгч бодис (ө.х. шингэн азот) дүүргэсэн саванд хийж тээвэрлэнэ. Генетикийн материалыг (үр, хөврөл үр) компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид хэрэглэх хүртлээ эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд хадгална. Хэрэглэсэн бол тээгч эхийг бүртгэнэ.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Генетикийн материал (үр, хөврөл үр) нийлүүлэгч аж ахуй

Компанийн хамгаалалттай аж ахуйн аль ч байгууламжид генетикийн материал (үр, хөврөл үр) нийлүүлэх аж ахуй дараах шаардлага хангасан байна:

- i) Генетикийн аливаа материал (үр, хөврөл үр) авахын өмнө оролцогч компани нийлүүлэгч аж ахуйд очиж бодит байдлыг газар дээр нь магадлах шалгалт хийж тухайн аж ахуй малын үр цуглуулах төвд (ө.х. ДМАЭМБ Кодексын бүлэг 4.6) зориулсан олон улсын стандартын дагуу малын эмчийн удирдлага зааварчилгаа дор үйл ажиллагаагаа явуулдаг эсэх, заавал мэдэгдэх өвчний сэжиг бүхий малын эрүүл мэндийн асуудлыг судлан шинжлэхэд шаардагдах биохамгааллын тогтолцоотой эсэхийг тогтоох нь зүйтэй.
- ii) Ачилт бүрийн тухайд генетик материалын донор малыг гарал үүслийн аж ахуйд наад зах нь 30 хоног тогтмол малласан байна.

iii) Ачилт бүрийн тухайд генетикийн материал цуглуулахаас өмнөх дор дурдсан хугацаанд мэдрэмтгий зүйлийн амьтанд онцгойлсон аливаа өвчний батлагдсан тохиолдол гараагүй байна:

Шүлхий: 3 сар

Бог малын мялзан өвчин (БММӨ): 21 хоног

iv) Монгол улс дахь эх үүсвэрээс авах материалын шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлнэ.

v) Хэрэв Монгол улсад импортлох бол генетикийн материал (үр, хөврөл үр) нь тус улсын импортын шаардлага хангасан, МЭНС-ийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний хэсэгт дурдсан хорио цээрийн хязгаарлалтад орохооргүй байна.

б) Генетикийн материалыг (үр, хөврөл үр) ялган тэмдэглэх, тээвэрлэх, хадгалах

i) Генетикийн материал (үр, хөврөл үр) бүхий гуурс нь шинэ бөгөөд донор, бэлтгэсэн газар, огноог ялгах харж болохоор шошготой байх ёстой.

ii) Генетикийн материал (үр, хөврөл үр) бүхий үрийн гуурсыг өмнө нь ариутгаад шинэ хөлдөөгч бодис (ө.х. шингэн азот) дүүргэсэн хөлдөөгч саванд хийж тээвэрлэх ба ингэхдээ эрүүл мэндийн статус доогуур эсхүл үл мэдэгдэх малын материал бүхий гуурстай хамт тээвэрлэж болохгүй.

iii) Генетикийн материалыг (үр, хөврөл үр) компанийн хамгаалалттай аж ахуй байгууламжид хэрэглэх хүртлээ эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд хадгална. Хэрэглэсэн тохиолдолд тээгч эх, хэрэглэсэн огноог бүртгэнэ.

2) Генетикийн материалаар (үр, хөврөл үр) хангах аж ахуй шаардлага хангасныг баталгаажуулах аргачлал

а) Генетикийн материалаар хангах аж ахуйг магадлан шалгах ажлын хүрээнд тухайн аж ахуйн үр цуглуулах төв нь үндэсний эрх бүхий байгууллагад бүртгэлтэй эсэх, САЗ болон өмнө нь хийгдсэн өвчний судалгаа шинжилгээний бүртгэл, баримт бичгийг үзэж шалгах, малын эрүүл мэндийг хамгаалах хууль, журмын шаардлагыг хэрхэн хангаж ирснийг тухайн аж ахуйн харьяалагдах аймгийн мал эмнэлгийн албатай холбогдон лавлах зэрэг ажлыг оруулна.

б) Монгол улсад генетикийн материал (үр, хөврөл үр)-аар хангаж байгаа аж ахуй, байгууламж бүрийг хариуцсан менежер дээрх шаардлага бүхий баримт бичигт гарын үсэг зурна.

в) Хэрэв импортолсон бол генетикийн материал (үр, хөврөл үр) нь хуулиар тогтоосон шаардлагын дагуу авсан мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ, МЭЕГ-аас олгосон импортын лицензтэй байна.

г) Компанийн хамгаалалттай аж ахуй байгууламжид ирэхээр нь ялгагдах шинж чанар болон шаардлага хангаж байгааг батлах баримтыг шалгана.

3) Хадгалах бүртгэл, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

а) Оролцогч компани генетикийн материал (үр, хөврөл үр) хүлээн авч байгаа аж ахуйн бүртгэлийг магадлан шалгах ажлын товч тодорхойлолтын хамт хадгална.

б) Хамгаалалттай аж ахуйд авчирсан генетикийн материалын шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д орсон бүртгэл

в) Хариуцсан менежерээс ачилт бүрд олгосон дагалдах баримт бичиг (1 жил)

г) Хэрэв импортолсон бол мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээний хуулбар, хорио цээрийн хяналтад хамруулсан талаар МЭЕГ-аас олгосон нотлох баримт

- д) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид ашиглаж, хадгалж байгаа бүх генетикийн материалын (үр, хөврөл үр) бүртгэл (1 жил)

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Монгол улсын аль ч аж ахуйд нийлүүлж байгаа генетикийн материал нь (үр, хөврөл үр) өвчингүй, тайван байх шаардлагыг хангаж байгаа тухай мэдүүлгийн загвар
- ii. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид хадгалж байгаа генетикийн материалын (үр, хөврөл үр) бүртгэл
- iii. Аж ахуйд ашиглаж байгаа генетикийн материалыг (үр, хөврөл үр) хүлээн авагчийн хийсэн бүртгэл, ашигласан огноо

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртүүлэх шаардлагын талаар өөрчлөлт орсон.

В.04. Орцын хяналт: Тэжээл, ус

Тодорхойлолт:

Малын тэжээл, усаар дамжин өвчин нэвтрэх эрсдэлийг удирдах шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Байгууламжид ашиглах аливаа тэжээл, ус нь баталгаатай байх шаардлагын дагуу халдварт өвчний үүсгэгчийн бохирдолгүй байх ёстой.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Малын тэжээл

- i) Хоолны үлдэгдэл болон хаягдлаар тэжээхийг хориглоно.
- ii) Хэрэв аж ахуй дээрээ тэжээлээ хольж бэлтгэх бол тэжээлд тавьдаг шаардлагыг бүх орцод мөрдөнө.
- iii) Тэжээл, түүний хольцыг чанарын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлдэг компани, тэжээвэр болон зэрлэг амьтан, түүний дотор хортон шавж, мэрэгч, шувууны нөлөөгөөр бохирдохоос сэргийлсэн биохамгаалал бүхий аж ахуйгаас авна.
- iv) Тэжээл, тэжээлийн орцыг хүлээн авахдаа савлагааны гадна талаас нь харж шалган органик материалын илт бохирдолгүй болохыг тогтооно.
- v) Аливаа тэжээл, түүний орцоос учирч болох эрсдэлийг дараах аргаар бууруулна:
 - (1) Хорголжлох, шахмал болгох явцад хийх дулааны боловсруулалт, эсхүл
 - (2) Ашиглахын өмнө 120 хоног хадгалах, эсхүл
 - (3) Химийн боловсруулалт (жишээ нь: формальдегид гэх мэт).
- vi) Байгууламж дээрх тэжээл, тэжээлийн хольц хадгалах агуулахыг мал, зэрлэг амьтан, хортон шавж, мэрэгч, шувуу нэвтрэн орохоос хамгаалсан байна.

б) Усанд тавих шаардлага

- i) Мал ундаалах ус нь малын өвчний үүсгэгчийн бохирдолгүй байна. Үүний тулд дараах аль нэг арга хэрэглэнэ:
 - (1) Суурин газрын ус хангамжийн шугамын ус ашиглах,
 - (2) Гүний худгийн ус ашиглах,
 - (3) Болзошгүй бохирдлыг арилгахын тулд гадаргын голын усыг татаж боловсруулан (жишээ нь: хлоржуулах, хэт ягаан туяагаар ариутгах гэх мэт) ашиглах.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Тэжээл, түүний орц нийлүүлэгч бүрийн бүртгэлтэй байна.
- б) Тэжээл, түүний орцын ачилт бүрийг хүлээн авах зөвшөөрөл олгохдоо эрсдэлийг бууруулахад хэрэглэсэн аргыг тэмдэглэж авна.
- в) Байгууламжид хадгалж байгаа бүх тэжээлийн нөөцийн бүртгэлийг эрсдэл бууруулсан бүртгэлийн хамт хадгална.
- г) Агуулахыг мал, зэрлэг амьтан, хортон шавж, шувуу нэвтрэн орохоос найдвартай хамгаалсан болохыг тогтоох шалгалтыг үе үе хийнэ.

- д) Малаа услах гадаргын усыг мал, амьтан хавьтахгүй гэхийн баталгаагүй орон нутгийнхаа эх үүсвэрээс авах бол онцгойлсон өвчний үүсгэгчийг идэвхгүйжүүлж чадах арга болон ус боловсруулах боломжит аргыг авч үзсэн эрсдэлийн тусгайлсан дүн шинжилгээ хийнэ.
- е) Ус боловсруулахад эрсдэлийн удирдлагын ямар арга хэрэгжүүлэх шийдвэрээ гаргаж шаардлагатай хяналт шинжилгээ хийж хэрэгжүүлнэ.

- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид тэжээл нийлүүлэгчийн бүртгэл
 - б) Тэжээл, тэжээлийн орцыг хүлээн авсан баримт, түүний дотор өвчний эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээний тухай тэмдэглэл
 - в) Байгууламж дээрх тэжээлийн нөөцийн жагсаалт, бүртгэл,
 - г) Малын усны бүртгэгдсэн эх үүсвэр.
 - д) Гадаргын усны боловсруулалтад (хэрэв хэрэглэдэг бол) байнгын хяналт-шинжилгээ хийдгийн нотолгоо

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Онцгойлсон өвчний үүсгэгчийг идэвхгүйжүүлэх С.10. хэсэг дэх үзүүлэлт

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Date	Хувилбарын дугаар	Comment
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	С.10-р хэсэг: Онцгойлсон өвчний эпидемиологийн үзүүлэлтийг лавлах хэсэгт нэмсэн.

В.05. Орцын хяналт: Эмийн бүтээгдэхүүн (Вакцин, бичил биетний эсрэг эм)

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн малд хэрэглэх мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний (вакцин, бичил биетний болон шимэгч хорхойн эсрэг эм) эх үүсвэрт холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компанийн хэрэглэж байгаа бүх эмийн бүтээгдэхүүн, эм нь МЭЭГ-ын дэргэдэх Малын эмийн салбар зөвлөлөөс олгосон бүртгэлтэй, малд хэрэглэж болох зөвшөөрөлтэй байх ёстой. Мал эмнэлгийн вакцин нь ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын дагуу үйлдвэрлэсэн байх ёстой. Оролцогч компанид нийлүүлсэн мал эмнэлгийн эмийн үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан, үйл ажиллагаандаа ISO9001 чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүн (вакцин, бичил биетний болон, шимэгч хорхойн эсрэг эм) сонгон авах
 - i) Оролцогч компани мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнийхээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлж дараах шаардлага хангасан ханган нийлүүлэгчид зөвшөөрөл олгоно:
 - (1) Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүн нь МЭЭГ-ын бүртгэлтэй, малд хэрэглэж болох зөвшөөрөлтэй,
 - (2) Онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) эсрэг хэрэглэх вакциныг ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын дагуу үйлдвэрлэсэн.
 - ii) Оролцогч компанид нийлүүлж байгаа мал эмнэлгийн эмийн үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан, үйл ажиллагаандаа ISO9001 чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг байна.
- б) Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүн хэрэглэх нь

Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнийг В18, В19, В20, В21, В23, В24, В26 хэсэгт бичсэн аргачлалыг мөрдөн хэрэглэнэ.

Эдгээр САЗ-д тусгагдаагүй нөхцөлд мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнийг хэрэглэх зайлшгүй шаардлага гарсан бол онош тогтоолгох, жөр бичүүлэх, эмчилгээ хийх ажлыг малын эмчийн удирдлага, зааварчилгаа дор хийсэн болохыг нотлон харуулах баримтыг хадгална.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Оролцогч компани мал эмнэлгийн бүтээгдэхүүний өөрийн хэрэгцээгээ тооцоолж онцгойлсон өвчний эсрэг дархлаажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, тохиолдож болзошгүй халдварт болон шимэгчтэх өвчнөөс сэргийлэх, тэмцэх, эмчлэхэд шаардагдах бүтээгдэхүүнээ болон түүний тоо хэмжээг тогтооно.

- б) Шаардагдах мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой нийлүүлэгчид магадлах шалгалт хийж тухайн компани ҮЗД-ын гэрчилгээтэй, ISO9001 стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг, үндэсний хэмжээнд бүртгэлтэй бөгөөд олон улсын стандарт хангасан бүтээгдэхүүн нийлүүлдэг эсэхийг тогтооно.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацааны хамт).
- а) Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний зөвшөөрөлтэй бүтээгдэхүүн, нийлүүлэгчийн бүртгэл.
- б) Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний худалдан авалт, хүлээн авалтын бүртгэл.
- в) Байгууламж дээр хадгалж байгаа мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний нөөцийг тэдгээрийн хүчинтэй хугацааны хамт оруулсан жагсаалт, бүртгэл.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. МЭЕГ-ын дэргэдэх Малын эмийн зөвлөлөөс зөвшөөрсөн мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний бүртгэлийн лавлагаа
- ii. ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын Шүлхий болон БММӨ-ий бүлгүүдийн лавлагаа
- iii. Мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний зөвшөөрөлтэй нийлүүлэгчийн цахим хуудас болон/эсхүл хамгаалалттай аж ахуйд хэрэглэж байгаа мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний мэдээллийн хуудасны лавлагаа

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.06. Орцын хяналт: Тоног төхөөрөмж

Тодорхойлолт

Компанийн хамгаалалттай аж ахуйд малд ашиглахаар оруулах тоног төхөөрөмжид холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйд малд ашиглахаар оруулах тоног төхөөрөмж, хэрэгсэл нь (малыг байран маллах, тэжээх, эмчлэх, тээвэрлэхэд хэрэглэх тоног төхөөрөмж, хэрэгсэл, мөн түүнчлэн малтай харьцах ажилтны хувийн хамгааллын хувцас) халдварт өвчний үүсгэгчийн бохирдолгүй байх бөгөөд үүсгэгчээр бохирдохооргүй нөхцөлд хадгалдаг байна.

Шаардлага ба аргачлал:

- 1) Шаардлага
 - а) Малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах
 - i) Малд ашиглах тоног төхөөрөмж нийлүүлэх боломжтой нийлүүлэгч компанид чанарын болон ариун цэврийн шаардлага ханган ажилладаг эсэхийг магадлах шалгалт хийнэ.
 - ii) Хамгаалалттай аж ахуйд оруулж малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэл нь:
 - (1) шинэ; аль эсхүл
 - (2) цэвэрлэж, халдваргүйтгэсэн байна.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгслийг хүлээн авах бүрдээ сайтар үзэж шалган органик материалаар бохирдоогүй болохыг тогтооно.
- 3) Хадгалах бүртгэл, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэгчийн батлагдсан жагсаалт
 - б) Малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгслийн ачилт бүрийг хүлээн авсан бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Малд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэгчийн батлагдсан жагсаалт
- ii. Малд ашиглаж байсан хуучин тоног төхөөрөмжид хэрэглэхийг зөвшөөрсөн халдваргүйжүүлэгч

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.07. Орцын хяналт: Хэвтрийн материал

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн малд хэрэглэх хэвтрийн материал нэвтрүүлэхэд хамаарах шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйд оруулах малын хэвтрийн материал (сүрэл, модны үртэс, зоргодос, өөр бусад материал) халдварт өвчний үүсгэгчээр бохирдоогүй байх бөгөөд бохирдуулахгүйгээр хадгалдаг байна.

Шаардлага ба аргачлал:

- 1) Шаардлага
 - а) Малын хэвтрийн материал олж авах
 - i) Малын хэвтрийн шаардлага хангасан материал нийлүүлэгч компанид чанар, ариун цэврийн шаардлага хангаж ажилладаг эсэхийг магадлах шалгалт явуулна.
 - ii) Өмнө нь малд хэрэглэж байгаагүй хэвтрийн материалыг хамгаалалттай аж ахуйд оруулна. Хэрэв энэ нь баталгаагүй бол (ө.х. задгай талбайгаас авсан сүрэл), түүнийг хамгийн багадаа 120 хоног малд ойртуулахгүй.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Малд хэрэглэх хэвтрийн материалыг хүлээн авах бүрдээ сайтар үзэж өмнө нь мал хүрч байсныг илтгэхээр гадны органик материалын бохирдол (ө.х. шавхай, цус, үс ноос) байгаа эсэхийг шалгана.
- 3) Хадгалах бүртгэл, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Малд хэрэглэх хэвтрийн материал нийлүүлэгчийн батлагдсан жагсаалт
 - б) Малд хэрэглэх хэвтрийн материалтай хүлээн авсан бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Малд хэрэглэх хэвтрийн материал нийлүүлэгчийн батлагдсан жагсаалт

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.08. Биоаюулын эрсдэлийн удирдлага: Тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл

Тодорхойлолт:

Бараа, тэжээл, багаж төхөөрөмж ачих, ажиллагсдыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, малын эмчийн болон зочдын автомашиныг оруулаад тээврийн бүх хэрэгсэлтэй холбоотой халдварт өвчний эрсдэлийг удирдах шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид нэвтрэх тээврийн хэрэгсэлд хамгаалалттай аж ахуйн гадна мал, амьтан эсхүл өвчний үүсгэгчид өртсөн байх магадлал, түүнчлэн байгууламжийн доторх малд хүрэлцэх (шууд эсхүл шууд бусаар) магадлалд суурилан эрсдэлийн үнэлгээ хийж өндөр, дунд, бага гэж зэрэглэн ангилна. Орж ирж байгаа тээврийн хэрэгсэлд эрсдэлд суурилсан арга хэмжээ, үүний дотор бүрэн цэвэрлэж халдваргүйтгэх, зөвхөн дугуйг халдваргүйтгэх, байгууламж дотор хэсүүлэхийг хориглох зэрэг аргаар эрсдэлийг удирдана.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Ирж байгаа тээврийн хэрэгслийн эрсдэлийн үнэлгээ

i) Ирж байгаа тээврийн хэрэгсэл бүрд эрсдэлийн үнэлгээ хийх ба ингэхдээ тэд хамгаалалттай аж ахуйн гадна талд мал эсхүл халдварт өвчний эх үүсвэрт хүрэлцсэн байх магадлал, мөн түүнчлэн байгууламж дотор орж ирээд малтай шууд болон шууд бус замаар хүрэх магадлалыг авч үзнэ.

ii) Хамгаалалттай аж ахуйн гадна талд мал, халдварт өвчний эх үүсвэрт хүрсэн байх магадлалыг дараах байдлаар (гадаад нөлөөлөл) авч үзэх хэрэгтэй:

(1) мал тээвэрлэх тээврийн хэрэгсэл, тэжээл тээвэрлэх тээврийн хэрэгсэл, малын эмчийн унаа болон өмнөх 7 хоногийн дотор ферм, хот айл, зах, мал төхөөрөх газарт очсон аливаа тээврийн хэрэгсэл - ӨНДӨР

(2) бохирдсон, гэхдээ эрсдэл өндөр биш аливаа тээврийн хэрэгсэл - ДУНД

(3) ажиллагсдын нийтийн тээврийн хэрэгсэл, харахад цэвэрхэн зочдын унаа - БАГА

iii) Байгууламж дотор малтай шууд болон шууд бус замаар хүрэх магадлал (дотоод нөлөөлөл) нь:

(1) дотоод байгууламжийн тээврийн хэрэгсэл, ажиллагсад ашигладаг дотоод хэсэгт очсон аливаа тээврийн хэрэгсэл - ӨНДӨР

(2) Дотоод хэсгээс тусгаарлагдсан, ажиллагсад, байгууламжийн тээврийн хэрэгсэл ашигладаг, зочдын унаа зогсоодог хэсэгт байгаа бүх тээврийн хэрэгсэл - БАГА.

iv) Тээврийн хэрэгслийн нийт эрсдэлийг тооцоолохдоо (ЖИЧ: доорх туслах суурь үзүүлэлтээс лавлана уу):

(1) Гадаад нөлөөлөлд өртөх нь их бол - ӨНДӨР

(2) Гадаад нөлөөлөлд өртөх нь ДУНД эсхүл БАГА байх нь дотоод нөлөөлөлд өртөх нь ӨНДӨР эсхүл БАГА байхтай хосолбол - ДУНД

(3) Гадаад нөлөөлөлд өртөх нь бага, бас дотоод нөлөөлөлд өртөх нь бага бол - БАГА

- б) Ирж байгаа тээврийн хэрэгсэлд эрсдэлийг удирдах
- и) Ирж байгаа тээврийн хэрэгсэлд тооцоолсон эрсдэлийн дагуу дараах арга хэмжээ авна :
- (1) ӨНДӨР:
- Ачаа буулгахаас өмнө гадна тал, мал хүрдэг хэсгийг (мал ачдаг машинд) цэвэрлэж халдваргүйтгэнэ.
 - Байгууламжид орохоос өмнө дугуй, нум хэсгийг халдваргүйтгэнэ.
 - Байгууламжийн дотор бохирдлын шууд болон шууд бусаар дамжуулах боломжийг аль болохоор бага байхаар тооцож замын хөдөлгөөнийг төлөвлөнө.
- (2) ДУНД
- Байгууламжид орохоос өмнө дугуй, нум хэсгийг халдваргүйтгэнэ.
 - Байгууламжийн дотор бохирдлын шууд болон шууд бусаар дамжуулах боломжийг аль болохоор бага байхаар тооцож замын хөдөлгөөнийг төлөвлөнө.
- (3) БАГА
- Байгууламжид орохоос өмнө дугуй, нум хэсгийг халдваргүйтгэнэ.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Тээврийн хэрэгслийг төрлөөр нь ангилан тогтооно (мал тээвэрлэх тээврийн хэрэгсэл, тэжээл тээвэрлэх тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж тээвэрлэх тээврийн хэрэгсэл, ажиллагсдын нийтийн тээврийн хэрэгсэл, малын эмчийн унаа, зочдын унаа).
- б) Өмнөх 7 хоногийн дотор тухайн тээврийн хэрэгсэл ферм, хот айл, зах, мал төхөөрөх газарт очсон эсэхийг жолоочоос нь лавлана.
- в) Дугуй нь харахад цэвэрхэн эсэхийг шалгана.
- г) Гадаад болон дотоод нөлөөллийг илрүүлж, нийт учрах эрсдэлийг тооцоолно.
- д) ӨНДӨР эрсдэлтэй тээврийн хэрэгслийн тухайд нэвтрэхээс нь өмнө цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн эсэхийг баталгаажуулна.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Байгууламжид нэвтэрсэн тээврийн хэрэгсэл бүрийн бүртгэл, цаг, огноо, тээврийн хэрэгслийн төрөл, эрсдэлийн зэрэг
- б) Дээр дурдсаны адилаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийг бүртгэнэ.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Эрсдэлийг тооцоолох матриц :

Эрсдэлийн төсөөлөл		Гадаад нөлөөллийн эрсдэл		
		ӨНДӨР мал ачдаг тээврийн хэрэгсэл, тэжээл тээвэрлэдэг тээврийн хэрэгсэл, малын эмчийн унаа, өмнөх 7 хоногийн дотор ферм, хот айл, зах, мал төхөөрөх газарт очсон аливаа тээврийн хэрэгсэл	ДУНД Бохирдсон, гэхдээ эрсдэл өндөр биш аливаа тээврийн хэрэгсэл	БАГА Ажиллагсдын нийтийн унаа, зочдын харахад цэвэрхэн унаа
	ӨНДӨР байгууламжийн дотоод тээврийн хэрэгсэл,	ӨНДӨР	ДУНД	ДУНД

Дотоор нөлөөллийн эрсдэл	ажиллагсад ашигладаг дотоод хэсэгт очсон аливаа тээврийн хэрэгсэл			
	БАГА Дотоод хэсгээс тусгаарлагдсан, ажиллагсад, байгууламжийн машин ашигладаг, зочдын унаа зогсдог хэсэгт байгаа бүх тээврийн хэрэгсэл	ӨНДӨР	ДУНД	БАГА

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.09. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Хүний нөөцийн удирдлага, сургалт

Тодорхойлолт:

Ажилтнуудыг биохамгааллын шаардлагыг ойлгодог, сахин мөрддөг, ялангуяа компанийн хамгаалалттай аж ахуйн гадна талаас орж ирэхдээ эрсдэлийг удирддаг болгох хүний нөөцийн удирдлага, сургалтад холбогдох болон шаардлагыг шахаж шаардуулалгүй, ил тод дагаж мөрддөг соёлыг ажиллагсдад төлөвшүүлэхтэй холбоотой шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Бүх ажилтан компанийн хамгаалалттай аж ахуйн үндсэн зорилтууд, оролцогч компанид өгөх үр өгөөж, өөрсдийн гүйцэтгэх ажил үүрэгт хамаарах биохамгааллын зааврын САЗ-ын талаар сургалтад хамрагдана. Ажиллагсад хамгаалалттай аж ахуйд нэвтрэхдээ бохирдол оруулчихгүй байх эрсдэлийг удирдах биохамгааллын шаардлагыг ойлгож мэдсэн байна. Удирдлага нь ажилтны сургалт, хөгжлийн ажлаар дамжуулан компанийн хамгаалалттай аж ахуй, түүний биохамгааллын зааварт орсон САЗ-ын ач холбогдлыг идэвхтэй аргаар байнга ойлгуулан сануулах, ажлын үр дүнтэй гүйцэтгэлийг сайшааж, алдаанаасаа суралцах болон залруулах арга хэмжээг авч чаддаг болоход онцгой анхаарч үл тохирлыг арилгахад шаардагдах хариу арга хэмжээ авдаг байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Ажилтанд зориулсан сургалт

i) Загварчилсан сургалтын хөтөлбөрийг дараах зүйлийг хамруулан боловсруулна:

(1) Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн тогтолцоо, түүний тус улсад өгөх үр өгөөж

(2) Компанийн хамгаалалттай аж ахуй, түүний бүтэц, үйл ажиллагаа, компанид өгөх үр өгөөж

(3) Биохамгааллын зааврын САЗ-ын бүлгүүд

- Орцын хяналт
- Биоаюулын эрсдэлийн удирдлага
- Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага
- Гарцын хяналт
- Дотоод хяналт
- Хөндлөнгийн хяналт

(4) Тухайн ажил үүрэгт тохирох сургалт

ii) Бүх ажилтан ажилд орох үеийн, улмаар давтан сургалтад хамрагдана.

б) Хамгаалалттай аж ахуйд ажиллагсад орох, гарах

i) Хэрэв боломжтой бол зөвхөн захиргааны ажил эрхэлдэг ажиллагсад болон ажлын байр нь (мал болон малын байранд хүрэхгүй) малтай харьцдаг хэсгээс (мал, малын байранд шууд болон шууд бус замаар хүрэх) тусдаа байна. Ингэх боломжгүй бол бүх ажилтан малтай харьцаж ажиллах үүрэгтэй ажилтанд зориулсан журмыг дагаж мөрдөнө.

- ii) Зөвхөн захиргааны ажил эрхэлдэг ажиллагсад орохдоо мөрдөх эрүүл ахуйн үндсэн арга хэмжээнд гутал, гараа цэвэрлэж халдваргүйтгэх орно. Эдгээр ажиллагсад байгууламжийн зөвхөн захиргааны хэсэгт орж болно. Малтай харьцах үүрэг бүхий ямар ч ажилтан захиргааны хэсэгт нэвтрэх эрхгүй. Захиргааны болон малтай харьцдаг ажиллагсад нийтийн үйлчилгээний хэсэгт (үдийн цайны болон амрах өрөө, угаалгын өрөө, машины зогсоол) нэг дор цугларахгүй байна.
 - iii) Малтай харьцах үүрэг бүхий ажиллагсад (мал, малын байранд шууд болон шууд бус замаар харьцах) хамгаалалттай аж ахуйд орохдоо биохамгааллын тодоор тэмдэглэсэн (ө.х. өнгөт шугам татсан) хаалгаар дамжин хувцсаа бүрэн сольж усанд орсны дараа орно.
- в) Хамгаалалттай аж ахуйн гадна байгаа ажилтанд тавих шаардлага
- i) Хамгаалалттай аж ахуйн гадна байхдаа малын халдварт өвчний эх үүсвэр байж болзошгүй зүйлээс аль болохоор хол байна.
 - ii) Ажилтан нь хамгаалалттай аж ахуйн гаднах малтай харьцахгүй байна.
 - iii) Хамгаалалттай аж ахуйд орохоос өмнөх 48 цагт ажилтан нь мал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй шууд бусаар харьцаагүй байна. Шууд бусаар харьцах гэдэг нь малтай ферм, хот айлд зочлох, мал, малын гаралтай бүтээгдэхүүн худалддаг (малын зах) газар очих, эсхүл ферм, хот айл, малын захад ажилладаг хүмүүстэй уулзахыг хэлнэ.
- г) Ажиллагсдын удирдлага
- i) Гол зорилго нь биохамгааллын шаардлагыг сахин мөрдөх соёлыг төлөвшүүлэн дадал зуршил болгох, үүний тулд ажиллагсад юу хийх шаардлагатай байгаагаа ойлгох, ойлгосноо хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллаж, алдаа гарч болохыг хүлээн зөвшөөрч, гол нь алдаагаа зөв олж тогтоон засаж залруулдаг байна.
 - ii) Удирдлагын зүгээс хамгаалалттай аж ахуй, түүний биохамгааллын зааврын САЗ-ыг тасралтгүй сахин мөрдөхийн ач холбогдлыг дотоод мэдээлэл харилцаагаар дамжуулан байнга сануулна.
 - iii) Биохамгааллын заавар САЗ-ыг дагаж мөрдөөгүй тохиолдлыг түүний шалтгаан, үр дагавар, үл тохирлыг дахин гаргахгүйн тулд юу хийх шаардлагатай талаар, ө.х. САЗ-ын тодорхойлолт, баримт бичгийг нягтлан хянаж түүнийг тодорхой, салаа утгагүй болгох, дагаж мөрдөхөд тулгарч байгаа бэрхшээлийг арилгах эсхүл шийдвэрлэх аргыг олох, ажилтныг сургах, хөгжүүлэх талаар санаачлагатай, ил тод мэдээлдэг байх механизмыг удирдлагын зүгээс дэмжих хэрэгтэй.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Удирдлага нь сургалтын хөтөлбөрийг боловсруулж, гарын үсэг зурж батлах бөгөөд САЗ-д өөрчлөлт орох болгонд, мөн суралцсан хүмүүсийн саналын дагуу тогтмол шинэчилнэ.
 - б) Ажилтан тус бүрийн сургалтад хамрагдсан бүртгэлийг хөтөлж хадгална.
 - в) Ажилтан бүрийг захиргааны үүрэгтэй аль эсхүл малтай харьцан ажиллах үүрэгтэй гэж томилсон байна. Энэ томилгооны оноосон нэрийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, энгэрийн тэмдэгт тэмдэглэнэ. Ажилтан бүр болон бусад хүмүүс хараад ялгах боломжтой өнгөөр ялгасан энгэрийн тэмдэг, хувцаслалт гэх мэт хараад ялгах боломжтой зүйл ашиглана.
 - г) Захиргааны ажилтан ажиллах хэсгийг хэрэв боломжтой бол өнгөт шугам болон тэмдгээр тодорхой ялган тэмдэглэсэн байна. Захиргааны ажиллагсад

байгууламж дахь зөвхөн заасан хэсэгт гутал, гараа цэвэрлэн, халдваргүйтгэдэг тусгай хаалгаар дамжин нэвтэрч, мөн гарч болно.

- д) Дараах үйл явдлыг үл тохиролд тооцно:
 - i) Захиргааны ажилтан захиргааны ажилд хуваарилсан хэсгээс гадагш гарах
 - ii) Малтай харьцах ажилтан захиргааны ажлын хэсэгт орох
- е) Малтай харьцан ажиллах үүрэгтэй ажилтан зөвхөн өнгөт туузаар тодорхой заагласан усанд орох, хувцас солих өрөөгөөр дамжин байгууламжид орж, гарна.
- ж) Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, ажилтныг сургах гэрээнд эдгээр шаардлагыг тусгана.
- з) Ажилтан орох, гарах цэг дээр мөрдөх шаардлагыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг зохион гаргаж, байрлуулна.
Байгууламжид нэвтрэх үед ажиллагсад гарын үсэг зурдаг бүртгэлд шаардлагыг сахин мөрдөхийг баталгаажуулах хэсгийг нэмж оруулах.

- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Сургалтын төрөлжсөн сэдвийг боловсруулсан, шинэчилсэн, удирдлагын баталсан баримт бичиг
 - б) Ажилтны ганцаарчилсан сургалтын бүртгэл
 - в) Захиргааны болон малтай харьцаж ажиллах үүргээр нь ангилсан ажиллагсдын жагсаалт
 - г) Ажилтныг захиргааны болон малтай харьцаж ажиллах үүрэгтэйг нь сайн ялгагдахаар харуулах энгэрийн тэмдэг, хувцаслалт
 - д) Байгууламжид нэвтрэх ёстой ажиллагсдын нэрс болон ирцийн бүртгэл
 - е) Ажиллагсдын гарын үсэг бүхий орсон, гарсан бүртгэл
 - ж) Шаардлага хангуулсан тухай тэмдэглэл
 - з) Ажиллагсдын гарын үсэг бүхий орсон, гарсан бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Захиргааны үүрэгт ажилд зориулсан хэсгийг тодорхой заасан байгууламжийн газрын зураг (боломжтой бол), захиргааны болон малтай харьцаж ажиллах ажилтны гарах, орох цэг
- ii. Ажлын байрны тодорхойлолтод оруулах гэрчилгээ, шаардлагын загвар
- iii. Ажиллагсдын холбоо барих хаяг, орсон гарсан бүртгэл
- iv. Шаардлага хангуулсан тухай тэмдэглэлийн загвар
- v. Байгууламжийг өнгөтөөр тэмдэглэх бүдүүвч, жишээ нь:
 - а. шар: захиргааны үүрэг бүхий ажилтанд зориулсан хэсэг, тэднийг энэ хэсгээс гарахыг хориглоно.
 - б. улаан: малтай харьцаж ажиллах үүрэг бүхий ажилтанд зориулсан хэсэг, тэднийг энэ хэсгээс гарахыг хориглоно.
 - с. хөх: үйлдвэрлэлийн нэгж хооронд дотоод биохамгааллын хяналтын нэмэлт шаардлагыг заах нэмэлт хэсэг.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.10. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Зочид

Тодорхойлолт:

Зочдыг хүлээн авах, түүнд хамаарах биохамгааллын эрсдэлийг удирдах шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Ирэх бүх зочдыг урьдчилан мэдэгдсэн, биохамгааллын эрсдэлээр нь ангилсан, эрсдэлийн шаардлагатай удирдлагаар хангасан байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Зочдын эрсдэлийн үнэлгээ

- i) Чухал биш зочин хүлээн авахгүй байх
- ii) Хөндлөнгийн хяналт шалгалт, МЭЕГ, аймгийн хөдөө аж ахуйн газраас малын эрүүл мэндийн мэдэгдлийг магадлан судлах, багаж төхөөрөмж, байр байгууламжид засвар, үйлчилгээ хийх ажилтнууд, нийлүүлэлтийн нөхцөл байдлыг газар дээр нь үзэж баталгаажуулахаар ирэх хэрэглэгчдийг (экспортын үйл ажиллагаа эрхлэгч орно) зайлшгүй ирэх зочид гэж үзнэ.
- iii) Бүх зочид ирэхийнхээ өмнө компанийн хамгаалалттай аж ахуйн захиргаатай холбогдож зорилго, бүрэлдэхүүнээ танилцуулна.
- iv) Айлчлал бүрд, зочин нэг бүрд зөвшөөрөл олгох шаардлагатай.
- v) Айлчлал бүрийг малд шаардлагагүйгээр шууд болон шууд бусаар хүрэх, хавьтахыг дээд зэргээр багасгасан байхаар төлөвлөнө.
- vi) Айлчлал бүрийг дараах байдлаар ангилна :
 - (1) ӨНДӨР эрсдэлтэй: малд шууд эсхүл шууд бус замаар хүрэх, хавьтах бол
 - (2) БАГА эрсдэлтэй: малд шууд эсхүл шууд бус замаар хүрэхгүй, хавьтахгүйгээр зөвхөн заасан хэсэгт зорчино

б) Зочдын эрсдэлийн удирдлага

- i) Зөвшөөрөл авсан зочдод ирэхээр нь биохамгааллын шаардлага тавих тухайгаа урьдчилан мэдэгдэнэ.
- ii) Бүх дэг журмыг сахиулахын тулд зөвшөөрөлтэй айлчлал бүрийг зохицуулан ажиллах үүрэгтэй ажилтныг томилно.
- iii) Бүх зочид ирэхээсээ өмнө 48 цагийн дотор шууд эсхүл шууд бус замаар малд хүрээгүй, хавьтаагүй байх ёстой. Үүнд хот айл, фермд зочлоогүй, малын гаралтай бүтээгдэхүүн агуулдаг эсхүл боловсруулдаг захаар ороогүй байх мөн хамаарна. Энэ шаардлагыг хангасан тухай баримтад гарын үсэг зурсны дараа зочилно.
- iv) Дараах байдлаар нэвтэрнэ:
 - (1) ӨНДӨР эрсдэл: усанд орж, хувцсаа сольж орох
 - (2) БАГА эрсдэл: гутал болон гараа цэвэрлэж халдваргүйтгээд орох
- v) Бүх зочдыг зорчих хугацаанд тухайн айлчлалыг хариуцсан ажилтан эсхүл ийм үүрэг хүлээсэн ажилтан дагалдана.

- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Зайлшгүй хийгдэх айлчлал бүрд түүний зорилго, бүрэлдэхүүн, байгууламжид зочлох хэсэг, айлчлахтай холбоотой биохамгааллын эрсдэлийг дурдсан айлчлалын төлөвлөгөө гаргана.
 - б) Айлчлал бүрд удирдлагаас зөвшөөрөл авах ажлыг эхлүүлнэ.
 - в) Айлчлалыг зохицуулах ажлыг хариуцахаар томилогдсон ажилтан зочинд тавих шаардлагыг ирэхээс нь 48 цагаас багагүй хугацааны өмнө танилцуулна.
 - г) Байгууламжид орохын өмнө зочдод тавих шаардлагыг дахин сануулж түүнийг биелүүлэх амлалтын баримтад гарын үсэг зурна.
 - д) Зочныг ӨНДӨР эсхүл БАГА эрсдэлтэйгээс нь хамааруулан тусгайлан заасан орох хэсгийг зааж, дагалдан явна.

- 3) Хадгалах бүртгэл, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Удирдлагаас зөвшөөрсөн айлчлал бүрийн төлөвлөгөө
 - б) Зөвшөөрсөн айлчлал бүрийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ирсэн зочдын нэр
 - в) айлчилсан хугацаа/огноо, зорилго бүхий бүртгэл
 - г) Биохамгааллын шаардлага хангасан тухай зочны гарын үсэг зурсан баримт

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Айлчлалын төлөвлөгөөний болон удирдлагын зөвшөөрлийн загвар,
- ii. Зочдод урьдчилан илгээх боломжтой ӨНДӨР болон БАГА эрсдэлтэй зочдод тавих биохамгааллын шаардлагын тодорхойлолт,
- iii. Зочдын бүртгэлийн загвар
- iv. Зочдод тавих биохамгааллын шаардлагын хуудасны загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.11. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж доторх үйлдвэрлэлийн нэгж хооронд биохамгааллын арга хэмжээгээр зааглахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Байгууламж дахь бүх малыг үйлдвэрлэлийн нэгжид хуваарилна. Үйлдвэрлэлийн нэгж нь мэдрэмтгий нэг зүйлийн малтай, ө.х. зөвхөн үхэр, эсхүл зөвхөн хонь эсхүл ямаатай байна.

Үйлдвэрлэлийн тухайн нэгж бүр хуваарилж өгсөн байрандаа тоног төхөөрөмж, ажиллагсдаа солилгүйгээр ажиллаж үйлдвэрлэлийн нэгж хооронд мал, хүн, тоног төхөөрөмжийн шилжилт хөдөлгөөнийг аль болохоор хамгийн бага төвшинд байлгана. Хэрэв дээрх шилжилт хөдөлгөөн хийхээс өөр аргагүй бол цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, хүмүүсийн гадуур хувцсыг солих гэх мэтээр биохамгааллын арга хэмжээ авна.

Хэрэв үйлдвэрлэлийн нэгжүүдийн малын популяцийг хооронд нь зааглах ажлыг биохамгааллын дотоод арга хэмжээгээр хэрэгжүүлэх боломжгүй бол удирдлага зохион байгуулалтын үүднээс нийт малын популяцийг үйлдвэрлэлийн нэг нэгж гэж авч үзнэ. Энэ нь биохамгаалал, малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагын холбогдох САЗ-д нөлөөлнө.

Байгууламжийн малын дэд-популяцийг үйлдвэрлэлийн нэгжүүдэд хуваарилан зааглах нь эцсийн дүндээ биохамгаалал, удирдлага зохион байгуулалт, зардлын үр өгөөжийг аль ч талаас нь тэнцвэртэй байлгах үүднээс эрсдэл, ашиг аль алийг харгалзсан шийдвэр байх болно. Зөвлөхөд, нэг байгууламжид 3-6 үйлдвэрлэлийн нэгж байх нь тохиромжтой.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлох

- i) Нэг байранд маллаж байгаа амьсгалах агаар нэгтэй дан нэг зүйлийн мэдрэмтгий малын бүлэг бүрийг эсхүл нийтлэг нэг менежментийн тогтолцоотой, доторх аль ч бүлэг нь биохамгааллын ижил эрсдэлтэй (ө.х. төрөлжүүлэн малладаг нийт малын малчин нь нэг, хэрэглэдэг тоног төхөөрөмж нь нэг) төрөлжүүлэн өсгөдөг малыг үйлдвэрлэлийг нэг нэгж гэж үзнэ.
- ii) Компанийн хамгаалалттай аж ахуйн оноосон нэртэй эсхүл улсын бүртгэлийн дугаартай үйлдвэрлэлийн нэгжид хамгаалалттай аж ахуйн байгууламж дахь мал нэг бүр ямагт харьяалагдана.
- iii) Үйлдвэрлэлийн нэгж шинээр байгуулагдсан (байгууламжид орсон; малыг дахин бүлэглэсэн; байгууламж доторх байр хооронд малыг шилжүүлсэн) эсхүл өмнөх 30 хоногийн дотор мал шинээр нэмсэн бол ТОГТВОРГҮЙ үйлдвэрлэлийн нэгж гэж үзнэ.
- iv) Үйлдвэрлэлийн нэгж шинээр байгуулагдаагүй, салж хуваагдаагүй, эсхүл өмнөх 30 хоногт мал шинээр нэмээгүй эсхүл гадагш гаргаагүй (хорогдсоноос бусад) бол ТОГТВОРТОЙ үйлдвэрлэлийн нэгж гэж үзнэ.

- v) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн үйлдвэрлэлийн нэгж бүр оноосон тусгай нэртэй, байр, холбогдох байрнаас ялгах боломжтой, ТОГТВОРТОЙ эсхүл ТОГТВОРГҮЙ гэсэн аль нэг ялгах тэмдэглэгээтэй байна.
 - б) Үйлдвэрлэлийн нэгж хооронд биохамгаалал хэрэгжүүлэх
Үйлдвэрлэлийн нэгж бүр нь биохамгааллын хаалт (ө.х. нэвтрэх үед биохамгааллыг дээд зэргээр сахих нөхцөлийг бий болгох зорилгоор гадуур хувцас, гутал солих, гар угаах хэсгийг тодотгох намхан хана гэх мэт биет хаалт) бүхий ажиллагсад орох, гарах цэгтэй байх бөгөөд тодорхой таних тэмдэглэгээтэй байна.
 - i) Ажиллагсад үйлдвэрлэлийн нэгжид орох, гарахдаа хувцас, гутал солих, гар угаах боломжтой биохамгааллын хаалт бүхий цэгээр ямагт дамждаг байх хэрэгтэй.
 - ii) Үйлдвэрлэлийн нэгж бүр тогтсон ажиллагсад, байр, багаж төхөөрөмжөөр үйл ажиллагаагаа явуулахыг чухалчилна.
 - iii) Үйлдвэрлэлийн нэгж хооронд тээврийн хэрэгсэл эсхүл багаж төхөөрөмж шилжүүлэх шаардлага гарвал тэдгээрийг маш сайн цэвэрлэж халдваргүйтгэнэ.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Байгууламж нь мал нэг бүрийг ялган тэмдэглэсэн, үйлдвэрлэлийн нэгжид мөшгөн тогтоох боломжтой байх ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын тогтолцоог хэрэгжүүлнэ.
 - б) Мал нэг бүрийг ялган тэмдэглэх нь чухал хэдий ч үйлдвэрлэлийн мөчлөгөөр ТОГТВОРТОЙ нэгжид ө.х. малаа таслаагүй, нэмээгүй, байгууламжаас төхөөрөлтөд аваагүй нэгжид бүлгийн түвшинд хэрэгждэг ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын тогтолцоотой байхад хангалттай.
 - в) Мөшгөн тогтоох тогтолцоо нь үйлдвэрлэлийн нэгжийн нэр, дугаар, байгууламж, малын тоо, компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн малын бүх бүлгийн ТОГТВОРТОЙ эсхүл ТОГТВОРГҮЙ статусыг тодорхойлох боломжтой байх ёстой.
 - г) Үйлдвэрлэлийн нэгж бүрийн малын тоо толгойг тогтмол (хамгийн багадаа: сар тутамд) тулган шалгаж баталгаажуулж, тоо зөрвөл шалтгааныг тогтоож байх хэрэгтэй.
 - д) Үйлдвэрлэлийн нэгж бүрийн орох, гарах бүх цэгт тодорхой тэмдэглэгээтэй биохамгааллын хаалт байрлуулна.
 - е) Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлд зориулсан цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх заавартай, тодорхой тэмдэглэгээ бүхий хэсэгтэй байна.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Үйлдвэрлэлийн тухайн нэгж, түүнд оноосон нэр, дугаар, байгууламж, малын тоо, ТОГТВОРТОЙ эсхүл ТОГТВОРГҮЙ аль статустай болохыг өдөр бүр бүртгэж тэмдэглэнэ.
 - б) Мал нэг бүрээ ялган тэмдэглэдэг, мөшгөн тогтоодог үйл ажиллагаатай (чухалчилна) компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид үйлдвэрлэлийн нэгж бүрээр мал нэг бүрийн хувийн ялгах тэмдэглэгээний дугаарыг бүртгэнэ.
 - в) Үйлдвэрлэлийн нэгж бүрийн орсон болон гарсан ажиллагсад, тоног төхөөрөмжийн бүртгэл.
 - г) Шилжүүлсэн тоног төхөөрөмжийн бүртгэлд түүнийг цэвэрлэж халдваргүйтгэсэн тухай баталгаа.
 - д) Малын тоо толгойг сар бүр тулган шалгасныг нотлох баримт

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Компанийн хамгаалалттай аж ахуйн ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоох тогтолцооны тодорхойлолт.
- ii. Үйлдвэрлэлийн нэгжүүдийн орох, гарах цэгт биохамгааллын хаалт хийх, ажиллагааг хангах заавар.
- iii. Биохамгааллын хаалтын хаяг, тэмдэглэгээ.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Date	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Нэг байгууламж 3-6 үйлдвэрлэлийн нэгжтэй байх зөвлөмж орсон..

В.12. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн ээлж хоорондын биохамгааллын заавар

Тодорхойлолт

Үргэлжилсэн үйл ажиллагаатай үйлдвэрлэлийн нэгжид тогтмол хугацаанд, түүнчлэн “бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” зарчмаар явуулсан үйлдвэрлэлийн төгсгөлд байр, тоног төхөөрөмжийг цэвэрлэж, халдваргүйтгэл хийхэд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал. Бэлчээрийн маллагаатай бол малын хашаа хороог болон арчлах маллахад хэрэглэдэг тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг тогтмол цэвэрлэж халдваргүйтгэх замаар биохамгааллын зааврыг хэрэгжүүлнэ.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Биохамгааллын зааврыг мал маллагааны тогтолцоод тохируулж өгснөөр малын байр болон/эсхүл мал арчилж малладаг бүх хэсэг эрүүл ахуйн сайн нөхцөл бүрдэнэ.

“Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” зарчим бүхий мал аж ахуйн үйлдвэрлэл нь үйлдвэрлэлийн төгсгөлд байр, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлийн мөчлөгийн нэг хэсэг болгон сайтар цэвэрлэж, халдваргүйтгэдэг болгоно.

Мал тасралтгүй хүлээн авч үйлдвэрлэл явуулдаг тогтолцоо нь байр, тоног төхөөрөмжийг тогтмол хугацаанд цэвэрлэж, халдваргүйтгэдэг болгоно. Тоног төхөөрөмжийг тогтмол хугацаанд бүрэн цэвэрлэж халдваргүйтгэх ажлыг үйлдвэрлэлийн мөчлөгтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Мал бэлчээрт байх хугацаанд ч тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, халдваргүйтгэдэг байна.

Мал маллаж байгаа нөхцөлд шавар шавхай байх нь зайлшгүй боловч малын байр, тоног хэрэгслээ эрүүл ахуйн шаардлага хангасан нь харагдахуйц цэвэр байлгах хэрэгтэй.

Жич: Хорио цээрийн байгууламж нь “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” тогтолцоод тохирсон байх ёстой (САЗ В2 лавлах).

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” менежмент
 - i) “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” зарчимд суурилсан үйлдвэрлэлийн нэгжийн үйлдвэрлэлийн ээлж бүрийн төгсгөлд байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийдэг удирдлага зохион байгуулалтын арга нь халдварт өвчин нэгж дотор тархах эрсдэлийг удирдах хамгийн сайн арга юм.
 - ii) Гадна талын эх үүсвэрээс мал байнга авч оруулдаг хэсэгт “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” үйлдвэрлэлийг удирдан хэрэгжүүлэхдээ хорио цээрийн дэглэм алдагдсаны улмаас онцгойлсон өвчин нэвтэрч болох аливаа нөлөөллийг удирдах асуудлыг авч үзэх хэрэгтэй (ЖИЧ: ийм байдалд хүрвэл байгууламжийн зөвшөөрөл тэр даруй цуцлагдана. Нэгж дотор өвчин тархахыг бууруулах нь өвчнийг устгах, зөвшөөрлөө дахин олж авахад тустай).
- б) Үйлдвэрлэлийн ээлж бүрийн төгсгөлд ЭСХҮЛ үйлдвэрлэлийн мөчлөгийн дагуу тогтоосон хугацаанд хийх байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл

- i) Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийхдээ: эхлээд бүх өтөг шавхай, хэвтшийг авч бүх гадаргуугаас ил харагдах органик зүйлийг ус, угаалгын шингэнээр угааж арилган халдваргүйтгэлийн бодисоор хэсэг зуур үйлчилсний дараа түүнийг зайлуулаад хатаана. Дараа нь мал, хэвтрийн материалыг шинээр оруулна.
- ii) “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” тогтолцоогоор ажиллаж байгаа үйлдвэрлэлийн нэгжийн үйлдвэрлэлийн ээлж бүрийн төгсгөлд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийнэ.
- iii) Гаднаас малыг бүлгээр нь тасралтгүй оруулдаг тогтолцоогоор ажиллаж байгаа байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг тогтмол хийхээр үйлдвэрлэлийн мөчлөгт оруулж программчилна.

2) Шаардлагыг хангах аргачлал

- а) Үйлдвэрлэлийн мөчлөг бүрд хийх цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг товлосон үйлдвэрлэлийн нэгж бүрийн үйлдвэрлэлийн мөчлөгийн тодорхойлолт
- б) Малын байр, малтай харьцахад ашигладаг тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх ажлын тодорхойлолт
- в) “Бүгдийг зэрэг оруулаад зэрэг гаргах” тогтолцоотой нөхцөлд дахин мал оруулахын өмнө эсхүл гаднаас мал тасралтгүй оруулдаг тогтолцоотой нөхцөлд тогтмол цэвэрлэгээ хийдэг мөчлөгтэй бол үйлдвэрлэлийн ээлж бүрийн дараа хийсэн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг газар дээр нь шалгаж баталгаажуулсан байдал

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацааны хамт).

- а) Малын бүх байр тоног төхөөрөмжид хийсэн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэл.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Малын байр, тоног төхөөрөмжид цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх ажлын тодорхойлолт
- ii. Малын байр, тоног төхөөрөмжид хийсэн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэлийн загвар.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.13. Биоаюулын эрсдэлийн удирдлага: Ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт

Тодорхойлолт:

Байгууламж дахь мал, түүнчлэн компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргах үед компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван болохын гэрчилгээнд хамрагдах мал, малын гаралтай бүтээгдэхүүний ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтод холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Үйлдвэрлэлийн нэгж бүр оноосон нэр, бүртгэлийн дугаартай (үйлдвэрлэлийн нэгжийн мал бүр ялгах тэмдэглэгээтэй бол бүр сайн) байх бөгөөд үйлдвэрлэлийн тогтолцооны дагуу мөшгөн тогтоох боломжтой болно. Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргаж байгаа (экспортыг оруулна) мал, бүтээгдэхүүнд олгох гэрчилгээг тодорхой нэг үйлдвэрлэлийн нэгж болон малд (илүү зохистой) зориулан олгодог болно. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж хооронд хийгдэх болон түүнд орох, гарах бүх шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлдэг болно.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Үйлдвэрлэлийн явц дахь ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж нь мал бүрийг үйлдвэрлэлийнхээ туршид ялган таних, мөшгөн тогтоох боломжтой байх ялган тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын тогтолцоо хэрэгжүүлнэ.
 - ii) Бодгаль мал бүрийг ялгах тэмдэглэгээг илүү чухалчилдаг хэдий ч үйлдвэрлэлийн бүх мөчлөг нь ТОГТВОРТОЙ буюу ө.х. төхөөрөлтөд шилжүүлэхээр байгуулсан бүлгийг хуваадаггүй, нэмдэггүй, авч хоцордоггүй (жишээ нь нэмж мал авах, эхээс ялгах) үйлдвэрлэлийн нэгжид малыг бүлгээр нь ялган тэмдэглэх, мөшгөн тогтоох тогтолцоо хэрэгжүүлэхэд хангалттай байна.
 - iii) Бодгаль малын тэмдэглэгээ (ө.х. эмнэх, ээмэглэх), бүлгийн тэмдэглэгээ, үйлдвэрлэлийн нэгжийн ялгах тэмдэглэгээг бусад удирдлагын болон биохамгааллын шинж байдал, үйл явдлыг бүртгэх боломж олгодог төвлөрсөн баримтат болон/эсхүл цахим системд бүртгүүлсэн байна.
 - iv) Мөшгөн тогтоох тогтолцоо нь ялгах тэмдэглэгээ, байгууламж, малын тоо болон компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж дахь аль ч цаг үеийн малын бүх бүлгийн статус ТОГТВОРТОЙ эсхүл ТОГТВОРГҮЙ аль нь байсан болохыг тодорхойлох боломжтой байх хэрэгтэй.
 - v) Үйлдвэрлэлийн нэгж болон байгууламж бүрийн малын бодит тоог тогтмол (хамгийн багадаа: сар тутам) баталгаажуулдаг байна.
- б) Боловсруулалтын явц дахь ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт (Компанийн хамгаалалттай аж ахуй дотор боловсруулж байгаа бол)
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуй дотроо төхөөрөх болон боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа бол ялган тэмдэглэх, мөшгөн тогтоох тогтолцоо нь үйлдвэрлэлээс эхлээд боловсруулалтын түршид мөшгөн тогтоох боломжтой

байх ба ө.х. үйлдвэрлэлтэй холбоо бүхий л бүртгэл нь боловсруулалтаас гарч байгаа гулууз мах эсхүл бүтээгдэхүүнтэй холбоотой байна.

- в) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас мал, бүтээгдэхүүн гаргах (экспорт орно) үеийн ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолт
- i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргаж байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүн хамгаалалттай аж ахуйд үйлдвэрлэсэн болон/эсхүл боловсруулсан гэдгийг ялгах тэмдэглэгээтэй байна.
- ii) Компанийн хамгаалалттай аж ахуйд үйлдвэрлэх, боловсруулахтай холбоотой удирдлага, зохион байгуулалт, биохамгааллын бүртгэл, тэмдэглэл нь компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргаж байгаа бүх мал, бүтээгдэхүүнтэй холбоотой байх хэрэгтэй.
- г) Байгууламж хооронд хийгдэх болон байгууламжид орох, гарах малын шилжилт хөдөлгөөнийг мөшгөн тогтоох бүртгэлийг МЭНС-д оруулна.
- i) Мөн түүнчлэн хамгаалалттай аж ахуйн байгууламж хооронд хийгдэх болон байгууламжид орох, гарах малын шилжилт хөдөлгөөнийг мөшгөн тогтоох компанийн тогтолцооны бүртгэлийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт оруулж баталгаажуулсан байна.

2) Шаардлага баталгаажуулах аргачлал

- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн ялган тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын тогтолцооны тодорхойлолт
- б) Дотоод хяналтын тогтолцооны хүрээнд болон хөндлөнгийн хяналт шалгалтын явцад компанийн хамгаалалттай аж ахуйн ялган тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын тогтолцоог баталгаажуулсан байдал.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Компани дахь ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын бүртгэл, тэмдэглэл (2 жил)
- б) МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсгийн бүртгэл (байнга)
- в) Хөндлөнгийн хяналт шалгалтын тайлан (2 жил).

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Компанийн хамгаалалттай аж ахуйн малын ялгах тэмдэглэгээ (имнэх, ээмэглэх) хийх бүдүүвч
- ii. Үйлдвэрлэлийн нэгжийн оноосон нэр, бүртгэлийн дугаар, байгууламж, статус нь **ТОГТВОРТОЙ** эсхүл **ТОГТВОРГҮЙ** эсэх, малын тоо, удирдлага, зохион байгуулалт, биохамгаалалд хийсэн хяналт шинжилгээний мэдээллийг оруулсан компанийн хамгаалалттай аж ахуйн мэдээллийн сан

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртгүүлэх шаардлагыг оруулсан.

В.14. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Зэрлэг амьтан, шувуу, хортон шавж, мэрэгчтэй тэмцэх

Тодорхойлолт:

Зэрлэг амьтан, шувуу, хортон шавж, мэрэгчийн нөлөөнөөс дээд зэргээр хамгаалахтай холбоотой шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Хамгаалалтын хил заагийн дагуу хашаа барьснаар зэрлэг амьтан болон бусад мал, амьтныг нэвтрүүлэхгүй байлгана.

Хамгаалалттай аж ахуйн байгууламжийн хэмжээнд хортон шавж, мэрэгчээс хамгаалах, хяналт-шинжилгээ хийх, тэмцэх арга хэмжээг өндөр-эрсдэл бүхий хэсэгт төвлөрүүлэн хэрэгжүүлдэг болно.

Малын байр, малтай харьцдаг хэсэг, тэжээлийн агуулах нь зэрлэг шувууны нөлөө хамгийн бага түвшинд байхуйц хийц бүтээцтэй, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалттай байна.

Жич: Шувуу онцгойлсон өвчин болох шүлхий болон БММӨ-д мэдрэмтгий биш боловч ялангуяа шүлхий зэрэг халдварлалт өндөртэй өвчний халдварыг гадаргуугийн бохирдлыг зөөн шууд бус замаар дамжуулна. Малыг байранд маллахаас өөрөөр зэрлэг шувууны нөлөөнөөс хамгаалах арга үндсэндээ байхгүй юм. Иймд малыг гадаа маллаж байх хугацаанд малын байр, байгууламжид зэрлэг шувуу татагдах, ойртох магадлалыг дээд зэргээр бууруулах нь энэхүү САЗ-ын зорьсон үр дүн байх болно.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Хамгаалалтын хил заагаар хашаа барих

- i) Нийт байгууламжийн хамгаалалтын хил заагийн уртаар үргэлжилсэн хашаа барина.
- ii) Байгууламжийн хамгаалалтын хил заагийн дагуу хашаалах нь зэрлэг болон бусад мал, амьтан нэвтрэхээс хамгаална. Давхар хашаалах болон/эсхүл хашаагаа цахилгаан хүчдэлд холбох аргыг авч үзэх хэрэгтэй. Байгууламжийн хамгаалалтын хил заагийн дагуу болон түүний дотуур хашаа барьж хослуулах нь гаднах мал, амьтныг хашаан доторх малтай ямар нэг байдлаар шууд харьцахаас хамгаална.
- iii) Мал, бусад амьтан орохоос хамгаалж тээврийн хэрэгсэл, ажиллагсад ордог, гардаг хэсгийг хаалгатай эсхүл тортой байлгана.

б) Малын байр, малтай харьцах хэсэг, тэжээлийн агуулахад зэрлэг шувуу нэвтрэн орохоос дээд зэргээр хамгаалах

- i) Мал малладаг/байлгадаг, малтай харьцдаг хэсэг, тэжээлийн агуулахын хийц бүтээц, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт нь шувууны нөлөөнд өртөх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах аргаар байх хэрэгтэй.
- ii) Байшингийн цонх, хаалга, агааржуулагчийг шувуу орохоос хамгаалж торлоно.
- iii) Задгай талбайд гаргах, ялангуяа мал гадаа тэжээх үеэр шувуу татагдах, ойртох эрсдэлийг хамгийн бага байлгах аргаар зохион байгуулна.

- iv) Малтай хэсэгт зэрлэг шувуу олноороо ирээд байвал тэднийг саатуулах, үргээх, ө.х. тор татах, дуу чимээ эсхүл механик аргаар үргээх арга хэрэглэнэ.
- в) Хортон шавж, мэрэгчээс хамгаалах, хяналт-шинжилгээ хийх, тэмцэх хөтөлбөр
 - i) Хортон шавж, мэрэгчид ялаа, ширх, бүүрэг, жоом, хачиг, хулгана, харх, суусар, сарьсан багваахай орно.
 - ii) Байгууламж бүрд хортон шавж, мэрэгчээс хамгаалах, хяналт-шинжилгээ хийх, тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
 - iii) Байшингийн эргэн тойронд хайрга, чулуу, тор ашиглан мэрэгч үүрлэхээс хамгаалж агааржуулагч, хаягдал усны хоолой, сувгийн ам, хөндий ханын амсрыг торлох.
 - iv) Малын байрны гадна талд өгөөш тавьж мэрэгч устгах ажил хэрэгжүүлэх.
 - v) Мэрэгч татагдах тэжээлийг хоржуулан мэрэгчийг барих, устгах ажил хэрэгжүүлж үр ашигт хяналт-шинжилгээ хийх.
 - vi) Малын байр, малтай харьцах хэсэгт эрүүл ахуй, ариун цэврийг сахих, үүний дотор хог хаягдлыг зайлуулах, өвс тэжээл хог ургамлыг бага байлгах.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Хамгаалалтын хил заагийн дагуу барьсан хашааны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгана.
 - б) Малын байр, малтай харьцах хэсэг, тэжээлийн агуулах шувуунаас хамгаалсан байдлыг тогтмол шалгана.
 - в) Хортон шавж, мэрэгчээс хамгаалах, хяналт-шинжилгээ хийх, тэмцэх баримтжуулсан хөтөлбөртэй байна.
 - г) Зэрлэг шувуу, мэрэгчийн хяналт-шинжилгээг тогтмол хийх бөгөөд хэрэв тэдгээрийн популяцийн тоо өсөж байгаа бол төлөвлөгөөг нягтлах, шинэчлэх удирдлагын арга хэмжээ авна.
 - д) Байгууламжид аливаа зэрлэг амьтан нэвтэрсэн бол шалтгааныг нь судлах бөгөөд биохамгааллын зөрчлийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай ноцтой үйл явдал гэж үзнэ.
- 3) Хадгалах бүртгэл, нотолгоо (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Хил заагаар татсан хашааг шалгасан дотоод хяналтын бүртгэл.
 - б) Шувууны хамгаалалтыг шалгасан дотоод хяналтын бүртгэл
 - в) Хортон шавж, мэрэгчтэй тэмцэх хөтөлбөрөөс хяналт-шинжилгээний тайлан.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Бүрэн бүтэн байдлыг шалгах гол цэгүүдийг (шувуунаас хамгаалах тор гэх мэт) заасан, мэрэгчийг хордуулах, барих цэгүүдийг тэмдэглэсэн барилга, хамгаалалтын хил заагийг харуулсан байгууламжийн газрын зураг.
- ii. Хортон шавж, мэрэгчээс хамгаалах, хяналт-шинжилгээ хийх, тэмцэх хөтөлбөрийн загвар.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.15. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Биохамгааллын зөрчлийн үед хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө

Тодорхойлолт:

Биохамгааллын ноцтой зөрчлийг тогтоох, бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, МЭЭГ-д мэдэгдэхэд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Биохамгааллын ноцтой зөрчилд хүргэж болзошгүй үйл явдлуудыг тодорхойлж, тэдгээрийн компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэн бүтэн байдалд учруулж болох эрсдэлийг дээд зэргээр багасгах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулсан байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Биохамгааллын ноцтой зөрчлийг тодорхойлох

i) Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын ноцтой зөрчилд дараах зүйл орно:

(1) Хамгаалалтын хил заагийн дотор зэрлэг амьтан нэвтэрснийг илрүүлсэн

(2) Компанийн хамгаалалттай аж ахуйд мал нийлүүлсэн аж ахуйд онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) тохиолдол эсхүл дэгдэлт тэрхүү аж ахуйгаас ачуулсан барааг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор батлагдсан (ө.х. хорио цээрийн хугацаанд)

б) Биохамгааллын ноцтой зөрчлийн үед хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах

i) Бэлэн байдлын төлөвлөгөөнд аюулыг олж тогтоох, аюулыг арилгах (хэрэв боломжтой бол) арга зам, гүнзгийрүүлсэн тандалт болон хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, байгууламжаас гаргаж байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд компанийн хамгаалалттай аж ахуйгаас олгох гэрчилгээг асуудал шийдвэрлэгдэх хүртэл түдгэлзүүлэх, нөхцөл байдал болон түүний өөрчлөлтийг МЭЭГ мэдэгдэх асуудлыг тодорхойлон оруулна.

ii) Байгууламжийн хамгаалалтын хил заагаас дотогш зэрлэг амьтан орж ирсэн боловч байгууламж доторх малтай ойртоогүй нөхцөлд байгууламжаас гаргаж байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгохыг 30 хоног түдгэлзүүлнэ. Байгууламж дахь мал бүхий үйлдвэрлэлийн бүх нэгжид малын ашиг шим буурах эсхүл өвчний эмнэл зүйн ямар нэг шинж тэмдэг илэрвэл гүнзгийрүүлсэн хяналт шинжилгээ хийнэ. Хэрэв эдгээр нь дараагийн 30 хоногт илрээгүй бол түдгэлзүүлэлтийг цуцлана.

iii) Байгууламжийн хамгаалалтын хил заагаас дотогш зэрлэг амьтан орж байгууламж доторх малтай ойр байсан нь батлагдсан нөхцөлд байгууламжаас гаргаж байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгохыг 30 хоног түдгэлзүүлнэ. Үйлдвэрлэлийн нэгжийн малтай ойр байсан зэрлэг амьтныг байгууламж

дээрээ тусгаарлаж дараагийн 14 хоногт өвчнийг судлан шинжилнэ. Байгууламж дахь мал бүхий үйлдвэрлэлийн бүх нэгжид малын ашиг шим буурах эсхүл өвчний эмнэл зүйн ямар нэг шинж тэмдэг илэрвэл гүнзгийрүүлсэн хяналт-шинжилгээ хийнэ. Хэрэв дараагийн 30 хоногт өвчин батлагдаагүй бол түдгэлзүүлснээ цуцлана.

- iv) Мал нийлүүлдэг аж ахуйд онцгойлсон өвчин батлагдвал хүлээн авсан бүх малд хорио цээрт оруулахад хийдэг тогтмолжсон шинжилгээ хийснээс хойш 14-өөс багагүй хугацаанд хорио цээрийн шинжилгээг давтан хийж болохоор тооцож хорио цээрийн хугацааг сунгана.
- v) Биохамгааллын ноцтой зөрчлийг мэдэгдэх, бэлэн байдлын төлөвлөгөө хэрэгжүүлэх
 - i) Дээрх аливаа нөхцөл байдалд компанийн хамгаалалттай аж ахуй МЭЕГ-т нөхцөл байдлаа болон байгууламжаас гаргаж байгаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд компанийн хамгаалалттай аж ахуйгаас гэрчилгээ олгохыг түдгэлзүүлсэн тухайгаа сар тутмын тогтмол тайланд оруулан мэдэгдэх бөгөөд үйл явдлыг шийдвэрлэсэн гэж үзэх хүртэл гүнзгийрүүлсэн хяналт-шинжилгээний үр дүнг сар бүр шинээр мэдээлнэ.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
Бэлэн байдлын баримтжуулсан төлөвлөгөөтэй байна.
- 3) Хадгалах бүртгэл, нотолгоо (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Биохамгааллын аливаа бүртгэгдсэн зөрчлийн судалгаа, шинжилгээ (2 жил)
 - б) Биохамгааллын аливаа бүртгэгдсэн зөрчлийн хяналт-шинжилгээний тайлан (2 жил)

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хяналт-шинжилгээний тайлангийн загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.16. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн гүйцэтгэлд хийх хяналт-шинжилгээ

Тодорхойлолт:

Малын эрүүл мэндийн асуудлыг эрт илрүүлэхийн тулд үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг хэмжих гол үзүүлэлтэд байнга хийх хяналт-шинжилгээнд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Үйлдвэрлэлийн нэгж, үйлдвэрлэлийн явцад хамаарах гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт, судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлэх шаардлагатайг илтгэх үзүүлэлтийг тодорхойлж, тэдгээрт байнга хяналт-шинжилгээ хийдэг байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтийг тогтоох, эрүүл мэндийн судалгаа шинжилгээ хийх шаардлагыг тодорхойлох үзүүлэлт
 - i) Өвчингүй, тайван үед үйлдвэрлэлийн өөр өөр нэгжийн үйл ажиллагааны хүлээгдэж буй гүйцэтгэлд хамаарах гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтийг тодорхойлно.
 - ii) Үржүүлгийн сүрэгт хамаарах гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд хээл авалт, хээл хаялт, тугаллалт/хургалалт/ишиглэлтийн түвшин; төлийн хорогдлын түвшин; тусад нь маллахаар эхээс салгах үеийн төлийн жин орно.
 - iii) Өсгөн үржүүлэх сүрэгт хамаарах гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд өсөлт (амьдын жин эсхүл биеийн өсөлтийг үнэлэх бусад арга); амьдрах чадвар, **тэжээл төлц** орно.
 - iv) Бүх сүрэгт хорогдол (үхсэн мал), өвчлөлийн (өвчтэй) түвшинд байнгын хяналт-шинжилгээ хийнэ. Мал хорогдох, өвчлөх үйл явдал бүрд анхаарал тавьж онцгойлсон өвчин биш болохыг ялгаварлана.
 - v) Малын гол өвчнөөр тайван нөхцөлд байгаа байгууламжийн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтийн хэвийн хэлбэлзлийг тооцоолон тогтооно.
 - vi) Малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээ хийхэд хүргэх хангалтгүй гүйцэтгэлийг илтгэх түвшинг тогтооно.
- б) Гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийх, бүртгэл тайлан бэлтгэх
 - i) Үйлдвэрлэлийн нэгж бүрд гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд хийх хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлнэ.
 - ii) Үйлдвэрлэлийн хяналт-шинжилгээний тогтолцоонд үйлдвэрлэлийн мөчлөгийн явц болон төгсгөлд наад зах нь нэг удаа шалгах цэг гаргаж өгдөг байхаар хяналт-шинжилгээний давтамжийг тогтооно.
 - iii) Гүйцэтгэл хангалтгүй байгааг илтгэх босго түвшинг давбал үйлдвэрлэлийн нэгжид мал эмнэлгийн судалгаа шинжилгээг эхлүүлнэ.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- a) Өөр өөр үйлдвэрлэлийн нэгжийн гүйцэтгэлийн гол үзүүлэлт, судалгаа шинжилгээг хийхэд хүргэх хангалтгүй гүйцэтгэлийг илтгэх босго түвшин, тэдгээрийг тодорхойлох арга зүй
 - b) Нотолгоо гаргаж чаддаг хяналт-шинжилгээний тогтолцоо
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацааны хамт).
- a) Үйлдвэрлэлийн нэгж бүрд гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийсэн бүртгэл тэмдэглэл
 - b) Зайлшгүй хийх болсон мал эмнэлгийн судалгаа шинжилгээний бүртгэл тэмдэглэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийх, бүртгэл тэмдэглэл хөтлөх загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр

Тодорхойлолт:

Үйлдвэрлэлийн нэгж бүр онцгойлсон өвчингүй (шүлхий болон БММӨ), тайван болохыг нотлон харуулах тандалтад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж болон үйлдвэрлэлийн нэгж бүр МЭЭГ-аас зөвшөөрсөн оношлох үйлчилгээ үзүүлэгч болон оношилгооны аргаар идэвхтэй тандалт явуулах замаар үйлдвэрлэлийн нэгж дэх малын төрөлд хамаарах онцгойлсон өвчингүй, тайван болохоо (шүлхий болон БММӨ) (ө.х. үхэрт шүлхий; хонь, ямаанд: шүлхий болон БММӨ) нотлон харуулах чадвартай байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэгчтэй тандалтын гэрээ байгуулна.
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуй бүр МЭЭГ-аас зөвшөөрсөн оношлох үйлчилгээ үзүүлэгчтэй оношлох шинжилгээ хийлгэх гэрээ байгуулна.
 - ii) Гэрээнд илгээх сорьцын төрөл, тоо, давтамжийг зааж, илрүүлэх шинжилгээнд сорьцыг нийлүүлж шинжлэх эсэх, ямар шинжилгээ хийх талаар тохиролцоно.
- б) Өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны төлөвлөгөөг байгууламж болон үйлдвэрлэлийн нэгж тус бүрээр боловсруулж, хэрэгжүүлнэ. Дор тодорхойлсноор тогтвортой үйлдвэрлэлийн нэгжид тархалт 0.1, аль эсхүл тогтворгүй үйлдвэрлэлийн нэгжид 0.03 тархалттай байх нөхцөлд өвчингүй, тайван болох нь 95%-ийн үнэмшилтэй байхаар тандалтын загвартай байна. Ерөнхийдөө ижил үр дүнд хүрэх өөр тандалтын загвар ашиглах боломжтой бөгөөд тандалтын өөр загваруудын талаарх зааварчилгааг авах боломжтой.
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн нэгж бүр өвчингүй, тайван болохоо нотлох шинжилгээнд үйлдвэрлэлийн нэг мөчлөгийн хугацаанд нэгээс доошгүй эсхүл наад зах нь зургаан сар тутамд сорьц цуглуулна. Компанийн хамгаалалттай аж ахуйгаас мал гаргахаас өмнө (худалдах эсхүл төхөөрөх) эсхүл малын гаралтай бүтээгдэхүүн экспортлохоос өмнө өвчингүй, тайван болохоо нотлох шинжилгээнд сорьц цуглуулж үр дүнг мэдээлсэн байх ёстой.
 - (1) Компанийн хамгаалалттай аж ахуй дотроо мал төхөөрдөг бол өсвөр малаас төхөөрөлтийн үед сорьц авч болно.
 - ii) Үйлдвэрлэлийн нэгж өвчингүй, тайван болохоо нотлох шинжилгээнд сорьц цуглуулахаас өмнөх 30 хоногт ТОГТВОРТОЙ байсан бол тархалтыг 0.1 байхаар тооцон тандалтын загвараа гаргаж энгийн санамсаргүй түүврийн арга хэрэглэнэ.
 - iii) Хэрэв ТОГТВОРГҮЙ үйлдвэрлэлийн нэгж өвчингүй, тайван болохоо нотлох шинжилгээнд сорьц цуглуулсан бол тархалтыг 0.03 байхаар тохируулах ёстой.
 - iv) ТОГТВОРТОЙ үйлдвэрлэлийн нэгжид түүврийн хэмжээ нь санамсаргүй сонгосон 30 мал байна. (таамаглал: загварчилсан тархалт =0.1; бүлгийн

- хэмжээ <1000; аргын мэдрэх чанар =0.99; аргын өвөрмөц чанар =1; популяцид шаардлагатай мэдрэх чанар =0.95).
- v) ТОГТВОРГҮЙ үйлдвэрлэлийн нэгжид түүврийн хэмжээ нь санамсаргүй сонгосон 96 мал байна. (таамаглал: тархалт=0.03; бүлгийн хэмжээ <1000; аргын мэдрэх чанар =0.99; аргын өвөрмөц чанар =1; популяцид шаардлагатай мэдрэх чанар =0.95).
 - vi) Сорьцын төрөл нь оношлох үйлчилгээний лабораторийн хийсэн зохион байгуулалтаас хамаарч түүвэрт сонгогдсон мал бүрээс авах ямар нэг нэмэлтгүй хуруу шилэнд авсан бүхэл цус эсхүл хамар залгиурын арчдас байна.
 - vii) Сорьцын ялгах тэмдэглэгээг сорьц авсан хуруу шил дээр нь шууд бичих аль эсхүл дараах мэдээллийг тайлж унших боломжтой код бэхэлж өгнө. Үүнд: сорьц авсан огноо, малын ялгах тэмдэглэгээний мэдээлэл (чухалчилна), үйлдвэрлэлийн нэгж (заавал), онцгойлсон өвчнөөс хамгаалах дархлаажуулалтын байдал, Оролцогч компанийн байгууламж.
 - viii) Үйлдвэрлэлийн нэгжийн бүх сорьцыг сайтар хамгаалж хүйтэн хэлхээний нөхцөл бүрдүүлэн савлаад (хагарах, асгарахаас хамгаалан давхар савлана) оношлох шинжилгээ хийлгэх хүсэлт бүхий зохих маягтын хамт бэлтгэж 48 цагийн дотор лабораторид хүргэхээр яаралтай илгээнэ.
- в) Тайван болохыг нь зарлан мэдэгдэх өвчнийг оношлох шинжилгээ
- i) Байгууламж эсхүл үйлдвэрлэлийн нэгж бүрээс авсан судалгааны бүх сорьцыг оношлох үйлчилгээ үзүүлэгчийн лабораторид бүгдийг хамтад нь нэгэн зэрэг өгнө. Ингэснээр лабораторийн үр дүнгийн маягтад бүх үр дүн хамтдаа бичигдэнэ.
 - ii) Байгууламж эсхүл үйлдвэрлэлийн нэгж бүрээс авсан судалгааны бүх сорьцыг тухайн хамгаалалттай аж ахуйн зарлан мэдэгдэх өвчин тус бүрээр (шүлхий болон БММӨ) шинжилнэ.
 - iii) Хэрэглэх оношилгооны шинжилгээ нь илрүүлэх эсхүл баталгаажуулах батлагдсан шинжилгээ байж болно (А8. Лабораторийн оношлох үйлчилгээ хэсгээс лавлана уу).
 - iv) Онцгойлсон өвчний эсрэг дархлаажуулалт хэрэглэж байсан байгууламж эсхүл үйлдвэрлэлийн нэгжид өвчингүй, тайван болохыг нотлох шинжилгээ хийх бол халдвартай малыг дархлаажуулсан малаас ялгах боломжтой оношилгооны арга хэрэглэнэ.
 - v) Илрүүлэх шинжилгээг УТ-ПГУ-д суурилан хийх бол шинжилгээний тоо, өртгийг (ө.х. зардлын үр өгөөж) бууруулах үүднээс лабораторитой тохиролцон 5 хүртэл сорьцыг нийлүүлэн шинжилж болно. Сорьцыг аж ахуй дээр бус лабораторид нийлүүлж бэлтгэнэ. Нийлүүлсэн дээж сөрөг дүн үзүүлбэл нийлүүлсэн дээж тус бүрийг сөрөг гэж үзнэ. Нийлүүлсэн дээж эерэг гарвал нийлүүлсэн дээж бүрийг тусад нь шинжилж түүний үр дүнгээр эерэг эсхүл сөрөг гэж хариу гаргана.
 - vi) Өвчингүй, тайван болохыг нотлон харуулах судалгаанд байгууламж болон үйлдвэрлэлийн нэгжээс авсан бүх дээжид хийсэн оношлох шинжилгээний үр дүнг лаборатори аль болохоор саатуулалгүй мэдээлнэ.
 - vii) Оношлох шинжилгээний үр дүнг оролцогч компанид хүргүүлэхийн зэрэгцээ оношлох үйлчилгээ үзүүлэгч нь ЭЕРЭГ үр дүнтэй сорьцын талаар МЭЭГ-т мэдэгдэх замаар хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- г) Үр дүнг мэдэгдэх.
- i) Оролцогч компани өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны үр дүнг МЭЭГ-т мэдэгдэнэ.

Бүгд СӨРӨГ дүн үзүүлбэл, мал, малын гаралтай бүтээгдэхүүнд өвчингүй, тайван болохыг батлах гэрчилгээ олгож экспортлох (үндэсний экспортын протоколын дагуу) зэргээр компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргахыг зөвшөөрч болно.

ii) ЭЕРЭГ ямар ч дүн үзүүлбэл:

- (1) Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу МЭЕГ-т мэдэгдэх
- (2) Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг цуцална.
- (3) Компанийн хамгаалалттай аж ахуй цаашид гэрчилгээ олгохгүй.
- (4) Гарсан өвчний эсрэг авах бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг идэвхжүүлж, өмнөх 30 хоногт компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгосон хэрэглэгчдэд мэдэгдэнэ.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- a) Өвчингүй, тайван компанийн хамгаалалттай аж ахуйгаас мал, малын гаралтай бүтээгдэхүүн гаргахаас өмнө болохыг нотлох судалгаанаас гарсан сөрөг үр дүнг баталгаажуулна.
- b) Өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны үйл явц, үр дүнг хөндлөнгийн хяналт шалгалтын үеэр түүний бүртгэл, тэмдэглэлийг үзэж нягтлан шалгана.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- a) Компанийн хамгаалалттай аж ахуй болон эрх бүхий оношлох үйлчилгээ үзүүлэгч хооронд байгуулсан оношлох шинжилгээний үйлчилгээ үзүүлэх гэрээ;
- b) Байгууламж болон түүний үйлдвэрлэлийн нэгж бүрд хийх өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны төлөвлөгөө;
- c) Өвчингүй, тайван болохыг нотлох судалгаа бүрд зориулж авсан сорьцын бүртгэл;
- d) Өвчингүй, тайван болохыг нотлох судалгаа хийх бүрд лабораторийн илгээх хуудасны маягт (хувь);
- e) Өвчингүй, тайван болохыг нотлох судалгаа бүрийн лабораторийн шинжилгээний үр дүнгийн маягт.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. МЭЕГ зөвшөөрөл олгосон оношлох үйлчилгээ үзүүлэгчийн жагсаалт
- ii. МЭЕГ зөвшөөрөл олгосон оношлох шинжилгээний арга
- iii. Өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны явцад сорьц бүртгэх загвар.
- iv. Лабораторид илгээх сорьцыг савлах, илгээх заавар.
- v. Лабораторид илгээх хуудасны маягт.
- vi. Хэсэг С. Оролцогч компани болон эрх бүхий лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэгч хооронд байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар.
- vii. Хэсэг С. УМЭАЦТЛ-ийн оношилгооны чадавх, үнийн мэдээлэл
- viii. Хэсэг С. Өвчингүй, тайван болохыг нотлох өөр хувилбар судалгааны зөвлөмж.
- ix. Хэсэг С. Лабораторийн оношлох үйлчилгээний хэрэгцээг шаардлагыг тогтоох үйл явц.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Орсон өөрчлөлт: Хэсэг С. УМЭАЦТЛ-ын оношилгооны чадавх, үнийн мэдээлэл

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар

Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

72

Хувилбар: 0.3

В.18. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Дархлаажуулалх хөтөлбөр

Тодорхойлолт:

Онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) эсрэг дархлаажуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Онцгойлсон өвчинд (шүлхий болон БММӨ) холбогдох эрсдэлийг удирдахад зориулан компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлдэг байна.

Онцгойлсон өвчний эсрэг дархлаажуулалт хийх шийдвэрийг хуулийн шаардлага (тухайлбал: Монгол улсын хууль тогтоомж, үндэсний стратеги, МЭЭГ-ын техникийн стандарт), компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн орших газар зүйн бүсэд хэрэглэх МЭЭГ-ын зөвлөмж, халдварт өвчинд өртөх магадлал, түүний үр дагаварт холбогдуулан оролцогч компанийн өөрийн хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн гаргадаг байна.

Дархлаажуулалт хэрэгжүүлэхээр бол вакцин үйлдвэрлэгчид МЭЭГ-аас зөвшөөрөл авсан, вакцин нь бүртгэгдсэн байх ба дархлаажуулалтыг үйлдвэрлэгчийн зөвлөмж, дотоодын хууль тогтоомжийн заалт болон/эсхүл МЭЭГ-ын удирдамжаар хэрэгжүүлдэг байна. Дархлаажуулалтын дараа хяналт-шинжилгээг тогтмол хугацаанд хийж популяцийн дархлаа хамгийн багадаа 70% хүрсэн эсэхийг нотлон харуулдаг байна.

Дархлаажуулалт хэрэгжүүлж байгаа бол компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэл болон МЭНС-ийн дархлаажуулалтын хэсэгт бүртгүүлдэг байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулалтын хөтөлбөр боловсруулах
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид дархлаажуулалт хэрэглэж болох эсэх тус улс, бүсэд хэрэгжүүлэх хууль журмын заалтыг судалж компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулах хөтөлбөрийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу боловсруулна.
 - ii) Хууль тогтоомжид дархлаажуулах хөтөлбөрт тавигдах шаардлагыг заагаагүй тохиолдолд компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулах хөтөлбөрийн зорилго, тавигдах шаардлагыг вакцин үйлдвэрлэгчийн зөвлөмж аль эсхүл эрсдэлийн тусгайлсан үнэлгээнд тулгуурлан тодорхойлно. Жишээ нь компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулалтын хөтөлбөр боловсруулахад харгалзах эрсдэлийн дүн шинжилгээнд байгууламжид болон тухайн орон нутагт гарсан өвчний түүхэн баримт, өвчин үүсгэгч нутгийн омог, тэдгээрийн эсрэг хэрэглэсэн янз бүрийн вакцины үр нөлөө, өвчнөөс хамгаалахад хамгийн их ач холбогдолтой байж болох популяци; дархлаажуулалт эхлэхэд эхийн дархлаа нь нөлөөлж болзошгүй нас, өөр өөр эмгэг төрүүлэгчийн эсрэг хэрэглэх вакцины харилцан нөлөөллийг харгалзан үзнэ.

- iii) Шүлхий болон БММӨ-ий эсрэг дархлаажуулах ердийн хөтөлбөрийг 4 дүгээр хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. Хамгаалалттай аж ахуй байгуулах үндэсний хөтөлбөрийн дархлаажуулалтын шаардлагыг харгалзан үзсэн дархлаажуулах хөтөлбөрийн зөвлөмж, янз бүрийн эх үүсвэрээс нийлүүлэх вакцин

Өвчин	Эхний олголт	Сэргээх тун	Нас гүйцсэн	Эсрэгтөрөгч	Хадгалалт
Шүлхий	малд 14 хоногийн бойжилттой байхаас эхлээд	4-5 долоо хоногийн дараа	6 сар тутамд	Тухайн бүс нутагт эргэлдэж байгааг нь тогтоосон вируст тохирно гэж сонгон идэвхгүйжүүлсэн омгууд	2-8°C
БММӨ	3 сар орчмын бойжилттой хурга, ишгэнд нэг тун	1 настайд нь сэргээх тун олгоно	Өвчин гарсан үед зөвхөн нас гүйцсэн малд эсхүл дархлаажуулсан эсэх нь тодорхойгүй малд.	Сулруулсан амьд вируст вакцин.	2-8°C

б) Зөвшөөрөлтэй вакцин сонгон авах

Компанийн хамгаалалттай аж ахуй нь дараах шаардлага хангасан вакцин нийлүүлэх гэрээг малын вакцины найдвартай үйлдвэрлэгчтэй байгуулна: Санал: Энэ зохицуулалт боломжгүй. Гоцын вакциныг зөвхөн улс өөрөө сонгож авах зохицуулалт үйлчилж байгаа. Иймд захиалга өгөх асуудлаар эхний ээлжинд тусгах

- i)
- (1) МЭЕГ-ын дэргэдэх Малын эмийн салбар зөвлөлөөс олгосон бүртгэлтэй, малд хэрэглэж болох зөвшөөрөлтэй,
 - (2) ДМАЭМБ-ын Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын дагуу үйлдвэрлэсэн,
 - (3) Үйлдвэрлэлийн зохистой дадлын дагуу, ISO9001 чанарын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэн ажилладаг үйлдвэрт үйлдвэрлэсэн.
- ii) Нийлүүлэлтийн гэрээ нь дархлаажуулах хөтөлбөрийн дагуу компанийн хамгаалалттай аж ахуйн хэрэгцээг бүрэн хангаж чадахаар байна.
- в) Дархлаажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- i) Компанийн хамгаалалттай аж ахуйд нийлүүлсэн вакциныг бараа материал хариуцсан этгээд хүлээн авч түүний цувралын дугаар, хүлээн авсан огноо, хүчинтэй хугацааг бүртгэж авна.
 - ii) Вакциныг малд хэрэглэх хүртэл бараа материал хариуцсан нэгжид үйлдвэрлэгчийн зөвлөсөн нөхцөлд хадгална. Цахилгаан тасрах үед ашиглах цахилгааны үүсгүүр бэлдсэн байх хэрэгтэй. Вакцины хадгалалтын горим хэвийн байгаа эсэхийг хяналт-шинжилгээгээр баталгаажуулна.
 - iii) Компанийн хамгаалалттай аж ахуйн дархлаажуулах хөтөлбөр болон вакцин үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу мал дархлаажуулна.
- г) Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээг жил бүр эсхүл өөр үндэслэлээр түүний давтамжийг өөрчлөн явуулах
- i) Байгууламжид онцгойлсон өвчний эсрэг дархлаажуулалт хийхдээ дархлаажуулсан зорилтот популяцийг төлөөлөх судалгаа хийж дархлаажуулах хөтөлбөр хэрэгжүүлснээр популяцид хангалттай дархлаа тогтоосон эсэхийг баталгаажуулна.
 - ii) Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээ судалгааг онцгойлсон өвчин тус бүрээр хийх ба энэ нь байгууламжийн дархлаажуулах хөтөлбөрөөс хамаарна. Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээний давтамжийг

байгууламж болон хамгаалалттай аж ахуй стратегийн болон эпидемиологийн нөхцөл байдлыг үндэслэн өөрчилнө.

- iii) Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээ судалгаагаар зорилтот популяци дахь ийлдэс судлалын таньцын тархалт наад зах нь 70% болохыг нотлон харуулна .
 - iv) Зорилтот популяцийн мал 2000-аас их бол түүврийн хэмжээ 61 (таамаглал: загвар тархалт= 80%; алдаа= 10%).
 - v) Зорилтот популяцийн мал 2000-аас их бол түүврийн хэмжээ багасах ба дараах томъёогоор тооцоолно: $n = (1.96^2/d^2) \times p(1-p)$; n нь түүврийн хэмжээ, d нь алдаа, p нь 80% гэж таамагласан тархалт
- д) Дархлаа тогтцыг илэрхийлэх ийлдэс судлалын таньц 70% хүрэхгүй байвал дархлаажуулах хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг нягталж үзээд ийм үр дүн гарсны шалтгааныг тогтооно.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Компанийн хамгаалалттай аж ахуй дархлаажуулах хөтөлбөртэй эсэхийг баталгаажуулна.
 - б) Малын вакцин **үйлдвэрлэгчтэй** хийсэн нийлүүлэлтийн гэрээтэй эсэхийг баталгаажуулна.
 - в) Вакцины ачилт нэг бүрийг бараа материал бүртгэж авахад тавигдах шаардлагын дагуу хүлээн авсан эсэхийг баталгаажуулна.
 - г) Нөөцөд байгаа вакцины хадгалалтын нөхцөлийг долоо хоног тутамд хянан шалгана.
 - д) Хөндлөнгийн хяналт шалгалт хийх үеэр баримт бичиг, вакцины нөөц, түүний бүртгэлийг шалгах замаар дархлаажуулах хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг хянан үзнэ.
 - е) Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээ судалгааны дүнг хянан үзнэ.
- 3) Хадгалах бичиг баримт, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Вакцин үйлдвэрлэгч вакцины зөвшөөрлийн шаардлага хангаж байгааг нотлох баримт.
 - б) Хүлээн авсан вакцины ачилтын баримт бичиг.
 - в) Байгууламж дахь вакцины нөөцийн бүртгэл
 - г) Үйлдвэрлэлийн нэгжийн малын дархлаажуулалтын бүртгэл
 - д) Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээ судалгааны үр дүн.
 - е) Байгууламжид хийгдсэн дархлаажуулалтын бодит байдалтай нийцэх эсэхийг баталгаажуулах МЭНС-ийн дархлаажуулалтын хэсэгт орсон бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Дархлаажуулах хөтөлбөрийн төлөвлөлгөө
- ii. Байгууламж дахь вакцины нөөцийн бүртгэлийн загвар.
- iii. Байгууламжид хадгалаж байгаа вакцины хадгалалтын нөхцөлд хяналт-шинжилгээ хийх загвар.
- iv. Хийгдсэн дархлаажуулалтын бүртгэлийн загвар.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

25/04/2024	0.2	Дархлаажуулалтын дараах хяналт-шинжилгээний давтамжийг жил бүр тогтоохын оронд стратегийн болон эпидемиологийн нөхцөл байдлыг үндэслэн тогтоохоор, Дархлаажуулалтын бодит байдал МЭНС-ийн дархлаажуулалтын хэсгийн бүртгэлтэй нийцэж байх зэрэг өөрчлөлтүүд орсон

Zero Draft

В.19. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Эмчилгээний хөтөлбөр

Тодорхойлолт:

Мал эмчлэх болон эмийн бүтээгдэхүүн, түүний дотор антибиотик, шимэгчийн эсрэг эм, үрэвслийн эсрэг, өвчин намдаах эмд тавих шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Мал эмчлэх болон эмийн бүтээгдэхүүнийг найдвартай үйлдвэрлэгчээс болон нийлүүлэгчээс авч малын эмчийн жор, зөвлөгөөний дагуу хэрэглэж үнэн зөв бүртгэл хөтөлж, төхөөрөхөөс өмнө хүлээх хугацааг дагаж мөрддөг байна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Мал эмчлэх болон эмийн бүтээгдэхүүн сонгон авах
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуй нь дараах шаардлага хангасан мал эмчлэх болон мал эмнэлгийн бүтээгдэхүүн нийлүүлэх найдвартай **үйлдвэрлэгчтэй** байгуулна:
 - (1) МЭЕГ-ын дэргэдэх Малын эмийн салбар зөвлөлөөс олгосон бүртгэлтэй, малд хэрэглэж болох зөвшөөрөлтэй,
 - (2) Үйлдвэрлэлийн зохистой дадлын дагуу, ISO9001 чанарын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэн ажилладаг үйлдвэрт үйлдвэрлэсэн.
 - б) Мал эмнэлгийн хяналт, зааварчилгаа,
 - i) Мал эмчлэх эмийн бүтээгдэхүүнийг малын эмчийн зөвлөсний дагуу боловсруулсан өвчнөөс сэргийлэх, тэмцэх, эмчлэх төлөвлөгөөний дагуу хэрэглэнэ.
 - ii) Төрөлжүүлэн өсгөн үржүүлдэг янз бүрийн малын эрүүл мэндийг хамгаалах батлагдсан төлөвлөгөөний дагуу мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнийг байнга болон тогтоосон хугацаанд хэрэглэнэ.
 - iii) Өвчтэй малыг яаралтай илрүүлж малын эмчийн үзлэг хийн онош тогтоож хийх эмчилгээг төлөвлөнө.
 - в) Төхөөрөлтийн өмнөх хүлээх хугацаа
 - i) Мах, бусад бүтээгдэхүүнд малын эмийн бүтээгдэхүүн үлдэхээс сэргийлж төхөөрөлтийн өмнө малын эм гадагшлах тогтоосон хугацааг хүлээнэ. Энэ хугацааг “хүлээх хугацаа” гэх ба малын эм тус бүрд өөр байна.
 - ii) Малын зарим эмд дээрх хүлээх хугацаа нь тодорхойгүй байвал энэ хугацааг мах бэлтгэлд төхөөрөх малд 63 хоногоор тооцно.
 - iii) Төхөөрөлтийн өмнөх хүлээх хугацаанд эмийн эмчилгээ хийсэн ямар ч малыг тодорхой ялган тэмдэглэх ба энэ нь төхөөрөлтөөс гарах бүтээгдэхүүнийг хэрхэхийг шийдвэрлэх боломж олгоно.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Малын эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөө боловсруулж малын эмчийн зөвшөөрөл авсан байна.
- б) Үйлдвэрлэлийн нэгжээс төхөөрөлтөд оруулахаар мал шилжүүлэхийн өмнө хийсэн эмчилгээний бүртгэлийг шалгаж малын эмийн бүтээгдэхүүн хэрэглэснээс

хойш хүлээх хугацаа өнгөрөөгүй байхад нэг ч мал шилжүүлээгүй болохыг баталгаажуулсан байна.

- 3) Хадгалах баримт бичиг, нотлох барим (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Малын эмийн бүтээгдэхүүн нийлүүлэгчийн **үйлдвэрлэгчийн** жагсаалт, үйлдвэрлэгчийн нэрээр
 - б) Үйлдвэрлэлийн нэгжид тусгайлан тогтоосон хугацаанд болон шаардлага гарсан үед эм хэрэглэсэн бүртгэл.
 - в) Өвчтэй мал, түүнийг үзсэн, оношилсон, эмчилсэн бүртгэл.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Малын эрүүл мэндийн удирдлагын төлөвлөгөөний загвар
- ii. Үйлдвэрлэлийн нэгж дээр хийсэн эмчилгээний бүртгэл хөтлөх загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.20. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх, удирдах

Тодорхойлолт:

Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх, удирдахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт, өвчлөл (өвчтэй мал), хорогдол (үхсэн мал)-д хяналт-шинжилгээг тасралтгүй хийх тогтолцоотой байна. Малын эрүүл мэндийн үйл явдлыг малын эмч шинжлэн судалдаг байна. Хэрэв онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) сэжиг илэрвэл сэжиглэсэн өвчтэй малаас сорьц авч онцгойлох өвчин мөн эсэхийг тогтоолгохоор оношлох үйлчилгээ үзүүлэгчид илгээдэг байна..

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Үйлдвэрлэл, өвчлөл, хорогдолд тасралтгүй хийх хяналт-шинжилгээ
 - i) Үйлдвэрлэлийн гол үзүүлэлт, өвчлөл (өвчтэй мал), хорогдол (үхсэн мал)-д хийх хяналт-шинжилгээг тогтмол хийх ба үйлдвэрлэлийн нэгж бүрд тогтоосон хугацаанд үе үе хийнэ.
 - ii) Үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт урьдчилан тогтоосон босго түвшнээс давсан тохиолдлыг малын эрүүл мэндийн үйл явдал гэж үзэх ба мал эмнэлгийн судалгаа шинжилгээг эхлүүлнэ.
 - iii) Учир нь олдохооргүй аливаа өвчлөл, хорогдол гарсан тохиолдлыг малын эрүүл мэндийн үйл явдал гэж үзэх ба мал эмнэлгийн судалгаа шинжилгээг эхлүүлнэ.
- б) Малын эрүүл мэндийн үйл явдал нь мал эмнэлгийн судалгаа шинжилгээ хийхэд хүргэнэ.
 - i) Малын эрүүл мэндийн үйл явдалд мал эмнэлгийн судалгаа шинжилгээ хийхийн зорилго нь оношлох, эмчилгээг боловсруулах малын эрүүл мэндийн төлөвлөгөөнд бодитой сайжруулалт хийхэд оршино.
 - ii) Өвчтэй мал оношлох, эмчлэх мал эмнэлгийн судалгаа шинжилгээний үеэр малын эмч өөрийн мэргэжлийн дүгнэлтээ гаргана.
 - iii) Онцгойлсон өвчний эмнэл зүйн шинж тэмдэг (амьдад нь хийсэн үзлэгээр) эсхүл бие бүтцийн эмгэг өөрчлөлт (задлан шинжилгээгээр тогтоосон) үзүүлсэн ямар ч малыг сэжигтэй тохиолдолд тооцох ба цус, эдийн сорьцыг лабораторид шинжилж ялгаварлах оношилгоо хийнэ.
- в) Онцгойлсон өвчнийг ялгаварлахад зориулан өвчний сэжигтэй тохиолдлоос сорьц авах
 - i) Сэжигтэй тохиолдлоос цус, эдийн сорьц авч шаардлагын дагуу савлаж лабораторид сорьц илгээх дагавар бичгийн хамт нэн даруй илгээн онцгойлсон өвчнийг ялгаварлан оношлох хүсэлт гаргана.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуйд гарсан өвчний сэжигтэй тохиолдлоос сорьц илгээснийг хүлээн авч түүнийг удаалгүйгээр боловсруулах талаар оношлох үйлчилгээ үзүүлэгчид урьдчилан мэдээлнэ.

- iii) Оношлох үйлчилгээ үзүүлэгч онцгойлсон өвчнийг ялгаварлан оношлох илрүүлэх эсхүл баталгаажуулах шинжилгээг малын эмч/оролцогч компанийн хүсэлт, өөрсдийн мэргэжлийн байр суурь аль алийг харгалзан явуулна.
- г) ЭЕРЭГ үр дүнг МЭЕГ-т мэдэгдэх
 - i) Онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) аливаа ЭЕРЭГ үр дүнг:
 - (1) Хууль журмаар хүлээсэн үүргийн дагуу МЭЕГ-т мэдэгдэнэ.
 - (2) Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг хүчингүй болгоно.
 - (3) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас цаашид гэрчилгээ олгохыг зогсооно.
 - (4) Өвчний үйл явдалд зориулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг идэвхжүүлэхийн хамт өмнөх 30 хоногт компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ хүлээн авсан аливаа хэрэглэгчдэд мэдэгдэнэ.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Үйлдвэрлэлийн нэгж бүрийн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт, өвчлөл хорогдлын хяналт-шинжилгээний тогтолцоог дотоод хяналтын тогтолцоонд төвлөрүүлэн хянан үзнэ.
 - б) Хөндлөнгийн хяналт шалгалт хийх үеэр өвчний сэжигтэй бүх тохиолдлыг тогтоон, хянан үзнэ.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа)
 - а) Үйлдвэрлэлийн нэгж бүрийн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт, өвчлөл, хорогдлын хяналт-шинжилгээний бүртгэл, тайлан
 - б) Өвчний сэжигтэй тохиолдлын мал эмнэлгийн судалгаа шинжилгээний тайлан
 - в) Өвчний сэжигтэй тохиолдлын лабораторийн шинжилгээний дүн

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хэсэг С. Оролцогч компани болон эрх бүхий лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэгчийн хооронд байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар.
- ii. Хэсэг С. УМЭАЦТЛ-ийн оношилгооны чадавх, үнийн мэдээлэл
- iii. Хэсэг С. Лабораторийн оношлох үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тогтоох үйл явц
- iv. ДМАЭМБ Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлагын 3.1.8-р бүлэг Шүлхий, 3.8.9-р бүлэг БММӨ.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Орсон өөрчлөлтүүд: Гарцын хяналтын талаарх Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний үг хэллэг Хэсэг С. УМЭАЦТЛ-ын оношилгооны чадавх, үнийн мэдээлэл

В.21. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Бичил биетний эсрэг эмийн болгоомжтой хэрэглээ

Тодорхойлолт:

Бичил биетний эсрэг эмийн нийцэмжтэй хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуй нь ДМАЭМБ-ын олон улсын стандарт, удирдамжид нийцсэн бичил биетний эсрэг эмийн болгоомжтой хэрэглээг дэмжих баримтжуулсан хөтөлбөртэй байна. Малын өвчнөөс сэргийлэх, тэмцэхэд бичил биетний эсрэг эмийн тогтмол хэрэглээг хамгийн бага түвшинд байлгана. Малын өвчнийг малын эмчийн дүгнэлтийн дагуу тавьсан онош, заасан эмчилгээ, зааварчилгааг баримтлан эмчилдэг болно.

Жич: Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ0) фторхинолоний бүлэг, 3 ба 4-р үеийн цефалоспорин, колистинд тусгайлан дараах зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Малд эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй байхад өвчнөөс сэргийлэх зорилгоор тэжээл усанд нь нэмэх замаар хэрэглэхгүй байх;
- Нэгдүгээр эгнээний эмийн эмчилгээнд үндэслэлгүйгээр үл хэрэглэх, хоёрдугаар эгнээний эмээр хэрэглэхдээ бактер судлалын шинжилгээний дүнг үндэслэх;
- Шошгын зааварт ороогүй заалтаар хэрэглэхийг хязгаарлаж өөр аргагүйд хүрвэл хэрэглэхээр тооцох, ингэж хэрэглэхдээ дотоодын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг мөрдөх;
- Тэдгээрийг өсөлт идэвхжүүлэгчээр хэрэглэхийг яаралтай хориглох.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн бичил биетний эсрэг эмийн нийцэмжтэй хэрэглээний талаарх бодлого боловсруулах.
 - i) Оролцогч компани бүр бичил биетний эсрэг эмийн бодлогыг ДМАЭМБ-ын олон улсын стандарт, удирдамжид нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх
 - ii) Өвчнөөс хамгаалах, тэмцэхэд бичил биетний эсрэг эм хэрэглэхийг хамгийн бага түвшинд байлгах.
- б) Бичил биетний эсрэг бүхий л эмчилгээг мал эмнэлгийн зааварчилгааны дагуу хийх
 - i) Бичил биетний эсрэг эмийг ямагт малын эмчийн зааварчилгаа, заалтаар хэрэглэх
- в) Төхөөрөхийн өмнөх хүлээх хугацаа
 - i) Мах болон бусад бүтээгдэхүүнд бичил биетний эсрэг эм үлдцээс сэргийлж төхөөрөхийн өмнө малын эм гадагшлах тогтоосон хугацааг хүлээнэ. Энэ хугацааг “хүлээх хугацаа” гэх ба бичил биетний эсрэг бодис тус бүрд өөр байна.
 - ii) Бичил биетний эсрэг зарим эмд дээрх хүлээх хугацаа нь тодорхойгүй байвал энэ хугацааг маж-бэлтгэлд төхөөрөх малд 63 хоногоор тооцно.

i) Төхөөрөхийн өмнөх хүлээх хугацаанд бичил биетний эсрэг эмийн эмчилгээ хийсэн ямар ч малыг тодорхой ялган тэмдэглэх ба энэ нь гарах бүтээгдэхүүнийг хэрхэх шийдвэр гаргах боломж олгоно.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- a) Бичил биетний эсрэг эмийн нийцэмжтэй бодлоготой байх.
- b) Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний талаар үйлдвэрлэлийн нэгж бүрд мал эмнэлгээс өгсөн зааварчилгааг хянан үзэх
- v) Төхөөрөлтөд мал шилжүүлэхээс өмнө үйлдвэрлэлийн нэгжид хийсэн бичил биетний эсрэг эмийн эмчилгээ, бичил биетний эсрэг эм хэрэглэсний дараа хүлээх хугацаанд мал шилжүүлээгүй болохын баталгааг шалгах
- г) Хөндлөнгийн хяналт шалгалтын үеэр мал эмнэлгээс олгосон зөвшөөрөл, эмчилгээний бүртгэлийг хянан үзэх

3) Хадгалах бүртгэл, нотолгоо (боломжтой бол хадгалах хугацаа).

- a) Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний талаар үйлдвэрлэлийн нэгж бүрд мал эмнэлгээс өгсөн заавар, чиглэл.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Үйлдвэрлэлийн нэгж бүрд бичил биетний эсрэг эмээр эмчилгээ хийх төлөвлөгөөний загвар.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.22. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Малын тавлаг байдал

Тодорхойлолт:

Малын тавлаг байдалд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани аж ахуй эрхлэх тогтолцоо болон ашиг шимийн шинжээр нь төрөлжүүлэн өсгөж байгаа малд тохирсон малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөөг ДМАЭМБ Кодексын 7.9. Малын тавлаг байдал ба махны үхрийн аж ахуй эрхлэх тогтолцоо болон 7.5. Мал, амьтныг төхөөрөх, нядлах бүлгийн зөвлөмжийг мөрдөн боловсруулна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Аж ахуй эрхлэх хугацаанд малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөө
 - i) Оролцогч компани өөрийн байгууламждаа аж ахуй эрхлэх тогтолцоо болон ашиг шимийн байдлаар нь төрөлжүүлэн өсгөж байгаа малд тохирсон малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
 - ii) Энэ төлөвлөгөөнд малын тавлаг байдлыг хангахын тулд мал маллагааны орчин, маллаж арчлах арга ямар байлгах ёстойг тодорхойлж өгнө.
 - iii) Малын тавлаг байдлыг илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг (хэмжиж болохуйц) үр дүнд суурилан тогтоох хяналт-шинжилгээ хийх тогтолцоотой байна.
 - iv) Мал хариуцаж ажиллах ажиллагсдыг сурган дадлагажуулснаар дээрх төлөвлөгөөг ойлгож, ур чадвартай болж малыг эерэг хандлагаар арчилж маллана.
 - v) Малыг наад зах нь өдөр бүр, тугаллах үнээ, нялх төл, эхээс дөнгөж ялгасан төл, шинээр сэлбэсэн сүрэг, өвчтэй эсхүл гэмтсэн малыг илүү ойр ойрхон үзэж шалгаж байх хэрэгтэй.
 - vi) Засах, сүүл тайрах, эвэр тайрах, тугалмай хайрах, тамгалах, дөрлөх зэрэг өвдөлт үүсгэдэг ажилбаруудыг өвдөлт, зовуур, стрессийг хамгийн бага түвшинд байлгах үүднээс цөөлөх, боловсронгуй болгох, өөр аргаар солих хэрэгтэй.
 - vii) Өвчтэй, гэмтсэн амьтныг түргэн оношилж, эмчилж эсхүл энэрэнгүй аргаар нядлах хэрэгтэй.
- б) Төхөөрөлтийн явц дахь малын тавлаг байдал
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн дотор малыг төхөөрөхдөө малын тавлаг байдлыг хэрхэн хангахыг төлөвлөсөн мал төхөөрөх үйлдвэр/цэгт хэрэгжүүлнэ.
 - ii) Малаа хайрлаж стресст оруулахгүй, гэмтээлгүй маллах туршлагатай, арга ухаантай малчинтай байна.
 - iii) Малыг муужруулах, төхөөрөхдөө шаардлагын дагуу зөв бэхэлсэн байна.
 - iv) Муужруулах (механик, цахилгаан, хийгээр) төхөөрөх (цуслах) арга нь ашиг шимээр нь төрөлжүүлсэн ангилсан малд тохирсон, төхөөрөх явцад мал ухаан өрж сэргэхээргүй байхаар уг ажлыг гүйцэтгэнэ.

- в) Ажиллагсдыг сургах
 - и) Мал аж ахуй хариуцсан ажиллагсад өөрсдийн гүйцэтгэх үүрэгт хамаарах малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөөний талаар сургалтад хамрагдаж мэддэг болсон байх хэрэгтэй.

- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
 - а) Малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөөтэй эсэх.

- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Хүний нөөцийн сургалтын бүртгэл.
 - б) Малын тавлаг байдлын илтгүүрт хяналт-шинжилгээ хийсэн бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. ДМАЭМБ Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, Стандарт 7.13 Малын тавлаг байдал болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо
- ii. ДМАЭМБ-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, Стандарт 7.5 Мал төхөөрөлт
- iii. ISO Техникийн стандарт 34700:2016 Малын тавлаг байдлын удирдлага.

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.23. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Өвчин үйл явдал тохиолдох үеийн бэлэн байдлын төлөвлөгөө

Тодорхойлолт:

Онцгойлсон өвчин (шүлхий болон БММӨ) компанийн хамгаалалттай аж ахуйн дотор гарч батлагдахад хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны явцад (CA3 В.17) эсхүл малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний үр дүнгээр (CA3 В.20) батлагдсан онцгойлсон өвчний тохиолдлыг өвчний үйл явдал гэж авч үзнэ.

Өвчний үйл явдлыг МЭЕГ-т нэн даруй мэдэгдэх ба хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл түдгэлзүүлнэ. Сорьц авахын (CA3 В.17) эсхүл эмнэл зүйн шинж тэмдэг илэрхийн (CA3 В.20) өмнөх 30 хоногт компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргасан мал, компанийн хамгаалалттай аж ахуйд төхөөрсөн малын гаралтай бүтээгдэхүүнийг мөшгөн тогтоох ба компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг хүлээн авсан аливаа этгээдэд өвчний үйл явдлын талаар албан ёсоор зөвлөн мэдээлнэ. Өвчин гарсан үйлдвэрлэлийн нэгжийг тусгаарлаж нэг ч малгүй болгосны дараа дахин малжуулахаас өмнө байр, тоног хэрэгслийг цэвэрлэж халдваргүйтгэнэ.

Дахин зөвшөөрөл авах өргөдөл гаргахын өмнө тухайн эзэмшил эсхүл ашиглалтын газрын үйлдвэрлэлийн бүх нэгж өвчингүй, тайван гэдгээ өвчингүй, тайван болохыг нотлох судалгаагаар (CA3 В.17) дахин баталгаажуулна. Өвчин гарсан үйлдвэрлэлийн бүх нэгжийг нэг ч малгүй болгосны дараа цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийн дахин мал оруулсан, компанийн хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн бүх нэгжид өвчингүй, тайван болохыг нотлох нэмэлт судалгаа (В.17) хийж дууссаны дараа хамгаалалттай аж ахуй зөвшөөрлөө дахин сэргээх өргөдөл компани МЭЕГ-т гаргаж болно. Өвчнөөс ангижирч тайван болохын тулд авсан бүх арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх боломжтой арга замыг тодорхойлохын хамт эрсдэлийн удирдлагын өөрчлөлтийг илтгэсэн өвчний үйл явдлыг шинжлэн судалсан мэдээллийг өргөдөлд оруулна.

Байгууламжид гарсан өвчний үйл явдлыг МЭНС-д бүртгэнэ.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Өвчний үйл явдлын тодорхойлолт

- i) Хорио цээрт орох үед (CA3 В.2) тогтоогдсон тохиолдлоос бусад хамгаалалттай аж ахуй дахь малд батлагдсан онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) аливаа тохиолдлыг өвчний үйл явдал гэж авч үзнэ.
- ii) Батлагдсан тохиолдол гэж эрх бүхий оношлох үйлчилгээ үзүүлэгчийн хийсэн баталгаажуулах шинжилгээгээр эерэг дүн үзүүлсэн тохиолдлыг хэлнэ.
- iii) Өвчний үйл явдал гэж үзэхээр тохиолдол батлагдмагц оролцогч компани компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гаргаж байгаа аливаа бүтээгдэхүүнд олгодог өвчингүй, тайван гэсэн гэрчилгээ олгохоо зогсоох хэрэгтэй.

- iv) Өвчний үйл явдал гэж үзэх тохиолдол батлагдсанаас хойш компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гарсан мал, малын гаралтай бүтээгдэхүүний аливаа шилжилт хөдөлгөөнийг өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн хууль тогтоомж, журмын шаардлагын дагуу зохицуулна.
- б) Өвчний үйл явдлыг мэдэгдэх
 - i) Өвчний үйл явдлыг МЭЕГ-т нэн даруй мэдэгдэх ёстой ба үүнийг үндэслэн компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг тэр даруй түдгэлзүүлнэ.
 - ii) Өвчний үйл явдлыг МЭНС-д бүртгэнэ.
- в) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас саяхан гаргасан мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг мөшгөн тогтоох
 - (1) Мөшгөн тогтоолтын хугацааг сорьц авсан (өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны явцад илэрч батлагдсан тохиолдолд) эсхүл эмнэл зүйн шинж тэмдэг илрүүлсэн (малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний явцад тогтоогдсон бол) өдрөөс эхлэн тухайн холбогдох онцгойлсон өвчний нууц үе хоёр удаа өнгөрөх хугацаагаар урагшаа авч үзнэ.
 - ii) Мөшгөн тогтоолтын дээрх хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуйгаас шилжүүлсэн, үүний дотор экспортолсон малын бүх ачилтыг хүлээн авсан байршил хүртэл нь мөшгөн тогтооно. Ачуулсан малтай холбоотойгоор олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван гэсэн гэрчилгээнд нөлөөлөхөөр өвчний үйл явдал тогтоогдсон талаар хүлээн авсан талд мэдэгдэнэ.
 - iii) Мөшгөн тогтоолтын хугацаанд төхөөрсөн малаас гаралтай бүх бүтээгдэхүүнийг олж тогтооно. Хэрэв тэдгээр бүтээгдэхүүн компанийн хамгаалалттай аж ахуйд байсаар байгаа бол өвчингүй, тайван гэсэн гэрчилгээ олгоход тохирохгүй гэж ялган тэмдэглэнэ. Хэрэв тэдгээр бүтээгдэхүүнийг мөшгөн тогтоох хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргасан, үүний дотор экспортолсон бол тэдгээрийг хүлээн авсан байршил хүртэл нь мөшгөн тогтооно. Ачуулсан бараатай холбоотойгоор олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван гэсэн гэрчилгээнд нөлөөлөхөөр өвчний үйл явдал тогтоогдсон талаар хүлээн авсан талд мэдэгдэнэ.
- г) Халдвартай үйлдвэрлэлийн нэгжид нэг ч малгүй болгосны дараа цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийн дахин малжуулах
 - i) Мал, хүн, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр өвчин дамжин халдварлаж болох дотоод урсгалд биохамгааллын хатуу арга хэмжээ хэрэгжүүлэх замаар өвчний тохиолдол батлагдсан үйлдвэрлэлийн бүх нэгжийг тусгаарлана.
 - ii) Үйлдвэрлэлийн нэгжийг малгүй болгох төлөвлөгөө боловсруулахдаа уг гарсан өвчинд холбогдох тэмцэх арга хэмжээний хуулийн шаардлагыг анхаарах хэрэгтэй.
 - iii) Малгүй болгосны дараа өвчний тохиолдол батлагдсан үйлдвэрлэлийн нэгжийн байр, тоног төхөөрөмжийг дахин мал оруулахаас өмнө сайтар цэвэрлэж халдваргүйтгэнэ.
- д) Өвчингүй, тайван болсныг дахин баталгаажуулах
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван статусыг дахин баталгаажуулах үйл явц өвчний тохиолдол батлагдсан үйлдвэрлэлийн бүх нэгжийг малгүй болгож сайтар цэвэрлэж халдваргүйтгэж дууссаны дараа эхэлнэ. Энэ огноог тайланд тодорхой, баталгаажуулж болохоор оруулах хэрэгтэй.
 - ii) Өвчний тохиолдол батлагдсан үйлдвэрлэлийн бүх нэгжийг малгүй болгож цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийж дууссан өдрөөс хойш компанийн

хамгаалалттай аж ахуйн доторх үйлдвэрлэлийн бусад бүх нэгжид өвчингүй, тайван болохыг нотлох судалгааг (САЗ В.17) наад зах нь нэг удаа явуулах ба ингэхдээ судалгаанд сорьц авсан огноог тэмдэглэсэн байх, бүх сорьц нь СӨРӨГ дүн үзүүлсэн байх ёстой.

- iii) Дахин баталгаажуулалтын явцад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (САЗ В.16) болон малын эрүүл мэндэд (В.20) холбогдох хяналт-шинжилгээг үргэлжлүүлж өвчингүй, тайван болохыг нотлох баримт бүрдүүлнэ.
 - iv) Компанийн хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн бүх нэгж өвчингүй, тайван болохыг нотлох наад зах нь нэг удаагийн судалгаагаар (САЗ В.17) бүгд СӨРӨГ үр дүнтэй болох нь тогтоогдсоны дараа хөндлөнгийн баталгаажуулагчаар хяналт шалгалт хийлгэх шаардлагатай.
- е) Дахин баталгаажуулалтын өргөдөл
- i) Компанийн хамгаалалттай аж ахуй шаардлага хангасны дараа оролцогч компани дахин баталгаажуулалтын өргөдөл бэлтгэнэ.
 - ii) Өргөдөлд өвчинтэй тэмцэхэд авсан арга хэмжээ, өвчингүй, тайван болсныг гэрчлэх нотолгоог тайлбарласан тайланг хавсаргана.
 - iii) Өргөдөлд бас хөндлөнгийн баталгаажуулагчийн хийсэн хяналт шалгалтын тайланг хавсаргана.
 - iv) Дахин баталгаажуулалт хийснийг МЭЕГ-аас баталсан өдрөөс энэ баталгаа хүчин төгөлдөр болж оролцогч компани байгууламжаас гаргаж байгаа аливаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд өвчингүй, тайван гэрчилгээ олгож эхэлнэ.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Өвчний үйл явдал тохиолдох үеийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна.
- б) Өвчний үйл явдлын дараа хийх хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалт нь оролцогч компанийн бэлтгэсэн тайланд тодорхойлсон өвчинтэй тэмцэх бүх арга хэмжээ, өвчингүй, тайван болохыг нотолсон судалгааг бодит байдал, баримт бичиг аль алийг хослуулан шалгаж баталгаажуулахад төвлөрнө.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Өвчний аливаа үйл явдал тохиолдоход уг үйл явдлын шалтгаан, мөшгөн тогтоолт, тэмцэх арга хэмжээ, дахин баталгаажуулалтад холбогдох бүртгэл тайлан, нотолгоог хамруулсан файл шинээр үүсгэн хадгална.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. ДМАЭМБ-ын олон улсын стандартад зааснаар нууц үе нь:
 - а. Шүлхий: 14 хоног
 - б. БММӨ: 21хоног
- ii. Шүлхий болон БММӨ-ий халдвартай аж ахуйд өвчинтэй тэмцэхэд тавих МЭЕГ-ын шаардлага, удирдамж

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Өвчин илэрсэн өдрөөс өмнөх хугацаа гэж ойлгогдохоор мөшгөх хугацааг тодруулсан. Орсон өөрчлөлтүүд: Өвчний үйл явдлыг МЭНС-д бүртгүүлдэг байх

		Гарцын хяналтын талаарх Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний нэр томьёо

Zero Draft

В.24. Гарцын хяналт: Мал

Тодорхойлолт

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас мал гаргах үед өвчингүй, тайван болохыг баталгаажуулан гэрчилгээ олгоход холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани нь өөрийн хамгаалалттай аж ахуйгаас ачигдаж байгаа мал бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд заасан өвчингүй, тайван болох шаардлагыг хангаж байгааг баталгаажуулах ёстой. Ийнхүү баталгаажуулсан нөхцөлд оролцогч компани хамгаалалттай аж ахуйн дараах гэрчилгээг өөрийн албан бичгийн хуудас дээр Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн тогтолцооны нэр, бэлгэ тэмдгийг ашиглан олгоно:

[Хавсаргасан бүртгэл]-д тодорхойлсон мал бүхий ачаа нь [Оролцогч компани, компанийн хамгаалалттай аж ахуй, байгууламжийн нэр]-ээс [огноо]-ний өдөр гарсан бөгөөд тухайн хугацаанд энд дурдсан ачаа болон гарал үүслийн байгууламж нь Монгол улсын хууль тогтоомж, журам болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-аас зөвшөөрч, баталгаажуулсан техникийн нөхцөлийн дагуу Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд тавигдсан бүх шаардлагыг хангасан бөгөөд дараах өвчингүй, тайван болно:

үхэрт: шүлхий

хонь, ямаанд: шүлхий ба бог малын мялзан өвчин (БММӨ)

Дээрх шаардлагыг МЭЕГ-ын цахим хуудаснаас [[www.XXXXX](#)] олон нийт үзэх боломжтой.

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гарч буй малын шилжилт хөдөлгөөн бүрийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгэнэ. Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг МЭНС-д байршуулах ёстой ба ингэснээр экспортын ачилтын тухайд тухайн гэрчилгээг МЭНС-ын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох явцад туслах баримт бичиг болгон ашиглах боломжтой болно.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Ачигдах мал, түүнийг гаргаж байгаа үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлох
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гарч буй мал бүхий ачаа бүрд малын тоо, холбогдох үйлдвэрлэлийн нэгж, үйлдвэрлэлийн нэгжийн харьяалагдах байгууламж, байгууламжийн харьяалагдах компанийн хамгаалалттай аж ахуй, компанийн хамгаалалттай аж ахуйг удирдах оролцдог компани тус бүрийн оноосон нэр, бүртгэлийн дугаар бүхий жагсаалтыг дагалдуулна.
 - ii) Хэрэв компанийн хамгаалалттай аж ахуйн ялган тэмдэглэх тогтолцоо нь мал нэг бүрийг ялган тэмдэглэдэг бол ачигдах мал нэг бүрийг ялгах таних тэмдэглэгээг энэ жагсаалтад оруулна.
- б) Үйлдвэрлэлийн нэгжийн шаардлага хангасан байдлыг баталгаажуулах

- i) Тухайн ачаа компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд хамрагдах шаардлагыг хангаж байгаа эсэх нь түүнийг гаргах компанийн хамгаалалттай аж ахуй одоогоор зөвшөөрөлтэй болох нь баталгаатай, үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, тайван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамрагдаагүй гэдгээс шалтгаална.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуй нь одоогоор зөвшөөрөлтэй болохыг компанийн хамгаалалттай аж ахуйн статус, түүний зөвшөөрөлтэй байгууламжийг тэмдэглэсэн МЭЕГ-ын албан ёсны бүртгэлийг шалган баталгаажуулна.
 - iii) Тухайн ачааг гаргах үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, тайван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамааралгүй гэдгийг тухайн компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэл, баримт бичгийг лавлан үзэж баталгаажуулна.
- в) Оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгох
- i) Оролцогч компани бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурах үүрэг хүлээсэн ажилтан/ажилтнуудыг томилно.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ нь МЭЕГ-аас баталсан загвартай байна.
 - iii) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг Монголын хивэгч малын хамгаалалттай аж ахуйг хүлээн зөвшөөрсөн зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколд албан ёсоор хэлэлцэн тохиролцсон тохиолдолд МЭЕГ-аас олгосон Экспортын гэрчилгээнд дагалдах, эсхүл Монгол улсын мал аж ахуйн дотоодын зах зээлд маркетинг хийхэд туслах баримт бичиг болгон ашиглаж болно.
- г) МЭНС-д шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, гэрчилгээг байршуулах
- i) МЭҮН нь шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлж, компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг байршуулна.
- 2) Шаардлагын баталгаажуулах аргачлал
- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурахыг хариуцсан ажилтанд хүсэлт гаргах бүрдээ гэрчилгээнд хамрагдах шаардлага хангасан болохын нотолгоог хавсаргана.
 - б) Хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтын үеэр оролцогч компани олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнээс түүвэрлэж түүний формат болон гэрчилгээ олгоход шаардлага хангасан болохын нотолгоог шалгана.
 - в) МЭНС-мөшгөн тогтоолтын хэсэг дэх бүртгэл компанийн бүртгэлтэй тохирч байх ёстой.
 - г) МЭЕГ-ын албан ёсны эрхтэй малын эмч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд экспортын гэрчилгээ олголтод ашиглах нэмэлт шалгалт хийх, нотлох баримт ирүүлэхийг хүсэж болно.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурж болох оролцогч компанийн ажилтнуудын бүртгэл.
 - б) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний бүртгэл, холбогдох нотлох баримтын хамт (2 жил)
 - в) МЭНС-ийн мөшгөн тогтоолтын бүртгэл (байнга)

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хэсэг С. Оролцогч компанийн олгодог компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Орсон өөрчлөлтүүд: Шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртгүүлэх шаардлага, Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний нэр томъёо, гэрчилгээг МЭНС-д байршуулах шаардлага.

В.25. Гарцын хяналт: Генетикийн материал (Үр, хөврөл үр)

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас мал гаргах үед өвчингүй, тайван болохыг баталгаажуулан гэрчилгээ олгоход холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани нь өөрийн хамгаалалттай аж ахуйгаас ачигдаж байгаа генетикийн материал (үр, хөврөл үр) бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд заасан өвчингүй, тайван болох шаардлагыг хангаж байгааг баталгаажуулах ёстой. Ийнхүү баталгаажуулсан нөхцөлд оролцогч компани хамгаалалттай аж ахуйн дараах гэрчилгээг өөрийн албан бичгийн хуудас дээр Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн тогтолцооны нэр, бэлгэ тэмдгийг ашиглан олгоно:

[Хавсаргасан бүртгэл]-д тодорхойлсон генетикийн материал (үр, хөврөл үр) бүхий ачаа нь [Оролцогч компани, компанийн хамгаалалттай аж ахуй, байгууламжийн нэр]-ээс [огноо]-ний өдөр гарсан бөгөөд тухайн хугацаанд энд дурдсан ачаа болон гарал үүслийн байгууламж нь Монгол улсын хууль тогтоомж, журам болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-аас зөвшөөрч, баталгаажуулсан техникийн нөхцөлийн дагуу Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд тавигдсан бүх шаардлагыг хангасан бөгөөд дараах өвчингүй, тайван болно:

үхэрт: шүлхий

хонь, ямаанд: шүлхий ба бог малын мялзан өвчин (БММӨ)

Дээрх шаардлагыг МЭЕГ-ын цахим хуудаснаас [[www.XXXXXX](#)] олон нийт үзэх боломжтой.

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гарч буй генетикийн материалын шилжилт хөдөлгөөн бүрийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгэнэ. Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг МЭНС-д байршуулах ёстой ба ингэснээр экспортын ачилтын тухайд тухайн гэрчилгээг МЭНС-ийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох явцад туслах баримт бичиг болгон ашиглах боломжтой болно.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Ачигдах генетикийн материал (үр, хөврөл үр), түүнийг гаргаж байгаа үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлох
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гарч буй малын генетикийн материал (үр, хөврөл үр), бүхий ачаа бүрд үрийн гуурсын (эсхүл бусад савалгаа) тоо, бэлтгэсэн эцэг, эх малын ялгах тэмдэглэгээ, цуглуулсан огноо, холбогдох үйлдвэрлэлийн нэгж, үйлдвэрлэлийн нэгжийн харьяалагдах байгууламж, байгууламжийн харьяалагдах компанийн хамгаалалттай аж ахуй, компанийн хамгаалалттай аж ахуйг удирдах оролцдог компани тус бүрийн оноосон нэр, бүртгэлийн дугаар бүхий жагсаалтыг дагалдуулна.
- б) Үйлдвэрлэлийн нэгжийн шаардлага хангасан байдлыг баталгаажуулах
 - i) Тухайн ачаа компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд хамрагдах шаардлагыг хангаж байгаа эсэх нь түүнийг гаргах компанийн хамгаалалттай

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар

92

Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

Хувилбар: 0.3

- аж ахуй одоогоор зөвшөөрөлтэй БОЛОН тухайн генетикийн материал (үр, хөврөл үр) цуглуулсан өдөр зөвшөөрөлтэй байсан болох нь баталгаатай, үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, таван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамрагдаагүй гэдгээс шалтгаална.
- ii) Компанийн хамгаалалттай аж ахуй нь одоогоор зөвшөөрөлтэй БОЛОН тухайн генетикийн материал (үр, хөврөл үр) цуглуулсан өдөр зөвшөөрөлтэй байсан болохыг компанийн хамгаалалттай аж ахуйн статус, түүний зөвшөөрөлтэй байгууламжийг тэмдэглэсэн МЭЕГ-ын албан ёсны бүртгэлийг шалган баталгаажуулна.
 - iii) Тухайн ачааг гаргах үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, тайван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамааралгүй гэдгийг тухайн компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэл, баримт бичгийг лавлан үзэж баталгаажуулна.
- в) Оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгох
- i) Оролцогч компани бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурах үүрэг хүлээсэн ажилтан/ажилтнуудыг томилно.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ нь МЭЕГ-аас баталсан загвартай байна.
 - iii) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг Монголын хивэгч малын хамгаалалттай аж ахуйг хүлээн зөвшөөрсөн зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколд албан ёсоор хэлэлцэн тохиролцсон тохиолдолд МЭЕГ-аас олгосон Экспортын гэрчилгээнд дагалдах, эсхүл Монгол улсын мал аж ахуйн дотоодын зах зээлд генетикийн материалыг (үр, хөврөл үр) маркетинг хийхэд туслах баримт бичиг болгон ашиглаж болно.
- г) МЭНС-д шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, гэрчилгээг байршуулах
- i) МЭҮН нь генетикийн материалын (үр, хөврөл үр) шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлж, компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг байршуулна.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурахыг хариуцсан ажилтанд хүсэлт гаргах бүрдээ гэрчилгээнд хамрагдах шаардлага хангасан болохын нотолгоог хавсаргана.
 - б) Хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтын үеэр оролцогч компани олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнээс түүвэрлэж түүний формат болон гэрчилгээ олгоход шаардлага хангасан болохын нотолгоог шалгана.
 - в) МЭНС-мөшгөн тогтоолтын хэсэг дэх бүртгэл компанийн бүртгэлтэй тохирч байх ёстой.
 - г) МЭЕГ-ын албан ёсны эрхтэй малын эмч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд экспортын гэрчилгээ олголтод ашиглах нэмэлт шалгалт хийх, нотлох баримт ирүүлэхийг хүсэж болно.
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурж болох оролцогч компанийн ажилтнуудын бүртгэл.
 - б) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний бүртгэл, холбогдох нотлох баримтын хамт (2 жил)

в) МЭНС-ийн мөшгөн тогтоолтын бүртгэл (байнга)

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- ii. Хэсэг С. Оролцогч компанийн олгодог компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Орсон өөрчлөлтүүд: Шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртгүүлэх шаардлага, Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний үг хэллэг, гэрчилгээг МЭНС-д байршуулах шаардлага.

В.26. Гарцын хяналт: Мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас мах, махан бүтээгдэхүүн, баталгаажилт шаарддаг бусад бүтээгдэхүүнийг (ө.х. арьс, үс) гаргах үед өвчингүй, тайван болохыг баталгаажуулан гэрчилгээ олгоход холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал.

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани нь өөрийн хамгаалалттай аж ахуйгаас ачигдаж байгаа мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн (ө.х. арьс, үс) бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд заасан өвчингүй, тайван болох шаардлагыг хангаж байгааг баталгаажуулах ёстой. Ийнхүү баталгаажуулсан нөхцөлд оролцогч компани хамгаалалттай аж ахуйн дараах гэрчилгээг өөрийн албан бичгийн хуудас дээр Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн тогтолцооны нэр, бэлгэ тэмдгийг ашиглан олгоно:

[Хавсаргасан бүртгэл]-д тодорхойлсон мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн бүхий ачаа нь [Оролцогч компани, компанийн хамгаалалттай аж ахуй, байгууламжийн нэр]-ээс [огноо]-ний өдөр гарсан бөгөөд тухайн хугацаанд энд дурдсан ачаа болон гарал үүслийн байгууламж нь Монгол улсын хууль тогтоомж, журам болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-аас зөвшөөрч, баталгаажуулсан техникийн нөхцөлийн дагуу Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд тавигдсан бүх шаардлагыг хангасан бөгөөд дараах өвчингүй, тайван болно:

үхэрт: шүлхий

хонь, ямаанд: шүлхий ба бог малын мялзан өвчин (БММӨ)

Дээрх шаардлагыг МЭЕГ-ын цахим хуудаснаас [[www.XXXXX](#)] олон нийт үзэх боломжтой.

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гарч буй генетикийн материалын шилжилт хөдөлгөөн бүрийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгэнэ. Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг МЭНС-д байршуулах ёстой ба ингэснээр экспортын ачилтын тухайд тухайн гэрчилгээг МЭНС-ийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох явцад туслах баримт бичиг болгон ашиглах боломжтой болно.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Ачигдах мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн, түүнийг гаргаж байгаа үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлох
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гарч буй мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүн бүхий ачаа бүрд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төхөөрсөн, боловсруулсан огноо, холбогдох үйлдвэрлэлийн нэгж, үйлдвэрлэлийн нэгжийн харьяалагдах байгууламж, байгууламжийн харьяалагдах компанийн хамгаалалттай аж ахуй, компанийн хамгаалалттай

аж ахуйг удирдах оролцдог компани тус бүрийн оноосон нэр, бүртгэлийн дугаар бүхий жагсаалтыг дагалдуулна.

- б) Үйлдвэрлэлийн нэгжийн шаардлага хангасан байдлыг баталгаажуулах
- i) Тухайн ачаа компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд хамрагдах шаардлагыг хангаж байгаа эсэх нь түүнийг гаргах компанийн хамгаалалттай аж ахуй одоогоор зөвшөөрөлтэй болон төхөөрсөн, боловсруулсан өдөр зөвшөөрөлтэй байсан болох нь баталгаатай, үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, тайван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамрагдаагүй гэдгээс шалтгаална.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуй нь одоогоор зөвшөөрөлтэй болон төхөөрсөн, боловсруулсан өдөр зөвшөөрөлтэй байсан болохыг компанийн хамгаалалттай аж ахуйн статус, түүний зөвшөөрөлтэй байгууламжийг тэмдэглэсэн МЭЕГ-ын албан ёсны бүртгэлийг шалган баталгаажуулна.
 - iii) Тухайн ачааг гаргах үйлдвэрлэлийн нэгж нь өвчингүй, тайван болохыг нотлох судалгаанд хамрагдаж дууссан бөгөөд малын эрүүл мэндийн аливаа шийдэгдээгүй судалгаа шинжилгээний ажилд хамааралгүй гэдгийг тухайн компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэл, баримт бичгийг лавлан үзэж баталгаажуулна.
- в) Оролцогч компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгох
- i) Оролцогч компани бүр компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурах үүрэг хүлээсэн ажилтан/ажилтнуудыг томилно.
 - ii) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ нь МЭЕГ-аас баталсан загвартай байна.
 - iii) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг Монголын хивэгч малын хамгаалалттай аж ахуйг хүлээн зөвшөөрсөн зах зээлд нэвтрэх АЦУАЦ-ийн протоколд албан ёсоор хэлэлцэн тохиролцсон тохиолдолд МЭЕГ-аас олгосон Экспортын гэрчилгээнд дагалдах, эсхүл Монгол улсын мал аж ахуйн дотоодын зах зээлд генетикийн материалыг (үр, хөврөл үр) маркетинг хийхэд туслах баримт бичиг болгон ашиглаж болно.
- г) МЭНС-д шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, гэрчилгээг байршуулах
- i) МЭҮН нь генетикийн материалын (үр, хөврөл үр) шилжилт хөдөлгөөнийг МЭНС-ийн мөшгөн тогтоолтын хэсэгт бүртгүүлж, компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг байршуулна.
- 2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал
- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурахыг хариуцсан ажилтанд хүсэлт гаргах бүрдээ гэрчилгээнд хамрагдах шаардлага хангасан болохын нотолгоог хавсаргана.
 - б) Хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтын үеэр оролцогч компани олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнээс түүвэрлэж түүний формат болон гэрчилгээ олгоход шаардлага хангасан болохын нотолгоог шалгана.
 - в) МЭНС-мөшгөн тогтоолтын хэсэг дэх бүртгэл компанийн бүртгэлтэй тохирч байх ёстой.
 - г) МЭЕГ-ын албан ёсны эрхтэй малын эмч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд экспортын гэрчилгээг олголтод ашиглах нэмэлт шалгалт хийх, нотлох баримт ирүүлэхийг хүсэж болно.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар

96

Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

Хувилбар: 0.3

- а) Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд гарын үсэг зурж болох оролцогч компанийн ажилтнуудын бүртгэл.
- б) Оролцогч компаниас олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний бүртгэл, холбогдох нотлох баримтын хамт (2 жил)
- в) МЭНС-ийн мөшгөн тогтоолтын бүртгэл (байнга)

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- iii. Хэсэг С. Оролцогч компанийн олгодог компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Орсон өөрчлөлтүүд: Шилжилт хөдөлгөөнийг МЭНС-д бүртгүүлэх шаардлага, Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний нэр томьёо, гэрчилгээг МЭНС-д байршуулах шаардлага.

В.27. Гарцын хяналт: Үхсэн мал, хог хаягдал, бохирын ус

Тодорхойлолт:

Үхсэн мал, хог хаягдал, бохирын усыг тохирох аргаар биоаюулгүй болгох, устгахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гарч байгаа үхсэн мал, хог хаягдал, бохирын усыг тус улсын малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны хууль тогтоомж болон тухайн орон нутгийн аливаа захирамжид заасны дагуу устгана. Өвчингүй, тайван гэрчилгээ олгох шаардлага эдгээр хог хаягдалд хамаарахгүй.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны асуудалд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлагыг тодорхойлно.

i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас байнга гарах хог хаягдлыг (үхсэн мал, хог хаягдал, бохирын ус) тэдгээрт хамаарах аливаа хууль ёсны шаардлагыг мөрдөн тус улсын малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны хууль тогтоомж болон тухайн орон нутгийн аливаа захирамжид заасны дагуу устгана.

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гарч буй хог хаягдлын урсгалыг (үхсэн амьтан, хог хаягдал, бохирын ус) устгахдаа тус улсын малын эрүүл мэнд, байгаль орчны хууль болон тухайн орон нутгийн аливаа захирамжид заасан тэдгээрт хамаарах аливаа хууль ёсны шаардлагыг мөрдөнө.

ii) Оролцогч компани өөрийнхөө байгууламжид мөрдөх хуулийн жагсаалт гаргаж тэдгээрт нийцсэн хог хаягдлын устгалын төлөвлөгөө боловсруулна.

б) Хог хаягдлыг компанийн хамгаалалттай аж ахуйгаас хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлагад нийцүүлэн гаргах

i) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас хаях бүх хог хаягдлыг тус улсын болон орон нутгийн хууль тогтоомжийг үндэслэн боловсруулсан хог хаягдлыг устгах төлөвлөгөөний дагуу устгана.

ii) Өвчний үйл явдал тохиолдсоны улмаас мал олноороо хорогдож халдварт өвчний үүсгэгчээр бохирдсон их хэмжээний бохир ус, бусад хаягдал гарахад улсын хэмжээнд арга хэмжээ авна. Оролцогч компани МЭЭГ болон хүрээлэн буй орчны эрх бүхий байгууллагуудтай шууд хамтран ажиллаж тавигдах шаардлагыг биелүүлнэ.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

а) Хог хаягдлыг устгах төлөвлөгөөтэй байна.

3) Хадгалах бүртгэл, нотолгоо (боломжтой бол хадгалах хугацаа).

а) Хог хаягдлын устгалын хэвийн горимыг нотлон харуулах тогтмол хөтөлдөг бүртгэл тэмдэглэл

б) Өвчний үйл явдал тохиолдсон хугацаанд улсын хэмжээний өвчинтэй тэмцэх шаардлагыг ханган ажилласныг нотлон харуулах бүртгэл тэмдэглэл, нотолгоо.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Холбогдох хууль эсхүл шаардлагын хуулбар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

Zero Draft

В.28. Гарцын хяналт: Тоног төхөөрөмж

Тодорхойлолт:

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид малд ашиглаж байсан аливаа тоног төхөөрөмжийг, ялангуяа өвчний үйл явдал тохиолдсоны дараа биохамгааллын шаардлага ханган гаргахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйгаас малд тогтмол ашиглаж байгаад гаргаж байгаа тоног төхөөрөмж цэвэрхэн байх ёстой ба харин тэдгээрт өвчингүй, тайван гэрчилгээ олгохгүй. Өвчний үйл явдал тохиолдсон хугацаанд малд ашиглаж байсан тоног төхөөрөмжийг цэвэрлэж халдваргүйтгэх ба тус улсын хууль тогтоомжид заасан бол аливаа хяналтын нэмэлт арга хэмжээ авна.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Компанийн хамгаалалттай аж ахуйд малд ашиглаж байгаад гаргаж байгаа тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэнэ.
 - i) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид малд ашиглаж байгаад гаргах тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэнэ.
 - ii) Малд ашиглаж байсан тоног төхөөрөмж компанийн хамгаалалттай аж ахуйгаас олгодог гэрчилгээнд хамрагдахгүй.
- б) Өвчний үйл явдал тохиолдсон хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуйн малд ашиглаж байгаад гаргаж байгаа тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл
 - i) Өвчний үйл явдал тохиолдсон хугацаанд тухайн өвчинтэй тэмцэх хууль ёсны хөтөлбөрийн нэмэлт шаардлагыг хэрэгжүүлэх шаардлага гарч болзошгүй бөгөөд аливаа тоног төхөөрөмжийг компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргахдаа энэ шаардлагыг мөн биелүүлсэн байна.
 - ii) Өвчний үйл явдал тохиолдсон хугацаанд малд ашиглаж байсан тоног төхөөрөмжийг компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжаас гаргахдаа цэвэрлэж халдваргүйтгэнэ.

2) Шаардлагыг хангах аргачлал

- а) Байхгүй

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Байхгүй

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Байхгүй

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоо: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар
Огноо: 2024 оны 5-р сарын 1-ны өдөр

100

Хувилбар: 0.3

В.29. Дотоод хяналт: Баримт бичиг, бүртгэл хөтлөлт

Тодорхойлолт:

Бүртгэл, баримт бичиг хөтлөхөд холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, хөтөлбөрийн шаардлага хангаж байгааг нотлон харуулахад хэрэглэгдэх баримт бичиг, бүртгэл, нотолгоог хадгалж байх ёстой ба хөндлөнгийн хяналт шалгалт хийх үед болон МЭЭГ-ын албан ёсны эрхтэй малын эмч экспортын гэрчилгээ олгох зорилгоор хүсэх үед бэлэн байлгана.

Хэрэв шаарддаг бол компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэл МЭНС-д хадгалагдаж байгаа албан ёсны бүртгэлтэй тохирч байх ёстой.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Бүртгэл, баримт бичиг хөтлөх, хадгалах

i) Оролцогч компани өөрийн хамгаалалттай аж ахуйдаа бүртгэл, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог боловсруулах ба биохамгааллын заавар САЗ-ын загварт тодорхойлсон ёсоор бүртгэл, нотолгоог хадгалдаг болгоно (хэрэв заасан бол хамгийн бага хугацаагаар).

Оролцогч компани наад зах нь биохамгааллын зааварт тусгагдсан САЗ-ын загварт заасан бүртгэл, баримт бичиг, нотлох баримтыг хадгалахын (хэрэв заасан бол хамгийн бага хугацаагаар) нөхцөлийг бүрдүүлэхийн тулд өөрийн хамгаалалттай аж ахуйд бүртгэл, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог боловсруулсан байна.

ii) Оролцогч компани нь үйл ажиллагааныхаа ямар үед бүртгэлээ Монгол улсын малын эмнэлгийн нэгдсэн систем (МЭНС)-д илгээхээ нарийн тогтоож, түүнийгээ мөрдөж ажиллана.

б) Баталгаажуулалтад ашиглахаар хүсэх үед бүртгэл, баримт бичгийг бэлэн байлгах

i) Компанийн хамгаалалттай аж ахуй хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгаагаа нотлохын тулд өөрийн үйл ажиллагааг нотлон харуулах бүртгэл, баримт бичиг, нотолгоог баталгаажуулах нь зайлшгүй чухал үйл ажиллагаа юм.

ii) Бүртгэл, баримт бичиг, нотолгоонд дотоод хяналт хийж, тэдгээрийг шаардлага хангахуйц цогц, шинэчлэгддэг, мөн МЭНС-д байгаа албан ёсны бүртгэлтэй тохирдог байлгана.

iii) Хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалт хийх үеэр оролцогч компанийн ажилтан хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлага хангаж байгааг нотлох бүртгэл, баримт бичиг, нотолгоог харуулах аливаа үндэслэл бүхий хүсэлтийг биелүүлэхэд бэлэн байх ёстой.

iv) Компанийн хамгаалалттай аж ахуйгаас гаргаж байгаа мал, генетикийн материал, мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бусад бүтээгдэхүүний аль ч ачилтад холбогдуулан МЭЭГ-ын албан ёсны эрхтэй малын эмч

экспортын гэрчилгээ олгох явцад оролцогч компанийн ажилтан хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлага хангаж байгааг нотлох бүртгэл, баримт бичиг, нотолгоог харуулах аливаа үндэслэл бүхий хүсэлтийг биелүүлэхэд бэлэн байх ёстой.

- 2) Шаардлагыг хангах аргачлал
 - а) Хөндлөнгийн баталгаажуулагчийн хяналт шалгалтын үеийн баталгаажуулалт, албан ёсны эрхтэй малын эмчийн олгох экспортын гэрчилгээ
- 3) Хадгалах бүртгэл, нотолгоо (боломжтой бол хадгалах хугацаа).
 - а) Албан ёсны бүртгэлийн файл
 - б) Албан ёсны бүртгэлийн файлыг тусгасан ажлын файл, бүртгэл
 - в) Компанийн бүртгэлтэй тулгасан МЭНС-ийн бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. байхгүй

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	МЭНС-д албан ёсны бүртгэл хөтөлдөг байх талаар өөрчлөлт орсон.

В.30. Дотоод хяналт: Тогтмол тайлагналт

Тодорхойлолт:

Оролцогч компаниас МЭЕГ-т сар, жил тутам тогтмол тайлагнахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани үйл ажиллагааныхаа тойм болон хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлагыг хэрхэн хангадгаа нотлон харуулах тайланг МЭЕГ-т сар, жил тутам тогтмол илгээнэ.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

а) Сар тутмын тайлан

- i) Оролцогч компани сар тутмын тайлангаа хуанлийн сар дууссанаас хойш 7 хоногийн дотор МЭЕГ-т илгээнэ.
- ii) Дараах мэдээлэл агуулсан тайланг МЭЕГ-ын гаргасан жэв загвараар гаргаж ирүүлнэ:
 - (1) Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн албан ёсны бүртгэлд оруулсны дагуу оролцогч компанийн болон компанийн хамгаалалттай аж ахуйн оноосон нэр, бүртгэлийн дугаарын мэдээлэл;
 - (2) Тухайн тайлангийн хугацаанд гарсан аливаа хэвийн бус үйл явдал (САЗ В.31) тэдгээрийг хэрхэн удирдаж байгааг тодорхойлох, түүнчлэн тэдгээр хэвийн бус үйл явдлыг шийдвэрлэж, зогсоох хүртэл мэдээллийг оруулах.
 - (3) Тухайн тайлангийн хугацаанд хийсэн хөндлөнгийн баталгаажуулагчийн хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг хавсаргана. Аливаа ноцтой болон томоохон үл тохирлыг залруулахаар удирдлагаас авсан хариу арга хэмжээ, төлөвлөгөөг ирүүлнэ.
 - (4) Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгаа байдал, түүний дотор онцгойлсон өвчний (шүлхий болон БММӨ) сэжигтэй эсхүл батлагдсан тохиолдол байхгүй болохыг гэрчлэн мэдэгдэл ирүүлнэ.

б) Жил бүрийн тайлан

- i) Оролцогч компани бүр жил бүрийн тайлангаа хуанлийн жил дууссанаас хойш 1 сарын дотор МЭЕГ-т илгээнэ.
- ii) Дараах мэдээлэл агуулсан тайланг МЭЕГ-ын гаргасан загвараар гаргаж ирүүлнэ:
 - (1) Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн албан ёсны бүртгэлд оруулсны дагуу оролцогч компанийн болон компанийн хамгаалалттай аж ахуйн оноосон нэр, бүртгэлийн дугаарын мэдээлэл;
Тайлангийн хугацаанд хянан засварласан САЗ зэрэг компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар эсхүл чанарын тогтолцоонд оруулсан аливаа томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг хэвийн бус үйл явдлын хариу арга хэмжээний үед болон дотоод хяналт эсхүл хөндлөнгийн хяналт шалгалтын явцад илэрсэн үл тохирол, гарсан үр дүнтэй холбон тайлбарлан тусгана.

- (2) Байгууламж тус бүрийн нийт малын популяцийн тооллогын дүн (жилийн эцэст байсан, жилийн турш төхөөрсөн бөгөөд гэрчилгээ дагалдуулан ачигдсан малын тоо),
- (3) Байгууламж болон үйлдвэрлэлийн нэгжид өвчингүй, тайван болохыг нотлох судалгаа бүрд хийсэн лабораторийн шинжилгээний **тайлант** жилд хүлээн авсан дүнг хавсаргана.
- (4) **Тайлант** жилд оролцогч компанийн олгосон компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний албан ёсны бүртгэлийн хуулбарыг хавсаргана.
- (5) **Тайлант** жилд хийсэн малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний дүнгийн хураангуйг ирүүлнэ.
- (6) **Тайлант** жилд хийсэн малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөөний дагуу явуулсан үйл ажиллагааны товчлол
- (7) **Тайлант** жилд бичил биетний эсрэг нийцэмжтэй хөтөлбөрийн дагуу явуулсан үйл ажиллагааны товчлол.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) МЭЕГ сар, жил тутмын тайланг хүлээн авснаа баталгаажуулна.
- б) МЭЕГ нь тайланд орсон мэдээлэл хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн шаардлага хангаж байгааг баталгаажуулах шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээлэл эсхүл тодруулга хүсэж болно.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Оролцогч компани болон МЭЕГ-д байгаа сар тутмын тайлан.
- б) Оролцогч компани болон МЭЕГ-д байгаа жил бүрийн тайлан.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хэсэг С. Тогтмол ирүүлэх тайлангийн загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээний үг хэллэг

В.31. Дотоод хяналт: Хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх, тайлагнах

Тодорхойлолт:

Хэвийн бус үйл явдлыг (ө.х. компанийн хамгаалалттай аж ахуйн хэвийн үйл ажиллагаанд бүхэлд нь аюул эсхүл эрсдэлд учруулах боломжтой) МЭЕГ-т мэдэгдэх, тайлагнахад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах хүн:

Энэ аргачлалыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани нь компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван байдалд эрсдэл учруулах боломжтой аюул эсхүл эрсдэл болон эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний талаар МЭЕГ-т байнга мэдээлдэг байна.

Иймд хэвийн бус үйл явдалд компанийн хамгаалалттай аж ахуйн өвчингүй, тайван байдалд аюул эсхүл эрсдэл учруулж болох үйл явдлыг хэлэх ба үүний дотор:

- Биохамгааллын ноцтой зөрчил (САЗ В.15)
- Малын эрүүл мэндийн судалгаа хийхэд хүргэсэн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт (САЗ В.16)
- малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээ эхлүүлсэн (САЗ В.20)

МЭЕГ-т мэдэгдэх нь зөвхөн ил тод байдлыг хангах зорилготой бөгөөд МЭЕГ энэ асуудлыг шийдвэрлэх ямар нэг арга хэмжээ авах үүрэг хүлээхгүй. Нэмэлт мэдээлэл хүсч болно.

ЖИЧ: Энэхүү САЗ-д тодорхойлсон хэвийн бус үйл явдлыг мэдэгдэх, тайлагнах нь өвчний үйл явдал (САЗ В.23), хөндлөнгийн хяналт шалгалтын (САЗ В.32) мэдэгдэл, тайлагналтын шаардлагаас өөр юм.

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) Хэвийн бус үйл явдлыг илрүүлэн тогтоох, ангилах
 - i) САЗ В.15, В.16, В.20-д тодорхойлсон ямар ч хяналт-шинжилгээгээр хэвийн бус үйл явдал илрэхэд түүнийг албан ёсоор бүртгэж ангилна (дээр дурдсан төрлөөр).
 - ii) Хэвийн бус үйл явдал бүрд оролцогч компани эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээ авч бүртгэлд оруулан баримтжуулах бөгөөд тухайн үйл явдлыг шийдвэрлэж хаах хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээг хянана.
- б) Хэвийн бус үйл явдлын бүртгэл
 - i) Хуанлийн сард компанийн хамгаалалттай аж ахуйд тохиолдсон хэвийн бус үйл явдлыг сар тутмын тогтмол тайланд (САЗ В.30) хураангуйлсан хэлбэрээр тайлагнана.
 - ii) Үйл явдал дуусаж шийдвэрлэгдэх хүртэл дараагийн сар тутмын тайланд үйл явдлын төлөв байдлыг шинэчлэн ирүүлнэ.

2) Шаардлагыг баталгаажуулах аргачлал

- а) Хэвийн бус үйл явдлын бүртгэлийг хөндлөнгийн хяналт шалгалт хийх үеэр хянан үзэхэд бэлэн байлгана.

3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).

- а) Хэвийн бус үйл явдлын бүртгэл
- б) Сар тутмын тайлан.

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хэсэг С. Тогтмол тайлангийн загвар (ЖИЧ: Сар тутмын тайлангийн загварт хэвийн бус үйл явдлын мэдээллийн тайланд тавигдах шаардлагыг оруулсан)

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл

Одоогийн хувилбарын дугаар 0.1

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн

В.32. Хөндлөнгийн хяналт: Төрийн баталгаажуулагч этгээдийн хийх хөндлөнгийн хяналт шалгалт

Тодорхойлолт:

Төрийн баталгаажуулагч этгээдийн хийх хөндлөнгийн хяналт шалгалтад холбогдох шаардлага, түүнийг хангах аргачлал

Хариуцах ажилтан:

Энэ зааврыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг хариуцуулж томилсон ажилтныг энд оруулна.

Гарах үр дүн:

Оролцогч компани өөрийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний байгууламж нэг бүрд эрх бүхий төрийн баталгаажуулагч этгээдээр хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмол гүйцэтгүүлэхээр тохиролцсон байна.

Биохамгааллын нийтлэг зааварт тавигдсан шаардлагыг оролцогч компани хэрхэн хангаж ажиллах ёстойг тодорхойлсон оролцогч компанийн биохамгааллын зааврыг хөндлөнгийн хяналт шалгалт хийхэд лавлах баримт бичиг болгон ашиглана. Компанийн хамгаалалттай аж ахуй бүрийг бүртгэж, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд биохамгааллын нийтлэг зааврын бүхий л шаардлагатай элементийг компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааварт тусган зохицуулсан эсэхийг тусгайлан үнэлэх ажил багтдаг. Үүнээс гадна төрийн баталгаажуулагч этгээд үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврыг мөн лавлах баримт бичиг болгон ашиглаж болох ба компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын шаардлагыг хангаж байгаа эсэх, түүнчлэн компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврыг даган мөрдөж байгаа эсэхэд ажиглалт хийж болно.

Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж нэг бүрд хяналт шалгалт хийх давтамжийг МЭЭГ-аас дараахын аль нэг байдлаар тогтооно:

- Хэвийн давтамж = 6 сар тутамд
- Сайн гүйцэтгэлд үндэслэн цөөрүүлсэн давтамж = 12 сар тутамд
- Ноцтой үеийн давтамж = 3 сар тутамд

Оролцогч компани өөрийн компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний байгууламж нэг бүрд тэдгээрийн гүйцэтгэлд суурилан тогтоосон хяналт шалгалтын давтамжийн дагуу төрийн баталгаажуулагч этгээдээр хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх хуваарь гаргах үүрэгтэй.

Компанийн хамгаалалттай аж ахуйд хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын тайлан нь компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний байгууламж нэг бүрд хийсэн байгууламжийн хяналт шалгалтын хамгийн сүүлийн тайлангуудаас бүрдэнэ.

Төрийн баталгаажуулагч хөндлөнгийн хяналт шалгалт хийх хугацаанд холбогдох байгууламжид илэрсэн аливаа үл тохирлыг тэдгээрээс өвчин нэвтрэх эсхүл өвчингүй, тайван байдал алдагдах эрсдэл учрах байдлаар нь ӨНДӨР ЭРСДЭЛ/НОЦТОЙ, ДУНД ЭРСДЭЛ/ТОМООХОН, эсхүл БАГА ЭРСДЭЛ/ЖИЖИГ гэж ангилна. Төрийн баталгаажуулагч этгээд шаардлагатай залруулах арга хэмжээг зааж өгч болно. Оролцогч компани залруулах арга хэмжээг дараах хүснэгтийн дагуу өөрөө шийдэн хэрэгжүүлж болно.

Хүснэгт 1. Үл тохирлын ангилал, түүний мөрөөр авах арга хэмжээ

Журамласан ангилал	ISO 9001 ангилал	Эрсдэлийн зэрэгт үзүүлэх нөлөөлөл	Үл тохирлын мөрөөр авах залруулах арга хэмжээ	Хугацаа
Өндөр эрсдэлтэй	Ноцтой	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл алдагдахад хүргэх өндөр эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Өмнө нь гарсан үр дагавар байгаагүй нотолгоо гаргах	7 хоногийн дотор
Дунд эрсдэлтэй	Томоохон	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл алдагдахад хүргэх дунд зэргийн эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Эрсдэлийг цаашид бууруулж байгаа нотолгоо гаргах	1 сарын дотор
Бага эрсдэлтэй	Жижиг	Үл тохирлоос шалтгаалан өвчин нэвтрэх эсхүл баталгаажуулалтын гэрчилгээнд итгэл хүргэж болзошгүй бага зэргийн эрсдэл	Эрсдэлийг цаашид бууруулах Эрсдэлийг цаашид бууруулах чиглэлээр САЗ-д хийсэн өөрчлөлт эсхүл сургалтын талаар тайлбар өгөх	Дараагийн хяналт шалгалтаас өмнө

Шаардлага ба аргачлал:

1) Шаардлага

- а) МЭЭГ төрийн баталгаажуулагч этгээдийг томилж зөвшөөрөл олгоно.
- б) Компанийн хамгаалалттай аж ахуйн төрийн баталгаажуулагч этгээдтэй хамтран ажиллана.
 - i) Оролцогч компани бүр МЭЭГ-ын баталсан жагсаалтын компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний байгууламж нэг бүрд хөндлөнгийн хяналт шалгалт хийх төрийн баталгаажуулагч этгээдтэй тохиролцно.
 - ii) Ажлын нөхцөлийг оролцогч компани, төрийн баталгаажуулагч этгээд хоорондоо хэлэлцэн тохиролцоно. Ингэхдээ төрийн баталгаажуулагч этгээдийн хараат бус байдлыг тодорхой зааж, түүнийг хүндэтгэн үзнэ. Үзүүлсэн үйлчилгээний төлбөр үйлчилгээний үр дүнгээс ямар ч хамааралгүй байх ёстой.
 - iii) Компанийн хамгаалалттай аж ахуй хэд хэдэн аймагт байрших олон байгууламжтай бол төрийн баталгаажуулагч өөр өөр этгээд байгууламж тус бүрд хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын тайлангаа МЭЭГ-т хүргүүлнэ. Компанийн хамгаалалттай аж ахуйд хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг хамгийн сүүлд байгууламжуудад хийсэн хяналт шалгалтын тайлангуудыг нэгтгэсэн багц гэж үзнэ.
- в) Хөндлөнгийн хяналт шалгалт хийх хуваарь, гүйцэтгэл
 - i) Оролцогч компани өөрийнхөө байгууламж нэг бүрд хийлгэх хөндлөнгийн хяналт шалгалтын хуваарь гаргах үүрэгтэй ба түүнийг өмнө тохиролцсон

- ажлын нөхцөлийн дагуу төрийн баталгаажуулагч этгээдэд урьдчилан мэдэгдэнэ.
- ii) Оролцогч компани хөндлөнгийн хяналт шалгалт хийх бүрд түүнийг төлөөлөн харилцах ажилтныг томилно. Энэ ажилтан нь төлөвлөлтийн явцад төрийн баталгаажуулагч этгээдтэй харилцах ба компанийн хамгаалалттай аж ахуйд хяналт шалгалт оруулах бэлтгэл ажлыг ханган ажиллах үүрэгтэй.
 - iii) Хөндлөнгийн хяналт шалгалт бүрийг компанийн хамгаалалттай аж ахуйн шалгалтад хамрагдаж буй байгууламжийн биохамгааллын зааврын бүх асуудлыг бүхэлд нь хамран явуулна. Төрийн баталгаажуулагч этгээд нь хяналт шалгалт хийх бүрдээ ямар асуудалд төвлөрч лавшруулан шалгалт хийхээ илэрхийлж болно.
 - iv) Төрийн баталгаажуулагч этгээд хяналт шалгалт хийх үед холбогдох ажилтантай ярилцах эсхүл холбогдох баримт бичиг, нотлох баримттай танилцах хүсэлт гаргаж болох ба оролцогч компани үндэслэл бүхий бүх хүсэлтийг хангах.
- г) Хөндлөнгийн хяналт шалгалтын үеэр илэрсэн үл тохирол
- i) Хөндлөнгийн хяналт шалгалтаар илрүүлсэн үл тохирлыг холбогдох байгууламж бүрээр гаргаж ӨНДӨР эрсдэл/Ноцтой, ДУНД эрсдэл/Томоохон, эсхүл БАГА эрсдэл/Жижиг гэж ангилна (Журамласан болон ISO9001 стандартын ангилалд зааснаар).
 - ii) Төрийн баталгаажуулагч этгээд байгууламжид хяналт шалгалт хийж дууссан өдрийн хаалтын уулзалтын үеэр аливаа ӨНДӨР эрсдэл/Ноцтой эсхүл ДУНД эрсдэл/Томоохон үл тохирлыг илтгэнэ.
 - iii) Төрийн баталгаажуулагч байгууламж бүрд хөндлөнгийн хяналт шалгалт хийж дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор хөндлөнгийн хяналт шалгалт хийсэн тайлангаа бэлтгэнэ. Энэ тайланд тухайн байгууламжид илэрсэн бүх үл тохирол, тэдгээрийн ангиллыг зааж өгнө. Тайланд залруулах тусгай арга хэмжээг шууд зааж өгч болох ба эсхүл оролцогч компаниар тодорхойлуулахаар үлдээж болно. Төрийн баталгаажуулагч этгээд тайланг оролцогч компанид хүлээлгэн өгнө.
 - iv) Оролцогч компани шийдвэрээ гаргаж үл тохирол бүрийг залруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ. Тэдгээрийг дээрх хүснэгтэд заасан хугацаанд эргээд төрийн баталгаажуулагч этгээдэд тайлагнана.
- д) Хөндлөнгийн хяналт шалгалтын үр дүнг тайлагнах
- i) Оролцогч компани хөндлөнгийн хяналт шалгалтын үр дүнг МЭЕГ-т тайлагнах үүрэгтэй.
 - ii) Оролцогч компани хүлээн авсан хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг МЭЕГ-т илгээх дараа сарын тайландаа хавсаргана.
 - iii) Оролцогч компани хяналт шалгалтаар илэрсэн аливаа ӨНДӨР эрсдэл/Ноцтой эсхүл ДУНД эрсдэл/Томоохон үл тохирлыг удирдах хариу арга хэмжээг тодорхойлон сар тутамд МЭЕГ-т тайлагнана.
 - iv) Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийн статус эсхүл байгууламжид хийх хяналт шалгалтын давтамжид оруулсан аливаа өөрчлөлтийг МЭЕГ-аас оролцогч компанид шууд мэдээлнэ.
 - v) Үүний дагуу оролцогч компани дараагийн хөндлөнгийн хяналт шалгалт хийх огноог төрийн баталгаажуулагч этгээдтэй тохиролцоно.

2) Шаардлагын хангах аргачлал

- а) Оролцогч компани болон эрх бүхий төрийн баталгаажуулагч этгээдийн хооронд байгуулсан гэрээ эсхүл санамж бичиг.

- б) Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд хийх хяналт шалгалтын хуваарь, давтамж.
 - в) Хөндлөнгийн хяналт шалгалтын бэлэн-бөмсөн тайлан.
 - г) Удирдлагын зүгээс зөвшөөрсөн бүх үл тохирлыг залруулах арга хэмжээ
- 3) Хадгалах баримт бичиг, нотлох баримт (боломжтой бол хадгалах хугацаа).
- а) Оролцогч компани болон эрх бүхий төрийн баталгаажуулагч этгээдийн хооронд байгуулсан гэрээ эсхүл санамж бичиг.
 - б) Хяналт шалгалтын хуваарь
 - в) Хөндлөнгийн хяналт шалгалтын тайлан
 - г) Үл тохирол, залруулах арга хэмжээний бүртгэл

Туслах материал (САЗ-д хавсаргах нь зүйтэй):

- i. Хэсэг С. Үл тохирлын мөрөөр авсан арга хэмжээний тайлангийн загвар.
- ii. Хэсэг С. Оролцогч компани болон эрх бүхий хөндлөнгийн баталгаажуулагч этгээдийн хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар

Хувилбарыг мөшгөн олох мэдээлэл:

Одоогийн хувилбарын дугаар 0.2

Одоогийн хувилбарын статус: ТӨСӨЛ

Огноо	Хувилбарын дугаар	Тайлбар
19/03/2024	0.1	Батлуулахаар илгээсэн
25/04/2024	0.2	Захиргаа, удирдлагын гарын авлагатай нийцүүлсэн засвар: МЭЕГ төрийн баталгаажуулагч этгээдийг томилж, зөвшөөрөл олгоно. Засварт журамласан болон ISO9001 ангиллын үл тохирлыг уялдуулах завсар орсон.

Хэсэг С. Компанийн хамгаалалттай аж ахуйд зориулсан зөвлөмж, загвар, маягт

С.01. Хамгаалалттай аж ахуй бүртгүүлэх өргөдлийн маягт

Компанийн аж ахуйг бүртгүүлэх өргөдлийн маягт

Шараар тодруулсан хэсгийг өргөдөл гаргагч бөглөнө.

Тодорхойлолт	Өргөдөл гаргагч бөглөх хэсэг
Оролцогч Компанийн нэр	
Оролцогч компанийн төв байрны хаяг	
Оролцогч компанийн цахим хуудас	
Оролцогч компанийг төлөөлөн харилцах гол этгээдийн нэр	
Оролцогч компанийг төлөөлөн харилцах гол этгээдийн гүйцэтгэх үүрэг	
Оролцогч компанийг төлөөлөн харилцах гол этгээдийн имэйл хаяг	
Оролцогч компанийг төлөөлөн харилцах гол этгээдийн утасны дугаар	
Компанийн хамгаалалттай аж ахуйн нэр	<i>Санал болгох загвар: [Оролцогч компанийн нэр] Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуй</i>
Малын дэд-популяцийг бүрдүүлэгч мэдрэмтгий зүйлийн мал	<i>Үхэр, хонь ба/эсхүл ямаа</i>
Онцгойлсон өвчин	<i>үхэр: шүлхий хонь ба ямаа: шүлхий, БММӨ</i>
Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар	Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын электрон хувилбарыг энэ өргөдөлд хавсаргана.
Өргөдөл гаргасан огноо	

Нийцлийн мэдэгдэл	<p>Би, <i>[Гол харилцах хүний нэрийг оруулна уу]</i> (доор гарын үсэг зурсан) <i>[Компанийн хамгаалалттай аж ахуйн нэрийг оруулна уу]</i> болон зөвшөөрөл бүхий байгууламж (ө.х. компанийн хамгаалалттай аж ахуйд хамаарах зөвшөөрөл бүхий үйлдвэрлэл, боловсруулалтын байгууламж) бүрийг хамруулан мэдэгдэх нь:</p> <p>1. <i>[Оролцогч компанийн нэрийг оруулна уу]</i> нь Монгол улсын <i>[Мал аж ахуйн салбар]</i> хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу үүргээ биелүүлж, компанийн хамгаалалттай аж ахуйн өмчлөгчийн үүргийг гүйцэтгэх болно.</p> <p>2. <i>[Оролцогч компанийн нэрийг оруулна уу]</i> нь Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн биохамгааллын нийтлэг зааврыг компанийн журамд нэгтгэж, үүнтэй холбогдуулан компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврыг батлан гаргаж, түүнийг зөвшөөрөл бүхий бүх байгууламжид хэрэгжүүлэхээ амлаж байна.</p> <p>3. <i>[Оролцогч компанийн нэрийг оруулна уу]</i> нь зөвшөөрөл бүхий бүх байгууламжид компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврыг хянах дотоод хяналтын үр дүнтэй механизмыг боловсруулж, баримтжуулж, хэрэгжүүлэхээ амлаж байна.</p> <p>4. <i>[Оролцогч компанийн нэрийг оруулна уу]</i> нь Монгол улсын Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд, түүний дотор ээлжит хяналт шалгалт зэргээр ил тод хяналт тавих, удирдан чиглүүлэх шаардлагыг хангахаа амлаж байна.</p>
Гол харилцах этгээдийн гарын үсэг	
Гарын үсэг зурсан огноо	

С.06. Хамгаалалттай аж ахуйд байгууламж бүртгүүлэх өргөдлийн маягт

Шараар тодруулсан хэсгийг өргөдөл гаргагч бөглөнө.

Жич: Байгууламж болгонд тусдаа маягт бөглөнө.	
Тодорхойлолт	Өргөдөл гаргагч бөглөх хэсэг
Оролцогч компанийн нэр	
Байгууламжийн нэр	
Байгууламжийн хаяг	
Байгууламжийн газар зүйн байршлын солбицол	
Байгууламжийг төлөөлөн харилцах гол этгээдийн нэр	
Байгууламжийг төлөөлөн харилцах гол этгээдийн гүйцэтгэх үүрэг	
Байгууламжийг төлөөлөн харилцах гол этгээдийн имэйл хаяг	
Байгууламжийг төлөөлөн харилцах гол этгээдийн утасны дугаар	
Байгууламжийн ангилал*	
Энэ байгууламжид хяналт шалгалт хийх хөндлөнгийн баталгаажуулагч	
Өргөдөл гаргасан огноо	
Нийцлийн мэдэгдэл	Би, [Гол харилцах хүний нэрийг оруулна уу] (доор гарын үсэг зурсан) [байгууламжийн нэрийг оруулна уу] -ийн нэрийн өмнөөс энэхүү өргөдлийн маягтад оруулсан мэдээлэл үнэн зөв бөгөөд байгууламж нь [Компанийн хамгаалалттай аж ахуйн нэрийг оруулна уу]-ын биохамгааллийн зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг болохыг мэдэгдэж байна.
Гол харилцах этгээдийн гарын үсэг	
Гарын үсэг зурсан огноо	

*Байгууламжийн ангилал:

A. Ерөнхий байгууламж: гадны олон эх үүсвэрээс эрүүл мэнд, тавлаг байдлаар тэнцсэн мал, амьтныг хүлээн авч тэжээлд дасгах, бүлэглэн маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

B. Бордооны байгууламж: өсвөр малыг бүлэглэн байран маллах зориулалттай үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж.

C. Ерөнхий болон бордооны нэгдмэл байгууламж: ерөнхий болон бордооны үйл ажиллагаа хослуулан эрхлэх үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

D. Үржүүлэг, үйлдвэрлэлийн нэгдсэн байгууламж: гаднаас мал, амьтан авах хэрэгцээг багасгах зорилгоор үржүүлгийн сүрэг, мал, амьтан өсгөн бойжуулах хэсэг бүхий үйлдвэрлэлийн нэг төрлийн байгууламж

E. Төхөөрөх болон боловсруулах байгууламж: мал, амьтныг төхөөрч, гулуузыг нь боловсруулах үйл ажиллагаа явуулах байгууламж

F. Үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэгдсэн байгууламж: үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах үйл ажиллагааг явуулах нэг дор байршуулсан байгууламж

G. Үржүүлэг, үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах нэгдсэн байгууламж: үржүүлэг, үйлдвэрлэх, төхөөрөх, боловсруулах үйл ажиллагааг явуулах нэг дор байршуулсан байгууламж

Zero Draft

C.03. Тогтмол илгээх тайлангийн загвар

Сар тутмын тайлангийн загвар

Оролцогч компанийн нэр:	
Оролцогч компани, компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэлийн дугаар:	
Сар:	
Жил:	
Хэвийн бус үйл явдлын төрөл, тохиолдсон огноо (статус=шинэ):	Байгууламж, үйл явдлын тодорхойлолт, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулна:
Биохамгааллын ноцтой зөрчил (CAЗ B.15) эсхүл эрүүл мэндийн судалгаа шинжилгээ хийхэд хүргэсэн гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт (CAЗ B.16) эсхүл эхлүүлсэн малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээ (CAЗ B.20)	Үйл явдлын тодорхойлолт: Байгууламж: Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө:
Хэвийн бус үйл явдлын төрөл, тохиолдсон огноо (статус=үргэлжилж буй):	Эрсдэлийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл:
<i>Өмнөх тайлангаас хойш болж байгаа бүх үйл явдлын эхэлсэн огноо, төрөл</i>	<i>Эрсдэлийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэлийг өгүүлнэ</i>
Хэвийн бус үйл явдлын төрөл, тохиолдсон огноо (статус=шийдвэрлэсэн):	Эрсдэлийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл:
<i>Өмнөх тайлангаас хойш сарын хугацаанд шийдвэрлэгдсэн бүх үйл явдлын эхэлсэн огноо, төрөл</i>	<i>Эрсдэлийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл, түүний болон үйл явдлын үр дагавар</i>
Хөндлөнгийн хяналт шалгалтад хамрагдах байгууламж:	Хөндлөнгийн хяналт шалгалт хийсэн огноо:
Нотлох баримт, мэдэгдэл	
Дээр жагсаасан байгууламжийн хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг хавсаргана.	
Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийн дагуу жагсаасан бүх байгууламж нь биохамгааллын зааврын шаардлага, тэр дундаа хамгаалалттай аж ахуйд маллаж байгаа мэдрэмтгий зүйлийн малд хамаарах онцгойлсон өвчний сэжигтэй эсхүл батлагдсан тохиолдол байхгүй байх шаардлагыг хангаж байгаа болох мэдэгдэл Үүнд: үхэрт: шүлхий; хонь ба ямаанд: шүлхий, БММӨ.	

Компанийн хамгаалалттай аж ахуйн гол харилцах этгээдийн гарын үсэг :	
Нэр	
Огноо:	

Жил бүрийн тайлангийн загвар

Оролцогч компанийн нэр:	
Оролцогч компани болон компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэлийн дугаар :	
Жил:	
Биохамгааллын зааврын өөрчлөлт, шинэчлэлт:	Биохамгааллын зааварт оруулсан аливаа өөрчлөлт, шинэчлэлтийг тодорхойлж, тэдгээрийг лавлах САЗ-ын дугаар, шинэчлэлт хийх шалтгааныг өгүүлнэ.
Байгууламж – Популяци	Популяцийн тооллогын дүн:
<i>Байгууламжийн нэр, бүртгэлийн дугаар:</i>	<i>Жилийн эцэст тоологдсон малын тоо, мэдрэмтгий зүйл тус бүрээр + төхөөрсөн + ачуулсан</i>
Байгууламж - өвчнөөр тайван болохыг нотлох судалгаа	Өвчнөөр тайван болохыг нотлох талаар хийж байгаа судалгааны тоо
<i>Байгууламжийн нэр, бүртгэлийн дугаар:</i>	<i>Тайлангийн жилийн хугацаанд өвчнөөр тайван болохыг нотлох судалгаанд хамрагдсан мэдрэмтгий зүйлийн мал бүхий үйлдвэрлэлийн нэгжийн нийт тоо</i>
Байгууламж – Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ:	Гэрчилгээ олгосны дараахачилтын тоо, төрөл
<i>Байгууламжийн нэр, бүртгэлийн дугаар::</i>	<i>1. Ачуулсан малын тодорхойлолт: (мэдрэмтгий зүйл тус бүрээр: ачилтын тоо, ачуулсан малын нийт тоо толгой) 2. Ачуулсан үржүүлгийн бүтээгдэхүүний тодорхойлолт: (мэдрэмтгий зүйл тус бүрээр: ачилтын тоо, ачуулсан үрийн гуурсны нийт тоо, ачуулсан хөврөл үрийн гуурсны нийт тоо) 3. Ачуулсан мах, махан бүтээгдэхүүний тодорхойлолт: (мэдрэмтгий зүйл тус бүрээр: ачилтын тоо, савлагааны нэгжийн тоо, төрөл, нийт жин)</i>
Байгууламж – малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээс	Огноо, тодорхойлолт
<i>Байгууламжийн нэр, бүртгэлийн дугаар:</i>	<i>Судалгаа шинжилгээ хийхэд хүргэсэн үйл явдлын огноо, судалгааны явц, үр дүнгийн товч тодорхойлолт бичнэ</i>
Малын тавлаг байдал – хийсэн ажлаа тодорхойлно:	

Бичил биетний эсрэг нийцэмжтэй хөтөлбөр – хийсэн ажлаа тодорхойлно:	
Нотлох баримт, мэдэгдэл	
Бүх байгууламжийн хэмжээнд хийсэн өвчингүй, тайван болохыг нотлох судалгааны тайланг хавсаргана.	
Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн гэрчилгээний албан ёсны бүртгэлийн хуулбарыг хавсаргана.	
Компанийн хамгаалалттай аж ахуйн гол харилцах этгээдийн гарын үсэг :	
Нэр	
Огноо:	

Zero Draft

С.04. Үл тохирлын мөрөөр авах арга хэмжээний тайлангийн загвар

Доорх маягыг ӨНДӨР ЭРСДЭЛ/НОЦТОЙ, ДУНД ЭРСДЭЛ/ТОМООХОН үл тохирлыг залруулах удирдлагын хариу арга хэмжээг байгууламжаас тухайн үл тохирлыг шийдвэрлэн хаах хүртэл сар бүр тайлагнахад ашиглана.

Оролцогч компани:				
Байгууламж:				
Хөндлөнгийн хяналт шалгалт хийсэн огноо:				
Үл тохирол	Ангилал	Тодорхойлолт (биохамгааллын зааврын лавлагаа орно)	Удирдлагын хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	Төлөв байдал

C.05. Компанийн хамгаалалттай аж ахуй гэрчилгээний загвар

**Монгол улсын хивэгч малын
хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоонд тавих
техникийн шаардлага хангасны дагуу**

[Компанийн хамгаалалттай аж ахуйн нэр]-д

[Оролцогч компанийн нэр]-аас

олгосон

Компанийн хамгаалалттай аж ахуй гэрчилгээ

Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээг олгосон оролцогч компани:

Оролцогч компанийн нэр	Компанийн хамгаалалттай аж ахуй нэр	Байгууламжийн нэр

Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээнд хамрагдах [үхэр/хонь/ямаа]-аас гаралтай [амьд мал/мал, амьтны генетикийн материал/мах, махан бүтээгдэхүүн]-ийн ачааны дэлгэрэнгүй мэдээлэл:

Ялган тэмдэглэгээ:	Тодорхойлолт	Тоо хэмжээ (Тоо/Жин)

Дээр тодорхойлсон [үхэр / хонь / ямаа]-аас бэлтгэсэн [Мал / Генетикийн материал / Махан, махан бүтээгдэхүүн] бүхий ачаа нь энэ байгууламжаас [огноо]-ний өдөр гарсан бөгөөд тухайн хугацаанд энд дурдсан ачаа болон гарал үүслийн байгууламж нь Монгол улсын хууль тогтоомж, журам болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-аас зөвшөөрч, баталгаажуулсан техникийн нөхцөлийн дагуу Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд тавигдсан бүх шаардлагыг хангасан бөгөөд шүлхий өвчин, бог малын мялзан өвчингүй (БММӨ) [Жич: Ачаанд багтсан барааг үхрээс бэлтгээгүй бол БММӨ-ийг устгах], тайван болно. Дээрх шаардлагыг МЭЕГ-ын цахим хуудаснаас [www.XXXXX] олон нийт үзэх боломжтой.

Олгосон огноо:
Гарын үсэг:
Нэр:
Албан тушаал:

С.06 Оролцогч компани болон лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэх эрх бүхий бүхий этгээд хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйд лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд болон оролцогч компанийн хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар

Нэг талаас:

Компани (цаашид “Захиалагч” гэх):

түүнийг төлөөлж (Нэр: албан тушаал):

Нөгөө талаас:

Мал эмнэлгийн лаборатори (цаашид “Гүйцэтгэгч” гэх):

түүнийг төлөөлж (Нэр: албан тушаал):

нар дор дурдсан гэрээг байгуулав.

1. Энэхүү гэрээнд хамрагдах компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж

[Компанийн нэр]-ын компанийн хамгаалалттай аж ахуйн дор дурдсан байгууламжид лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлнэ:

- а) 1-р байгууламжийн нэр, хаяг:
- б) 2-р байгууламжийн нэр, хаяг:
- в) гэх мэт:

2. Ерөнхий зүйл

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн (баталгааг хангах тогтолцоо) хууль, журам, техникийн стандартын дагуу зөвшөөрөл олгосон компанийн хамгаалалттай аж ахуйд лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хэлэлцэн тохиролцохдоо оролцогч компани (Захиалагч) болон мал эмнэлгийн лаборатори (Гүйцэтгэгч) энэхүү үйлчилгээ үзүүлэх гэрээний загварыг жишиг болгон ашиглаж болно.

Баталгааг хангах тогтолцооны иж бүрэн стратеги, бүтэц, техникийн шаардлагыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, хамгаалалттай аж ахуйн журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар, захиргаа, удирдлагын гарын авлагд тодорхойлсон болно. Баталгааг хангах тогтолцоо нь онцгойлсон өвчингүй, тайван гэдгийн нотолгоо болж өгдөг стандартчилагдсан биохамгааллын тогтолцоог Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулан бий болгох, хэрэгжүүлэх боломжийг оролцогч компаниудад олгодог арга зам юм.

Оролцогч компани биохамгааллын зааврыг боловсруулах ба түүнийг хөтөлбөрийн шаардлага хангасан нөхцөлд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн

ерөнхий газар (МЭЭГ) батална. Оролцогч компани биохамгааллын зааврыг тухайлсан байгууламжуудад хэрэгжүүлснийхээ дараа тэдгээр байгууламжид компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл авна.

ДМАЭМБ-ын олон улсын стандартад лабораторийн оношлох үйлчилгээ явуулах аргазүй чанарын баталгаа, мал эмнэлгийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгох, хяналт тавих шаардлагыг зааж өгсөн байдаг. Тэдгээр олон улсын стандартыг хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны баримт бичигт эш татан оруулсан болно.

Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт хамаарах онцгойлсон өвчин:

Үхэрт: шүлхий өвчин

Хонь ба ямаанд: шүлхий өвчин, бог малын мялзан өвчин (БММӨ)

3. Үйлчилгээний ерөнхий тодорхойлолт

Захиалагч нь шаардлага гарсан үед компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж тус бүрээс цуглуулсан сорьцод зөвшөөрөгдсөн аргаар оношлох шинжилгээ хийлгэх үйлчилгээ авна. Сорьц цуглуулж, шинжилгээ хийх ажлыг өвчингүй, тайван болохыг нотлох тогтмол судалгааны үеэр эсхүл шаардлага гарсан үед хийдэг малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний үеэр хийнэ. Шинжилгээний зорилго нь онцгойлсон өвчин байгаа эсхүл байхгүй болохыг баталгаажуулахад оршино. Өвчингүй, тайван болохыг нотлох судалгааг [6 сар тутамд] компанийн хамгаалалттай аж ахуй байгууламж бүрийн үйлдвэрлэлийн нэгж бүрд явуулж лабораторийн оношлох шинжилгээг биохамгааллын зааварт заасан түүврийн хэмжээ, санамсаргүй түүвэрлэлт, сорьцын савлалт, лабораторид илгээх, сорьцыг нийлүүлж шинжлэх, лабораторийн зөвшөөрөгдсөн арга хэрэглэх, үр дүнг мэдээлэхэд тавих шаардлагыг ханган хийж гүйцэтгэнэ. Хяналт-шинжилгээгээр малын эрүүл мэндийн үйл явдал илэрвэл малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээ хийж мал эмнэлгийн мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээр онцгойлсон өвчнийг шинжилгээ хийж ялгаварлах шаардлагатай гэж үзвэл лабораторийн оношлох шинжилгээ хийнэ.

4. Үүрэг хариуцлага

- а. Хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны баримт бичигт тус гэрээний Захиалагчийг оролцогч компани гэж, Гүйцэтгэгчийг оношилгооны лаборатори гэж тус тусых нь үүрэг хариуцлагыг заасныг энд хураангуйлан оруулав.
- б. Захиалагч нь өөрийн компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл бүхий бүх байгууламжийг, тэр дундаа тэдгээр байгууламжид маллаж байгаа мэдрэмтгий зүйлийн малд хамаарах онцгойлсон өвчингүй, тайван нотолгоо гаргадаг тандалтын тогтолцоог бий болгож, удирдах үүрэгтэй.
- в. Захиалагч нь өвчингүй, тайванг нотлох судалгааг шаардлагатай цаг хугацааны хүрээнд хуваарийн дагуу зохион байгуулж, малын эрүүл мэндийн судалгаа хийхэд оношилгооны лабораториор шинжилгээ хийлгэх шаардлагатай эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Захиалагч нь оношилгооны лабораторийн шинжилгээ хийлгэхийг хүссэн сорьцыг хүлээлгэн өгөх, хүргүүлэх талаар Гүйцэтгэгчид хангалттай хугацааны өмнө урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- г. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ирүүлсэн сорьцод баталгааг хангах тогтолцооны шаардлага, ДМАЭМБ-ын олон улсын стандартын дагуу оношлох шинжилгээг хараат бусаар, үнэнч шударгаар гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

5. Үйлчилгээний хамрах хүрээ

- a. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж
- i. Захиалагч нь компанийн хамгаалалттай аж ахуйд хамруулах байгууламжийг тогтооно. Тэдгээр байгууламжийг энэхүү үйлчилгээ үзүүлэх гэрээний дээрх 1-р зүйлд жагсаана.
 - ii. Гүйцэтгэгч нь өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт орших компанийн хамгаалалттай аж ахуйн аль ч байгууламжид оношилгооны лабораторийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрнө.
 - iii. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж өөр өөр нутаг дэвсгэрт харьяалагддаг бол Захиалагч нь тэдгээр байгууламж бүрд оношилгооны лабораторийн үүргийг гүйцэтгэх Гүйцэтгэгчийг сонгон үйлчилгээ авах үүрэгтэй.
 - iv. Захиалагч нь Гүйцэтгэгчийн харьяаллын нутаг дэвсгэрт хамаарах компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийнхаа тоог нэмэх эсхүл хасах хүсэлтэй байгаагаа Гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Гүйцэтгэгчийн оношлох үйлчилгээ үзүүлэх байгууламжийн тоог нэмэх эсхүл хасах нь энэхүү гэрээг шинэчлэх үндэслэл болно.
- б. Магадлан итгэмжлэгдсэн лабораторид хэрэглэж байгаа оношилгооны зөвшөөрөгдсөн аргын хүртээмж
- i. Гүйцэтгэгч нь онцгойлсон өвчинд зориулан хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд зөвшөөрөгдсөн оношлох шинжилгээний аргын жагсаалтыг гаргана. Тэдгээрийг 1 дүгээр хавсралтын 2-р хүснэгтэд жагсаасан болно.
 - ii. Гүйцэтгэгч нь өөрийн лабораторийн оношлох шинжилгээний үйлчилгээг ISO 17025 стандартын дагуу магадлан итгэмжлүүлсэн байх бөгөөд магадлан итгэмжлэлийн хамрах хүрээнд хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрөөр зөвшөөрөгдсөн онцгойлсон өвчнийг оношлох шинжилгээний арга орсон байна.
 - iii. Захиалагч нь Гүйцэтгэгчээс компанийн хамгаалалттай аж ахуйн доторх байгууламжийн үйлдвэрлэлийн нэгжид тогтмол хийгдэх өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэх зорилгоор санал болгосон оношлох шинжилгээний зөвшөөрөгдсөн аргыг багтаасан тандалтын төлөвлөгөөг боловсруулна. Оношилгооны зөвшөөрөгдсөн аль аргыг сонгох нь сорьц түүвэрлэсэн үйлдвэрлэлийн нэгж дэх онцгойлсон өвчнөөс хамгаалах дархлаажуулалтын байдал, Гүйцэтгэгчийн санал болгох оношилгооны аргыг шууд хэрэглэх боломж зэргээс хамаарна. Тэдгээрийг 1 дүгээр хавсралтын 3-р хүснэгт эсхүл 3, 4 дүгээр хүснэгтэд жагсаасан болно.
 - iv. Оношлох шинжилгээнд ашиглах урвалж бодис, багаж хэрэгсэл, хүн хүчний хүртээмжээс шалтгаалсан саатал гаргахгүйн тулд Гүйцэтгэгч нь оношлох шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан Захиалагч талд шинжилгээ хийж дуусгахад шаардагддаг хугацааны (ө.х. сорьц урьдчилан хүлээн авах хугацаа) талаар тодорхой ойлголт өгсөн байна.
- в. Оношилгооны лабораторид шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах
- i. Захиалагч нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгж эсхүл нэгжүүдэд (эсхүл компанийн хамгаалалттай аж ахуй гэж батлагдахаас өмнө тандалт хийх байгууламж) өвчингүй, тайван болохыг нотлох судалгааг хийхээр товлосон хугацааг Гүйцэтгэгч талд урьдчилан мэдэгдэнэ. Захиалагч сорьцын тоо, сорьц авах огноог 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө урьдчилан мэдэгдэнэ.
 - ii. Захиалагч нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид хийх онцгойлсон өвчнийг ялгаварлан оношлох шинжилгээнд зориулан хэзээ сорьц цуглуулахыг Гүйцэтгэгч талд урьдчилан мэдэгдэнэ. Захиалагч авах сорьцын

барагцаа тоо, сорьцын төрөл, сорьц авах огноог түргэн хувьсах амаргүй нөхцөлд аль болох эрт мэдэгдэнэ.

- iii. Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүссэн шинжилгээг сорьц хүлээн авах өдрөө шинжлэхэд бэлэн, боломжтой байгаагаа баталгаажуулж, шаардагдах урвалж бодис, багаж төхөөрөмж, хүн хүчээ бэлтгэн шинжилгээг саатал гаргалгүйгээр хийх ба шинжлэх хүртлээ сорьцыг баталгаатай нөхцөлд хадгална.
- г. Сорьц авах, илгээх, хүлээн авах, шинжлэх
- i. Байгууламжийн малаас сорьц авах ажлыг Захиалагч гүйцэтгэнэ. Үйлчилгээ үзүүлэх энэхүү гэрээний хүрээнд шинжилгээнд авах энгийн сорьц нь [ямар нэг нэмэлтгүй хуруу шилэнд авах бүтэн цус, нэг малаас нэг сорьц эсхүл фосфатын буфержүүлсэн уусмалтай хуруу шилэнд авсан хамар залгиурын арчдас, нэг малаас авсан хоёр талын арчдас (хоёр арчдасыг нэг хуруу шилэнд хамт хийж болно)] байна.
 - ii. Захиалагч нь сорьцыг хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн дор дурдсан шаардлагын дагуу шошголж савлан Гүйцэтгэгч талд илгээнэ:
 - а) Хуруу шилэн дээр шошголох аль эсхүл дараах мэдээллийг тайлж унших боломжтой код бэхэлж өгнө. Үүнд: сорьц авсан огноо, малын зүйл, ялгах тэмдэглэгээний мэдээлэл (чухалчилна), үйлдвэрлэлийн нэгж (заавал), онцгойлсон өвчнөөс хамгаалах дархлаажуулалтын байдал, зорилго (өвчингүй, тайванг нотлох судалгаа эсхүл малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээ), оролцогч компанийн байгууламж
 - б) Сайтар хамгаалан хүйтэн хэлхээний нөхцөл бүрдүүлэн давхар саванд савласан байна.
 - в) Гүйцэтгэгч талд 48 цагийн дотор хүргэхээр яаралтай илгээнэ.
 - iii. Гүйцэтгэгч сорьцыг хүлээн аваад үйлдвэрлэлийн нэг нэгжээс ирсэн бүлэг сорьц бүрийг хүлээн авсан нэг багц болгоно.
 - iv. Захиалагчтай гэрээ байгуулсан Гүйцэтгэгч хэрэв хамар залгиурын арчдасны дээжийг ПГУ-аар шинжлэх бол нэг үйлдвэрлэлийн нэгжээс ирсэн 5 хүртэл сорьцыг нэг төрлийн шинжилгээнд зориулан нийлүүлж болно. Нийлүүлсэн дээж сөрөг дүн үзүүлбэл түүнд орсон бүх дээжийг сөрөг гэж үзнэ. Нийлүүлсэн дээж ЭЕРЭГ дүн үзүүлбэл Гүйцэтгэгч нийлүүлсэн бүх дээжийг тус тусад нь дахин шинжилж үр дүнг тус бүрээр нь гаргана.
 - v. Гүйцэтгэгч нь ISO 17025 стандартын магадлан итгэмжлэлд дурдсан олон улсын болон улсын стандарт шинжилгээний аргачлалыг мөрдөн оношилгоонд зөвшөөрөгдсөн, гэрээгээр тохиролцсон аргаар оношлох шинжилгээ хийнэ.
- д. Үр дүнг тайлагнах
- i. Гүйцэтгэгч үйлдвэрлэлийн нэг нэгжээс ирсэн сорьцын багц бүрийн үр дүнгийн тайланг бэлтгэнэ. Тайланд Гүйцэтгэгчийн ISO 17025 стандартын магадлан итгэмжлэлд заасан ёсоор эрх олгосон ажилтан гарын үсэг зурна.
 - ii. Гүйцэтгэгч үр дүнгийн тайланг Захиалагч талд аль болох хожимдуулахгүйгээр илгээнэ. Хэрэв Гүйцэтгэгч сорьц хүлээн авснаас хойш ажлын гурваас дээш өдрөөр хожимдуулна гэж тооцвол сорьц хүлээн авч бүртгэлд оруулах үедээ эсхүл хожимдуулах нөхцөл үүсэнгүүт түүнийг илтгэнэ.
 - iii. Гүйцэтгэгч бүх үр дүн, түүний дотор ЭЕРЭГ үр дүнг нууцална.
 - iv. Захиалагч нь онцгойлсон өвчинд холбогдох аливаа ЭЕРЭГ үр дүнг хууль тогтоомжийн шаардлагын дагуу МЭЕГ-д мэдэгдэх үүрэгтэй.

6. Үйлчилгээний шинж чанар

- a. Төлөөлөн харилцах этгээд
 - i. Захиалагч болон Гүйцэтгэгч хоёулаа тэдгээрийг төлөөлөн харилцах хүнийг томилж, энэ гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүх харилцааг тэдгээр төлөөллөөр дамжуулан явуулна.
 - ii. Захиалагч эсхүл Гүйцэтгэгч аль нэг талын төлөөлөл солигдсон тохиолдолд нөгөө талдаа 24 цагийн дотор мэдэгдэнэ.

- б. Чанар:
 - i. Захиалагч нь баталгааг хангах тогтолцооны, тэр дундаа онцгойлсон өвчингүй, тайван байдлаа хадгалахтай холбоотой шаардлагыг хэвийн нөхцөл байдалд ханган биелүүлж байгааг өндөр түвшинд баталгаажуулж чадах биохамгааллын батлагдсан заавар, түүний дотор дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг амлалт хүлээнэ.
 - ii. Захиалагч нь ISO 17025 стандартын магадлан итгэмжлэлд дурдсан олон улсын болон улсын стандарт, шинжилгээний аргачлалыг мөрдөн оношлох үйлчилгээ үзүүлнэ.

- в. Баримтлах хугацаа
 - iii. Захиалагч болон Гүйцэтгэгч тандалтыг төлөвлөх үеэр хоёул мэдээлэл харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллах замаар аль нэг талаас ирсэн аливаа хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор хариу өгч байх амлалт үүрэг хүлээнэ.
 - iv. Өвчингүй, тайванг нотлох судалгааг баталгаа хангах тогтолцоод урьдчилан төлөвлөсөн ёсоор явуулах цаг хугацааны боломж хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор тавьсан хүсэлтийг биелүүлэх болон энэхүү гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээнд холбогдох асуудал эсхүл саад бэрхшээл тулгарвал Захиалагч болон Гүйцэтгэгч хоёр тал аль нэг талдаа урьдчилан мэдэгдэх амлалт үүрэг хүлээнэ.
 - v. Захиалагч өвчингүй, тайванг нотлох судалгааны төлөвлөгөөг 3, хамгийн багадаа 2 долоо хоногийн өмнө Гүйцэтгэгч талд мэдэгдэнэ.
 - vi. Захиалагч онцгойлсон өвчнийг үгүйсгэх зорилгоор сорьц авч шинжлэх магадлалтай малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний талаар аль болохоор удаалгүйгээр Гүйцэтгэгчид мэдээлнэ.
 - vii. Захиалагч бүх сорьцыг авснаас хойш Гүйцэтгэгч талд 48 цагийн дотор, муутгалгүйгээр хүргэсэн байх амлалт үүрэг хүлээнэ.
 - viii. Гүйцэтгэгч оношлох шинжилгээг хэвийн нөхцөл байдалд ажлын 3 өдрийн дотор хийж үр дүнг тайлагнах, хэрэв ингэж чадахааргүй бол аль болох эрт мэдэгдэх амлалт үүрэг хүлээнэ.

- г. Нууцлал
 - i. Захиалагч нь малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаар Гүйцэтгэгч талд сорьц хүлээлгэн өгөх үед эсхүл өмнө нь мэдээлэх үүрэгтэй бөгөөд ингэснээр Гүйцэтгэгч тал оношлох ямар шинжилгээг хэр яаралтай хийх шийдвэрээ гаргана.
 - ii. Гүйцэтгэгч малын эрүүл мэндийн судалгаа шинжилгээний бүх мэдээлэл, бүх үр дүн, түүний дотор ЭЕРЭГ үр дүнг нууц гэж үзэн нууцлан ажиллана.
 - iii. Захиалагч нь онцгойлсон өвчинд холбогдох аливаа ЭЕРЭГ үр дүнг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу МЭЕГ-т мэдэгдэх үүрэгтэй.

7. Маргаан шийдвэрлэх

- а. Захиалагч болон Гүйцэтгэгч энэхүү гэрээнд тусгагдсан ажлыг үнэнч шударгаар хэрэгжүүлэн ажиллах амлалт үүрэг хүлээнэ.
- б. Хүссэн үйлчилгээгээр хангах Гүйцэтгэгчийн чадвар, үндэслэлтэй хүсэлтэд Захиалагчийн хариу өгөх байдал, үйлчилгээний хугацаа, чанар, эсхүл үйлчилгээний төлбөр, түүний төлөлттэй холбоотойгоор Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд аливаа маргаан үүсвэл талуудаас томилогдсон төлөөлөл хоорондоо нээлттэй, ажил хэрэгч байдлаар харилцан ярилцаж асуудлыг шийдвэрлэхийг талууд дээд зэргээр эрхэмлэх амлалт үүрэг хүлээнэ.
- в. Ийм маргаан үүссэн бүх нөхцөлд Захиалагч болон Гүйцэтгэгч маргаан үүссэн асуудлаар өөрсдийн байр сууриа аль нэг талдаа бичгээр тодорхой илэрхийлнэ. Маргаантай асуудлыг зөвшилцөн тохиролцож шийдвэрлэсний дараа түүнийг мөн бичиж баримтжуулна.
- г. Нээлттэй, ажил хэрэгч байдлаар ярилцаж, албан бичгээр харилцан маргааныг шийдвэрлэж чадаагүйгээс маргаан цааш өрнөсөн тохиолдолд эхлээд Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлагаас оролцуулж тэдэнд маргаантай асуудлыг бичгээр тодорхойлон, талуудын байр суурийн хамт танилцуулна. Хоёр тал харилцан зөвшилцөлд хүрч үүссэн маргааныг шийдвэрлэх зорилгоор Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлагууд харилцан ярилцна.
- д. Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлага асуудлыг шийдэж чадахгүй бол Захиалагч болон Гүйцэтгэгч аль аль тал нь МЭЕГ-т мэдэгдэнэ. Захиалагч болон Гүйцэтгэгчийн хоорондын харилцаа тасарснаас энэхүү гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээ цаашид баталгаагүй болох учраас дээрх мэдэгдлийг яаралтай өгнө. Ийм тохиолдолд шаардлагатай үйлчилгээг өөр этгээд үзүүлж чадах, энэ хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн батлагдсан статуст нөлөөлөх эсэхийг МЭЕГ харгалзан үзнэ.

8. Үйлчилгээний төлбөрийн жишиг ба нэхэмжлэл

- а. Үйлчилгээний төлбөрийг үзүүлсэн үйлчилгээний үр дүнгээс хамаарахгүй байхаар тогтоох ёстой ба ингэснээр бие даасан, хараат бус байдлын баталгаа хангагдана.
- б. Энэ гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхэд гарсан бодит зардал болон бусад үндэслэл бүхий зардлыг Захиалагчаас бүрэн нөхөж авах нь нягтлан бодох бүртгэлийн зарчим юм.
- в. Гүйцэтгэгчийн зардлыг Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн нэгж шинжилгээний үнийг үндэслэн гаргах бөгөөд хийлгэх шинжилгээний тооноос хамааруулан багцаалсны үндсэн дээр үнэ тохиролцож болно. Энэ зохицуулалтын хүрээнд хийх жилийн шинжилгээний барагцаалсан тоог үндэслэн зөвшөөрөгдсөн шинжилгээ нэг бүрийн зардлыг 1-р хавсралтын 2-р хүснэгтэд үзүүлсэн болно.
- г. Үнэ тогтооход дараах зүйлийг харгалзана:
 - i. Сорьц хүлээн авах, бүртгэж авах, нийлмэл сорьц бэлтгэх (нэмэлт зардал гарахааргүй, шинжилгээний үнэд ороогүй нөхцөлд)
 - ii. Хэрэв УТ-ПГУ-аар шинжилгээ хийнэ гэж тохиролцсон бол:
 - а) Нийлүүлсэн дээжээс нуклеин хүчлийг ялгах зардал
 - б) Онцгойлсон өвчин бүрд зориулан нийлүүлсэн дээж бүрд УТ-ПГУ-аар шинжлэхэд гарах зардал
 - iii. Хэрэв өөр шинжилгээ хийлгэхээр гэрээлсэн бол тухайн нэгж шинжилгээ хийх зардал
- д. Захиалагч болон Гүйцэтгэгч хамтран лабораторийн оношлох үйлчилгээний зардлыг дараах зүйлийг үндэслэн тооцоолж барагцаагаар гаргана:

- i. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүр дэх үйлдвэрлэлийн нэгжийн тоог мэдсэн байх,
- ii. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн бүх үйлдвэрлэлийн нэгжид хийх өвчингүй, тайванг нотлох судалгааны давтамжийг харгалзах,
- iii. Сорьц авах үед үйлдвэрлэлийн нэгж нь ТОГТВОРТОЙ эсхүл ТОГТВОРГҮЙ байсан эсэхийг харгалзах,
- iv. Үйлдвэрлэлийн нэгж бүрд онцгойлсон өвчин тус бүрээр хийх өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэх оношлох шинжилгээний аргын талаарх шийдвэр,
- v. Нийлүүлсэн дээж хэрхэн бэлтгэх тохиролцоо.
- e. Жил бүрийн эхэнд Захиалагч болон Гүйцэтгэгч тухайн жилийн үйлчилгээний нөхцөлтэй холбоотой гарах зардлыг барагцаалан тооцно.
- ж. Гүйцэтгэгч ажлын үр дүнг илгээснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэл бэлтгэхээр тохирно.
- з. Захиалагч зөрчилгүй нэхэмжлэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор төлбөр төлөхөөр тохирно.
- и. Үйлчилгээний өр төлбөртэй холбоотой аливаа маргааныг юуны өмнө дээр өгүүлсэн маргаан шийдвэрлэх хэсгийг мөрдөн шийдвэрлэнэ. Талууд өр төлбөртэй холбоотой маргааныг бусад аргаар шийдвэрлэж чадахгүй бол хуулийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй.

9. Гэрээг нягтлан хянах

- a. Үйлчилгээ үзүүлэх энэхүү гэрээг аль нэг тал нь цуцлах хүсэлтээ нөгөө талдаа хамгийн багадаа 3 сарын өмнө мэдэгдэж цуцлах хүртэл уг гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- б. Захиалагч болон Гүйцэтгэгч компанийн хамгаалалттай аж ахуйн үйлчлэх байгууламжийн тоо нэмэгдэх эсхүл хасагдах бүрд үйлчилгээ үзүүлэх гэрээг нягтлан хянаж шинэчилнэ.
- в. Захиалагч болон Гүйцэтгэгч гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 жилийн дотор гэрээг нягтлан хянаж шинэчилнэ.
- г. Гүйцэтгэгч нь МЭЕГ эсхүл Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос тогтоосон шинжилгээний үнэ төлбөрийн аливаа өөрчлөлтийг Захиалагч талд мэдэгдэх ба харин шинэ үнийг Захиалагчийн өмнө нь нэгэнт захиалсан сорьцод нөлөөлөхгүйгээр Гүйцэтгэгчийн урьдчилан товлосон өдрөөс эхлэн хэрэглэнэ.

10. Лавлах баримт бичиг

- a. Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуй: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар
- б. Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар
- в. ISO 17025
- г. *Үйлчилгээ үзүүлэх зохицуулалт хийх явцад компанийн хамгаалалттай аж ахуйд лабораторийн шинжилгээний үйлчилгээ авах хэрэгцээ, үнийг тооцоолсон байдал,*
- д. Үйлчилгээ үзүүлэгчийн хийх боломжтой шинжилгээний болон тэдгээрт холбогдох үнийн албан ёсны бүртгэл.

**Компанийг төлөөлж гарын үсэг зурсан
(-Захиалагч гэх):**

.....

Нэр:
Албан тушаал):
Огноо

Болон
Мал эмнэлгийн лаборатори
(Гүйцэтгэгч гэх):
Нэр:
Албан тушаал):
Огноо

Zero Draft

Хавсралт 1. Тандалтын зорилгоор хийхээр тохиролцсон оношлох шинжилгээ

1. Баталгааг хангах тогтолцооны хүрээнд онцгойлсон өвчний оношилгоонд хэрэглэхийг зөвшөөрсөн оношлох шинжилгээний арга

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааварт оношилгооны дараах аргыг онцгойлсон өвчний оношилгоонд олон улсын стандартад нийцүүлэн хэрэглэх баталгааг хангах тогтолцооны хүрээнд зөвшөөрсөн байна.

Хүснэгт 1. Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн хүрээнд хэрэглэхийг зөвшөөрсөн оношилгооны арга (Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын 3 дугаар хүснэгтээс хуулбарлав).

Өвчин	Ердийн илрүүлэх шинжилгээ *	Ердийн илрүүлэх тандалтаар эсхүл сэжигтэй тохиолдлыг судлан шинжлэх үед илэрсэн ЭЕРЭГ тохиолдлыг баталгаажуулах*	ДМАЭМБ гарын авлагаас лавлах бүлэг
Шүлхий	ЭБ-ЕЛИЗА (зөвхөн дархлаажуулаагүй нөхцөлд) ББУ-ЭБ-ЕЛИЗА (ББУ-аас цэвэршүүлсэн вакцин хэрэглэсэн нөхцөлд)	УТ-ПГУ ВНК-21 эсэд вирус ялгах	Chapter 3.1.8
БММӨ	Дархлааны эсрэг бие баригч ЕЛИЗА Хэвтээ нэвчилтийн хурдавчилсан сорил	УТ-ПГУ Вирус ялгах	Chapter 3.8.9

*Онош баталгаажуулалтад тохиромжтой энэ аргыг илрүүлэх шинжилгээнд хэрэглэж болох ба харин илрүүлэх шинжилгээгээр ЭЕРЭГ үр дүн гарвал түүнийг заавал баталгаажуулна. ДИВА (халдвар авсан амьтныг дархлаажуулснаас ялгаварлах) боломжтой ийлдэс судлалын тогтмолжсон хэрэглээний арга байхгүй. Монгол улсад малын өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрт шаардлагатай дархлаажуулалтын бодлогод энэ бүхнийг харгалзах нь зүйтэй.

2. Онцгойлсон өвчний оношилгоонд Гүйцэтгэгчийн хэрэглэх боломжтой шинжилгээний арга

Дээрх хүснэгтэд жагсааснаас Гүйцэтгэгчийн хийж чадах оношлох шинжилгээ

Хүснэгт 2. Гүйцэтгэгчийн санал болгож буй хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд зөвшөөрөгдсөн онцгойлсон өвчний оношилгооны арга

Өвчин	Гүйцэтгэгчийн санал болгож буй хөтөлбөрт зөвшөөрөгдсөн оношилгооны арга	Лавлагаа болгосон Үндэсний стандарт (эсхүл уг шинжилгээнд лавлагаа болох бусад гол аргачилсан техникийн баримт бичиг)	Нэгж шинжилгээний үнэ*
Шүлхий	1. 2. Бусад		
БММӨ			

*Гүйцэтгэгч шинжилгээний үнийг тогтооно. Шинжилгээний үнэд аливаа нэмэлт ажиллагаа (ө.х. сорьц нийлүүлэх), ПГУ шинжилгээний тухайд эхний шинжилгээний

болон (нуклейн хүчлийг ялгах орно) удаах шинжилгээний үнийг (олшруулах, илрүүлэх) харгалзах хэрэгтэй.

АЛЬ НЭГНИЙГ НЬ СОНГОХ:

3. Өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэхээр тохирсон оношлох шинжилгээний арга

Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын В.17-д тодорхойлсончлон онцгойлсон өвчингүй, тайванг байнга нотлон харуулах зорилгоор хийх судалгаанд үйлдвэрлэлийн нэгж бүрийн малаас санамсаргүй сонголтоор тогтмол сорьц авч шинжилдэг.

Өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэх оношилгооны аргыг сонгоход дараах гол бэрхшээл тохиолдоно:

- Онцгойлсон популяци өвчингүй, тайванг тогтооход хэрэглэх эсрэг бие илрүүлэх шинжилгээний дүнд дархлаажуулалтын байдал ба/эсхүл эхээс ялгаагүй эсхүл ялгаад удаагүй төлд дамжиж ирсэн идэвхгүй дархлаа нөлөөлөх боломжтой.
- Түүврийн хэмжээ, нэгж шинжилгээний үнэ, боломж болоцоо

Эдгээр зүйлийг харгалзан үзсэний дараа Захиалагч болон Гүйцэтгэгч өвчингүй, тайванг нотлох судалгаанд дараах оношилгооны аргыг хэрэглэхээр тохиролцоно (Жич: Үйлдвэрлэлийн өөр өөр нэгжид оношилгооны янз бүрийн арга хэрэглэхээр бол үүнийг хүснэгтэд тэмдэглэнэ)

Хүснэгт 3. Өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга

Өвчин	Өвчингүй, тайванг нотлох судалгаанд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга
Шүлхий	1. Үйлдвэрлэлийн нэгж 1 (эсхүл Х төрөл): оношлох шинжилгээ 2. Үйлдвэрлэлийн нэгж 2 (эсхүл Y төрөл): оношлох шинжилгээ Гэх мэт
БММӨ	

4. Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга

Гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлт, өвчлөл, хорогдлын түвшин эгзэгтэй буюу босго гэж урьдчилан тогтоосон түвшинд хүрч өөрчлөгдөхөд малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх ажлыг эхлүүлнэ. Онцгойлсон өвчний сэжигтэй тохиолдолд малын эмч мэргэжлийн дүгнэлт гаргаж уг өвчний сэжгийг батлах эсхүл үгүйсгэхийн тулд лабораторид оношлох шинжилгээг хийлгэнэ. Үүнийг үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын В.20-д тодорхойлсон болно.

Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэх оношилгооны аргыг сонгоход дараах гол бэрхшээл тохиолдоно:

- Халдварын эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэнтэй уялдуулан сорьцыг оновчтой-зөв цаг хугацаанд авах боломж
- Зорилтот популяцид халдвар байгааг батлахад хэрэглэх эсрэг бие илрүүлэх шинжилгээний дүнд дархлаажуулалтын байдал ба/эсхүл эхээс ялгаагүй эсхүл ялгаад удаагүй төлд дамжиж ирсэн идэвхгүй дархлаа нөлөөлөх боломжтой.
- Шинжилгээ хийх болон үр дүн гаргах хугацаа

Захиалагч болон Гүйцэтгэгч малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд дараах оношилгооны аргыг хэрэглэхээр тохиролцоно.

Хүснэгт 4. Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга

Өвчин	Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга
Шүлхий	3. Үйлдвэрлэлийн нэгж 1 (эсхүл Х төрөл): оношлох шинжилгээ 4. Үйлдвэрлэлийн нэгж 2 (эсхүл Ү төрөл): оношлох шинжилгээ Гэх мэт
БММӨ	

Жич: УТ-ПГУ нь дээжид эсрэг бие байгаа эсэхээс үл хамааран олон зорилгоор оношлох шинжилгээнд ашиглагддаг, өндөр нарийвчлалтай, өвчингүй, тайванг нотлох судалгаа болон малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх аль алинд тохирсон арга юм. Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэх явцад энэ аргыг хэрэглэхэд анхаарах өөр нэг зүйл нь ялангуяа сорьц авах малыг сонгохдоо сорьц түүвэрлэх тэрхүү цаг хугацаанд тэдгээрийн халдвар авсан байх магадлалд суурилан сонгох асуудал юм. Хэрэглэх багаж төхөөрөмж, урвалж бодис боломжийн үнээр олдох нь элбэгшихийн хэрээр УТ-ПГУ-ыг малын эрүүл мэндийн лабораторид өргөн хүрээтэй тандах судалгааны зорилгоор тогтмол хэрэглэх боломж нэмэгдэж байна. Хэрэв Захиалагч болон Гүйцэтгэгч аль аль тал нь УТ-ПГУ-ыг аль ч тохиолдолд оношилгоонд чухалчлан хэрэглэхээр тохиролцвол дээрх хоёр хэсгийг доорх байдлаар хялбар болгон нэгтгэнэ. Доорх хэсгийн болон хүснэгтийн дугаарыг энэхүү нийтлэг зааварт тодорхой болгон оруулах шаардлагатай ба харин тохиролцох явцад доорх хэсгийг сонговол 1 дүгээр хавсралтын 3-р хэсгийн 3-р хүснэгт болж өгнө.

ЭСХҮЛ:

5. Өвчингүй, тайванг нотлох судалгаа болон малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга

Захиалагч болон Гүйцэтгэгч өвчингүй, тайванг нотлох судалгаа болон малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд доорх оношилгооны аргыг хэрэглэхийг эрхэмлэн тохиролцоно. Эдгээр аргыг хэрэглэхгүйгээр зөвшөөрөл бүхий өөр аргыг үйлчилгээ үзүүлэгч санал болговол хэрэглэгч сорьц илгээх үеэр тусгайлсан санал хүсэлтээ илгээнэ.

Хүснэгт 5. Өвчингүй, тайванг нотлох судалгаа болон малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга

Өвчин	Малын эрүүл мэндийн үйл явдлыг судлан шинжлэхэд хэрэглэхээр тохиролцсон оношилгооны арга
Шүлхий	УТ-ПГУ
БММӨ	УТ-ПГУ

C.07. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн чадамж, зардал

Монгол Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос (УМЭАЦТЛ) 2024 оны 4 дүгээр сард ирүүлсэн доорх хүснэгт дэх мэдээллийг компаниуд төлөвлөгөө зохиоходоо ашиглаж болно. Үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл тохиролцох үедээ энэ мэдээллийг УМЭАЦТЛ-иос шууд авч баталгаажуулна.

Үхэр, бог мал, гахайд шүлхий өвчнийг шинжлэх								
№	Шинжилгээний арга	УМЭАЦТЛ	АМЭЛ	СМЭТ	МЭҮН	Хамгаалалт ай аж ахуй (хэрэв лабораторит ой бол)	Дээжийн төрөл	Нэгж шинжилгээний үнэ (1 дээж) (төгрөгөөр)
Ийлдэс судлалын шинжилгээ								
1	ББУ ЕЛИЗА	+	+	-	-	+	Ийлдэс	8,300
2	Эсрэг биеэр ийлдсэн хэвшил тогтоох (O, A, Asia-1) ЕЛИЗА	+	+	-	-	-	Ийлдэс	16800 (хэвшил тус бүр)
3	VNT	+	-	-	-	-	Ийлдэс	230,000
Вирус судлалын шинжилгээ								
5	Эсрэгтөрөгчөөр ийлдсэн хэвшил тогтоох (O, A, Ази-1) ЕЛИЗА	+	+	-	-	-	Эд, шүлс, арчдас	29000 (хэвшил тус бүр)
6	Түргэн сорил	+	+	+	+	+	Эд, шүлс, арчдас	40,000
7	Вирус ялгах	+	-	-	-	-	Эд, шүлс, арчдас, багалзуурын хусдас	230,000
Молекулын шинжилгээ								
9	Бодит цагийн УТ-ПГУ	+	+	-	-	+	Эд, шүлс, арчдас, багалзуурын хусдас	16,000
10	УТ-ПГУ	+	+	-	-	-	Эд, шүлс, арчдас, багалзуурын хусдас	16,000
11	Генийн дараалал тогтоох	+	-	-	-	-	Эд, шүлс, арчдас, багалзуурын хусдас	56,000
Бог малд хийх БММӨ-ний шинжилгээ								

№	Шинжилгээний арга	УМЭАЦТЛ	АМЭЛ	СМЭТ	ХМЭН	Хамгаалалттай аж ахуй			
Ийлдэс судлалын шинжилгээ									
1	Эб илрүүлэх ЕЛИЗА	+	+	-	-	+	Ийлдэс	16,800	
3	Ийлдэс саармагжуулах урвал	+	-	-	-	-	Ийлдэс		
4	Вирус судлалын шинжилгээ								230,000
5	Эб илрүүлэх ЕЛИЗА	+	+	-	-	-	Эд ба арчдас	16,800	
6	Түргэн сорил	+	+	+	+	+	Эд ба арчдас	9,800	
7	Вирус ялгах	+	-	-	-	-	Эд ба арчдас	230,000	
8	Молекулын шинжилгээ							Эд ба арчдас	
9	Бодит цагийн УТ-ПГУ	+	+	-	-	+	Эд ба арчдас	15,000	
10	УТ-ПГУ	+	+	-	-	-	Эд ба арчдас	14,000	
11	Генийн дараалал тогтоох	+	-	-	-	-	Эд ба арчдас	56,000	

УМЭАЦТЛ - Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори

АМЭЛ - Аймгийн мал эмнэлгийн лаборатори

СМЭТ - Сумын мал эмнэлгийн тасаг

МЭҮН - Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж

С.08. Лабораторийн оношлох үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг барагцаалан тооцоолох үйл явц

Үйлчилгээний гэрээ байгуулахдаа компанийн хамгаалалттай аж ахуйд шаардагдах лабораторийн шинжилгээ, түүний үнийг барагцаалан тооцох үйл явц

Лабораторийн шинжилгээний хэрэгцээ, үнэд дараах гол хувьсагчид нөлөөлнө:

1. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн үйлдвэрлэлийн нэгжийн тоо
2. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн үйлдвэрлэлийн бүх нэгжийг хамарсан өвчингүй, тайванг нотлох судалгааны давтамж
3. Шинжилгээ хийх ээлж ирсэн үеэр компанийн хамгаалалттай аж ахуйн доторх үйлдвэрлэлийн тогтолцоо тогтмол ТОГТВОРТОЙ үйлдвэрлэлийн нэгж хэвээр байгаа эсэх,
4. Онцгойлсон өвчин бүрд сонгох оношилгооны арга
5. Лабораторид сорьц нийлүүлж бэлтгэх шийдвэр
6. Нийлүүлсэн сорьцоос ЭЕРЭГ дүн гарч нийлүүлсэн сорьц бүрийг тусад нь шинжлэх шаардлага гарах магадлал.

Эдгээр хувьсагчийг үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын шаардлагын дагуу дараагийн хэсгүүдэд тайлбарласан бөгөөд шинжилгээний хэрэгцээг үндэслэлтэй тогтоохын тулд төлөвлөгөө зохиохдоо оролцогч компани болон оношилгооны лаборатори хэрхэн хамтран ажиллаж зохицуулалт хийх талаар зөвлөгөө өгнө.

Жич:

- Оролцогч компанийн байгууламжийн малын эмч доорх 1, 2, 3 дугаар асуудлаар ажиллана.
- Оролцогч компанийн байгууламжийн техникийн ажил хариуцсан этгээд, оношилгооны лабораторийн ажилтан нар доорх 4, 5, 6 дугаар асуудлыг хэлэлцэн тохиролцоно.
- Гэрээгээр үзүүлсэн бодит үйлчилгээний зардлын нөхөн төлбөрийг нэхэмжилнэ гэж зохицуулалт хийж болох хэдий ч энэ нь дор авч үзсэн асуудал зэрэг цөөнгүй шалтгааны улмаас хэлбэлзэнэ.
- Гэрээнд тусган зохицуулах нэмэлт асуудлыг энэ баримт бичгийн төгсгөлд оруулав.

1. Байгууламж бүрийн үйлдвэрлэлийн нэгжийн тоог тооцоолох

САЗ В.11. Биохамгааллын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар.

- Үйлдвэрлэлийн нэгжийг дараах байдлаар тодорхойлно: нэг байранд хамт маллаж байгаа мэдрэмтгий нэг зүйл малын бүлэг тус бүрийг (ө.х. түр байлгаж талбай, амьсгалах агаарын орон зай, байр нэгтэй) үйлдвэрлэлийн нэгж гэж үзнэ.

Үйлдвэрлэлийн нэгж нь эпидемиологийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилготой популяцийн үндсэн үйлдвэрлэлийн нэгж юм. Ийм учраас үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлж өгөх нь компанийн хамгаалалттай аж ахуйг байгуулах чухал алхам болдог. Үйлдвэрлэлийн нэгжид дараах САЗ чухал ач холбогдолтой:

- САЗ В.11, САЗ В.12, САЗ В.15-д тодорхойлсон үндсэн нэгжийн биохамгааллын заавар
- САЗ В.13-д тодорхойлсон ялгах тэмдэглэгээ, мөшгөн тогтоолтын шаардлага
- САЗ В.16-д тодорхойлсон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ
- САЗ В.17-д тодорхойлсон тандалтын хөтөлбөр болон өвчингүй, тайванг нотлох судалгаа

Байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгжийг тодорхойлох, тогтоохдоо малыг төрөлжүүлэн ангилсан байдал, үйлдвэрлэлийн тогтолцоо, байран маллагааг харгалзана.

Үйлдвэрлэлийн нэгж бүрийг компанийн хамгаалалттай аж ахуйн бүртгэлд тодорхой зааж өгсөн байна.

Биохамгаалал, удирдлага зохион байгуулалт, зардлын үр өгөөжийг аль ч талаас нь тэнцвэртэй байлгах үүднээс байгууламж бүр ойролцоогоор 3-6 үйлдвэрлэлийн нэгжтэй байхыг зөвлөдөг.

2. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн үйлдвэрлэлийн нэгжийн өвчингүй, тайванг нотлох судалгааны давтамжийг харгалзах

САЗ В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалт Хөтөлбөр

- Өвчингүй, тайванг нотлох судалгаа хийхэд шаардлагатай давтамжийг тогтоох: Компанийн хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн нэгж бүр үйлдвэрлэлийн мөчлөгийн хугацаанд наад зах нь нэг удаа эсхүл хагас жил тутамд өвчингүй, тайванг нотлох судалгаанд сорьц авч байх ёстой.

3. Шинжилгээ хийх ээлж ирсэн үеэр компанийн хамгаалалттай аж ахуйн доторх үйлдвэрлэлийн тогтолцоо тогтмол **ТОГТВОРТОЙ** үйлдвэрлэлийн нэгж хэвээр байгаа эсэхийг харгалзах

САЗ В.11. Биоаюулын эрсдэлийн удирдлага: Үйлдвэрлэлийн нэгж хоорондын биохамгааллын заавар.

- **ТОГТВОРТОЙ** эсхүл **ТОГТВОРГҮЙ** үйлдвэрлэлийн нэгжийг дараах байдлаар тодорхойлно:
 - шинээр байгуулагдсан (байранд мал оруулах, эхээс ялгах, мал дахин бүлэглэх) эсхүл өмнөх 30 хоногт мал нэмсэн бол **ТОГТВОРГҮЙ** үйлдвэрлэлийн нэгж гэж үзнэ.
 - өмнөх 30 хоногт хуваагдаж салаагүй эсхүл мал нэмээгүй, гаргаагүй (хорогдсоноос бусад) үйлдвэрлэлийн нэгжийг **ТОГТВОРТОЙ** үйлдвэрлэлийн нэгж гэж үзнэ

САЗ В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр

- Өвчингүй, тайванг нотлох судалгаанд авах түүврийн хэмжээг үйлдвэрлэлийн нэгж **ТОГТВОРТОЙ** эсхүл **ТОГТВОРГҮЙ**-гээс хамааруулан тогтоож эрсдэлд суурилсан таамаглалаар тооцоолно:
 - **ТОГТВОРТОЙ** үйлдвэрлэлийн нэгжид түүврийн хэмжээ: 30 бодгаль мал
 - **ТОГТВОРГҮЙ** үйлдвэрлэлийн нэгж: 96 бодгаль мал

Ийм учраас өвчингүй, тайванг нотлох судалгаа хийх үед **ТОГТВОРТОЙ** байсан үйлдвэрлэлийн нэгж зардал ихээхэн хэмнэх ба **ТОГТВОРТОЙ** үйлдвэрлэлийн нэгж болоход биохамгаалал бас сайн хэрэгжүүлсэн байна.

Мал байнга орж байдаг үйлдвэрлэлийн тогтолцооны хувьд өвчингүй, тайванг нотлох судалгаанд сорьц авах үед 30 хоногийн хугацаанд ТОГТВОРТОЙ байх бүлэг бий болгохоор удирдан зохицуулах хэрэгтэй.

Оролцогч компанийн үйлдвэрлэлийн тогтолцоо мал байнга оруулахад хяналт тавьж чадахгүй тохиолдолд дараах үндэслэл бүхий таамаглалаар сорьц авна:

үйлдвэрлэлийн нэгж бүрээс ТОГТВОРТОЙ үйлдвэрлэлийн нэгжийнхтэй адилаар (ө.х. 30 сорьц) 6 сар тутамд сорьц авна

Энэ нь компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгогдох 12 сарын хугацаатайгаар малласан нэг үеийн бүлэг малыг өвчингүй, тайванг нотлох судалгаагаар 2 удаа баталгаажуулна гэсэн үг юм; 18 сарын хугацаатайгаар маллах малд 3 удаа; 24 сарын хугацаатай бол 4 удаа гэх мэт.

Үржүүлгийн сүрэг бүхий байгууламж нь ихэвчлэн хагас-хаалттай байх магадлал өндөр тул үйлдвэрлэлийн системээр үржүүлгийн үйлдвэрлэлийн нэгжийг ТОГТВОРТОЙ байлгахад зохион байгуулах нь илүү хялбар байх боломжтой.

Энэ үнэлгээ, таамаглалын үр дүнг барагцаалан тооцоолох явцад тодорхой тодорхойлно.

4. Онцгойлсон өвчин тус бүрд сонгосон оношилгооны аргыг харгалзах

3. Оношилгоонд зөвшөөрөгдсөн аргыг үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг зааврын А.5 хэсгийн 3 дугаар хүснэгтэд тодорхойлов.

Оролцогч компани, түүний мал эмнэлгийн мэргэжилтэн, оношилгооны лаборатори авч хэлэлцэн оношлох шинжилгээний аргыг сонгоно. Гол харгалзах зүйл нь:

- Оролцогч компанийн байгууламж дахь дархлаажуулах хөтөлбөр. Онцгойлсон өвчний эсрэг дархлаажуулалт хэрэглэдэг бол ихэнх тохиолдолд ийлдэс судлалын шинжилгээгээр үгүйсгэнэ (ө.х. ЭБ-ЕЛИЗА; ЭБ-ЕЛИЗА халдвар авсан, дархлаажуулсан амьтныг ялгаж чаддаггүй [ДИВА] бол).
- Дээд зэргийн нарийвчлал (оношилгооны мэдрэх чанар болон өвөрмөц чанар). Энэ тал дээр УТ-ПГУ нь вирус ялгах болон ийлдэс судлалын шинжилгээнээс давуу талтай.
- Шинжилгээний зардал. УТ-ПГУ-ын болон ЭБ-ЕЛИЗА арган харьцангуй зардлыг харгалзан үзэх хэрэгтэй.

5. Лабораторид нийлүүлсэн сорьц хэрэглэх эсэхээ шийдэх

САЗ В.17. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр

- i) УТ-ПГУ хэрэглэх нөхцөлд шинжилгээ хийхийн өмнө лабораторид сорьц нийлүүлэх арга хэрэглэдэг: илрүүлэх шинжилгээ хийхэд шинжлэх дээжийн тоог цөөлөх, нэгж шинжилгээний үнийг багасгах (ө.х. зардлын өгөөж) үүднээс 5 хүртэлх сорьцыг нийлүүлж болдог. Сорьцыг хот айл, ферм дээр бус харин лабораторид нийлүүлнэ. Нийлүүлсэн дээжийн хариу сөрөг гарвал нийлүүлсэн бүх салангид дээж бүгд сөрөг байна. Харин нийлүүлсэн дээж ЭЕРЭГ гарвал нийлүүлсэн бүх салангид дээжийг тус тусад нь дахин шинжилж тус бүрээр нь ЭЕРЭГ эсхүл сөрөг болохыг тогтооно.

Ерөнхийдөө сорьц нийлүүлэх нь лабораторийн зардлыг бууруулах, ялангуяа ЭЕРЭГ сорьцын тоо маш бага (бараг тэг хэмжээнд байх) байх гэж таамагласан үед хэрэглэдэг арга юм. Хэрэв ЭЕРЭГ-ийн хувь ӨНДӨР байхад сорьц нийлүүлбэл сүүлд нь нийлүүлсэн салангид олон дээж дахин шинжлэхэд хүрнэ.

Оролцогч компани болон оношилгооны лаборатори сорьцыг өөр байдлаар нийлүүлэхээр тохиролцсон бол энэ ажлын зардлыг тооцох эсэхээ шийдвэрлэнэ. Оролцогч компани болон оношилгооны лаборатори хоёр хоорондоо сорьц нийлүүлэн шинжлэхээр тохиролцсон бол лабораторид сорьц хэрхэн нийлүүлэх, мөн энэ ажлын зардлыг тооцох эсэхээ шийдвэрлэнэ.

6. Нийлүүлсэн сорьц ЭЕРЭГ дүг үзүүлэхэд нийлүүлсэн салангид сорьцыг шинжлэх шаардлага гарах магадлалыг харгалзан үзэх

Нийлүүлсэн сорьц ЭЕРЭГ үр дүн үзүүлэхэд дээр тэмдэглэсэн шалтгааны улмаас хийх шинжилгээний тоо олширч зардал нь нэмэгдэнэ. Оролцогч компани болон оношилгооны лаборатори хоёул нийлүүлсэн дээж ямар нэг ЭЕРЭГ дүн үзүүлэхэд шаардагдах арга ажиллагаа, холбогдох зардлын талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй. УТ-ПГУ нь мэдрэх болон өвөрмөц аль ч чанараар маш өндөр учир хэдийгээр хуурамч эерэг дүн гарах учиргүй ч сорьц цуглуулснаас хойш түүнд орчны бохирдол оруулахгүй байх нь маш чухал юм.

Оролцогч компани биохамгааллыг ягштал хэрэгжүүлж уламжлалт тандалт, хяналт-шинжилгээг хэрэгжүүлэх замаар өвчингүй, тайван байдлаа хадгална гэсэн итгэл үнэмшилд суурилан өвчингүй, тайванг нотлох судалгааг явуулснаар ЭЕРЭГ үр дүн гарах магадлалыг хамгийн бага түвшинд байлгаж чадна.

Оролцогч компани болон оношилгооны лаборатори хоорондын гэрээнд зохицуулах, харгалзан үзэх, онцлох бусад зүйл (CA3 B.17):

- i) Сорьцыг хуруу шилэн дээр нь шууд ялган тэмдэглэгээ хийх аль эсхүл дараах мэдээллийг тайлж унших боломжтой код бэхэлж өгнө. Үүнд: сорьц авсан огноо, малын зүйл, малын ялгах тэмдэглэгээний мэдээлэл (чухалчилна), үйлдвэрлэлийн нэгж (заавал), онцгойлсон өвчнөөс хамгаалах дархлаажуулалтын байдал, онцгойлсон өвчин, оролцогч компанийн байгууламж
- ii) Үйлдвэрлэлийн нэгжийн бүх сорьцыг сайтар хамгаалан хүйтэн хэлхээний нөхцөл бүрдүүлэн савлаад (хагарах, асгарахаас хамгаалан давхар савлана), оношлох шинжилгээ хийлгэх хүсэлт бүхий зохих маягтын хамт бэлтгэж 48 цагийн дотор лабораторид хүргэхээр яаралтай илгээнэ.
- iii) Байгууламж эсхүл үйлдвэрлэлийн нэгж бүрээс авсан судалгааны бүх сорьцыг оношлох үйлчилгээ үзүүлэгчийн лабораторид бүгдийг хамтад нь нэгэн зэрэг өгнө. Ингэснээр лабораторийн үр дүнгийн маягтад бүх үр дүн хамтдаа бичигдэнэ.
- iv) Өвчингүй, тайван болохыг тогтоох судалгаанд байгууламж болон үйлдвэрлэлийн нэгжээс авсан бүх дээжид хийсэн оношлох шинжилгээний үр дүнг лаборатори аль болохоор саатуулалгүй мэдээлнэ.
- v) Оношлох үйлчилгээ үзүүлэгч нь оношлох шинжилгээний үр дүнг оролцогч компанид хүргүүлэхийн хамт ЭЕРЭГ үр дүнтэй сорьцын талаар МЭЕГ-т мэдэгдэх замаар хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.

C.09. Өвчингүй, тайван байдлыг нотлох судалгааны хувилбар боловсруулахад өгөх зөвлөмж

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуй

Зөвлөмж САЗ В.17 Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага: Тандалтын хөтөлбөр

Зорилго

Энэхүү зөвлөмжид САЗ В.17-д оруулсан судалгааны загвараас өөр хувилбараар тухайн байгууламж онцгойлсон өвчнөөр тайван болохыг адил үнэмшилтэйгээр тогтоож чадах өвчнөөр тайван болохыг нотлох судалгааны загвар гаргах хувилбаруудыг авч үзнэ. САЗ В.17-д өгүүлсэн судалгааны загвар нь судалгаа бүрийг үйлдвэрлэлийн нэг нэгжид тусад нь хийж үр дүнг тусад нь тооцоолох боломжтой нэг шатлалт судалгаанд зориулсан бөгөөд энэ зөвлөмжид дараах гурван өөр судалгааны загварын талаар тайлбарлана:

1. Үйлдвэрлэлийн нэгжүүдээс пропорциональ түүвэрлэлт хийж байгууламжид нэг шатлалт судалгаа хийх
2. Үйлдвэрлэлийн нэгжүүдээс пропорциональ түүвэрлэлт хийж ашиг шимийн чиглэлээр нь ангилсан малын популяцид нэг шатлалт судалгаа хийх
3. Байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгжид хоёр шатлалт судалгаа хийх

Ерөнхий зүйл

САЗ В.17-д байгууламжийг үйлдвэрлэлийн нэгжүүдэд хувааж, үйлдвэрлэлийн нэгж бүрээс тус тусад нь онцгойлсон өвчний шинжилгээнд зориулж 6 сар тутамд сорьц авч, шинжилгээ хийдэг байхаар заасан байдаг. Энэ хүрээнд өвчнөөр тайван болохыг нотлох судалгааны загварын үзүүлэлт ТОГТВОРТОЙ үйлдвэрлэлийн нэгжид халдварын тархалт 10%, ТОГТВОРГҮЙ үйлдвэрлэлийн нэгжид тархалт 3% байхад 95%-ийн үнэмшилтэй байхаар сонгосон болно. Судалгааны энэ загварыг энд бусдаас ялгаж үүднээс “*Үйлдвэрлэлийн нэгж бүр дэх нэг шатлалт судалгаа*” гэж нэрлэв.

Түүвэрлэлтийн энэ стратегийн давуу тал нь үйлдвэрлэлийн нэгж тус бүрд хамгийн тогтвортой байх цаг хугацааг чөлөөтэй сонгох боломж олгоно.

Байгууламжийн тус бүрийн өвчнөөр тайван гэдгийн үнэмшил нь дор дурдсан үйл ажиллагаа, нөхцөл байдлын үр дүнд бүрэлдсэн үнэмшлийн нийлбэр гэдгийг анхаарах хэрэгтэй.

- Түүхэндээ өвчин гарч байгаагүй
- Өвчнөөр тайван болохыг нотлох хамгийн сүүлийн үеийн судалгаа
- Биохамгааллын эрсдэлийн удирдлага
- Үйлдвэрлэлийн гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ

Бүх САЗ-ын загварын тухайд түүнтэй адилхан үр дүнд хүргэж чадах өөр хувилбарыг хэрэв шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоосон бол харгалзан авч үзэж болно.

Өвчнөөр тайван болохыг нотлох судалгаанд популяцид харьцуулалтын бүлэглэл байгуулж судлах арга зүй

Хяналт-шинжилгээ, тандалт, тайлагналтад эпидемиологийн нэг нэгж гэж тооцогддог байгууламжид нэг байранд хамт маллаж байгаа малын бүлгийг үйлдвэрлэлийн нэгж гэж

тодорхойлно. Үйлдвэрлэлийн нэгж нь судалгааны загварт хамгийн тохиромжтой, зөв үндэслэлтэй нэгж юм.

Зарим байгууламж нь популяцидаа харьцуулах зорилгоор олон бүлэглэж дотооддоо биохамгааллын хатуу дэглэм хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг байж болох бөгөөд ингэснээр нэг байгууламжид үйлдвэрлэлийн олон нэгжийг бий болгосон байдаг. Энэ нь ашиг шимийн байдлаар нэг бүлэглэл болгоод байгууламждаа хэд хэдэн үйлдвэрлэлийн нэгжид маллахад хүргэнэ. Биохамгааллын удирдлагын ийм арга барил нь сайн үр дүнд хүргэх боловч өвчнөөр тайван болохыг нотлох судалгаа хийхэд зардал их гарна. Өвчнөөр тайван болохыг нотлох судалгаанд хамгийн их зардлыг лабораторийн шинжилгээ хийхэд зарцуулах ба энэ зардлыг компани хянах ямар ч боломжгүй юм.

Өвчнөөр тайван болох судалгааг урьдчилан тогтоосон үнэмшлийн түвшинд үйлдвэрлэлийн нэгж бүрд хийх шаардлагагүйгээр байгууламжийн түвшинд өндөр үнэмшилтэйгээр тогтоох өөр судалгааны загвар бий. Судалгааны ийм хувилбарыг хэрэглэхэд хэрэв үйлдвэрлэлийн нэгжийн тоо ойролцоогоор 10-аас их байвал зардал бага гарах магадлалтай.

Жич: Экспортын худалдааны зориулалтаар (ө.х. экспортлох амьд мал, төхөөрөх мал, экспортлох мах, махан бүтээгдэхүүн) компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ олгодог хамгаалалттай аж ахуйд байгаа үйлдвэрлэлийн нэгж нь засгийн газар хоорондын экспортын протоколоор тохирсон шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд тухайн үйлдвэрлэлийн нэгжид өвчнөөр тайван болохыг тусгайлан баталгаажуулах асуудал тавигдах боломжтой. Импортлогч улстай тохиролцсон протоколоос хамаарч экспортын гэрчилгээ олгоход харгалзан үзэх зорилгоор дээрх үйлдвэрлэлийн нэгжид өвчнөөр тайван болохыг нотлох судалгаа хийх шаардлага гарч болно. Ийм судалгаа хийх эсэх нь экспортын протоколыг тохирч гэрээ байгуулсны дараа л тодорхой болно.

Өвчнөөр тайван болохыг нотлох судалгааны загварын хувилбар

Ямар ч тохиолдолд судалгааны ажлыг 6 сар тутамд тогтоосон нэг цаг хугацаанд давтан хийнэ. Энэ нь “Үйлдвэрлэлийн нэг нэгжид хийх нэг шатлалт судалгаа”-д цаг хугацаагаа чөлөөтэй сонгодог байдлаас өөр гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь “үйлдвэрлэлийн нэг нэгжид хийх нэг шатлалт судалгаа” хийхэд судалгаа бүрийн үр дүнг тус тусад нь боловсруулах боломжтой байдаг тул үйлдвэрлэлийн нэгж бүрд түүвэр хийх цаг хугацааг аль тохиромжтой байхаар сонгож болдог.

Бүх тохиолдолд санамсаргүй аргаар, түүний дотор хоёр шатлалт түүвэрлэлтийн аль аль түвшинд (байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгжид байгаа мал бүрээс сорьц авах, байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгжээс сорьц авах) түүвэрлэлт хийх шаардлагатай.

Оролцогч компани өөрийн зорилгод хамгийн сайн тохирох түүвэрлэлтийг дор дурдсан хүчин зүйлийг харгалзан сонгоно:

- Байгууламжийн популяци дахь харьцуулалтын бүлэглэл
- Цаг хугацааны уян хатан байдал
- Санхүүгийн зардал
- Ирээдүйн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг хангах эрсдэлийн түвшин (импортлогч улс орны байр суурь хараахан тодорхой болоогүй буюу тохиролцох шатанд байгаа зах зээлд нэвтрэх хэлэлцээрийг харгалзах)

1. Үйлдвэрлэлийн нэгжүүдийн пропорциональ төлөөлөл бүхий байгууламжийн нэг шатлалт судалгаа

Энэ хувилбар ёсоор тогтвортой болон тогтворгүй аль ч үйлдвэрлэлийн нэгжийн бүх малыг түүврийн хүрээнд хамруулж тухайд байгууламжийн хэмжээнд урьдчилан тогтоосон нэг цаг хугацаанд нэгдсэн нэг судалгаа хийнэ. Нийт түүврийн хэмжээг судалгааны загварын хэмжигдэхүүн дагуу тооцоолох ба дараа нь үйлдвэрлэлийн нэгж

бүрд байгууламж дахь малын тоонд харьцуулсан үйлдвэрлэлийн нэгжийн малын тооны дагуу пропорциональ түүвэрлэлт хийнэ.

Судалгааны загварын үзүүлэлт: сүрэг дэх өвчний тархалт = 0.01; популяцийн хэмжээ = 5000; шинжилгээний мэдрэх чанар =0.99; шинжилгээний өвөрмөц чанар = 1; популяцийн мэдрэмтгий чанарын түвшин =0.99.

Үүний үр дүнд бүх байгууламжаас түүвэрлэх бодгаль малын тоо 455 байх тооцоо гарна. Үйлдвэрлэлийн нэгж бүрээс түүний популяцийн тоотой пропорциональ байхаар түүвэр хийнэ. Жишээ нь: хэрэв ижил хэмжээтэй үйлдвэрлэлийн 10 нэгж байхад нэгж тус бүрээс 46 малаас сорьц авна.

2. Үйлдвэрлэлийн нэгжүүдээс пропорциональ байдлаар түүвэрлээд ашиг шимийн чиглэлээр нь ангилсан малын популяцид хийх нэг шатлалт судалгаа

Энэ хувилбар ёсоор үйлдвэрлэлийн нэгжүүдийг эпидемиологи, биохамгааллын үндсэн нэгжээр нь хэвээр байлгаж байгууламж дахь малын популяцийг цаашид ашиг шимийн ангиллаар ө.х. тугал/хурга/ишиг; нэг наст; нас гүйцсэн гэж хуваана. Байгууламж дахь ашиг шимийн үндсэн ангиллын малыг (эсхүл ашиг шимээр ижил ангиллын малтай үйлдвэрлэлийн нэгжүүдийн бүлгийг сонгох) урьдчилан тогтоосон нэг цаг хугацааны нэгдсэн нэг судалгаанд хамруулна. Нийт түүврийн хэмжээг судалгааны загварын үзүүлэлтийн дагуу тооцоолох ба дараа нь үйлдвэрлэлийн нэгж бүрд ашиг шимээр ангилсан малын нийт тоонд харьцуулан үйлдвэрлэлийн нэгж дэх бодгаль малын тооны дагуу пропорциональ түүвэрлэлт хийж судалгаанд хамрагдах зорилтот популяци болгоно.

Үйлдвэрлэлийн бүх нэгж зургаан сар тутамд судалгаанд хамрагддаг байх үүднээс ашиг шимийн байдлаар нь ангилсан янз бүрийн популяцид судалгаа явуулдаг.

Судалгааны загвар хэмжүүр үзүүлэлт, тухайлбал сүрэг дэх өвчний тархалтын түвшин нь түүвэрлэлт хийх үед ашиг шимээр ангилагдсан популяцийн үйлдвэрлэлийн нэгж тогтвортой байсан эсэхээс хамааран өөр өөр байна.

Ашиг шимээр ангилагдсан популяцийн үйлдвэрлэлийн бүх нэгж тогтвортой байх үед:

Судалгааны загварын үзүүлэлт: сүрэг дэх өвчний тархалт =0.05; популяцийн хэмжээ =5000; шинжилгээний мэдрэх чанар =0.99; шинжилгээний өвөрмөц чанар =1; популяцийн мэдрэмтгий чанарын түвшин =0.99.

Үүний үр дүнд ашиг шимээр ангилагдсан популяцид түүвэрлэх бодгаль малын тоо 93 байх тооцоо гарна. Үйлдвэрлэлийн нэгж бүр өөрийн популяцийн тоотой пропорциональ байхаар түүвэрлэлт хийнэ.

Ашиг шимээр ангилагдсан популяцийн үйлдвэрлэлийн аль нэг нэгж тогтворгүй байх үед:

Судалгааны загварын үзүүлэлт: сүрэг дэх өвчний тархалт =0.02; популяцийн хэмжээ =5000; шинжилгээний мэдрэх чанар =0.99; шинжилгээний өвөрмөц чанар =1; популяцийн мэдрэмтгий чанарын түвшин =0.99.

Үүний үр дүнд ашиг шимээр ангилагдсан популяцид түүвэрлэх бодгаль малын тоо 228 байх тооцоо гарна. Үйлдвэрлэлийн нэгж бүр өөрийн популяцийн тоотой пропорциональ байхаар түүвэрлэлт хийнэ.

3. Байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгж дэх бодгаль малд хийх хоёр шатлалт судалгаа

Хоёр шатлалт судалгааны загвар ёсоор аль ч түвшинд түүвэр хийх ба ө.х:

- Үйлдвэрлэлийн нэгж дэх малаас түүвэрлэх

- Байгууламжийн үйлдвэрлэлийн нэгжүүдээс түүвэрлэх

Хоёр шатлалт судалгаа хийх гэж байгаа нөхцөлд судалгааны загварын үзүүлэлт: үйлдвэрлэлийн нэгж дэх бодгаль малын дотор өвчний тархалт байх магадлал болон байгууламжийн дотор халдвар авсан үйлдвэрлэлийн нэгж байх магадлалыг тус тус харгалзан үзнэ.

Тогтоосон нэг цаг хугацаанд түүвэрлэлт хийх нь хоёр шатлалт судалгаанд чухал биш боловч түүвэр хийх явцад популяци тогтвортой байх ёстой буюу ө. х. энэ үед үйлдвэрлэлийн нэгжийн хооронд малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх нь чухал юм.

Үйлдвэрлэлийн нэгжүүдэд анх тогтоосон судалгааны загварын үзүүлэлт болон үнэмшлийн түвшин (0.1 тархалт, 95% үнэмшил) давтагдах ба учир нь судалгааны таамаглал энэ түвшинд өөрчлөгдөөгүй байдаг тул тогтвортой үйлдвэрлэлийн нэгж бүрээс 30 бодгаль мал түүвэрлэнэ. Үр дүнг бүхэл байгууламжийн хэмжээнд боловсруулж гаргах тул үйлдвэрлэлийн аль нэг нэгжийн тогтвортой байх эсэхийг энд харгалзахгүй.

Үйлдвэрлэлийн нэг нэгжид халдвар гарвал хэдийгээр биохамгааллын арга хэмжээ хэрэгжүүлдэг ч байгууламж дотор янз бүрийн замаар халдвар дамжина гэж үзэн байгууламжийн бусад үйлдвэрлэлийн нэгжийг халдвартай гэсэн таамаглал дэвшүүлнэ. Гэвч биохамгааллын хязгаарлалтаар халдварлалтыг бага түвшинд барих магадлалтай. Үйлдвэрлэлийн нэгж хоорондын халдварын тархалтыг 0.1 гэж таамаглаж болох үндэслэл бий. Энэ нь 20 үйлдвэрлэлийн нэгжтэй бол 2-т нь, 50 үйлдвэрлэлийн нэгжтэй бол 5-д нь халдвар тархсан гэсэн үг юм.

Хоёр шатлалт түүвэрлэлтийн загвар хэмжүүр үзүүлэлт нь янз бүр байна:

Загвар хэмжүүр үзүүлэлт:

- Үйлдвэрлэлийн нэгж дэх тархалт = 0.10
- Үйлдвэрлэлийн нэгжийн популяцийн тоо (үйлдвэрлэлийн нэгж дэх бодгаль мал) =200;
- Үйлдвэрлэлийн нэгжийн хооронд (эсхүл кластер) халдварын тархалт =0.10
- Үйлдвэрлэлийн нэгжийн тоо (эсхүл кластер) = 30 (жич: энэ нь бодит нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байх ба тооцооллыг давтана; доор хүснэгт үз)
- Үйлдвэрлэлийн нэгжид хийх шинжилгээний мэдрэх чанар =0.99;
- Үйлдвэрлэлийн нэгжид хийх шинжилгээний өвөрмөц чанар =1;
- Үйлдвэрлэлийн нэгж (кластер) доторх зорилтот мэдрэх чанар =0.95
- Үйлдвэрлэлийн нэгж (тогтолцооны) хоорондох зорилтот мэдрэх чанар =0.95

Дээрх жишээгээр тооцвол үйлдвэрлэлийн нэгж тус бүр 30 бодгаль мал түүвэрлэх нийт үйлдвэрлэлийн 20 нэгж байна.

Үйлдвэрлэлийн 30 нэгжтэй байгууламж гэж үзвэл түүврийн эцсийн хэмжээ (20x30) = 600 байна.

Үйлдвэрлэлийн нэгжийн тоогоороо ялгаатай байгууламжаас хоёр шатлалт түүвэр хийхэд гарах ялгааг доорх хүснэгтэд үзүүлэв :

Үйлдвэрлэлийн нэгжийн тоо	Үйлдвэрлэлийн нэгжийн түүврийн хэмжээ
10	10 (ө.х. бүх үйлдвэрлэлийн нэгжээс авах сорьц)
20	17
30	20
40	23
50	24

Түүврийн хэмжээг тооцоолоход лавлах материал:

EpiTools – Эпидемиологийн тооцоолол. AusVet Ltd. www.epitools.ausvet.com.au; [Epitools - Home \(ausvet.com.au\)](http://Epitools-Home(ausvet.com.au))

- Эпидемиологийн судалгаа; түүврийн хэмжээг тооцоолох
- Өвчнөөр тайван болохыг нотлон харуулах түүврийн хэмжээ; мэдрэх чанар хамгийн тохиромжтой байхаар таамагласан түүврийн хэмжээ
- мэдрэх чанар хамгийн тохиромжтой байхаар таамагласан 2 шатлалт түүврийн хэмжээ; мэдрэх чанарын тогтоосон кластерт тохирсон түүврийн хэмжээ

Zero Draft

С.10. Оролцогч компани болон зөвшөөрөл бүхий хөндлөнгийн баталгаажуулагчийн хооронд байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар

**Монгол улсын хивэгч малын
хамгаалалттай аж ахуйд үйлчилгээ үзүүлэхээр
оролцогч компани болон эрх бүхий хөндлөнгийн
баталгаажуулагчийн хооронд байгуулах
гэрээний загвар**

Нэг талаас:

Компани (цаашид “Захиалагч” гэх):
түүнийг төлөөлж (Нэр: албан тушаал):
.....

Нөгөө талаас:

**МЭЕГ-аас зөвшөөрөл олгосон
Хөндлөнгийн баталгаажуулагч
(цаашид “Гүйцэтгэгч” гэх):**
түүнийг төлөөлж (Нэр: албан тушаал):
.....

нар дор дурдсан гэрээг байгуулав.

2. Энэхүү гэрээнд хамрагдах компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж

[Компанийн нэр]-ын компанийн хамгаалалттай аж ахуйн дор дурдсан байгууламжид лабораторийн оношлох үйлчилгээ үзүүлнэ:

- а) 1-р байгууламжийн нэр, хаяг:
- б) 2-р байгууламжийн нэр, хаяг:
- в) гэх мэт:

3. Ерөнхий зүйл

Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоонд (*баталгааг хангах тогтолцоо*) хамаардаг компанийн хамгаалалттай аж ахуйд хөндлөнгийн хяналт шалгалт гүйцэтгэх нөхцөлийг хэлэлцэн тохиролцохдоо оролцогч компани (*Захиалагч*) болон Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-аас зөвшөөрч эрх олгосон Хөндлөнгийн баталгаажуулагч этгээд (*Гүйцэтгэгч*) энэхүү үйлчилгээ үзүүлэх гэрээний загварыг жишиг болгон ашиглаж болно.

Баталгааг хангах тогтолцооны иж бүрэн стратеги, бүтэц, техникийн шаардлагыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, хамгаалалттай аж ахуйн журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар, захиргааны ажлын гарын авлагад тодорхойлсон болно. Баталгааг хангах тогтолцоо нь онцгойлсон өвчингүй, тайван гэдгийн нотолгоо болж өгдөг стандартчилагдсан биохамгааллын тогтолцоог Дэлхийн

мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулан бий болгох, хэрэгжүүлэх боломжийг оролцогч компаниудад олгодог арга зам юм.

Оролцогч компани биохамгааллын зааврыг боловсруулах ба түүнийг хөтөлбөрийн шаардлага хангасан нөхцөлд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) батална. Оролцогч компани биохамгааллын зааврыг тухайлсан байгууламжуудад хэрэгжүүлснийхээ дараа тэдгээр байгууламжид компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл авна.

ДМАЭМБ-ын олон улсын стандартад зааснаар төрийн хяналт тавих, удирдан чиглүүлэх ажлыг хяналт шалгалтын тогтолцоогоор дамжуулан гүйцэтгэнэ.

Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт хамаарах онцгойлсон өвчин:

Үхэрт: шүлхий өвчин

Хонь ба ямаанд: шүлхий өвчин, бог малын мялзан өвчин (БММӨ)

4. Үйлчилгээний ерөнхий тодорхойлолт

Захиалагч нь зохих ёсоор сурч дадлагажин мэргэшсэн хяналтын байцаагчаар компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд тодорхой давтамжит хугацаанд хяналт шалгалтын үйлчилгээ авна. Хяналт шалгалтын зорилго нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар, улмаар баталгааг хангах тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулахад оршино. Хяналт шалгалтын үр дүнгээр хяналт шалгалтын тайлан бэлтгэж түүнд үл тохирлыг жагсаан ангилна. Хяналт шалгалтыг хэвийн нөхцөлд 6 сар тутамд давтан хийх ба энэ хугацааг хяналт шалгалтын дүнгээс хамааруулан МЭЕГ уртасгаж (жил бүр) эсхүл богиносгож (3 сар тутамд) болно.

5. Үүрэг хариуцлага

- a. Хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны баримт бичигт тус гэрээний Захиалагчийг оролцогч гэж, Гүйцэтгэгчийг хөндлөнгийн баталгаажуулагч гэж тус тусых нь үүрэг хариуцлагыг заасныг энд хураангуйлан оруулав.
- b. Захиалагч нь өөрийн компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл бүхий бүх байгууламжийг, тэр дундаа баримт бичиг, бүртгэлийн хэлбэрээр шаардлагыг хангаж байгаагийн анхдагч нотлох баримтыг бүрдүүлж байдаг дотоод хяналтын тогтолцоог бий болгож, удирдах үүрэгтэй.
- v. Захиалагч нь түүний үйл ажиллагааны гүйцэтгэлийн байдалд үндэслэн МЭЕГ-аас тогтоосон хугацаанд багтааж Гүйцэтгэгчийн хяналтын байцаагчийн боломжийг харгалзсан хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх хуваарь гаргах үүрэгтэй.
- г. Гүйцэтгэгч нь компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын шаардлагыг тухайн байгууламж хангаж байгаа эсэхийг хяналт шалгалтын зохистой дадлын хүрээнд хараат бусаар үнэнч шударгаар тогтоох үүрэг хүлээнэ. Хяналт шалгалтын зохистой дадлыг ISO 9001 стандартад зөвлөсөн болно.

6. Үйлчилгээний хамрах хүрээ

- a. Хяналт шалгалт хийлгэх компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж
 - i. Захиалагч нь компанийн хамгаалалттай аж ахуйд хамруулах байгууламжийг тогтооно. Тэдгээрийг энэхүү үйлчилгээ үзүүлэх гэрээний дээрх 1-р зүйд жагсаана.
 - ii. Гүйцэтгэгч нь өөрийн харьяалагддаг нутаг дэвсгэрт орших компанийн хамгаалалттай аж ахуйн аль ч байгууламжид хөндлөнгийн хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрнө.

- iii. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж өөр өөр нутаг дэвсгэрт харьяалагддаг бол Захиалагч нь тэдгээр байгууламж бүрд хөндлөнгийн хяналт шалгалтын үүргийг гүйцэтгэх Гүйцэтгэгчийг сонгон үйлчилгээ авах үүрэгтэй.
 - iv. Захиалагч нь Гүйцэтгэгчийн харьяаллын нутаг дэвсгэрт хамаарах компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийнхаа тоог нэмэх эсхүл хасах хүсэлтэй байгаагаа Гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Гүйцэтгэгчийн хяналт шалгалт хийх байгууламжийн тоог нэмэх эсхүл хасах нь энэхүү гэрээг шинэчлэх үндэслэл болно.
- б. Сурч дадлагажсан, эрх бүхий хяналтын байцаагчид тавих нөхцөл
- i. Гүйцэтгэгч нь МЭЕГ-аас зөвшөөрч эрх олгосон, бэлтгэгдсэн хяналтын байцаагчидтай байна. МЭЕГ-аас хяналтын байцаагчид хяналт шалгалт хийх зөвшөөрөл олгоход хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцоонд шаардагдах туршлагатай, мэргэшилтэй, хяналтын шалгалт хийх талаарх сургалтад хамрагдаж төгссөн байх шаардлага тавигдана.
 - ii. Гүйцэтгэгч нь компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд хамгийн багадаа хоёр хяналтын байцаагч ажиллуулахад хүрэлцэх бэлтгэгдсэн хяналтын байцаагчийн нөөцтэй байна. Эрх бүхий хяналтын байцаагч компанийн хамгаалалттай аж ахуйн олон байгууламжид үйлчилгээ үзүүлж болох боловч Гүйцэтгэгч нь өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт орших оролцогч компанийн хэрэгцээ шаардлагыг хангахад хүрэлцэх хүний нөөцтэй байх үүрэг хүлээнэ.
 - iii. Гүйцэтгэгч нь байгууламж бүрд хяналт шалгалт хийлгэхээр томилсон хяналтын байцаагчийн нэр, эрх олгосон зөвшөөрлийн байдал, холбоо барих дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагч талд өгнө.
- в. Компанийн хамгаалалттай аж ахуйд зөвшөөрөл олгох явцад хийх хяналт шалгалт
- i. Захиалагч нь өөрийн компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийг МЭЕГ-т албан ёсоор бүртгүүлсэн (өргөдлийг хүлээн авч биохамгааллын зааврыг баталгаажуулсныг хэлнэ) бөгөөд хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэхэд бэлэн болсон тухайгаа Гүйцэтгэгч талд мэдээлнэ.
 - ii. Захиалагч нь хяналт шалгалт хийх эрх бүхий хяналтын байцаагч томилж өгөхийг Гүйцэтгэгч талаас хүснэ.
 - iii. Гүйцэтгэгч талаас хяналтын байцаагчийг томилсны дараа Захиалагч нь түүнд байгууламжид холбогдох компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын хуулбарыг МЭЕГ-т албан ёсоор бүртгүүлсэн тухай мэдэгдэл, байгууламж дахь үйлдвэрлэлийн нэгж бүрд хийсэн өвчингүй, тайванг нотлох эхний судалгааны үр дүнгийн хамт хүлээлгэн өгнө.
 - iv. Захиалагч болон Гүйцэтгэгч хяналт шалгалт хийх огноог хяналт шалгалт хийлгэхэд бэлэн болж хийлгэхийг хүссэн анхны албан ёсны мэдэгдлээс хойш 3 сарын дотор тохиролцоно.
 - v. Компанийн хамгаалалттай аж ахуйд зөвшөөрөл олгох явцад байгууламжид хийх хяналтын шалгалтад 5 хүртэл ажлын бүтэн өдөр шаардагдана:
 - I. ажлын 2 хүртэл бүтэн өдөр төлөвлөх, Гүйцэтгэгч талаас баталгаажуулах,
 - II. ажлын 2 хүртэл бүтэн өдөр байгууламж дээр хяналт шалгалт хийх, Гүйцэтгэгч талаас баталгаажуулах
 - III. ажлын 1 хүртэл бүтэн өдөр тайлан бичих, Гүйцэтгэгч талаас баталгаажуулах
 - vi. Гүйцэтгэгчийн энэ цагийн хуваарилалт нь эрх бүхий хоёр хяналтын байцаагч хамт ажиллах, аль эсхүл нэг хяналтын байцаагч ганцаараа ажиллаж болох хуваарилалт болно.

- г. Компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрд хийх хяналт шалгалтын хуваарь гаргах, төлөвлөх
- i. Захиалагч байгууламждаа хяналт шалгалт хийлгэх хүсэлтээ Гүйцэтгэгч талд 2 сараас багагүй хугацааны өмнө албан ёсоор мэдэгдэнэ. Захиалагч болон Гүйцэтгэгчийн аль аль нь байгууламжийн зөвшөөрлийн статусыг хадгалахын тулд хяналт шалгалтыг хэзээ хийж дуусгах ёстойг тодорхойлохын тулд байгууламжид хийсэн хяналт шалгалтын хамгийн сүүлийн огноо, байгууламжийн гүйцэтгэлд суурилсан давтамжийг харах боломжтой байна. Гэхдээ заасан хугацаанд хяналт шалгалт хийх боломжтой хяналтын байцаагчид хүсэлт тавих нь Захиалагчийн үүрэг байна.
 - ii. Захиалагч болон Гүйцэтгэгч хоёр тал хяналт шалгалт хийх хугацааг тохиролцоно. Хяналт шалгалт хийх хугацаагаа тохиролцсоны дараа 2 долоо хоногийн дотор Захиалагч байгууламжид холбогдох компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын хамгийн сүүлийн шинэчилсэн хувилбарыг байгууламжийн үйлдвэрлэлийн нэгж бүрд хийсэн өвчнөөр тайван болохыг нотлох хамгийн сүүлийн судалгааны дүнгийн хамт хүлээлгэж өгнө.
 - iii. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч нь биохамгааллын заавар, байгууламжид өмнө нь хийсэн хяналт шалгалтын бүх тайланг нягтлан хянаж, байгууламж дээр хяналт шалгалтыг хэрхэн хийх төлөвлөгөөг хяналт шалгалтын хяналтын хуудас зэрэг төлөвлөлтийн аргачлал ашиглан боловсруулах ба ингэхдээ аль хэсгийг илүү анхаарахаа шийднэ.
 - iv. Захиалагч биохамгааллын шаардлага хангахтай холбоотой, тухайлбал хяналтын байцаагч байгууламжид биечлэн очихоос өмнө малд ойртохгүй байх, усанд орж хувцсаа солин байгууламжид нэвтрэх тухай мэдээллийг Гүйцэтгэгчийн хяналтын байцаагчид урьдчилан болон хяналт шалгалт хийх өдөр нь өгнө. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч байгууламжид ирэхийн өмнө болон ирэх үедээ биохамгааллын тэдгээр шаардлагыг хангахаа/хангаснаа Захиалагч талд баталгаажуулна.
 - vii. Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл бүхий байгууламжид хяналт шалгалт хийх ердийн хуваариар 3 хүртэл бүтэн өдөр шаардагдах буюу ө.х.:
 - i. ажлын 1 хүртэл бүтэн өдөр төлөвлөх, Гүйцэтгэгчээр баталгаажуулах,
 - ii. ажлын 1 хүртэл бүтэн өдөр байгууламж дээр биечлэн хяналт шалгалт хийх, Гүйцэтгэгчээр баталгаажуулах
 - iii. ажлын 1 хүртэл бүтэн өдөр тайлан бичих, Гүйцэтгэгчээр баталгаажуулах
 - v. Хэрэв Гүйцэтгэгч компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж ердийн бус нөхцөл байдалтай гэж үзвэл энэ хугацааг хяналт шалгалтыг төлөвлөх болон байгууламж дээр хяналт шалгалт хийх хоногийг нэмж 5 хүртэл бүтэн өдөр болгон сунгаж болно. Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар эсхүл үйлдвэрлэлийн тогтолцоонд томоохон өөрчлөлт орохыг ердийн бус нөхцөл байдалд тооцно. Томоохон(ө.х. >3) эсхүл ноцтой (ө.х. >1) үл тохирлын тоо их тохиолдолд хяналтын шалгалтыг хийхэд илүү хугацаа шаардах ердийн бус нөхцөл байдалд мөн тооцно.

д. Хяналт шалгалтын гүйцэтгэл

- i. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч хяналт шалгалт хийхээр ирэх өдөр, цагийг Захиалагч талд мэдээлнэ.
- ii. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч нэвтрэх үеийн Захиалагчийн биохамгааллын шаардлагыг дагаж мөрдөж байгаагаа баталгаажуулна.

- iii. Байгууламж дахь Захиалагчийн удирдлагын төлөөллийг оролцуулан хийх хяналт шалгалтын эхлэлийн уулзалтын үеэр Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч хяналт шалгалт хийх ажлаа танилцуулна.
 - iv. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч байгууламжид биечлэн хяналт шалгалт хийх хугацаанд ашиглах уулзалтын өрөө эсхүл ажлын өрөөг Захиалагч гаргаж өгнө.
 - v. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч биохамгааллын зааврын хэрэгжилттэй холбогдуулан ямар ч ажилтантай ярилцах, аль ч үйл ажиллагааны явц эсхүл баримт бичиг, бүртгэлтэй танилцах хүсэлт гаргаж болно. Захиалагч үндэслэл бүхий бүх хүсэлтийг биелүүлнэ.
 - vi. Хэрэв биохамгааллын зааварт заасан биохамгааллын хязгаарлалт нь биечлэн шалгаж баталгаажуулах нөхцөлийг хааж-хориглож байвал Гүйцэтгэгчийн хяналтын байцаагчийн хүсэлтийг Захиалагч виртуал аргаар жишээ нь компьютер эсхүл утас ашиглан цахим дуу дүрсээр харилцаж болно.
 - vii. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагч байгууламж дахь Захиалагчийн байгууламж дахь удирдлагын төлөөлөл хяналт шалгалтын төгсгөлд хийх хаалтын уулзалтад оролцох үеэр ажлынхаа үр дүнгийн хураангуйг болон илрүүлсэн аливаа үл тохирлыг жижиг, томоохон, ноцтой гэж ангилан танилцуулна.
- e. Хяналт шалгалтын үр дүнг тайлагнах
- i. Гүйцэтгэгч байгууламжид хяналт шалгалт хийж дууссанаас хойш ажлын 10 хоногт багтаан хяналт шалгалтын төгсгөлийн тайланг хүлээлгэн өгнө.
 - ii. Гүйцэтгэгчийн хяналт шалгалтын үр дүнгийн хураангуй, тэмдэглэл, илрүүлсэн аливаа үл тохирлыг **ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ/НОЦТОЙ, ДУНД ЭРСДЭЛ/ТОМООХОН, эсхүл БАГА ЭРСДЭЛТЭЙ/ЖИЖИГ** гэж тодорхой ангилан хяналт шалгалтын төгсгөлийн тайланд оруулна.
 - iii. Захиалагч компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламж бүрийн хяналт шалгалтын төгсгөлийн тайланг үл тохирлын мөрөөр авсан арга хэмжээний тайлангийн хамт сар тутмын тогтмол тайлан өгөхдөө МЭЕГ-т хүргүүлэх үүрэгтэй.

7. Үйлчилгээний шинж чанар

- a. Төлөөлөн харилцах этгээд
 - i. Захиалагч болон Гүйцэтгэгч хоёулаа тэдгээрийг төлөөлөн харилцах хүнийг томилж, энэ гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүх харилцааг тэдгээр төлөөллөөр дамжуулан явуулна.
 - ii. Захиалагч эсхүл Гүйцэтгэгч аль нэг талын төлөөлөл солигдсон тохиолдолд нөгөө талдаа 24 цагийн дотор мэдэгдэнэ.
- б. Чанар:
 - i. Захиалагч нь баталгааг хангах тогтолцооны, тэр дундаа онцгойлсон өвчингүй, тайван байдлаа хадгалахтай холбоотой шаардлагыг хэвийн нөхцөлд байдалд ханган биелүүлж байгааг өндөр түвшинд баталгаажуулж чадах биохамгаалалын батлагдсан заавар, түүний дотор дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг амлалт хүлээнэ.
 - ii. Гүйцэтгэгчийн хяналт шалгалтын хугацаанд биохамгааллын батлагдсан зааврын хэрэгжилтэд хараат бус бодит үнэлгээ өгч хяналт шалгалтын тайланд тодорхой тусгана. Хяналт шалгалтын тайланг МЭЕГ-ын заасан стандартаар бэлтгэнэ. Хяналт шалгалтыг ерөнхийдөө ISO 9001-д тодорхойлсон аргачлал, стандартад нийцүүлэн явуулна.

- в. Баримтлах хугацаа
- i. Захиалагч болон Гүйцэтгэгч тандалтыг төлөвлөх үеэр хоёул мэдээлэл харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллах замаар аль нэг талаас ирсэн аливаа хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор хариу өгч байх амлалт үүрэг хүлээнэ.
 - ii. Урьдчилан тохиролцсон давтамжаар ёсоор хяналт шалгалт явуулах цаг хугацааны бололцоо хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор тавьсан хүсэлтийг биелүүлэх болон энэхүү гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээнд холбогдох асуудал эсхүл саад бэрхшээл тулгарвал Захиалагч болон Гүйцэтгэгч хоёр тал аль нэг талдаа урьдчилан мэдэгдэх амлалт үүрэг хүлээнэ.
 - i. Хэвийн нөхцөлд Захиалагч болон Гүйцэтгэгч хяналт шалгалт хийх хугацааг хамгийн багадаа хуанлийн 2 сарын өмнө тогтооно. Энэ хугацааг ямар ч тохиолдолд харилцан тохиролцсоны үндсэн дээр богиносгож болно.
 - ii. Захиалагч компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврын байгууламжид холбогдох хамгийн сүүлийн шинэчлэгдсэн хувилбарыг хуваарьт хяналт шалгалт эхлэхээс 2 долоо хоногийн өмнө хүргүүлнэ.
 - iii. Гүйцэтгэгч хяналт шалгалт хийж байгаа үед хүссэн үндэслэл бүхий бүх хүсэлтийн хариуд Захиалагч тухайн шаардсан нотлох баримт, баримт бичиг, бүртгэлийг цаг тухайд нь гаргаж өгнө.
 - iv. Гүйцэтгэгч хяналт шалгалт хийж дууссанаас хойш ажлын 10 хоногт багтаан хяналт шалгалтын төгсгөлийн тайланг хүлээлгэн өгнө.
- а. Нууцлал
- i. Захиалагч нь өөрийн байгууламжид онцгойлсон өвчин (шүлхий, БММӨ) эсхүл хуулийн дагуу заавал мэдэгдэх малын аливаа өвчний батлагдсан тохиолдлыг Гүйцэтгэгч талд яаралтай (24 цагийн дотор) мэдэгдэнэ.
 - ii. Гүйцэтгэгч компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар, хяналт шалгалтын явцад болон хяналт шалгалтын үр дүнд олж авсан аливаа нотлогоо, баримт бичиг, бүртгэл, тайлантай холбоотой нууцлалыг задруулахгүй хадгална.
 - iii. Байгууламжийн онцгойлсон өвчинд холбогдох малын эрүүл мэндийн статуст гарсан эрсдэл эсхүл өөрчлөлтийг Захиалагч болон Гүйцэтгэгч аль аль тал МЭЕГ-т мэдээлж байх амлалт үүрэг хүлээнэ.

8. Маргаан шийдвэрлэх

- а. Захиалагч болон Гүйцэтгэгч энэхүү гэрээнд тусгагдсан ажлыг үнэнч шударгаар хэрэгжүүлэн ажиллах амлалт үүрэг хүлээнэ.
- б. Хүссэн үйлчилгээгээр хангах Гүйцэтгэгчийн чадвар, үндэслэлтэй хүсэлтэд Захиалагчийн хариу өгөх байдал, үйлчилгээний хугацаа, чанар, эсхүл үйлчилгээний төлбөр, түүний төлөлттэй холбоотойгоор Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд аливаа маргаан үүсвэл талуудаас томилогдсон төлөөлөл хоорондоо нээлттэй, ажил хэрэгч байдлаар харилцан ярилцаж асуудлыг шийдвэрлэхийг талууд дээд зэргээр эрхэмлэх амлалт үүрэг хүлээнэ.
- в. Ийм маргаан үүссэн бүх нөхцөлд Захиалагч болон Гүйцэтгэгч маргаан үүссэн асуудлаар өөрсдийн байр сууриа аль нэг талдаа бичгээр тодорхой илэрхийлнэ. Маргаантай асуудлыг зөвшилцөн тохиролцож шийдвэрлэсний дараа түүнийг мөн бичиж баримтжуулна.
- г. Нээлттэй, ажил хэрэгч байдлаар ярилцаж, албан бичгээр харилцан маргааныг шийдвэрлэж чадаагүйгээс маргаан цааш өрнөсөн тохиолдолд эхлээд Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлагаас оролцуулж тэдэнд маргаантай асуудлыг бичгээр тодорхойлон, талуудын байр суурийн хамт танилцуулна. Хоёр тал

харилцан зөвшилцөлд хүрч үүссэн маргааныг шийдвэрлэх зорилготойгоор Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлагууд харилцан ярилцана.

- д. Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын дээд удирдлага асуудлыг шийдэж чадахгүй бол Захиалагч болон Гүйцэтгэгч аль аль тал нь МЭЕГ-т мэдэгдэнэ. Захиалагч болон Гүйцэтгэгчийн хоорондын харилцаа тасарснаас энэхүү гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээ цаашид баталгаагүй болох учраас дээрх мэдэгдлийг яаралтай өгнө. Ийм тохиолдолд шаардлагатай үйлчилгээг өөр этгээд үзүүлж чадах, энэ хугацаанд компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжийн батлагдсан статуст нөлөөлөх эсэхийг МЭЕГ харгалзан үзнэ.

9. Үйлчилгээний төлбөрийн жишиг ба нэхэмжлэл

- а. Үйлчилгээний төлбөрийг үзүүлсэн үйлчилгээний үр дүнгээс хамаарахгүй байхаар тогтоох ёстой ба ингэснээр бие даасан, хараат бус байдлын баталгаа хангагдана.
- б. Энэ гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхэд гарсан бодит зардал болон бусад үндэслэл бүхий зардлыг Захиалагчаас бүрэн нөхөж авах нь нягтлан бодох бүртгэлийн зарчим юм.
- в. Үнэ тогтооход дараах зүйлийг харгалзана:
- i. Гүйцэтгэгчийн хяналтын байцаагчид олгохоор тохиролцсон ажлын нэг өдрийн хөлс,
 - ii. Байгууламжид биечлэн хяналт шалгалт хийхтэй холбогдон гарах унаа, байр, хоолны зардлын нөхөн төлбөрийг олгох тохиролцсон нөхцөл
- г. Хяналт шалгалт хийх чадавх, хяналт шалгалтын үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлэхээр Гүйцэтгэгчээс гарсан бодит болон нэмэлт зардлыг хяналтын байцаагчийн ажлын нэг өдрийн тохиролцсон хөлсөд оруулж тооцно. Ажлын нэг өдрийн тохиролцсон хөлс XXXXX.
- д. Байгууламжид биечлэн хяналт шалгалт хийхтэй холбогдон гарсан унаа, байр, хоолны зардлын нөхөн төлбөр тооцох тохиролцсон аргад бодит зардал (ө.х. зарцуулсныг нотлох нэхэмжлэл) болон бусад үндэслэл бүхий зардал (ө.х. тохиролцсон хязгаарт багтах зах зээлийн бодит үнэ ханш) орно. .
- е. Захиалагч болон Гүйцэтгэгч талууд дараах үндэслэлийг баримтлан жилийн үйлчилгээний барагцаа зардлыг тооцохоор тохиролцоно:
- i. Тухайн жилд зөвшөөрөл авах шаардлагатай байгууламж бүр: 5 х ажлын нэг өдрийн тохиролцсон хөлс (хяналт шалгалт хийх бүрд зарцуулах өдрийн тоог тохиролцсон ажлын нэг өдрийн тохиролцсон хөлсөөр үржүүлнэ); дээр нь нэмээд
 - ii. Тухайн жилийн туршид хуваарийн дагуу байгууламжид хийх ээлжит хяналт шалгалт: 3 х ажлын нэг өдрийн тохиролцсон хөлс (хяналт шалгалт хийх бүрд зарцуулах өдрийн тоог ажлын нэг өдрийн тохиролцсон хөлсөөр үржүүлнэ); дээр нь нэмээд
Ердийн бус нөхцөл байдлын улмаас ээлжит аливаа хяналт шалгалт хийх нэмэлт ажлын өдөр шаардлагатай бол: Нэмэлт өдрийн тоо х ажлын нэг өдрийн тохиролцсон хөлс; дээр нь нэмээд
 - iii. Байгууламжид биечлэн хяналт шалгалт хийхтэй холбогдон гарах унаа, байр, хоолны зардлыг бодит болон үндэслэлтэй зардлаар ялган жагсаасан нөхөн төлбөр. Замын зардлыг 1 км тутамд XXXXX байхаар тооцно.
- ж. Жил бүрийн эхэнд Захиалагч болон Гүйцэтгэгч тухайн жилийн үйлчилгээтэй нөхцөлтэй холбоотой гарах зардлыг барагцаалан тооцно.
- з. Хяналт шалгалтын тайланг хяналт шалгалт бүрийн дараа ирүүлэх үед Гүйцэтгэгч нь ажлын бодит өдрийн тоо болон зардлыг жагсаасан нөхөн төлбөрийг үндэслэн

нэхэмжлэх үйлдэнэ. Хэрэв аль нэг жилийн нэхэмжлэхийн дүн нь тооцоолсон дүнгээс хэтэрсэн бол Гүйцэтгэгч нь нэхэмжлэлийн үндэслэлийг тайлбарлана.

- и. Гүйцэтгэгч хяналт шалгалтын тайланг илгээснээс хойш 30 хоногт багтааж нэхэмжлэх бэлтгэхээр тохиролцоно.
- к. Захиалагч зөрчилгүй нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор төлбөр төлөхөөр тохиролцоно.
- л. Үйлчилгээний өр төлбөртэй холбоотой аливаа маргааныг юуны өмнө дээр өгүүлсэн маргаан шийдвэрлэх хэсгийг мөрдөн шийдвэрлэнэ. Талууд өр төлбөртэй холбоотой маргааныг бусад аргаар шийдвэрлэж чадахгүй бол хуулийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй.

10. Гэрээг нягтлан хянах

- а. Үйлчилгээ үзүүлэх энэхүү гэрээг аль нэг тал нь цуцлах хүсэлтээ нөгөө талдаа хамгийн багадаа 3 сарын өмнө мэдэгдэж цуцлах хүртэл уг гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- б. Захиалагч болон Гүйцэтгэгч компанийн хамгаалалттай аж ахуйн үйлчлэх байгууламжийн тоо нэмэгдэх эсхүл хасагдах бүрд үйлчилгээ үзүүлэх гэрээг нягтлан хянаж шинэчилнэ.
- в. Захиалагч болон Гүйцэтгэгч гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 жилийн дотор гэрээг нягтлан хянаж шинэчилнэ.
- г. Гүйцэтгэгч нь МЭЕГ эсхүл Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос тогтоосон шинжилгээний үнэ төлбөрийн аливаа өөрчлөлтийг Захиалагч талд мэдэгдэх ба харин шинэ үнийг Захиалагчийн өмнө нь нэгэнт захиалсан сорьцод нөлөөлөхгүйгээр Гүйцэтгэгчийн урьдчилан товлоосон өдрөөс эхлэн хэрэглэнэ.

11. Лавлах баримт бичиг

- а. Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуй: Үйл ажиллагааны төлөвлөгөө, биохамгааллын нийтлэг заавар
- б. Компанийн хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар
- в. ISO 17025
- г. *Үйлчилгээ үзүүлэх зохицуулалт хийх явцад компанийн хамгаалалттай аж ахуйд лабораторийн шинжилгээний үйлчилгээ авах хэрэгцээ, үнийг тооцоолсон байдал,*
- д. Үйлчилгээ үзүүлэгчийн хийх боломжтой шинжилгээний болон тэдгээрт холбогдох үнийн албан ёсны бүртгэл.

Компанийг төлөөлж гарийн үсэг зурсан
(-Захиалагч гэх):

Нэр:

Албан тушаал):

Огноо

болон

МЭЕГ-аас зөвшөөрсөн хөндлөнгийн
баталгаажуулагч (Гүйцэтгэгч гэх):

Нэр:

Албан тушаал):

Огноо

.....

.....

.....

Zero Draft

C.11. Онцгойлсон өвчний эпидемиологийн үндсэн үзүүлэлт

Шүлхий өвчний эпидемиологийн үндсэн үзүүлэлт

1. Монгол улсад бүртгэгдсэн шүлхий өвчний үүсгэгч омог (хамгийн сүүлд бүртгэгдсэнээр)
 - Шүлхийн О хэвшлийн вирус (2022)
 - Шүлхийн А хэвшлийн вирус (2016)
 - Шүлхийн Ази 1 хэвшлийн вирус (2005)
2. Мэдрэмтгий мал, амьтны зүйл:үхэр, хонь, ямаа, ямаа, сарлаг, тэмээ
 - Зэрлэг амьтан: буга, цагаан зээр, зэрлэг гахай
3. Монгол улсын эпидемиологийн нөхцөл байдал
 - Улс орон даяар эндемик
4. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас Монгол улсын статусыг хүлээн зөвшөөрсөн байдал
 - Энд хэрэглэхгүй
5. Монгол улс дахь тэмцэх стратеги
 - Вакцинжуулалт
 - Тандалт
 - Дэгдэлтийн судалгаа, яаралтай вакцинжуулалт
 - Бүсчлэл (өвчнөөр тайван гэж хүлээн зөвшөөрөгдсөн газар зүйн бүс одоогоор байхгүй)
 - Хамгаалалттай аж ахуй байгуулах (өвчнөөр тайван гэж хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалттай аж ахуй одоогоор байхгүй)
1. Дамжин халдварлах механизм
 - Халдвартай амьтантай шууд хавьтах
 - Халдвартай малын шүүрэл, ялгадсанд шууд бусаар хүрэх
 - халдвартай мал, амьтан байгаа хүрээлэх орчин
 - халдвартай мал, амьтанд хэрэглэсэн тоног төхөөрөмж
 - халдвартай мал, амьтанд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл,
 - халдвартай мал, амьтан байсан хүрээлэх орчинд байсан тээврийн хэрэгсэл,
 - халдвартай мал, амьтан байсан хүрээлэх орчинд хэрэглэсэн эсхүл халдвартай амьтантай харьцахад өмссөн хувцас, гутал
 - халдвартай амьтанд хүрсэн хүн (хамрын хөндийд 48 цаг)
 - халдвартай амьтны гаралтай бүтээгдэхүүнээр бусад мал, амьтан тэжээх (ө.х. хоолны үлдэгдэл, хаягдал)
 - Агаар дуслаар тархах
6. Худалдаанд эрсдэлтэй бараа
 - Мэдрэмтгий зүйлийн амьд мал
 - Мэдрэмтгий зүйлийн малын үр, хөврөл үр
 - Мэдрэмтгий зүйлийн малын мах, махан бүтээгдэхүүн
 - Мэдрэмтгий зүйлийн малын сүү, сүүн бүтээгдэхүүн
 - Мэдрэмтгий зүйлийн малын арьс шир, үс ноос
 - Мэдрэмтгий зүйлийн мал идүүлж байсан малын тэжээл
7. Өвчний нууц үе
 - Дээд тал нь 14 хоног
8. Идэвхгүйжүүлэх нөхцөл
 - Дулаанаар идэвхгүйжүүлэх:
 - 70°C-д 30 минут
 - 132 хэмд 1 секунд
 - Идэвхгүйжүүлж чадах pH:
 - <6
 - >9

Химийн идэвхгүйжүүлэлт:

- Идэмхий натри (2%), натрийн карбонат (4%), нимбэгийн хүчил (0.2%), цууны хүчил (2%), натрийн гипохлорид (3%), калийн пероксимоносульфат/хоолны давс (1%), хлорын давхар исэл
- иодофор, дөрөвт аммонийн нэгдэл, фенолд ялангяа органик зүйл байгаа нөхцөлд тэсвэртэй

Үйлдвэрлэлийн явцад идэвхгүйжих:

- Мах, махан бүтээгдэхүүн, сүү, цөцгий, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс, шир, ангийн олдворт идэвхгүйжүүлэх зөвшөөрөгдсөн аргыг ДМАЭМБ-ын кодексоос лавлана уу.

9. Лавлагааны материал:

Шүлхий өвчний дэлхийн лавлагаа лаборатори: улс бүрийн тайлан: Монгол улс (Монгол улс (wrlshulхий.org))

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Шүлхий өвчний лавлагааны хуудас

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, Бүлэг 8.8 шүлхий өвчний халдвар (Газрын амьтны эрүүл мэндийн кодексийн цахимаар - ДМАЭМБ - Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага)

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлага, Бүлэг

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн мэдээллийн систем (WANIS (WOAH.org)):

- Монгол улс, Шүлхий өвчний нөхцөл байдлын дүн шинжилгээ,
- Монгол улс, Шүлхийн тандалт ба тэмцэх арга хэмжээний дүн шинжилгээ,
- Монгол улсын хагас жил тутмын тайлан

Бог малын мялзан өвчний эпидемиологийн үндсэн үзүүлэлт

1. Монгол улсад бүртгэгдсэн шүлхий өвчний үүсгэгч омог (хамгийн сүүлд бүртгэгдсэнээр)

- Бог малын мялзан өвчний вирус (БММӨВ), мөн бог малын морбиливирус гэж нэрлэнэ (БММВ (2022))
- Host range in Монгол улс
Мэдрэмтгий мал, амьтны зүйл: хонь, ямаа, сарлаг,
Зэрлэг амьтан: буга, цагаан зээр,
- Монгол улсын эпидемиологийн нөхцөл байдал
Алаг цоог тохиолдоно
- Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас Монгол улсын статусыг хүлээн зөвшөөрсөн байдал
Энд хэрэглэхгүй
- Өвчинтэй тэмцэх Монгол улсын стратеги
Вакцинжуулалт
Тандалт
Хамгаалалттай аж ахуй байгуулах (өвчнөөр тайван болох нь хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалттай аж ахуй одоогоор байхгүй)
- Дамжин халдварлах механизм
Халдвартай амьтантай шууд хавьтах

Халдвартай малын шүүрэл, ялгадсанд шууд бусаар хүрэх

- халдвартай мал, амьтан байгаа хүрээлэн буй орчин
- Халдвартай мал, амьтанд хэрэглэсэн тоног төхөөрөмж
- халдвартай мал, амьтанд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл,
- халдвартай мал, амьтан байсан хүрээлэх орчинд байсан тээврийн хэрэгсэл,
- халдвартай мал, амьтан байсан хүрээлэх орчинд хэрэглэсэн эсхүл халдвартай амьтантай харьцахад өмссөн хувцас, гутал

7. Худалдаанд эрсдэлтэй бараа

Мэдрэмтгий зүйлийн амьд мал

Мэдрэмтгий зүйлийн малын үр, хөврөл үр

Мэдрэмтгий зүйлийн малын мах, махан бүтээгдэхүүн

Мэдрэмтгий зүйлийн малын сүү, сүүн бүтээгдэхүүн

Мэдрэмтгий зүйлийн малын арьс шир, үс ноос

Мэдрэмтгий зүйлийн мал идүүлж байсан малын тэжээл

8.Өвчний нууц үе

Дээд тал нь 21 хоног

10. Идэвхгүйжүүлэх нөхцөл

Дулаанаар идэвхгүйжүүлэх:

- 70C-д 30 минут

Идэвхгүйжүүлж чадах рН <4

- >11

Химийн идэвхгүйжүүлэлт:

- Алгогол, эфир, ердийн угаалгын бодис, фенол, натрийн шүлт (2%) зэрэг ихэнх халдваргүйжүүлэгч бодист идэвхгүйжнэ.

Үйлдвэрлэлийн явцад идэвхгүйжих:

- Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, ноос, ноолуур, арьс, шир, ангийн олдворт идэвхгүйжүүлэх зөвшөөрөгдсөн аргыг ДМАЭМБ-ын кодексоос лавлана уу

8. Лавлагааны материал:

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, БММӨ-ий өвчний лавлагааны хуудас

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, бүлэг 14.7 Бог малын мялзан өвчний вирусийн халдвар (Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, цахимаар - ДМАЭМБ - Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага)

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлага, Бүлэг 3.8.9. Бог малын мялзан өвчин (бог малын морбиливирус) (ДМАЭМБ Газрын амьтны өвчний оношилгоо, вакцины гарын авлага: бүлэг 3.8.9 БММӨ)

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, дэлхийн мал, амьтны эрүүл мэнд мэдээллийн систем (WAHIS (WOAH.org)):

- Монгол улс Монгол улсын хагас жил тутмын тайлан

Нэгдсэн үндэстний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХААБ), EMPRES-i (Empres-i (fao.org))

Бог малын мялзан өвчнийг дэлхий даяар устгах хөтөлбөр II & III : Overview of the үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тойм (БММӨ дэлхий даяар устгах хөтөлбөр I & III)

C.13 Нэр томъёоны тодорхойлолт

Компанийн хамгаалалттай аж ахуйн бүтэц

Биохамгааллын заавар

- Компанийн хамгаалалттай аж ахуйн бүрэлдэхүүний бүх байгууламжид тавих хууль эрх зүй, техникийн болон захиргааны шаардлагыг оролцогч компани хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон чанарын удирдлагын тогтолцооны баримт бичиг

Компанийн хамгаалалттай аж ахуй

- Оролцогч компанийн (эсхүл сайн дурын үндсэн дээр хамтран ажиллахаар шийдвэрлэсэн оролцогч компаниудын бүлэг) боловсруулан хэрэгжүүлж байгаа, МЭЕГ дэмжиж, хүлээн зөвшөөрсөн биохамгааллын хөтөлбөр

Байгууламж

- Оролцогч компани хамгаалалттай аж ахуйдаа байгуулсан үйлдвэрлэл, төхөөрөлт болон/эсхүл боловсруулалтын үйл ажиллагаа эрхлэх газар

Оролцогч компани

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, хамгаалалттай аж ахуйн журам, тэдгээрт нийцүүлэн гаргасан МЭЕГ-ын стандартад заасан шаардлагыг ханган ажиллах чадвартай Монгол улсын мал аж ахуй эрхлэх, мах үйлдвэрлэх, төхөөрөх болон/эсхүл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд

Үйлдвэрлэлийн нэгж

- Хяналт-шинжилгээ, тандалт судалгаа, тайлан мэдээлэлд эпидемиологийн нэг нэгжээр тооцогдон нэг байранд хамт эсхүл биохамгааллын адил эрсдэлд маллагдаж байгаа мал амьтны бүлэг

Онцгойлсон өвчин

- Монгол улсын хивэгч малын хамгаалалттай аж ахуйн баталгааг хангах тогтолцооны шаардлага ёсоор тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлж, өвчнөөр тайван болохыг гэрчилгээгээр баталгаажуулах өвчин. Компанийн бүх хамгаалалттай аж ахуйд заавал тогтоож өгөх онцгойлсон өвчинд:

Хамгаалалттай аж ахуйд үхэр маллаж байгаа тохиолдолд:

- Шүлхий өвчин

Хамгаалалттай аж ахуйд хонь, ямаа маллаж байгаа тохиолдолд:

- Шүлхий өвчин
- Бог малын мялзан өвчин (БММӨ)

Онцгойлсон аюул

- Зарим улсын зах зээлийн өндөр босго, түүнчлэн бичил биетний эсрэг бодисын тэсвэржилт, тийм бодисын хэрэглээ (ББЭБТ/ББЭБХ), мал, амьтны тавлаг байдлын талаарх олон улсын стандартад тавигддаг шаардлагын улмаас мал,

амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг экспортын зах зээлд гаргахад саад болдог өвчний бус бусад аюул

Малын эрүүл мэндийн удирдлага

Хэвийн бус үйл явдал (CA3 B.15, B.16, B.20, B.31)

- Биохамгааллын ноцтой зөрчил ЭСХҮЛ үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ эсхүл эмнэл зүйн сэжигтэй тохиолдлын аль нэгнээс үүдэн явуулах мал, амьны эрүүл мэндийн судалгаа шинжилгээ.

Мал, амьтны эрүүл мэндийн үйл явдал, Мал, амьтны эрүүл мэндийн судалгаа шинжилгээ (CA3 B.20)

- Гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлт хэвийн хэмжээнээс хэтэрсний эсхүл эмнэл зүйн сэжиг илэрсний үр дүнд тогтоогдсон өвчний сэжигтэй тохиолдол, түүнтэй холбогдуулан хийх онцгойлсон өвчнийг үгүйсгэх судалгаа шинжилгээ

Биохамгааллын ноцтой зөрчил (CA3. B.15)

- Байгууламжийн хамгаалалттай газрын хил заагаар мэдрэмтгий зүйлийн зэрлэг амьтан нэвтрэн орж ирсэн эсхүл компанийн хамгаалалттай аж ахуйд мал, амьтан нийлүүлдэг аж ахуйд онцгойлсон өвчний (шүлхий өвчин, БММӨ) тохиолдол хамгийн сүүлд мал, амьтан авснаас хойш 30 хоногийн дотор (ө.х. хорио цээрийн хугацаанд) батлагдсан эсхүл өвчин дэгдсэн.

Өвчний үйл явдал (CA3 B.20)

- Компанийн хамгаалалттай аж ахуй дотор онцгойлсон өвчний лабораториор батлагдсан тохиолдол гарч улмаар хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг тэр даруй түдгэлзүүлэхэд хүргэсэн үйл явал.

Өвчнөөр тайван болохыг тогтоох судалгаа (CA3. B.17)

- Тайван гэж үзэхэд шаардагдах үнэмшлийн түвшинд хийж чадах тандалт судалгааны батлагдсан удирдамжийн дагуу үйлдвэрлэлийн нэгж болон байгууламж бүрд тогтмол явуулдаг, онцгойлсон өвчинд зориулсан идэвхтэй тандалт

Орох үеийн хорио цээр (CA3. B.2)

- Мал, амьтныг компанийн хамгаалалттай аж ахуйн байгууламжид оруулахын өмнө тусгаарлаж, шинжлэх үйл явц.

Үйлдвэрлэлийн хэмжүүр үзүүлэлтийн хяналт-шинжилгээ (CA3 B.16)

- үйлдвэрлэлийн нэгжийн дотор үйлвэрлэлийнх нь чиглэлээр төрөлжүүлэн ангилсан малын бүлэг бүрд хамаарах гүйцэтгэлийн гол хэмжүүр үзүүлэлтийг тогтоох, хяналт-шинжилгээ хийх, тэдгээрийн хэвийн хэмжээ хэтэрсэн тохиолдолд судлан шинжлэх шаардлагыг тогтоох.

Захиргаа удирдлагын үйл ажиллагаа

Өргөдөл гаргах

- Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрөл авах үйл явцыг эхлүүлэхийн тулд оролцогч компани шаардлагатай мэдээллийн хамт хүсэлтээ илгээх

Зөвшөөрөл

- Өвчнөөр тайван бөгөөд биохамгааллын батлагдсан зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдгийг баталгаажуулсны дараа МЭЕГ-аас зөвшөөрсөн компанийн хамгаалалттай аж ахуй болохын батламж

Компанийн хамгаалалттай аж ахуйн гэрчилгээ

- Компанийн хамгаалалттай аж ахуйгаас борлуулалтад ачуулж буй мал, амьтан, генетикийн материал, мах, махан бүтээгдэхүүн, мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүний гарал үүслийн болон өвчнөөр тайван статусыг хэрэглэгчдэд батлах зорилгоор оролцогч компанийн зүгээс олгож болохыг зөвшөөрсөн баримт бичиг

Албан ёсны баталгаа

- Албан ёсны эрх бүхтэй малын эмчийн олгох экспортын гэрчилгээ зэрэг төрөөс олгох гэрчилгээ.

Бүртгэл

- Оролцогч компанийн хүсэлтийг баримт бичгийн бүх шаардлагыг хангасан, түүний дотор биохамгааллын заавраа батлуулсан гэж үзэж хүлээн авсны баталгаа.

Сэргээх

- Түдгэлзлийг хүчингүй болгох

Цуцлах

- Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг бүрмөсөн хүчингүй болгох

Түдгэлзүүлэх

- Компанийн хамгаалалттай аж ахуйн зөвшөөрлийг түр зуур хүчингүй болгох.

Хяналт

Хяналт шалгалт

- Биохамгааллын зааврын шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор тодорхой тодорхой тогтоосон аргачлалаар хийх үнэлгээ

Залруулах арга хэмжээ

- Оролцогч компанийн зүгээс үл тохирлыг залруулах баталгаа гаргаж байгаа арга хэрэгсэл.

Хөндлөнгийн хяналт

- Байгууламж нь үйл ажиллагаагаа өөрийн биохамгааллын зааврын шаардлагад нийцүүлэн явуулж байгааг төрөөс эрх олгосон баталгаажуулагч этгээдээр баталгаажуулах үйл ажиллагаа

Дотоод хяналт

- Байгууламж нь үйл ажиллагаагаа өөрийн биохамгааллын зааврын шаардлагад нийцүүлэн явуулахын тулд оролцогч компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

Үл тохирол

- Биохамгааллын зааврын шаардлагыг дагаж мөрдөөгүй болохыг тогтоосон хяналт шалгалтын үр дүн

Тогтмол тайлан

Тогтоосон загварын дагуу тодохой мэдээллээр хангах сар, жил тутмын тайлан

Zero Draft